

Дээрхийн Гэгээн
XIV Далай Лам

# ШҮГДЭНГИЙН ТУХАЙ АЙЛДВАР



“Монгол туургатан та бүхэн мэдэх байх. Дээр үед Төвдөд шашны сахиус эсэх нь эргэлзээтэй догшин буг гарсныг V Далай Лам Лувсанжамц бээр ерөөл буруудсан тангаргийн буг хэмээн танин барьсан юм. Шарын шашны эрдэм чадал төгс олон мэргэд, дээд төрөлхтөн нар V Далай Ламын тангаргийн буг хэмээн танин барьсныг хүлээн зөвшөөрч нийт Бурхан шашны таалалтай зохилдох зохионгуйг туурвиж байв.”

*Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Лам*



“Бидний энэрэн нигүүлсэгч багш Дээрхийн Гэгээнтэн Далай Ламын таалсан ёсоор олон дээд төрөлхтөн нар тангаргийн буг Дорж Шүгдэнд аврал одуулж, тахиж шүтэх нь зохисгүй хэмээн таалсан билээ. Энэхүү ном таны оюуныг гийгүүлж, зөв замыг сонгоход тань туслана гэдэгт би гүнээ итгэж байна.”

*IX Богд Жавзандамба Хутагт*



“Дээрхийн Гэгээнтэн Далай Лам ямар учраас Шүгдэнг шүтэхийг хориглосныг олон хүмүүс мэдэхгүй байна. Энэ ном Шүгдэнгийн тухай айлдсан Дээрхийн Гэгээнтний хуурмаггүй зарлигийг Монгол дахь түүний бүх шавь нарт хүргэх болно. Үнэндээ Шүгдэнг тахин шүтэх нь Бурханы номын анхааран авлага огтхон ч биш юм.”

*Ажаа Гэгээн*



“Монгол хэлтэй нутаг орон хийгээд ялангуяа Монгол оронд Бурханы шашин доройтсоныг дахин сэргээх, оршин байгааг дээш арвитгахын тулд авла орхилыг заан сургасан энэ мэт сургаалыг ард олон эх хэлээрээ унших нь бусдын худал хуурмагаар хэтрүүлэн ярих, хууран мэхлэх, толгой эргүүлэх зэрэгт үл автан хувь хүн өөрөө сайн мууг ялгахад тус хэрэг ихтэй билээ.”

*Жадо Ринбүүчи*



“Ямартай ч олон жилийн турш ажиглан шинжлээд Шүгдэнг шүтэх нь зохисгүй хэмээн хориглосон нь ганц Дээрхийн Гэгээнтэн Далай Лам биш юм. Наран мандаж харанхуйг гийгүүлдэг мэт шашин хийгээд амьтны тусыг агуу ихээр бүтээж байсан Гачэн Ишжанцан, Туган Лувсанчойжинямаа тэргүүтэн Гэлүгба ёсны билэг чанар төгс багш дээдэс нар Шүгдэнг шүтэхийг хориглож байв.”

*Зопа Ринбүүчи*

Д э э р х и й н   Г э г э э н

# XIV Далай Лам

## ШҮГДЭНГИЙН ТУХАЙ АЙЛДВАР

http://www.facebook.com/dalailambashugden

http://www.twitter.com/ShugdenMongolia

http://dalailambashugden.blogspot.com

© 2010 XIV Далай Лам

Дээрхийн Гэгээнтний энэхүү айлдварыг олон нийтэд хүргэх зорилгоор телевиз, радио, сонин, сэтгүүл, цахим хуудсанд нийтлэхдээ эх сурвалжийг дурдалгүйгээр үг, утгыг гуйвуулан нийтлэх болон ашиг олох зорилгоор худалдаалахыг хориглоно!

*“...Зургаан мутарт Гомбо, Чойжоо, Лхам*
*Дөрвөн нигуурт Гомбо, Жамсран Бэгз тэргүүтэн*
*Тахиж шүтэн бүтээх тангарагт сахиус бүгдэд*
*Тансаг ундаан дээжийн тахил үүнийг өргөе.*

*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн болон шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун…”*

*V Далай Лам Лувсанжамц*

# ГАРЧИГ

IX Богд Жавзандамба Хутагтын айлдвар - 8

Гандан Ширээтийн айлдвар - 10

Жадо Ринбүүчийн айлдвар - 12

Ажаа Гэгээний айлдвар - 28

Зопа Ринбүүчийн айлдвар - 31

Өмнөх үг - 58

Тангаргийн буг Шүгдэн гарсан түүх - 61

1. 2000 оны 3-р сарын 15-ний өдрийн айлдвар - 66

2. 2000 оны 12 сарын 6-ний өдрийн айлдвар - 70

3. 2001 оны 8-р сарын 2-ний өдрийн айлдвар - 85

4. 2002 оны 12-р сарын 2-ний өдрийн айлдвар - 88

5. 2002 оны 12 сарын 6-ний өдрийн айлдвар - 91

6. 2004 оны 1-р сарын 7-ний өдрийн айлдвар - 95

7. 2004 оны 3-р сарын 26-ний өдрийн айлдвар - 100

8. 2004 оны 12-р сарын 10-ний өдрийн айлдвар - 104

9. 2005 оны 8-р сарын 16-ний өдрийн айлдвар - 107

10. 2006 оны 1-р сарын 8, 9-ний өдрийн айлдвар - 115

11. 2006 оны 3-р сарын 27-ний өдрийн айлдвар - 121

12. 2006 оны 12-сарын 20-ний өдрийн айлдвар - 127

13. 2007 оны 9-р сарын 12-ний өдрийн айлдвар - 131

14. 2007 оны 11-р сарын 10-ний өдрийн айлдвар - 134

15. 2007 оны 12-р сарын 24-ний өдрийн айлдвар - 136

16. 2007 оны 1-р сарын 11-ний өдрийн айлдвар - 139

17. 2008 оны 1-р сарын 3-ний өдрийн айлдвар - 159

18. 2008 оны 1-р сарын 5-ний өдрийн айлдвар - 163

19. 2008 оны 1-р сарын 7-ний өдрийн айлдвар - 167

20. 2008 оны 1-р сарын 8-ний өдрийн айлдвар - 178

21. 2008 оны 1-р сарын 9-ний өдрийн айлдвар - 189

22. 2008 оны 1-р сарын 14-ний өдрийн айлдвар - 195

23. 2008 оны 7-р сарын 2-ний өдрийн айлдвар - 218

24. 2009 оны 1-р сарын 11-ний өдрийн айлдвар - 232

25. 2010 оны 1-р сарын 8-ний өдрийн айлдвар - 237

26. 2010 оны 8-р сарын 31-ний өдрийн айлдвар - 246

27. 2010 оны 10-р сарын 7-ний өдрийн айлдвар - 251

# IX БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН АЙЛДВАР

GANDAN LABRANG
H.H.THE IX BOGD JEVTSUNDAMBA KHUTAGT

Ulaanbaatar-38, Mongolia
Tell: 976-11-362499 Fax: 976-11-362499

Date 28-02-2012 № 012

*MESSAGE*

*I wish for long time that this book should be translated into the Mongolian language so that Mongolian people shall have access to the knowledge. According to many high lamas led by our kindest teacher, His Holiness the Dalai Lama, this spirit, Dorjee Shugden, is unworthy of worshipping and taking refuge. Indeed, all the prominent monasteries have banned this spirit worshipping for various reasons. And I hope that this book will enlighten you to choose the right path. I pray that we will contribute to the happiness of each other.*

*His Holiness the 9th Bogd Jetsun Dhampa Rinpoche*
*Spiritual Head of Mongolian Buddhism*

# IX БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН АЙЛДВАР

Миний бие энэхүү номыг монгол хэлнээ орчуулагдахыг удаан хугацааны турш хүсэж байсан. Ингэснээр монголчууд маань Шүгдэнгийн тухай бодит үнэнийг мэдэх боломжтой болох юм.

Бидний энэрэн нигүүлсэгч багш Дээрхийн Гэгээнтэн Далай Ламын таалсан ёсоор олон дээд төрөлхтөн нар тангаргийн буг Дорж Шүгдэнд аврал одуулж, тахиж шүтэх нь зохисгүй хэмээн таалсан. Мөн алдар цуутай бүхий л хийдүүд шүтэхээ больсон билээ.

Энэхүү ном таны оюуныг гийгүүлж, зөв замыг сонгоход тань тусална гэдэгт би гүнээ итгэж байна.

Бид бие биендээ амар амгаланг бэлэглэж байх болтугай хэмээн ерөөл тавин залбиръя.

Монголын Бурханы Шашны Тэргүүн
IX Богд Жавзандамба

# ГАНДАН ШИРЭЭТ
# РИЗОН СРАЙ ХУВИЛГААНЫ АЙЛДВАР


དགའ་ལྡན་ཁྲི་པ་རི་རྫོང་སྲས་སྤྲུལ་ཐུབ་བསྟན་ཉི་མ།

GADEN TRIPA RIZONG SRAS -TRUL
THUPTEN NYIMA

LUKHIL KHANGTSEN
DREPUNG LOSELING
L.C # 2 , TATTIHALLI
MUNDGOD-581411
N.K. KARNATAKA
SOUTH INDIA

PHONE: 08301 245658


DATE ____________________

༄༅།། འཕགས་ཡུལ་རྒྱ་གར་ལྷོ་ཕྱོགས་སེ་ར་ཆོས་སྐད་དུ་སོག་རིགས་སློབ་གཉེར་བ་རྣམས་ལ། དོལ་རྒྱལ་ལམ་ཤུགས་ལྡན་བསྟེན་ཕྱོགས་སྐོར་༸གོང་ས་༸རྒྱལ་དབང་སྐུ་ཕྲེང་ལྔ་པ་མཆོག་དང་། ༸རྒྱལ་དབང་སྐུ་ཕྲེང་བཅུ་གསུམ་པ་ཆེན་པོ་གཙོ་བོར་གྱུར་པའི་རྒྱལ་དབང་སྐུ་ཕྲེང་རིམ་བྱོན་དང་། པཎ་ཆེན་སྐུ་ཕྲེང་རིམ་བྱོན་དང་། ལྕང་སྐྱ་ངག་དབང་མཆོག་ལྡན། ལྕང་སྐྱ་རོལ་པའི་རྡོ་རྗེ། ཁྲི་ཆེན་ངག་དབང་མཆོག་ལྡན་སོགས་རི་བོ་དགེ་ལྡན་པའི་ཚད་ལྡན་བླ་མ་རྣམས་དང་། ས་སྐྱོང་བཀའ་གསུམ་སོགས་ཚད་ལྡན་བླ་མ་དུ་མས་ཤུགས་ལྡན་བསྟེན་ཕྱོགས་སྐོར་ལུང་རིགས་དུ་མའི་སྒོ་ནས་དགག་པར་མཛད་པའི་ཚད་ལྡན་གྱི་གཞུང་མང་པོ་སོག་རིགས་སྐད་དུ་བསྒྱུར་དང་སྒྱུར་བཞིན་པ་རྣམས་དོལ་རྒྱལ་གྱི་གནས་སྟངས་ཚུལ་བཞིན་མ་ཤེས་པ་ལོག་པའི་ལམ་དུ་འཁྲིད་པ་རྣམས་ལ། སྤྱི་ནོར་༸གོང་ས་༸སྐྱབས་མགོན་སྐུ་ཕྲེང་བཅུ་བཞི་པ་ཆེན་པོ་མཆོག་ནས་བཀའ་སློབ་སྔ་ཕྱི་རིམ་པར་བསྩལ་བ་རྣམས་འབྲེལ་ཡོད་ཁག་ལ་གསལ་བཤད་མཛད་ཐུབ་ཚེ། རིས་མེད་རྒྱལ་བསྟན་ཡོངས་རྫོགས་ལ་ཕན་ཚུན་དག་སྣང་ནོར་བུའི་འོད་སྣང་གིས་ཁྱབ་སྟེ་འཛམ་གླིང་ཡོངས་ལ་ཞི་བདེ་འབྱུང་བའི་རྒྱུར་གྱུར་ངེས་ལགས་པས་གཟུར་གནས་བློ་ལྡན་རྣམས་ཀྱིས་ཐུགས་དགོངས་དཔྱིས་སུ་མངའ་བ་མཁྱེན། མཁྱེན། མཁྱེན།

ཅེས་སྨོན་པའི་མཚམས་སྦྱོར་དང་
བཅས་དགའ་ལྡན་ཁྲི་རབས་བརྒྱ་དང་གཉིས་པ་རི་རྫོང་སྲས་སྤྲུལ་ཐུབ་བསྟན་ཉི་མས། ཕྱི་ལོ་༢༠༡༣
ཟླ་བ་༤པའི་ཚེས་༡༥བཟང་པོར་བྲིས།།

GADEN TRIPA THUPTEN NYIMA

RIZONG LABRANG CHANGSPA, DISTT. LEH LADAKH - 194101 J&K STATE NORTH INDIA. Ph. 01982 - 253103

# ГАНДАН ШИРЭЭТ
# РИЗОН СРАЙ ХУВИЛГААНЫ АЙЛДВАР

Хутагт Жагарын орны өмнө зүг дэх Сэра хийдэд суралцаж буй монгол хуврагууд Ялгуусны эрхт V Далай Лам болон XIII Далай Лам голлосон Далай Ламын дүрүүд хийгээд Ванчин Богдын дүрүүд, Жанжаа Агваанчогдон, Жанжаа Ролбийдорж, Дэчин Агваанчогдон тэргүүтэн Гэлүгбын шашны билэг чанар төгөлдөр дээдсүүд хийгээд Сажава, Нинмава, Гаржүдбын билэг чанар төгөлдөр олон мэргэдийн Шүгдэнг шүтэхийг эш, ухааны үүднээс хориглон зохиосон айлдварууд болон Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Ламын Шүгдэнгийн тухай зэргэмчлэн айлдсан сургаалуудыг монгол хэлнээ хөрвүүлж, Шүгдэнгийн тухай байр байдлыг ёсчлон мэдэхгүй буруу мөрд хөтлөгдсөн нугууд болон бусад холбогдох хүмүүст тайлбарлаж буй нь Бурханы шашны урсгал дамжлага бүхэнд арилсан үзэгдлийн зэндмэнэ эрдэнийн гэрэл харилцан түгэх хийгээд дэлхий нийтэд амар амгалан гарахын шалтгаан болох нь магадтай тул шударга оюунтан нугууд бээр таалалдаан эрхшээн болгоогтун

хэмээх ерөөлийн завсар найруулга лугаа сэлтийг Зуун Хоёрдугаар Гандан Ширээт Ризон Срай Хувилгаан Түвдэнням бээр 2013 оны 8-р сарын 15-ний сайн өдөр бичив.

# ЖАДО РИНБҮҮЧИЙН АЙЛДВАР

རྣམ་རྒྱལ་མཁན་ཟུར་བྱ་དོ་སྤྲུལ་སྐུ།

**JHADO TULKU**

**(Abbot Emeritus of Namgyal Monastery)**

༄། ད་ལམ་འཕགས་ཡུལ་རྒྱ་གར་ལྷོ་ཕྱོགས་སེ་ར་ཆོས་སྡེར་དུ། སེར་བྱེས་མཁས་སྣན་གྲྭ་ཚང་གི་སློབ་གཉེར་བའི་ཁོང་ནས། ཆེན་པོ་ཧོར་གྱི་ཡུལ་ནས་ཕེབས་པའི་གཞུང་ཆེན་སློབ་གཉེར་བ་རྣམས་ཀྱིས་མ་སྐྱུལ་དང་བླང་གྲོས་བསམ་གཅིག་མཐུན་ཐོག་ནས། ས་སྟེང་རྒྱལ་བསྟན་ཡོངས་རྫོགས་ཀྱི་མངའ་བདག་༧སྤྱི་ནོར་༧གོང་ས་༧སྐྱབས་མགོན་ཆེན་པོ་༧རྒྱལ་བ་ཡིད་བཞིན་ནོར་བུའི་བཀའ་སློབ་དེབ་བྲེང་རྣམ་རྒྱལ་གྲྭ་ཚང་ཞེས་ཡོན་ལྡན་ཚོགས་ནས་པར་བསྐྲུན་གནང་བའི་ཁོང་ནས། རྡོལ་རྒྱལ་ལམ་ཤུགས་ལྡན་སྐོར་གྱི་བླང་དོར་བཀའ་སློབ་དེ་དེང་དུས་བྱེ་སོག་གི་སྐད་ཡིག་ཐོག་བབ་བསྒྱུར་གནང་འདུག་པ། འདི་བཞིན་སྤྱིར་སོག་སྐད་འབྲེལ་ཡོད་ལུང་པ་ཁག་དང་བྱེ་བྲག་ཏུ་སོག་ཡུལ་དུ་རྒྱལ་བསྟན་ཉམས་པ་སླར་གསོ་མི་ཉམས་གོང་འཕེལ་སྤྱད། ཕྱར་བླང་འཛུག་ཕྱོགས་བྱ་ཆེད་མི་མང་རྣམས་ལ་བླང་དོར་ལམ་སྟོན་གྱི་བཀའ་སློབ་རང་གི་ཡུལ་སྐད་ཐོག་གློག་འདོན་བྱ་རྒྱུ་ཡོད་པ་ནི། གཞན་གྱི་རྣམ་བཤད་བརྟུན་བསྒྲིག་གཡོ་འཁྲུལ་ངོག་མགོ་འཁོར་མ་འཕེབ་པ་དོ་བདག་རང་ངོས་ནས་ལེགས་ཉེས་རྣམ་དབྱོད་བྱ་ཐུབ་པའི་ཆེད་དུ་ཧ་ཅང་གལ་ཆེ་བས། སྐབས་འདིའི་ལས་དོན་མཉམ་བཞུགས་པ་ཡོངས་ལ་བསྔགས་བརྗོད་དང་མཐུན་འགྱུར་ཐུགས་རྗེ་ཆེ་ཞུ་བ་དང་ཆབ་ཅིག འཛམ་མགོན་རྒྱལ་བ་གཉིས་པའི་བསྟན་པ་འཆད་རྩོད་རྩོམ་གསུམ་གྱི་སྒོ་ནས་འཕེལ་རྒྱས་བསྐྱོད། ༧རྒྱལ་བ་ཡིད་བཞིན་ནོར་བུའི་བཀའ་སློབ་སོགས་སུ་ཐུད་བབ་བསྒྱུར་བསྐྲུན་ལྷུགས་ཞུ་བ་དང་ཆབ་གཅིག་འདུལ་ཁྲིམས་སློབ་གཉེར་མཛད་ཕྱིན་ཡོད་པའི་སྨོན་ལམ་བཅས།

རྣམ་རྒྱལ་མཁན་ཟུར་བྱ་དོ་སྤྲུལ་མིང་པས་ཟླ་ཚེས་ལ། ༦/༩/༢༠༡༢ བྲིས་པ་

དགེ་ལེགས་འཕེལ།། ||

Namgyal Monastery, P.O. McLeod Ganj-176219, Distract Kangra, H.P., India.
Cellphone: +91-9418043860, 9816119504, Email: namjhado@yahoo.com, thubtentashi@yahoo.com

# ЖАДО РИНБҮҮЧИЙН АЙЛДВАР

Хутагт Жагарын орны өмнө зүг дахь Сэра хийдийн монгол хуврагууд Ялгуусны шашны эзэн Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Багшийн айлдварыг Намжал Дацангаас эмхтгэн хэвлүүлж буйн дотроос Должал буюу Шүгдэнгийн тухай айлдсан сургаалыг орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлсэн байна.

Ер монгол хэлтэй нутаг орон хийгээд ялгамжаатай Монгол оронд Бурханы шашин доройтсоныг дахин сэргээх, оршин байгааг дээш арвитгахын тулд авла орхилыг заан сургасан энэ мэт сургаалыг ард олон эх хэлээрээ унших нь бусдын худал хуурмагаар хэтрүүлэн ярих, хууран мэхлэх, толгой эргүүлэх зэрэгт үл автан хувь хүн өөрөө сайн мууг ялгахад тус хэрэг ихтэй билээ.

Энэхүү номыг бүтээхэд оролцсон бүгдийг сайшаан, баярлаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд Зөөлөн Итгэлт Богд Ламын шашныг номлол, хэлцэл, туурвил гурвын үүднээс арвитгахын тухайд Дээрхийн Гэгээнтний сургаал номлолыг монгол хэлнээ үргэлжлүүлэн орчуулахыг хүсэмжлэн сахил санваар ариун байж, хичээл сургууль нь эцэстээ хүрэхийг ерөөе!

Намжал Дацангийн Хансүр Жадо Хувилгаан нэрт бээр
2012 оны IV сарын 6-ний өдөр бичив.
Сайн буян арвидах болтугай!

**2012 оны 9-р сарын 21-ний өдөр Жадо Ринбүүчийн Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх Идгаачойнзинлин дацанд хуран цугласан сүсэгтэн олонд “Арван Хангал”-ын даган соёрхол хайрлах үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар**

(Төвд эх)

(Монгол орчуулгыг унших)

ཐོག་མར་སྔོན་འགྲོའི་ཆོས་བཤད་དང་འབྲེལ་ནས་ངོ་སྤྲོད་ཅིག་བྱས་ན་བསམས་སོང་། དེའི་རྗེས་ལ་བགེགས་གཏོར་གཏོང་བ་དང་རྗེས་གནང་དེ་ཚོ་རིམ་གྱིས་འདོན་པའི་འཆར་གཞི་ཡོད། དེ་ལ་དེ་སྔོན་རྗེ་བཙུན་དམ་པའི་ཆོས་ཚོགས་ཀྱི་ཚོགས་མིས་མཐུལ་ཏེན་གསུམ་བཀུགས་ཏེ་ཨ་རོང་ཏང་གལ་(ཨ་རོང་ཞེས་པ་བཅུ་དང་། ཏང་གལ་ཞེས་སྐྱུང་ཞིང་སྐྱོབ་པ་ལ་གོ་ཞིང་། དེ་ལྟའི་ཡི་དམ་ཆོས་སྐྱོང་བཅུ་ནི། འཇིགས་བྱེད། ཕྱག་རྡོར། མགོན་པོ་ཕྱག་དྲུག། མགོན་དཀར། མགོན་པོ་ཞལ་བཞི། ཆོས་རྒྱལ། ལྷ་མོ། རྣམ་སྲས། ལྕམ་སྲིང་། ཚངས་པ་དཀར་པོ་བཅས་ཡིན།)གྱི་རྗེས་གནང་རྣམས་འདོན་རོགས་ཞེས་རེ་སྐུལ་བྱས་སོང་། དེར་བརྟེན། རྒྱུ་མཚན་དུ་མ་ཞིག་ལ་དམིགས་ཏེ་རྗེས་གནང་དེ་དག་དབུས་དགའ་ལྡན་དགོན་པ་དང་གྲྭ་ཚང་ཁག། དེ་འབྲེལ་གྱི་ས་ཁུལ་ཁག་གི་སེར་སྐྱ་ཐུན་མོང་ལ་དགག་བྱ་མེད་པར་འདོན་ཐུབ་ན་སྤྱི་ལ་ཕན་པ་སོགས་དགེ་མཚན་ཆེ་བར་མཐོང་བས་དེ་ལྟར་གཏན་འཁེལ་བྱུང་།

རྗེས་གནང་དེ་དག་སེར་སྐྱ་མང་ཚོགས་ཐུན་མོང་ལ་འདོན་པར་རྒྱུ་མཚན་དུ་མ་ཞིག་ཡོད་པ་ལས་དང་པོ་ནི། སོག་པོའི་ལུང་པ་འདིར་སྤྱི་ལོ་ཆིག་སྟོང་དགུ་བརྒྱ་སུམ་ཅུ་སོ་བརྒྱད་ནས་དཀའ་ངལ་སྣ་ཚོགས་བྱུང་ཞིང་སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་རིན་པོ་ཆེར་ཉམས་ཆག་ཆེན་པོ་བྱུང་། དེར་བརྟེན། མང་ཚོགས་ཁྲོད་ལྷ་གང་ཞིག་བསྟེན་གསོལ་བྱེད་འོས་པ་དང་མི་འོས་པའི་རྣམ་དབྱེ་འབྱེད་མི་ཤེས་པ་མང་ཙམ་ཡོད་པ་དང་། ལྷག་པར་དུ་མང་ཚོགས་ནང་སོག་པོའི་ལུང་པ་རང་ཉིད་དང་སྔ་མོ་ནས་འབྲེལ་བ་ཤིན་ཏུ་ཟབ་མོ་ཡོད་པའི་ལྷ་དེ་དག་ངོ་མ་འཕྲོད་པ་མང་ཙམ་ཡོད་པས་དེ་དག་ངོ་འཕྲོ

ད་པ་ཞིག་བྱུང་ན་བསམ་པ་དེ་ཡིན།

དེ་ནས་རྒྱུ་མཚན་གཉིས་པ་ནི། ཡི་དམ་ཆོས་སྐྱོང་བཙུ་པོ་དེ་སྔ་མོ་ནས་སོག་པོ་རྣམས་དང་འབྲེལ་བ་ཐུན་མོང་མ་ཡིན་པ་ཞིག་ཡོད་ཅིང་མང་ཚོགས་ཀྱི་ངོས་ནས་ཀྱང་དད་པ་ཆེན་པོ་ཡོད་པ་གསལ་པོ་རེད། གཞན་ཕར་ཟད་མིའི་མིང་ཚུན་ཆད་ལ་མ་ཧཱ་ཀཱ་ལ་ཟེར་བ་དང་། ཀྵེ་ཏྲ་པ་ལ་ཟེར་བ། ཛཱི་ན་མི་ཏྲ་ཟེར་བ་ལྟ་བུ་ལྷ་དེ་དག་དང་འབྲེལ་ཡོད་ཀྱི་མིང་བཏགས་པ་མང་པོ་ཡོད། འོན་ཀྱང་། ལོ་མང་པོ་ཞིག་གི་རིང་ལ་དམར་ཤོག་ཆགས་ཏེ་ཉམས་ཆག་ཆེན་པོ་བྱུང་ཡོད་པས། རང་ཉིད་ཀྱི་ཕ་མེས་ནས་བརྒྱུད་པའི་ཡི་དམ་ཆོས་སྐྱོང་དེ་དག་དང་འབྲེལ་བ་སླར་ཡང་མཐུད་པ་ཐུབ་པ་ཞིག་བྱུང་ན་བསམ་པ་དེ་ཡིན།

དེ་ནས་རྒྱུ་མཚན་གསུམ་པ་ནི། སོག་པོའི་མི་མང་རྣམས་དད་པ་ཆེན་པོ་དང་། ལྷ་སྲུང་དུ་འབོད་པ་གང་ཞིག་ཡིན་ཡང་ཅི་མི་སྙམ་པར་སྐྱབས་སུ་འགྲོ་ཚོག་ཚོག་དང་། བློ་སྙིང་བྲང་གསུམ་གཏད་ཚོག་ཚོག་ལྟ་བུ་ཞིག་ཡིན་པས། ད་ལན་ཡི་དམ་ཆོས་སྐྱོང་བཙུ་པོ་དེ་དག་ངོ་སྤྲོད་ལྟ་བུ་ཞིག་བྱས་ན། ལྷ་གང་བྱུང་དུ་བསྟེན་གསོལ་མི་བྱེད་པ་དང་བསྟེན་དོན་མི་འབྱུང་བར་ཕན་ཐོགས་ཆེན་པོ་ཞིག་ཡོང་ངེས་སྙམ་པ་དེ་ཡིན།

རྒྱུ་མཚན་གཙོ་བོ་དེ་ནི། ཚང་མས་མཁྱེན་གསལ་ལྟར་སྤྱི་ལོ་ཉིས་སྟོང་དྲུག་གི་ལོར། ༧སྤྱི་ནོར་༧གོང་ས་༧སྐྱབས་མགོན་ཆེན་པོའི་ཞལ་སྔ་ནས་ཀྱིས་རྟ་མགྲིན་ཡང་གསང་གི་བཀའ་དབང་བྱིན་རླབས་ཀྱི་ཚན་ཁ་རབ་ཏུ་འབར་བ་ཞིག་གནང་། སྐབས་དེར་མང་ཚོགས་ལ། སྤྱིར་ལྷ་གང་བྱུང་བྱུང་དང་། ཡང་སྒོས་རྒྱལ་པོ་ཤུགས་ལྡན་ཟེར་བ་རྟེན་གཞི་ཅན་དེ་བསྟེན་གསོལ་མ་བྱས་ན་ལེགས་པའི་བཀའ་སློབ་གསལ་པོ་ཞིག་གནང་། དེ་ནས་ན་ནིང་ཉིས་སྟོང་བཅུ་གཅིག་གི་ལོ་མཇུག་ཙམ་ལ་སོག་ཡུལ་འདིར་རྩེད་ཁང་ཆེན་པོ་དེའི་ནང་ཐུགས་རྗེ་ཆེན་པོའི་དབང་ཆེན་གནང་སྐབས། ང་རང་ཡང་དེར་བཅར་རྒྱུའི་སྐལ་བ་བཟང་པོ་བྱུང་ལ། སྐབས་དེར་ཡང་དྲེགས་པ་རྩོད་

གཞི་ཅན་དེ་བསྟེན་ན་ཉེན་ཁ་ཆེ་ལ་རྟོག་གླེང་མང་བ། བླ་མ་གོང་མ་རྣམས་ཀྱིས་བཀག་འགོག་གནང་བ་སོགས་ཀྱི་གསལ་བཤད་ཞིབ་ཅིང་ཕྲ་བ་ཞིག་གནང་བས། དེ་དག་གཞི་ལ་བཞག་ནས་ད་ཆ་ང་རང་ཚོས་གང་ཞིག་བསྟེན་ཆོག་པ་དང་། གང་ཞིག་བསྟེན་མི་འོས་པ་སོགས་ལེགས་པར་ཤེས་པའི་ཐོག་ནས། ད་གཟོད་ཡིད་དམ་ཆོས་སྲུང་བཙུ་ཟེར་བ་དེ་དག་འདི་དང་དེ་རེད་ཨང་སྐམ་པའི་ངེས་ཤེས་བརྟན་པོ་ཞིག་བྱུང་ན་ཤིན་ཏུ་ལེགས་པར་བསམས་ཤིང་། དགོས་པ་དེའི་དོན་དུའང་ད་ལན་ངས་མང་ཚོགས་རྗེས་གནང་ལ་མ་བཀག་པ་ཡིན། གོང་ཞུས་དང་འབྲེལ་བའི་གནས་ཚུལ་ཞིབ་ཅིང་རྒྱས་ལ་གསལ་ཞིང་དག་པ་རྣམས་ད་ལྟ་ངས་ཆོས་ཞུ་བ་ཚོར་བཀྲམས་པའི་༧སྐྱབས་མགོན་རིན་པོ་ཆེའི་བཀའ་སློབ་དེར་འཁོད་ཡོད་པས་ཁྱེད་རང་ཚོས་ཡག་པོ་ཞིག་ཀློག་རོགས་གནང་།

ད་ལྟ་ང་རང་སྒེར་གྱི་བསམ་ཚུལ་དུ་མ་ཚིག་ཉུང་ངུར་བསྡུས་ཏེ་བཤད་ན། དོན་དངོས་ཐོག་ནང་པ་སངས་རྒྱས་པའི་བསྟན་པ་དང་འགྲོ་བའི་དོན་ལ་མཛད་འཕྲིན་རབ་ཏུ་རྒྱས་པ་ད་ལྟའི་༧སྐྱབས་མགོན་རིན་པོ་ཆེ་སྐུ་ཕྲེང་བཅུ་བཞི་པ་འདི་ལྟ་བུ་ཞིག་སྔར་ཡང་མ་བྱུང་ལ་ཕྱིས་ཀྱང་འབྱུང་བར་དཀའ། ཞིབ་ཏུ་བསམས་ན་རང་ཅག་རྣམས་ཀྱི་བསོད་ནམས་ཀྱི་དཔལ་དུ་འདི་ལྟ་བུ་ཞིག་ཞལ་བཞུགས་པ་ནི་ཤིན་ཏུ་ནས་ཀྱང་རྩ་ཆེན་པོ་ཞིག་ཡིན་ལ། སྐྱེས་བུ་ཆེན་པོ་དེ་ལྟ་བུ་ཞིག་གིས་ང་ཚོ་ལམ་ཁ་ནོར་བ་ཞིག་ལ་ནམ་ཡང་འཁྲིད་མི་སྲིད། དེར་བརྟེན། ང་ཚོ་བོད་པ་ཚོ་ཡིན་ནའང་རེད། སོག་པོ་ཚོ་ཡིན་ནའང་འདྲ། ཚང་མས་ཅི་གསུང་བཀའ་བཞིན་སྒྲུབ་ཐུབ་པ་བྱུང་ན། སྤྱིར་ནང་པ་རྣམས་རྗོག་གཅིག་ཏུ་འགྲིལ་བ་དང་། ལྷག་དོན་རི་བོ་དགེ་ལྡན་པ་ནང་ཕན་ཚུན་ཐུགས་སྣང་དམ་ཚིག་གཙང་མ་འོ་ཆུ་གཅིག་འདྲེས་ལྟ་བུ་ཞིག་ངེས་པར་ཡོང་ཐུབ་པ་ཡིན།

ད་ལྟ་ང་ཚོས་རི་བོ་དགེ་ལུགས་པ་ཞེས་ཡང་ཡང་ལབ་ཀྱིན་ཡོད་པ་རེད་དེ། རྗེ་རིན་པོ་ཆེའི་གསུང་འབུམ་པོ་ཏི་བཅོ་བརྒྱད་ཀྱི་བརྗོད་བྱའི་ཐོག་ལ་དངོས་གནས་ཀྱི

ས་དབང་གནང་ས་ལ་དབང་དང་། ལུང་གནང་ས་ལ་ལུང་། ཁྲིད་གནང་ས་ལ་ཁྲིད་གནང་། དེ་ལྟ་བུའི་དབང་ལུང་མན་ངག་ཁྲིད་ཀྱི་གདམས་པ་ཟབ་མོ་ཚང་ལ་མ་ནོར་བ་མཐའ་དག་ཐུགས་ལ་མངའ་ཞིང་གཞན་ལ་གནང་ཐུབ་མཁན་༸གོང་ས་སྐྱུ་ཕྲེང་བཅུ་བཞི་པ་ལྟ་བུ་ཞིག་སྲིད་ན་རྟེན་དུ་མེད། དེ་ལྟ་ན། ཡིད་བཞིན་གྱི་ནོར་བུ་རིན་པོ་ཆེ་ཡིད་བཞིན་གྱི་ནོར་བུར་ཤེས་ཤིང་ངེས་པའི་ཐོག་ནས་དེ་ལ་རྒྱབ་འགལ་དུ་མ་སོང་བ་ཞིག་དང་། སྔོན་བོད་སོག་གི་མི་མང་ཡོངས་སུ་རྫོགས་པ་༸རྒྱལ་བ་བསོད་ནམས་རྒྱ་མཚོའི་ཞབས་འོག་ལ་གཅིག་ཏུ་འདུས་པ་ལྟར་ད་ལྟ་ཡང་དེ་བཞིན་བྱུང་ན་སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པའི་འགལ་རྐྱེན་དུ་འགྲོ་དོགས་ཚ་ནས་མེད་པར་མཐུན་རྐྱེན་འབའ་ཞིག་ཏུ་འགྱུར་ཏེ། སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་རྒྱས་པ་ལ་ཤིན་ཏུ་ཕན་ཆེ་སྙམ། དེ་ལྟར་སེར་སྐྱ་མི་མང་ཡོངས་སུ་རྫོགས་པས་བསམ་བློ་རྒྱ་ཆེན་པོ་ཞིག་གཏོང་ཐུབ་ན་ཞེས་ངས་གསོལ་འདེབས་ཞུ་གིན་ཡོད།

ད་ལན་༸སྐྱབས་མགོན་རིན་པོ་ཆེས་བཀའ་གནང་བ་དེ་བློ་བུར་དུ་ཁོང་གཅིག་པུས་དེ་འདྲ་གནང་བ་ཞིག་མ་ཡིན། ལོ་རྒྱུས་དེབ་ཐེར་དག་ལ་མཇལ་བ་ཡིན་ན། དེ་ཐོག་མར་བྱུང་བ་ནི་དུས་རབས་བཅུ་བདུན་པའི་ནང་རེད། དེ་ཡང་སྐབས་དེ་དུས་ཀྱི་དགེ་ལུགས་པའི་བསྟན་པའི་བདག་པོ་༸རྒྱལ་དབང་ལྔ་པ་ཆེན་པོ་དང་། པཎ་ཆེན་བློ་བཟང་ཆོས་ཀྱི་རྒྱལ་མཚན། ཨ་མདོའི་ཁུལ་ལ་ཀུན་མཁྱེན་འཇམ་དབྱངས་བཞད་པ། སོག་པོའི་ཁུལ་ལ་མཚོན་ན། ཇུན་འདུར་དགེ་རྒན་ཛྙ་ན་བཛྲ་སོགས་རེད། སྐབས་དེ་དུས་རྒྱལ་དབང་ལྔ་པ་ཆེན་པོས་ངོས་འཛིན་ཧི་འདྲ་ཞིག་གནང་ཡོད་དམ་ཞེ་ན། དེ་ནི་སྨོན་ལམ་ལོག་པ། སེམས་ཅན་ལ་གནོད་ཅིང་འཚེ་གདོང་བོ་དམ་སྲི་ཡིན་པ་ཞིག་ལ་ངོས་འཛིན་གནང་ཡོད། ཡང་འགའ་ཤས་ནས། དེ་ནི་༸རྒྱལ་དབང་ལྔ་པ་དང་སྤྲུལ་སྐུ་གྲགས་པ་རྒྱལ་མཚན་གྱི་བར་ལ་རིང་ཐུང་ཞིག་གམ་ལྷ་བྲང་མཐོ་དམན་གྱི་གནས་ཚུལ་ཞིག་ཡིན་རྒྱུ་རེད་བསམམས་ན་དེ་ཡང་མ་ཡིན་ཏེ། པཎ་བློ་བཟང་ཆོས་རྒྱན་གྱི་ལོ་རྒྱུས་དང་སྦྲེལ་ན། དེ་ཡང་སྤྲུལ་སྐུ་གྲགས་པ་རྒྱལ་མཚན་དགོངས་པ་

གཤེགས་ནས་བྲེགས་པར་གྱུར་ཏེ་བཀྲ་ཤིས་ལྷུན་པོ་ལ་ཆེད་དུ་གཉེར་ནས་རང་ཉིད་ཀྱི་རྩ་བའི་བླ་མ་པཎ་ཆེན་བློ་བཟང་ཆོས་རྒྱན་མཇལ་བར་འགྲོ་བའི་སྐབས་སུ། རྣམ་སྲས་རྟ་བདག་བརྒྱད་ཀྱིས་བསྐོར་ཏེ་མཇལ་ཁ་བཀག་ཡོད། གལ་ཏེ་དོན་དངོས་ཐོག་སྤྱི་ར་སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་དང་ཡང་སྒོས་དགེ་ལུགས་པའི་བསྟན་པ་འཛིན་མཁན་གྱི་སྲུང་མ་ཐུན་མོང་མ་ཡིན་པ་ཞིག་ཡིན་ན། རྣམ་སྲས་རྟ་བདག་བརྒྱད་ཀྱིས་ཡར་ཕེབས། པཎ་ཆེན་བློ་བཟང་ཆོས་རྒྱན་མཇལ་བར་ཕེབས་ཤིག་ཅེས་སོགས་གསུང་དགོས་ཚོད་ལ། དེ་ལས་བཟློག་སྟེ་ཕར་བཀག་པ་སོགས་ཡོངས་གྲགས་སུ་གྱུར་པ་དེ་དག་བྱུང་། དེ་ལྟར་སྐབས་དེའི་དགེ་ལུགས་པའི་བསྟན་པའི་བདག་པོ་༸རྒྱལ་བ་པཎ་ཆེན་དང་། ཀུན་མཁྱེན་འཇམ་དབྱངས་བཞད་པ། ཨུན་འདུར་དགེ་རྒན་ཛྙཱ་ན་བཛྲ་སོགས་ཀྱིས་བསྙེན་གསོལ་གནང་བའི་ལོ་རྒྱུས་མེད། གང་ལྟར་བློ་གཟུ་བོར་གནས་ཏེ་བལྟས་ན། དེ་ནི་སྐབས་དེ་དུས་ནས་ལབ་རྒྱུ་གླེང་རྒྱུ་མང་བ་ཞིག་དང་བཀྲ་མ་ཤིས་པ་ཞིག་ཡིན་པ་གསལ་པོ་རེད། ཡིན་ནའང་།འགའ་ཤས་ཤིག་གིས་དོལ་རྒྱལ་དེ་ཡག་པོ་ཡོད་པའི་གནས་ལུགས་ལྟར་སྣང་མང་ཙམ་བགྲངས་པ་ན། དེ་དེ་ལྟར་ཡིན་ནམ་སྙམ་སྟེ་བློ་རྩེ་གཅིག་ཏུ་གནས་མ་ཐུབ་པར་ཆུ་སྣ་གར་འཁྱིད་དུ་གྱུར་པའང་ཡོད་པས། ལེགས་ཉེས་སོ་སོར་འབྱེད་པའི་རྣམ་དཔྱོད་སྤྱོད་དེ་སྤང་བླང་མ་ནོར་བ་བྱ་རྒྱུ་དེ་ཤིན་ཏུ་གལ་ཆེ། དེ་ལྟར་མ་བྱས་པར་མགོ་འཁོར་ཏེ་གཅིག་དེ་བདེན་པ་ཡིན་ངེས་བསམས་ཏེ་ཕར་དུམ་བུ་གཅིག་ཏུ་ཆད། ཚུར་དུམ་བུ་གཅིག་ཏུ་ཆད།དེ་ལྟར་དུམ་བུ་དུ་མར་ཕྱིན་པ་ཡིན་ན། ནང་པ་ཡོངས་གཅིག་ཏུ་བསྒྲིལ་རྒྱུ་ཕར་ཟད། དགེ་ལུགས་པ་ཙམ་ཡང་གཅིག་ཏུ་བསྒྲིལ་བར་སྐྱོན་ཆགས་ཏེ་དབྲ་དགའ་གཉེན་སྡུག་ཟེར་བ་དེ་ཡོང་ངེས་ཡིན། དེ་ལྟར་བྱུང་ན། རྒྱ་དམར་གྱི་བསམ་དོན་གྲུབ་སྟེ། འོ་ད། ཁོང་ཚོ་ནང་པ་རྣམས་དུམ་བུར་ཆད་པ་ཡག་པོ་བྱུང་འདུག ། ང་ཚོའི་འདོད་དོན་གྲུབ་སོང་ཟེར་བའི་དབྲ་དགའ་བ་དང་། ཡང་སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་རྒྱས་པའི་འགལ་རྐྱེན་དུ་གྱུར་ཏེ་གཉེན་སྡུག་པ་ཟེར་བ་དེ་ཡང་ཡོང་བའི་ཉེན་ཁ་ཆེན་པོ་ཡོད། དེར་བརྟེན། མང་

ཚོགས་ཚང་མས་ལེགས་ཉེས་ཀྱི་གླང་དོར་མ་ནོར་བ་ཞིག་གནང་རོགས་གནང་ཞེས་ངས་ལག་གཉིས་ཐལ་མོ་སྦྱར་ཏེ་གསོལ་བ་འདེབས་ཀྱིན་ཡོད།

གཞན་ཡང་། ལམ་རིམ་གྱི་ཚོགས་ཞིང་ལ་མཚོན་ན། དེ་ནི་དགེ་ལུགས་པའི་སྐྱབས་གནས་གཙོ་བོར་བྱེད་པའི་མཆོད་པའི་རྟེན་ཞིག་རེད། དེའི་ནང་དུ་ཡང་རྒྱལ་པོ་ཤུགས་ལྡན་ཡོད་པའི་སྐད་ཆ་མེད། གལ་ཏེ་ཁོ་ཚོས་བཤད་པ་ལྟར་དེ་འདྲའི་གལ་ཆེན་པོ་ཞིག་ཡིན་ན་ཚོགས་ཞིང་ཚད་ལྡན་ནང་དུ་ཡོད་དགོས་ཚོད་རེད་དེ་མེད། དེ་ནས་ད་ལྟ་ང་རང་ཚོས་ཁ་རྒྱུན་དུ་ཨ་རོང་ཏང་གལ་(ཡི་དམ་ཆོས་སྐྱོང་བཅུ་ཞེས་ཡང་ཡང་བརྗོད་པ་ལས། སོག་པོའི་ཡི་དམ་ཆོས་སྐྱོང་བཅུ་གཅིག་གམ་བཅུ་གཉིས་ཞེས་པ་ལྟ་བུའི་ཁ་རྒྱུན་མེད། ཏ་ཅང་གལ་ཆེན་དུ་བརྩིས་པའི་སྐྱོང་མ་བཅུ་དེའི་ནང་དུ་ཚངས་པ་མ་གཏོགས་གཞན་དགུ་པོ་འཇིག་རྟེན་ལས་འདས་པ་ཁ་སྟག་ཡིན། དེ་ལྟར་སྐྱོང་མ་བཅུ་བདམས་སྟངས་དེའི་ཐོག་ནས་ཀྱང་སོག་པོའི་ཐུན་མོང་མ་ཡིན་པའི་སྐྱོང་མ་གང་དག་ཡིན་མིན་ཐག་ཆོད་པ་ཡིན། གང་ལྟར་དུས་ཚོད་འདི་ལྟ་བུར། ང་ཚོ་ཚང་མ་རྟོག་གཅིག་ལ་བསྒྲིལ་ཐུབ་རྒྱུ་དེ་ཏ་ཅང་གལ་ཆེན་པོ་རེད།

གོང་དུ་བླ་མ་གཅིག་གི་སློབ་མ་ཞེས་བརྗོད་པ་ནི། ༧རྒྱལ་དབང་སྐུ་ཕྲེང་བཅུ་བཞི་པ་ཆེན་པོ་འདིའི་སྐུ་ཐོག་ཙམ་མ་ཡིན་པར། ༧རྒྱལ་བ་བསོད་ནམས་རྒྱ་མཚོ་ནས་ད་ལྟ་ལ་ཐུག་གི་བར་དུ་བླ་མ་གཅིག་གི་སློབ་མར་གྱུར་ཏེ་གནས་པ་ཡིན་ལ། དེ་ཡང་སྤྱི་ལོ་༡༥༢༢ལོར་སོག་པོ་ཨལ་ཐན་ཆོས་ཀྱི་རྒྱལ་པོས་༧རྒྱལ་མཆོག་གསུམ་པ་བསོད་ནམས་རྒྱ་མཚོ་སོག་ཡུལ་དུ་དབུ་བླར་གདན་དྲངས། རྒྱལ་བློན་སེར་སྐྱ་འབངས་མི་མཆོག་དམན་བར་མ་ཐམས་ཅད་དམ་པའི་ཆོས་ཀྱིས་ཡོངས་སུ་ཚིམ་པར་མཛད་ཅིང་ཡང་དག་པའི་ལམ་དུ་བཀོད། དེ་ཙམ་དུ་མ་ཟད། ཡུལ་ལྷ་གཞི་བདག་མི་མིན་གྱི་རིགས་ཐམས་ཅད་ཀྱང་ཆོས་སྐྱོང་ལྷུམ་སྡིང་གིས་བཀུག་ཅིང་ཞགས་པས་འཁྲིད་ཏེ་བཀའི་འོག་ཏུ་བཙུག་ དབང་བསྒྱུར་ཅིང་དམ་ལ་བཞག །
དེ་ལྟར་

སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་རིན་པོ་ཆེ་དཀར་འཛམ་ཡུག་གཅིག་ལ་ཁྱབ་པར་མཛད་པའི་ལོ་རྒྱུས་ཡོད། ༸རྒྱལ་མཆོག་འདི་ཉིད་སླར་ཡང་སྤྱི་ལོ་༡༥༨༧ལོར་སོག་ཡུལ་དུ་ཆིབས་ཞལ་བསྒྱུར་ཏེ་སྐྱེ་བོ་ཕལ་གྱི་བློ་ལས་འགོངས་པའི་མཛད་པ་རླབས་པོ་ཆེ་བསྐྱངས། སྤྱི་ལོ་༡༥༨༩ལོར་༸རྒྱལ་མཆོག་བཞི་པ་ཡོན་ཏན་རྒྱ་མཚོ་སོག་ཡུལ་དུ་སྐུ་བལྟམས་ཏེ་སོག་པོའི་མི་ཡིན། ༸རྒྱལ་མཆོག་བཅུ་གསུམ་པ་ཆེན་པོས་ཀྱང་སོག་ཡུལ་ལ་ཞབས་ཀྱིས་བཅགས་ཏེ་དགོན་སྡེ་ཁག་ལ་དབང་ལུང་ཁྲིད་གསུམ་དང་། གཞུང་ཆེན་དཔེ་ཁྲིད། མང་ཚོགས་ལ་བླང་དོར་བཀའ་སློབ། དབང་དང་བྱིན་རླབས་གནང་བ་སོགས་སོག་པོའི་ཁྲོན་ཡོངས་ལ་བཀའ་དྲིན་གྱིས་ཁྱབ་པར་མཛད། ད་ལྟའི་༸རྒྱལ་མཆོག་བཅུ་བཞི་པ་ཆེན་པོ་འདི་ཉིད་ཀྱང་སོག་འབངས་རྣམས་ལ་ཐུགས་བརྩེ་ཤིན་ཏུ་ཟབ་ཅིང་མགོན་སྐྱབས་བླ་ན་མེད་པ་མཛད། དེ་ལྟར་སོག་པོའི་སེར་སྐྱ་མི་མང་གི་བདེ་ཐབས་ཉག་གཅིག་ཐུགས་ལ་བཀྲགས་ཏེ་སོག་ཡུལ་དུ་ཐེངས་བདུན་ཙམ་ཞབས་སོར་འཁོད་དེ་ལམ་རིམ་གསེར་ཞུན་མ་དང་དུས་འཁོར་བཀའ་དབང་གིས་མཚོན་པའི་དབང་ལུང་མན་ངག་དང་བླང་དོར་བཀའ་སློབ། དགེ་སྡིག་སྤང་བླང་གི་ལམ་སྟོན་སོགས་ཡང་ནས་ཡང་དུ་སྩལ་ཏེ་སོག་པོའི་མི་མང་རྣམས་གཞལ་བར་དཀའ་བའི་བཀའ་དྲིན་གྱིས་བསྐྱངས་དང་སྐྱོང་བའི་མུར་བཞུགས།

དེ་ལྟར་༸རྒྱལ་བ་སྐུ་ཕྲེང་རིམ་བྱོན་དང་༸པཎ་ཆེན་སྐུ་ཕྲེང་རིམ་བྱོན་ལ་བརྟེན་ནས་བོད་སོག་གི་བར་དུ་མི་ཐོག་དུ་མའི་རིང་བླ་སློབ་ཀྱི་འབྲེལ་བ་ཐུན་མོང་མ་ཡིན་པ་ཞིག་བྱུང་། དེ་ལྟ་ན། བླ་སློབ་དམ་ཚིག་མ་འགལ་ཞིང་དམ་ཚིག་གཙང་མར་གནས་པའི་ཐོག་ཇོག་གཅིག་ཏུ་བསྒྲིལ་ཐུབ་པ་བྱུང་ན། དེ་ནི་དོན་གྱིས་སྤྱགས་ལ་དགོས་རྒྱུ་སྤྱགས་ཁུ་ད་ར་ཟེར་བ་དེ་ཡིན་ལ། སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་རྒྱས་པ་ལ་ཡང་དེས་ཕན་ཞིང་། སེམས་ཅན་ལ་བདེ་སྐྱིད་འབྱུང་བར་ཡང་དེས་ཕན་པས་རང་ཅག་རྣམས་ཇོག་གཅིག་ལ་བསྒྲིལ་ཐུབ་པ་ཞིག་ཡོང་བའི་རེ་འདུན་གནང་དགོས་ཞེས་གསོལ་འདེབས་བྱེད་ཀྱིན་ཡོད།

ད་ལམ་སྣང་མའི་རྗེས་གནང་མང་ཚོགས་ལ་གཏོང་དགོས་པའི་རྒྱུ་མཚན་རྣམས་དེ་ཡིན། ད་སྐབས་སུ་བབས་པ་ང་རང་ཚོའི་སྣང་མའི་རྗེས་གནང་དེ། བར་ཆད་སེལ་བ་དང་ལམ་འགྲོ་ཡོང་བ། བཀྲ་ཤིས་པ་ཡོང་བ། གཞན་དབང་འོག་ཏུ་བསྡུ་ཐུབ་པ་ཟེར་བ་ལྟ་བུ་རང་དོན་ཡིད་བྱེད་ཀྱི་ཀུན་སློང་དང་འདྲེས་ན། ཆོས་དུག་ཏུ་སོང་བ་ཞེས་པ་དེ་ཡིན་པས་དེ་ལྟར་དུ་མ་སོང་བ་ཞིག་ངེས་པར་དུ་དགོས། སྣང་མ་དེ་དག་ནི་ཆོས་སྐྱོང་ཡེ་ཤེས་ཀྱི་སྤྱན་དང་ལྡན་པ། བསྟན་པ་དང་སེམས་ཅན་གྱི་དོན་ལ་ཐུགས་བརྩེ་བ་ཆེན་པོའི་ངང་ནས་ཆོས་སྐྱོང་གི་སྐུར་བཞེངས་པ་ཡིན་པས། དེ་དག་གི་གྲོགས་འཕྲིན་ལས་ལ་བརྟེན་ནས་ཆོས་སྒྲུབ་པའི་འགལ་རྐྱེན་ཞི་ཞིང་མཐུན་རྐྱེན་འགྲུབ་པ། སངས་རྒྱས་ཀྱི་བསྟན་པ་དར་ཞིང་རྒྱས་པ་སོགས་ལ་དམིགས་ཏེ། ངས་ད་ལན་ཡི་དམ་ཆོས་སྐྱོང་བཅུའི་རྗེས་གནང་ཞུ་གིན་ཡོད་བསམ་པ་དང་། ཀུན་སློང་བྱང་ཆུབ་ཀྱི་སེམས་ཀྱིས་ཟིན་པ་མ་མཐའ་ཡང་བཅོས་མ་ཚུན་ཆད་ཅམ་བཅོས་ཏེ་དགོངས་པ་བཞེས་རྒྱུ་དེ་ཏ་ཅང་གལ་ཆེན་པོ་རེད།

## 2012 оны 9-р сарын 21-ний өдөр Жадо Ринбүүчи Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх Идгаачойнзинлин дацанд хуран цугласан сүсэгтэн олонд "Арван Хангал"-ын даган соёрхол хайрлах үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

Эхлээд урьд одуулах номын айлдвар лугаа холбогдуулаад нэг зүйлийг тайлбарлая гэж бодлоо. Дараа нь саад тотгорыг арилгах балин гаргах хийгээд даган соёрхол тэдгээрийг дараалан хүртээнэ ээ.

Урьд "Жавзандамба Хутагт Төв"-ийнхөн мандлын гурван шүтээн өргөн, Арван Хангалын даган соёрхлыг (*Хангал хэмээх нь сахин аврах гэсэн утгатай бөгөөд тэр адилын ядам, номын сахиус арав нь: Жигжид, Чагдор, Зургаан Мутарт Махгал, Гонгор, Дөрвөн Нигуурт Махгал, Чойжал, Лхам, Намсрай, Жамсран, Цамбагарав сэлт юм.*) айлдаж өгнө үү хэмээн сануулсан юм. Үүнд шүтээд, мөн өөр олон учир шалтгаанд зоригдоод даган соёрхол тэдгээрийг төв Гандан хийд хийгээд дацан сургууль лугаа барилдлагатай хар шар бүхэнд хоригдохуун үгүйгээр тавьж чадвал нийтэд туслах тэргүүтэн буяны тэмдэг ихэд үзэгдсэн тул Арван Хангалын даган соёрхлыг тавихаар болсон юм аа.

Даган соёрхол тэдгээрийг хар шар олон нийтэд тавих болсон олон шалтгаан байгаагаас эхнийх нь: Монгол оронд 1937 оноос эхлэн элдэв бэрхшээл гарсан бөгөөд Бурханы шашин эрдэнэ машид доройтсон билээ. Үүнээс болоод олон хүмүүсийн дунд тэнгэр сахиус алинг шүтэх нь зохистой хийгээд зохисгүй болохыг ялгаж мэдэхгүй нь олон болсон хийгээд илүүтэйгээр олон хүмүүсийн дотор монгол орон лугаа эрт цагаас маш гүн барилдлагатай байсан Арван Хангал тэдгээрийг мэдэхгүй нь олон байгаа тул тэдгээрийг мэдэж үйлдээсэй гэж бодсон юм.

Хоёр дахь шалтгаан нь: Арван Хангал нь эртнээс монголчуудтай нийт бусын барилдлагатай байсан бөгөөд олон нийтээс ч ихэд сүжиглэдэг байсан нь тодорхой байдаг. Мөн монголчуудын нэрэнд ч гэсэн Махгал, Чадраабал, Зинаамидар гэх мэтээр ядам, сахиус тэдгээрийн нэртэй хүмүүс ч олон байдаг. Гэсэн ч олон жилийн турш коммунист

үзэл суртлын эрхээр ихэд доройтсон байгаа тул өөрсдийн эцэг өвгөдөөс дамжсан ядам, номын сахиус тэдгээртэй барилдлагатай байснаа үргэлжлүүлээсэй хэмээн бодсон юм.

Гурав дахь шалтгаан нь: Монголчууд Бурхан шашиндаа сүжиг ихтэй хийгээд тэнгэр сахиус гэж дууддаг алинд ч хамаагүй бодох зүйлгүйгээр аврал одуулдаг хийгээд бараг өр, зүрх, гол гурваа тушаачихмаар мэт байдаг тул энэ удаад Арван Хангалыг таниулбал тэнгэр сахиус гэгдэх хаа хамаагүй нэгнийг шүтэхгүй хийгээд шүтэхнээ ч эндүүрэл гарахгүй зэрэг тус ихтэй нэгэн ирэх нь магадтай хэмээн бодсон юм.

Хамгийн гол шалтгаан нь: Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. 2006 онд Дээрхийн Гэгээнтэн Далай Багш бээр Дамдин-Янсангийн авшиг адистидын хүч маш ихтэй нэгийг хайрласан. Тэр үед Дээрхийн Гэгээнтэн бээр олон нийтэд хандан, “Ер хаа хамаагүй тэнгэр хийгээд илүүтэйгээр Шүгдэн хэмээх сахиус эсэх нь эргэлзээтэй нэгнийг шүтэхгүй бол сайн” болохыг тодорхой зарлигласан билээ. Мөн Дээрхийн Гэгээнтэн уржнан 2011 оны сүүлээр Монгол оронд морилж, спортын их танхимд Жанрайсигийн Их Авшиг хайрлах үед, надад ч мөн тэнд ном сонсох хувь тохиож байсан бөгөөд тэр үед Дээрхийн Гэгээнтнээс, “Сахиус эсэх нь будлиантай Шүгдэнг шүтэх юм бол аюул ихсэж, бэрхшээл олшрох бөгөөд багш дээдэс нугууд бээр ч Шүгдэнг хориглож байсныг” тодорхой айлдсан тул тэдгээр нугуудыг суурьд агуулаад өдгөө бид алинг шүтэж болох хийгээд алинг шүтэж болохгүй тэргүүтнийг сайтар мэдээд, Арван Хангал тэдгээрийг энэ нь тэр мөн хэмээн магадтай мэдэж үйлдвэл машид сайн хэмээн бодсон бөгөөд хэрэг үүний тухайд энэ удаад би олон нийтийг даган соёрхолд ирэхийг хориглоогүй юм. Өмнө хэлсэн лугаа холбоотой байр байдлыг нарийн дэлгэрэнгүй тайлбарласан бүхэн энд тарааж буй Дээрхийн Гэгээнтэн Далай Багшийн айлдварт тодорхой байгаа тул та бүхэн сайтар уншиж үзээрэй.

Одоо миний өөрийн хувийн бодол санаа олон байгааг бага үгээр хураан хэлбэл: Бодит байдал дээр Бурханы шашин хийгээд амьтны тусад зохиол үйлс нь машид дэлгэрсэн одоогийн XIV Далай Багш адил нэгэн урьд ч эс гарсан бөгөөд

хойшид ч гарах нь бэрх. Сайтар бодох юм бол бидний буяны цогд энэ адил нэгэн оршиж байгаа нь машид чухагаас ч илүү чухаг мөн бөгөөд дээд төрөлхтөн тэр адилын нэгэн бээр биднийг буруу замд хэзээ ч хөтлөхгүй. Тиймээс Төвд, Монголчууд бид алин зарлигласныг ёсчлон бүтээвэл, ер Бурханы шашинтан нугууд нэгэн бүхэлд нэгдэх хийгээд илүүтэй Гэлүгбын шашны дотор ч өөр хоорондын таалал зохилдонгуй, тангараг ариун - ус сүү сүлэлдсэн мэт нэгэн магадтай ирж чадах юм.

Өдгөө бид гэлүгба хэмээн дахин дахин хэлдэг ч Богд Зонховын сүнбүм – арван найман ботийн өгүүлэгдэхүүний дээрээс үнэхээр авшиг бол авшгийг, эш бол эшийг, хөтөлбөр бол хөтөлбөрийг хайрлагч, тэр адилын авшиг, эш, хөтөлбөрийн гүн увдис бүхнийг эндүүрэлгүйгээр таалалдаа эрхшээсэн бөгөөд бусдад ч хөтлөн чадагч Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Багштай адил нэгэн орчлонгоос олдошгүй. Тиймээс чандмань эрдэнийг чандмань эрдэнэ мөн хэмээн танин магадлахын үүднээс түүн лугаа зөрчилдөн үл одох нэгэн хийгээд урьд Төвд, Монголын хүн ард бүхэн Ялгуусан Содномжамцын (*III Далай Лам. Орч.*) шавьд хуржс байсан мэт өдгөө ч мөн тэр адил болбоос Бурханы шашин эрдэнэ лугаа харшлах нөхцөлд одохын сэжиг угаас үгүй болж зохилдох шалтгаан ямагтад болоод Бурханы шашин дэлгэрэхэд ч машид их тустай хэмээн сэтгэнэ. Эдүгээ хар шар олноороо сайтар бодож үзээсэй хэмээн би бээр соёрхол тавин айлтгаж байна.

Далай Багш бээр ганцаараа гэнэт Шүгдэнг хориглоогүй юм. Түүхэн баримт бичгүүдийг судалж үзвэл, Шүгдэн нь анх XVII зууны үед гарсан байдаг. Тухайн үед гэлүгбын шашныг барьж байсан дээдсүүд нь: Ялгуусан Лувсанжамц (*V Далай Лам. Орч.*) хийгээд Ванчин Лувсанчойжижанцан (*IV Ванчин Богд. Орч.*), Амдугийн хуваарьт Бүхнийг айлдагч Жамьяншадба, Монгол оронд Өндөр Гэгээн Занабазар тэргүүтэн юм. Тэр үед Шүгдэнг Ялгуусан V Далай Лам бээр ямар мэт танин барьсан бэ гэвэл, тэр нь буруу ерөөлт, амьтан нугуудад хорлон хөнөөгч, мөн чанар нь тангаргийн буг мөн хэмээн танин барьсан байдаг. Зарим нь V Далай Лам хийгээд хувилгаан Дагважанцан

(*Шүгдэнгийн өмнөх төрөл. Орч.*) хоёрын хооронд байр суурь дээд доодын зөрчилдөөн л байсан гэж боддог. Тэр нь тийм биш юм. Учир нь, Ванчин Лувсанчойжижанцангийн түүх лугаа холбогдуулан үзвэл, Дагважанцан төрөл арилжиж буг болон төрөөд Дашлхүмбэ хийдэд тухайлан зорьж, өөрийн язгуурын багш Ванчин Лувсанчойжижанцантай уулзахаар ирэх үед Намсрай сахиус найман нөхрийн хамтаар хүрээлээд уулзахыг нь хориглосон байдаг. Хэрвээ үнэхээр л Бурханы шашны сахиус хийгээд илүүтэйгээр гэлүгбын шашныг баригч онцгой сахиус мөн байсан бол Намсрай сахиус найман нөхдийн хамтаар морилон угтаж, "Ванчин Лувсанчойжижанцанд бараалхахаар морилохтун" хэмээх тэргүүтэнг зарлиглах байсан ч түүнээс буцаад цааш хориглосон зэрэг түүх нь нийтэд алдаршсан байдаг. Мөн тухайн үеийн гэлүгбын шашныг барьж байсан дээдсүүд болох V Далай Лам, IV Ванчин Богд, Өндөр Гэгээн Занабазар, Гүнчин Жамьяншадба тэргүүтэн бээр шүтэж байсан гэх түүх ч байдаггүй. Ямартай ч шударга оюуны үүднээс үзвэл, Шүгдэн нь гарсан цагаасаа л хэл ам ихтэй хийгээд өлзий бусын нэгэн байсан нь тодорхой байдаг. Гэсэн ч зарим нэгэн бээр Шүгдэнг сайн болохын авир ёс хуурмаг олныг тоочвоос, тийм ч юм болов уу хэмээн санаад нэгэн үзүүрт оюунаар оршин үл чадаад буруу мөрд хөтлөгдөх нэгэн байгаа тул сайн мууг тус тусад нь ялгах тийн шинжлэлээр ажиглаад авла орхилыг эндүүрэлгүйгээр үйлдэх нь маш чухал юм. Тэр адил үйлдэлгүйгээр толгой нь эргээд тэр нь үнэн хэмээн магадлаад цааш нэг хэсэг болж тасраад, нааш нэг хэсэг болж тасраад олон хэсэг болчихвол Бурханы шашинтан бүхэн нэг бүхэлд нэгдэх нь бүү хэл гэлүгба ч дотроо нэгдэхэд гэмтэй болоод дайсанд баясалтай, саданд хорлолтой гэгч нь болох магадтай юм. Тэр мэт болчихвол, Хятадын улаантнуудын санаа бодол бүтээд, Бурханы шашинтнууд хэдэн хэсэг болчихсон байна, одоо бидний хэрэг бүтсэн хэмээн дайсан баясах хийгээд Бурханы шашин дэлгэрэхийн харшлах шалтгаан болж саданд хорлолтой гэх тэр нь ирж болох аюул байна. Тиймээс олон нийт бүгдээрээ сайн муугийн авла орхилыг эндүүрэлгүйгээр үйлдэж хайрлана уу хэмээн би бээр алгаа хавсран соёрхол тавья.

Өөр бас Мөрийн Зэргийн чуулганы орон нь гэлүгба нарын гол авралын орон, тахилын шүтээн юм. Түүний дотор Шүгдэн байдаг гэсэн яриа ч байдаггүй. Үнэхээр тэдний ярьдаг шиг тийм их чухаг нэгэн мөн юм бол жинхэнэ чуулганы орны дотор байх хэрэгтэй шүү дээ. Мөн бидний аман ярианд ч гэсэн “Арван Хангал” гэж дадал болсноос биш “Арван Нэгэн Хангал”, “Арван Хоёр Хангал” гэх мэтийн яриа байдаггүй. Машид чухалчлан үздэг ядам, номын сахиус тэдгээр арвын дотроос Цамбагараваас бусад ес нь бүгдээрээ ертөнцөөс гэтэлсэн ямагт мөн. Арван Хангал хэмээн тогтсоноос үзсэн ч Монголчуудын нийт бусын номын сахиус алин мөн, алин бишийг ч эцэслэн шийдэж болно. Ямартай ч энэ адилын цаг үед бид бүгд нэгэн бүхэл дор нэгдэж чадах нь маш их чухал юм шүү.

Өмнө, “нэг багшийн шавь” хэмээн өгүүлсэн маань, зөвхөн Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Ламын энэ үед ч биш, Ялгуусны эрхт Содномжамцын үеэс эхлээд өнөөг хүртэл бид нэг багшийн шавь нар байсаар ирсэн бөгөөд тэр нь ч 1577 онд Монголын Номын Хаан Алтан бээр III Далай Лам Содномжамцыг Монгол оронд багшаар урин залаад хаан, түшмэл, эгэл ард дээд доод дунд бүхнийг дээдийн номоор цэнгүүлэн зохиож үнэний мөрд байгуулсан билээ. Түүгээр ч үл барам газар орны тэнгэр, савдаг, хүмүүн бусын язгуур бүхнийг ч номын сахиус Жамсран бээр бөхийлгөн цалмаар хөтлөөд зарлигийн доор оруулж авшиг өгөөд дээд дор байгуулсан юм. Тэр мэт Бурханы шашин их эрдэнийг нийтэд дэлгэрүүлэн зохиосон түүх байдаг. III Далай Лам бээр дахин 1584 онд Монгол оронд заларч эгэл төрөлхтний оюунаас хэтэрсэн агуу их зохионгуйгаар тэтгэсэн. IV Далай Лам Ёндонжамц 1589 онд Монгол оронд мэндэлсэн монгол хүн юм. XIII Далай Лам бээр ч Монгол оронд заларч хийд оронд авшиг, эш, хөтөлбөр гурав хийгээд их гол номлолын хөтөлбөр, олон нийтэд авла орхилын зарлиг, авшиг хийгээд адис жанлав хайрлах тэргүүтнээр Монголын олон нийтэд зарлигийн ачийг түгээн зохиосон. Өдгөө Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Лам бээр ч монгол түмэнд таалал энэрэхүй машид гүн бөгөөд дээр үгүй өмөг авралыг зохиодог. Тэр мэт Монгол түмнийг амаржуулах арга ямагтыг л таалалдаа тунгаасаар

Монгол оронд долоон удаа заларч, “Мөрийн Зэрэг – Тунгаамал Алтан” хийгээд “Цагийн Хүрдний Зарлигийн Авшиг” гэх мэт авшиг, эш, увдис хийгээд авла орхилын сургаал хайрлах тэргүүтэнг дахин дахин соёрхож Монголын хүн ард нугуудыг хэмжихүйеэ бэрх зарлигийн ачаар тэтгэсэн бөгөөд өдгөө ч тэтгэсээр байна.

Төрөл дараалан заларсан Далай Ламын дүрүүд хийгээд Ванчин Богдод шүтээд Монгол, Төвд хоорондоо олон үеийн турш багш шавийн нийт бусын барилдлагатай байсаар ирсэн. Тиймээс багш шавийн тангараг лугаа үл харшлан тангараг ариунаар оршихын дээр нэгэн бүхэлд нэгдэж чадваас Бурханы шашин дэлгэрэхэд ч түүгээр туслах бөгөөд амьтан дор амгалан жаргалан гарахад ч түүгээр туслах тул бид нар нэгэн бүхэл дор нэгдэж чадахын хүсэл горилыг үйлдэх хэрэгтэй хэмээн соёрхол тавья.

Энэ удаад сахиусны даган соёрхлыг олон нийтэд тавих хэрэгтэй болсны учир шалтгаан нугууд нь энэ юм. Бидний сахиусны даган соёрхол энэ нь “ажил үйлс барцад саадгүй бүтэх”, “өлзий хутаг ирэх”, “бусдыг эрхэндээ хураан чадах” гэх мэтээр зөвхөн өөрийн тусыг сэтгэлдээ үйлдэхийн хотол өдөөлгө лугаа холилдвол ном хорд одох хэмээх тэр мөн болох тул тэр адилд үл одох нэгийг магадтай болгох хэрэгтэй. Тэдгээр сахиус нугууд нь номыг сахих билгүүний мэлмий лугаа төгөлдөр, шашин хийгээд амьтны тусад таалал их энэрэхүйн агаараас номын сахиусны лагшинг таалсан мөн тул тэдгээрийн тус хийгээд үйлс дор шүтээд номыг бүтээхийн харшлах шалтгаан амирлаад, зохилдох шалтгаан бүтэх хийгээд Бурханы шашин арвидан дэлгэрэх тэргүүтэнд зоригдоод “би энэ удаад Арван Хангалын даган соёрхлыг хүртэж байна” хэмээн санах хийгээд хотол өдөөлгө бодийн сэтгэлээр эзлэгдээд, адаглаваас засвартай бодь сэтгэлээр сэтгэлээ засах нь маш их хэрэг ихтэй юм шүү.

# АЖАА ГЭГЭЭНИЙ АЙЛДВАР

February 12, 2012

Greetings:

The 9th Jebtsundamba Khutughtu, spiritual leader of the Gelug lineage among the Mongols, has expressed most strongly his condemnation of the worship of the spirit Dorjee Shugden. I humbly praise his precious words and endorse his viewpoint.

As Tibetan Buddhists know, Sera Jey Monastery has always been acknowledged as one of the greatest of the monasteries of the Gelug lineage. Carrying on its tradition of excellence, monks of Sera Jey Monastic University in South India have recently translated into Mongolian a teaching that His Holiness the Dalai Lama gave between 2000 and 2010 that prohibits the worship of Shugden. The first fifteen days of this teaching -- His Holiness the 14th Dalai Lama – Preaching About Shugden - 1 -- have now been carefully edited and put into print (covering the teachings from 2000 – 2007). I strongly urge all Mongolians to pay strict attention to His Holiness the Dalai Lama's words so skillfully translated into their own language.

There are many people who are not aware of why His Holiness the 14th Dalai Lama has prohibited the worship of Shugden. This book brings the true teachings of His Holiness about Shugden to all his devotees in Mongolia.

It tells of the beginnings of Shugden worship and outlines carefully the harm that can befall its believers and, indeed, the harm that can happen to all living beings as a result of this evil practice. Shugden worship is not part of Buddhist practice.

In Mongolia, there has always been a strong student/teacher connection with all of the Dalai Lamas. But Shugden practitioners deny His Holiness the 14thDalai Lama. He, in turn, has decided that he will not accept a Shugden Worshipper as one of his students. By reading this book, we can discover why he has taken this position and realize how pure His Holiness' teachings are in contrast to those of Shugden. As a result, we can strengthen our devotion to him – our dear, kind and most patient teacher. We canalso learn that all the great lamas agree with His Holiness. These lamas are among those who are considered more scholarly and have kept their discipline more strictly than others.

His Holiness visited Drepung Gomang Monastery in South India in February 2011. At that time, he specifically told the Mongolian monks who were studying there that it was their duty to tell the truth about Shugden to those who are ignorant of its evils.

This book fulfills His Holiness' wishes. By translating "His Holiness the 14th Dalai Lama – Preaching About Shugden – 1"the monks of Sera Jey have carried out a most sacred trust. I bless them for their efforts, their diligence, their expertise, and above all, for their wisdom.

Most devotedly,



Arjia Rinpoche, Former Abbot of Kumbum Monastery in Amdo Tibet
Director of the Tibetan Mongolian Buddhist Cultural Center, Bloomington, Indiana

# АЖАА ГЭГЭЭНИЙ АЙЛДВАР

Монголын Бурханы шашны тэргүүн IX Богд Жавзандамба Хутагт бээр тангаргийн буг Дорж Шүгдэнг шүтэхийг хүчтэйгээр зэмлэн хориглодог байсан. Би Богд Гэгээний таалал оюуныг бишрэн, хуурмаггүй зарлигийг нь сүсэглэн дагадаг.

Сэра-Жэ дацан сургууль Шарын шашны агуу их хийдүүдийн нэг хэмээн үеэс үед хүлээн зөвшөөрөгдсөөр ирснийг Төвдийн Бурханы шашинтнууд мэднэ. Энэ уламжлалын үргэлжлэл болох Өмнөд Энэтхэг дэх Сэра-Жэ Шашны Их Сургуулийн монгол хуврагууд Дээрхийн Гэгээн XIV Далай Ламын 2000-2010 оны хооронд айлдсан Шүгдэнг шүтэхийг хориглосон айлдварыг монгол хэлнээ орчуулаад байна. Эхний 15 өдрийн (2000-2007 оны хооронд айлдсан) айлдварын орчуулгыг дахин хичээнгүйлэн хянаад "**Дээрхийн Гэгээн XIV Далай Лам – Шүгдэнгийн тухай айлдвар I**" (эхний хэвлэлт) нэртэйгээр хэвлэхэд бэлэн болгожээ. Дээрхийн Гэгээнтний зарлигийг монгол хэлнээ чадварлагаар орчуулахад анхааран оролцсон бүх монголчуудаар би бахархаж байна.

Дээрхийн Гэгээн Далай Лам ямар учраас Шүгдэнг шүтэхийг хориглосныг олон хүмүүс мэдэхгүй байна. Энэ ном Шүгдэнгийн тухай айлдсан Дээрхийн Гэгээнтний хуурмаггүй зарлигийг Монгол дахь түүний бүх шавь нарт хүргэх болно.

Шүгдэн анх шүтэгдэж эхэлсэн түүх хийгээд итгэн шүтэгчдээ аажмаар хорлон үйлддэгийг энэхүү ном өгүүлэх болно. Үнэндээ тангаргийн буг түүнийг шүтэх нь хамаг амьтанд хорлож буй хэрэг юм. Шүгдэнг тахин шүтэх нь Бурханы номын анхааран авлага огтхон ч биш юм. Монголчууд эртнээс үе үеийн Далай Лам нартай багш шавийн гүн бат барилдлагатай байсаар ирсэн. Шүгдэнг шүтэгчид Дээрхийн Гэгээн XIV Далай Ламыг үгүйсгэдэг. Дээрхийн гэгээнтэн Шүгдэнг шүтэгч хэнийг ч болов өөрийн шавь хэмээн таалдаггүй. Энэ номыг уншсанаар бид Дээрхийн Гэгээнтэн ямар учраас ийнхүү таалах болсон хийгээд түүний Шүгдэнгийн тухай айлдвар огтхон ч хуурмаггүй болохыг ухаарна. Улмаар бидний оройн дээд энэрэн нигүүлсэгч, гайхамшигтай хүлцэнгүй багшдаа зоригдсон сүсэг бишрэл

улам бүр батжих юм. Мөн бүх гайхамшигт багш нар Дээрхийн Гэгээнтэй таалал нэг байсныг бид мэдэх болно. Тэдгээр багш нар бол сахил санваараа чандлан сахисан, эрдэм чадал нь бусдаас хэтийдсэн дээд төрөлхтөнүүд байсан билээ.

Дээрхийн Гэгээнтэн 2011 оны II сард Өмнөд Энэтхэг дэх Брайбүн Гоман дацанд морилох үедээ Энэтхэгт суралцаж буй монгол хуврагуудад хандан “Дорж Шүгдэнг тангаргийн буг гэдгийг мэдэхгүй хүмүүст үнэнийг хэлэх нь та бүхний үүрэг юм шүү” хэмээн онцгойлон захисан юм. Энэхүү номыг орчуулснаараа Сэра-Жэ дацангийн монгол хуврагууд хүндтэй нэгэн хүсэлтийг биелүүлж буй хэрэг юм. Тэдний хичээл зүтгэл, мэдлэг чадвар, илүүтэйгээр билэг оюуныг нь үнэлж байна.

Индиана Мужийн Блүмингтон дахь
Төвд Монголын Буддын Соёлын Төвийн тэргүүн,
Гүнбүм хийдийн Хансүр Ажаа Гэгээн

## ЗОПА РИНБҮҮЧИЙН АЙЛДВАР

(англи эх)

(Монгол орчуулгыг үнших)

I am very happy that the monks of Idgaa Choizinling in the Mongolian city of Ulaanbaatar have translated into Mongolian the second book by His Holiness the Dalai Lama advising not to practice Dolgyal. This is good for oneself and others in this life and in all future lives. In order to definitely spread this advice in Mongolia, the former Namgyal Monastery Abbott Kyabje Jhado Rinpoche promised to print this, which is extremely kind.

The Idgaa Choizinling monks thought this would be a very, very special protection for the Mongolian people, as well as for those in other countries, to prevent deep damage and also an offering to His Holiness the Dalai Lama, for the success of His holy wishes. They also felt this would be a protection for individual people as well as for the teachings of Buddha, by keeping the teachings pure.

As I was asked for a foreword by the gekyö of Idgaa Choizinling, in the beginning I mentioned that it would be a few pages long, but it got a bit longer. I hope it is of some benefit to the readers' minds.

If the Idgaa Choizinling monks didn't bring this knowledge into Mongolia possibly no one would. So this is very precious and people are extremely lucky to be able to receive this advice from His Holiness the Dalai Lama.

*　*　*

For the world in general and especially for the people of the Snow Land of Tibet to have concordant thinking, without bias, in friendship and like a family in a harmonious relationship that is completely unified as one and to preserve and disseminate the stainless, precious teachings of the Buddha in this world.

I, bearing the name of a reincarnation, Thubten Zopa humbly present, in love and friendship these honest true facts. For the benefit of those who do not understand, in order to discover this.

Please undertake an honest investigation without the stained mind of biased discrimination.

This reliance on Dhogyal, be it by pure Dharma practitioners or by those for business or financial reasons, I wonder if this

has not been more harmful than the forceful annexation of Tibet by the Chinese Government and the destruction of the teachings of the Buddha.

If we ask, "Why is this?

Many of those who rely on Dhogyal have received teachings and initiations in the presence of His Holiness the Dalai Lama and have relied on His Holiness as their most kind Guru (Virtuous Friend). Nevertheless, later they have come to regard His Holiness as an enemy.

As you know very well, if you see your root Guru as an enemy, you have to experience the sufferings of the evil gone realms (lower realms) endlessly.

Like, stated in the Root Tantra of Guhyasamaja: "Even if you accumulate the five most heinous negative karma (without break of another life), it is still possible to attain the state of a Buddha in this life. But, if you have despised your Guru, it is impossible to attain Buddhahood in this life."

If one belittles or criticizes the Guru, then one belittles and criticizes all the Victorious ones. If one first relies on as Guru and then later makes mistakes in devoting to as guru. If that happens it becomes an extremely great loss in one's life, because the Guru is the action of all the Buddhas to subdue oneself. Manifested as Guru. The Guru is the form of action of all the Buddhas. Even the teacher who teaches you reading, even that teacher, even if you secretly despise and criticize, then one has criticized or belittled the Guru, and then that becomes the same as belittling or criticizing all the 10 direction Buddhas. This is from the text "The Essential Nectar".

Ones Virtuous Friends is the actions of all the Victorious Ones manifested into one's own Guru. Not having respect toward them is like not having respect to all the Victorious Ones. There is no heavier ripening aspect result.

After having had thought this is my Savior, then one becomes the disciple and then belittling them is the same as having belittled all the Buddhas, from that one will achieve suffering all the time. For many eons one will not meet with a Virtuous Friend or the precious teachings of the Buddha, and one will be reborn in the inexhaustible hells for many eons and have to experience un-

fathomable suffering.

Not only that, when oneself is not a Bodhisattva, getting angry to a Bodhisattva, even for a second, destroys a thousand eons of roots of virtue, as stated by the great Bodhisattva Shantideva:

"Whatever wholesome deeds,
Such as offering to the Buddhas and generosity,
That have been amassed for a thousand eons
Is destroyed by one instant of anger."

This is in dependence upon the power of the object, which becomes very powerful with a Buddha and even more powerful than this, is one's Guru. Due to this, for many eons one will never meet with virtuous friend and never meet with the teachings of the Buddha as well.

Therefore, relying on Dhogyal is extremely harmful to oneself. I think this is a great harm to the world in general, as well as to sentient beings and to the teachings of the Buddha.

Dhogyal is one, who in the past has broken samaya (pledges) and made harmful, mistaken prayers to the teachings of our Founder/Teacher: Buddha. This has been stated by one who knows the past and future.

Those who strongly practice Dhogyal eventually end up dying in the most dangerous manner. For example Geshe Yeshe Wongchuk, learned in scriptures and from the great seat of Sera Me Monastery, who invited the reincarnation of Pabonka Rinpoche to Tibet and made the incarnation take the life entrusting initiation of Dhogyal and the Heruka Body Mandala from Gonpa Sa Rinpoche. One day when travelling in a vehicle, they came up on a pass and although there were many people in the vehicle he alone fell out of the window, down the cliff and died.

Again, another business man Dorje Gyaltsen, who was a very strong practitioner of Dhogyal in secret, when he was tormented by sickness, he asked his wife to go to the usual place to propitiate Dhogyal. Not having known that he was a daily practitioner of Dhogyal, the wife although, very shocked had no choice but to comply with his wishes to go and make the tea offering (relying on Dhogyal for the success of actions) on his behalf. Then directly from the mouth of the sick person came the words,

"Up until now, Dhogyal has deceived me. I can see the actual ghost form of that vicious one. I have been deceived. I have been mistaken until now. I apologize and confess to my Gurus."

As he took his last breath, there was great fearful appearances and he died foaming at the mouth with an expression of being strangled. In the end, when his body was taken to the cemetery to be given to the vultures, even the vultures flew away without feeding on his flesh.

The other, is the one whose kindness is greater than the Buddhas of the three times, the one whose name is difficult to mention my great virtuous friend Gyen Thubten Yeshe, who was a strong practitioner of Dhogyal. When passing away, before his the last breath, he showed very clearly the expression that Dhogyal was not perfect. This has been my personal experience, from being together at the time of passing away.

For further information on this please read the letter recently sent from Tibet. Here you have no one to point finger at, out of biased thoughts of discrimination. For these signs of misery and downfall you can point your finger only at Dhogyal, for these are very clear signs. These are just examples. Please read the letter recently sent from Tibet.

***The letter from Tibet.***

*A collection of stories on manifested inauspiciousness in relation to Dhogyal.*

*In 2007, when visiting relatives in Baa Thang, I accepted an invitation to visit Sangwa Khato in the region of Baa, a town of twenty families. There, I heard directly from the people of the place about the manifested inauspiciousness in relation to Dhogyal.*

*Ten years ago, for the sake of timely rains and plentiful harvest in the region, they requested Baa Lakha Rinpoche for a divination of the prayers to be undertaken. Rinpoche advised them to build a stupa at a site seen from every direction. The stupa was built on top of a hill, in the upper part of the region. This was struck by a lightening which destroyed half of it. When the people of the region rebuilt the stupa, again it was struck by a lightening and half destroyed. When they rebuilt it again, before long the stupa on its own became crooked.*

*At that time Drakara Chophel, who had spent some years living in Drepung Monastery in South India became suspicious. So he had the inside fillings of the stupa searched and he found a thanka painting of Dhogyal. Everybody suspected that this was the cause of it all. Those who identified with this burnt the thanka.*

*Later, upon further investigation of the Dhogyal thanka they suspected the old monk Sangwa Kalsang from the area, who in the past was a practitioner of Dhogyal. But then, when His Holiness the Dalai Lama advised a few times, about the necessity for stopping the practice, some of them pretended to have stopped the practice. But in reality they had not done so and did the practice in secret. The Dhogyal thanka was placed in the stupa discreetly without the knowledge of the ordained and the lay people of the region.*

*Even this old monk, one day, he went to the home of a family to do the prayers of dispelling interferences with the ritual cake (tormas), but when he went to throw the ritual torma, all of a sudden he lost consciousness and died in a state of inauspiciousness.*

*For the last six, seven years, since the rebuilding of the stupa nothing of the sort has happened. The people of the region say in unison, that they have had timely rains, good harvests and the whole area has been completely rejuvenated.*

*In the past, the temple of the town used to have a statue of Dhogyal, which the people of the area had taken outside the walls of the temple and buried it within four solid walls.*

*I have destroyed the statue and the walled encasement so that nothing remains of it.*

*Again, under the jurisdiction of Dho Kham Lithang region in the town of Drarukha, there is a small monastery called Zangcho Dratsang. At this monastery is a monk, from Pompora House in Sera Me Monastery, South India, a Dhogyal practitioner by the name of Lobsang Norbu. After attaining a small level Geshe degree, he returned to his home town. Although, he had used his title of a Geshe to become the principle person of the monastery but the ordained and lay people of his home town did not like Dhogyal practitioners at all. He had also stated that he did not practice Dhogyal. But everyone, beginning with the ex-abbot of*

*the Dratsang, Lama Jamyang, ordained and the lay community all suspected him of being a practitioner.*

*To deceive the public and in order to have a huge gathering, one day, he announced the teachings on Maitreya's Wheel of Dharma. On the day of the actual event, during a break in the sessions, a dog came and broke the hands of some of the statues which had been made from blessed clay. These statues were the holy objects of the temple. There has been such news of inauspiciousness.*

*Then before long, lightning struck the monastery, broke the pole holding the victory banner in half and threw it in front of the monastery. After this, one night without any known reasons, the monastery caught on fire. Although the monastery was situated in the middle of the town, nobody noticed the fire. At day break, other than the charred grounds, everything else had been burnt to ashes. There was such inauspiciousness.*

*These stories of actual events in the past, I offer to the Jewel of our world His Holiness the Dalai Lama, in support of His Holiness' strong discouragement of Dhogyal practice and hoping in some small way to help.*

*Presented with respect and prostrations on*
*the 12th of November, 2011.*

Although, His Holiness the Dalai Lama did the practice of Dhogyal, earlier in his life, after many years of examination, he came to the very clear conclusion, that this practice is very harmful to the Dharma and sentient beings. His Holiness' advice, not to practice Dhogyal has been greatly criticized and contradicted by some of the highly learned Geshes of the main monasteries, who have written many books on this issue and well publicized them.

Recently, due to a highly learned scholar, Jangtse Geshe Gyen Drati, criticizing His Holiness over this issue, his monastery staff went before their protector Dharma Raja (Dhamchen Choegyel) and requested an answer sign as to whether it was better to expel the Geshe from the monastery or not. When it was answered that it was better to expel him, as the dough ball containing that answer came out, his writings criticizing His Holiness were read before the entire assembly of monks and he was ex-

pelled.

This kind of heavy negative karma, which brings the experience of unthinkable, inexpressible suffering for many eons is mainly due to the mistake of relying on Dhogyal practice.

More kind than all the Buddhas of the three times, Refuge and Protector, Lord of the Victorious Ones, the All Knowing One, the Highly Seeing Sublime One, His Holiness the Dalai Lama, has been prophesied by our Founder, Buddha, the Destroyer Qualified Gone Beyond. This was prophesied to a close entourage of Bodhisattvas whose name was Limitless Supreme Awareness.

Also, from the Guhyasamaja Tantra Treasure: Founder Vajradhara said to the Dharma King Indrabuti and so forth; "Amongst the limitless entourage of Bodhisattvas, listen Limitless Supreme Awareness. You, Bodhisattva, are a great Founder of transmigrating sentient beings. Until samsara is empty, till then, you will become the holy object of refuge and savior of transmigrators. Especially in the country of Snow Land, you will take birth in a holy body of form to disseminate the teachings of the Three Baskets of Dharma and enjoy benefitting transmigratory beings. 'Limitless Supreme Awareness', the Snow Land is the place to be subdued by the Bodhisattva Mahasattva Arya Avalokiteshvara. This region of the Snow Land is the place that will be subdued by you. Bodhisattva Avalokiteshvara 'Limitless Supreme Awareness', in this place you will brightly illuminate the Dharma teachings of the Three Baskets and the unsurpassable Vajra Vehicle." It has been thus stated.

If I further clarify this sutra quotation: when His Holiness the Dalai Lama visited Geshe Sopa's center: Deer Park, to give some teachings. One day the staff of the center had an audience with His Holiness. They expressed to His Holiness that His Holiness has stated many times that He Himself does not have bodhicitta and the realization of the right view. They said, "If His Holiness does not have the experience of these realizations, then ordinary beings like us don't have any hope." At that point, His Holiness feeling unbearable, (compassion, not wanting them to loose faith) and slipped out from the holy mouth that His Holiness did remember, that in the past life when His Holiness was a Bodhi-

sattva in the entourage of the Buddha in the Arya land of India. His Holiness gave a very clear answer.

Therefore Tibetans from the Snow Land ought to know that they are unbelievably fortunate. In short not just Tibetans, in this world many millions of people for eons after eons are led to peace and happiness, liberation and the state of omniscience. Is Holiness does unbelievable great activities unlike any other great holy being preserving the teachings of Buddha.

If the Precious Victorious One, His Holiness the Dalai Lama is not the actual Buddha and Arya Avalokiteshvara then you can say that in this world there is no emanation of Buddha benefitting sentient beings. In this way bodhicitta and the entire teachings of the Buddha becomes false. Therefore by practicing Dhogyal and practicing the teachings of the Buddha becomes contradictory to oneself. Then it becomes practicing that which is false by regarding it as truth.

At the great seat of Gomang Monastery College, one great Lama who strongly practiced Dhogyal, he took the great responsibility and spread the practice. Due to that he broke His Holiness's advice and became against His Holiness and then when he passed away his heart cracked apart in many pieces and his eye balls came out and so forth. This is just another example.

It is not only His Holiness the Dalai Lama who after many years of examining has advised against the practice of Dhogyal, many others, who are like one sun rising eliminating the darkness in this world, who have done great extensive works for the teachings of Buddha and transmigratory beings, such as Karchen Yeshe Gyeltsen and Thukyen Losang Chogye Nyima and many high valid Geluk Lamas and so forth have also advised to stop the practice of Dhogyal.

You can understand this if you look in the collection of their teachings. His Holiness the Dalai Lama has put together the advice that those great holy beings have given, and if you want to read them, please request the Private Office for the texts.

There have also been learned Geshes and valid Lamas who have practiced Dhogyal. For example Kyabje Pabonka Dechen Nyingpo, who did extensive benefit for the teachings of Buddha and transmigratory beings. People believed this was be-

cause he practiced Dhogyal that he was able to bring this extensive benefit through his holy actions. But this is a complete hallucination, without examining the facts, and because of that, with blind faith so many people practiced Dhogyal.

Kyabje Pabonka Dechen Nyingpo in the past practiced Most Secret Hayagriva - the circle of dharma from the pure appearance of the 5th Dalai Lama. But later he stopped those practices. One day he told his attendant: "tomorrow there will be a fat monk who will come to see me. But don't allow him inside my room". He said this precisely, but the attendant forgot what he said and when the fat monk came the next day, he allowed the monk to go inside the room (this was as an obstacle for those not practicing Dhogyal and especially for those practicing Dhogyal).

Later when the attendant entered inside the room, it seemed Lama was not happy, and looked sort of possessed. The thankas of Most Secret Hayagriva and others had been taken down and the Lama had changed in his actions.

But Kyabje Trijang Rinpoche and Kyabje Dechen Nyingpo are Buddha. Their practice of Dhogyal is the act of showing ordinary aspect for us. Showing ordinary aspect means showing mistakes. Otherwise there is no other meaning of showing ordinary aspect. Without showing this ordinary aspect for us, there is no method to guide us from samsara. Therefore by showing the aspect of having mistakes – this is what leads us to enlightenment. It is so extremely kind of the Guru to show this, it is like the Guru is giving us skies filled with wish-granting jewels.

Besides this example there are many ways the Guru shows the aspects of having mistakes. For example showing the aspect of being sick so that we have to explain which foods harm and what not to eat. Another example is when there is no road or if there is a precipice and we have to explain to not go that way. There are many ways the Guru shows having mistakes. When the appearance of mistakes in the actions of the Gurus comes it is extremely important to use that increase devotion, as this is the cause for oneself to achieve full enlightenment, or to support and to increase Guru devotion which one has generated in ones own mind without degenerating.

It is mentioned in the Tantric text *Tent* (Gur):

Oneself, is called Vajrasattva, and manifested in the form of the master (Guru), abides in ordinary form, with the aim to benefit sentient beings. The Tathagatas in degenerate times manifest as the Lama (Guru).

This is not only mentioned in Tantra but also it is mentioned in Sutra.

Buddha was giving a teaching on an extremely high mountain in the southern direction and at that time the Bodhisattva Meaningful to Behold thought: now the Buddha is giving teachings to us, but in the future, after Buddha has passed into the sorrowless state, there will be no one who will gives teachings. As he thought this the Destroyer Qualified Gone Beyond - Guru Shakyamuni Buddha proclaimed:“Hi, Meaningful to Behold, when the future comes I will abide in the body of the Abbott, I will abide in the form of the Master, and in order to ripen sentient beings I will show birth, old age, disease and death”.

Even the Guru is the actual Buddha, but from one’s own side if one does not look at Buddha, then as it is mentioned in the Kadampa Geshe Potowa Blue Pepung: even if Manjrushri and Chenrezig actually descend in front of you, but it won’t benefit at all, if from one’s own side one did not look at Buddha, then one cannot receive the blessing, one does not receive the profit, only loss. Like the story of the Gelong Lekparkarma, who served Buddha for twenty two years and in all that time he only looked at the Buddha as a liar, and as a result he was born in the lower realms, the inexhaustible hot hell realms, for eons.

Even if from the Guru’s side is not Buddha but from one’s own side if one devotes as Buddha then one receives only profit and no loss. For example the old mother actually believed the dog bone was Buddha’s tooth, she generated faith and from the blessings of the Buddha’s actual tooth entered and she received Buddha’s relic from the dog bone.

In reality in this way the disciple can attain the path and achieve enlightenment before the Guru, and then be able to do perfect works for sentient beings.

Also the 5$^{th}$ Dalai Lama mentioned: To the mind which is hallucinated, the opposite mid, ones mistakes manifest in the gurus actions. Realize that this is one’s own mistakes and abandon it

like poison.

So by seeing mistakes in the Guru's actions, according to the Lama Tsong Khapa tradition, it becomes a support to develop Guru devotion. Please think well on these quotations.

Having mistakes is like having a black mark on one's own face and seeing it in the reflection in the mirror. That is a sign that one's own face has the black spot, not the reflection.

If the Guru takes poison, we don't need to also eat poison. We need to examine, this is what I think. Like the peacock who by eating poison is able to live and become healthier, their magnificent color develops, like that if you are able to take poison and live, then it's ok to take poison. If you can transform poison into nectar, then can definitely take it.

AH LA LA HO

AH HO MAHA SUKHA.

From the teachings of Gyalwa Ensapa:

In short whatever great or small realization is generated, this is due to whatever great or small devotion one has generated towards the valid Guru, who is originator of all the attainments. Keep this advice as your heart practice, looking at the qualities of the Guru and not looking at the mistakes.

Until one is free from negative karma and obscurations, even if every single Buddha directly descends in front of you, you would have no fortune to see the supreme holy body, adorned with the holy signs and exemplifications, except this present appearance of the Guru (this means this ordinary appearance). To be able to see one's own Guru in the supreme holy body adorned with the holy signs and exemplifications, it is said that one needs to achieve the Path of Great Merit of the five Mahayana Paths, such as the Path of Contemplation of Continual Dharma and so forth.

In the past some outer beings (non-Buddhists) actually met the Buddha, but they saw him as an ordinary person, not having the pinnacle or even the one fathom of light rays from the holy body, or the other holy signs and exemplifications and so forth.

Arya Togme saw Maitreya Buddha in the form of a female dog, whose lower part of the body was covered in wounds

and maggots.

Also Nagpa Chopa, the great yogi, and Getsul Tsempuwa saw the mind sealed deity - Dorje Palmo - as an ordinary lady who had leprosy.

Even the learned and highly attained yogi Naropa, as well as all the human beings in the town, saw the highly attained Tilopa, who is the actual Buddha Vajradhara, but they all saw him as beggar burning and eating fish alive.

"Do not arise heresy even for one split second in the glorified Gurus actions, see whatever actions that are done as good, with this devotion may the blessings of the Guru enter in my heart". This prayer His Holiness does not accept, this is because the holy mind of Kyabje Pabonka Rinpoche, Trijang Rinpoche and His Holiness's mind are one. It is a teaching that their holy mind is one.

As it is mentioned in the text "Calling the Guru from Afar" by Kyabje Dechen Nyingpo:

> "The wisdom of great bliss of all Buddhas, one taste with the dharmakaya,
> Is itself the ultimate nature of all kind Lamas.
> I beseech you, Lama, dharmakaya, Please look after me always without separation, in this life, future lives, and the bardo".

This quotation is for people like me, who are extremely ordinary and filled with superstition, full of obscurations and negative karma.

His Holiness the Dalai Lama is the principal one who holds all the teachings of Buddha and spreads this in the world, therefore it is so important to follow His Holiness's request.

In this world there are so many religions, but our founder, the great kind mighty one Shakyamuni Buddha said: You should examine my teachings well, Bhikshus (learned ones), like burning, cutting and rubbing gold. Then take my teachings not just out of faith.

Therefore whatever we practice in Buddhism, we must examine it well, just as Buddha has advised and Buddha gave us freedom to do this. This is what I am expressing, please understand this.

Therefore to follow the advice of His Holiness the Dalai Lama, the omniscient one, this is for particularly oneself and generally for the Tibetans to be harmonious in life, under one constitution and to be in unity. This is to not rise problems life to life, and for the sun of happiness to rise in the world, for there to be perfect peace and happiness in this world, and for oneself and others to achieve liberation from samsara and the state of omniscience and to spread the stainless teachings of Buddha in this world, especially for the stainless Tibetan Mahayana Buddhism to increase and to not decrease. So it is for this reason that His Holiness the Dalai Lama advised to stop the practice of Dhogyal.

Some learned, high Lamas and Geshes even saw His Holiness the Dalai Lama as the enemy and criticized His Holiness's view. But still His Holiness's holy speech and view did not change. As it is mentioned that the subduer of the Snow land of Tibet is Chenrezig, and it very clearly explains that Chenrezig not only does the holy action of working for others and not working for oneself, but has great bodhicitta and powerful compassion, only doing the holy actions of guiding and saving the six types of sentient beings and showing compassion, like all the 10 directions Buddha's. This is the Arya supreme one Chenrezig.

In the past when I met His Holiness the Dalai Lama I expressed, with my big mouth, that myself being a representative, on behalf of the whole world in general and in particular the Tibetan people, even though the Lamas and Geshes criticized His Holiness, such as writing books against His Holiness the Dalai Lama, but still His Holiness never waivered in advising to stop the practice of Dhogyal, so for that, from the heart, how unfathomably greatly kind His Holiness is.

By reading this letter if you get upset, then just as the great compassionate Buddha practiced the paramita of patience to the harm givers, so please practice patience and live your life with a happy mind, this is important. Thank you very much.



1/3 translated by Ven.Tsen la, the rest translated by Lama ZopaRinpoche,
scribe Holly Ansett, Buddha Amitabha Pure Land,
July 3 – 11, 2012, checked by Lama Zopa Rinpoche.

# ЗОПА РИНБҮҮЧИЙН АЙЛДВАР

Монгол улсын нийслэл Улаанбаатар хот дахь Идгаачойнзинлин дацангийн хуврагууд Дээрхийн Гэгээнтний “Шүгдэнг эс шүтвэл өөр хийгээд бусдын энэ хойд бүхэнд сайн болохыг” зөвлөсөн хоёрдугаар номыг монгол хэлнээ хөрвүүлсэнд би ихэд баясаж байна. Намжал Дацангийн Хансүр Авралт Багш Жадо Ринбүүчи энэхүү номыг Монгол оронд түгээн хэвлэхэд туслахаа илэрхийлсэн нь маш их өгөөмөр явдал юм.

Идгаачойнзинлин дацангийн хуврагууд, энэхүү ном нь Монгол орны хийгээд бусад улс орны хүн ардыг асар их хохирлоос машид сайтар сахин хамгаалахын хамтаар Дээрхийн Гэгээнтэн Далай Ламын хиргүй ариун горил хүсэл бүхэн биелэхийн тухайд дахь тахил өргөл хэмээн үзжээ. Тэрчлэн тэд бээр үүгээр хувь хүн тус бүрээс гадна сургаал номыг хиргүй ариунаар хадгалснаар Бурханы Номыг ч сахин хамгаална хэмээн үзсэн байна.

Идгаачойнзинлин дацангийн гэсгүй лам энэхүү номын өмнөтгөлийг бичиж өгөхийг надаас хүсэх үед би цөөхөн хэдэн хуудас болно хэмээн бодож байсан боловч санаснаас урт болов. Үүнийг уншигч эрхмийн сэтгэл оюунд тустай байна хэмээн найдна.

Идгаачойнзинлин дацангийн хуврагууд ийнхүү Монгол орноо энэ мэдлэгийг тараагаагүй бол өөр хэн ч үүнийг үл гүйцэлдүүлэх байсан болов уу.

Тэгэхээр Дээрхийн Гэгээнтэн Далай Ламын энэхүү сургаал номтой учирч байгаа нь ихэд чухаг хийгээд хүмүүст машид завшаантай хэрэг билээ.

*　　*　　*

Дэлхий ертөнц хийгээд ялангуяа Цаст Төвдийн ард түмэн өөр хоорондоо сэтгэл зохилдон, алагчаалалгүйгээр амраг садан, ах дүү мэт эвсэн зохилдож, нэгэн язгуурт хурах хийгээд энэ дэлхий дээр хир үгүй Бурханы шашин их эрдэнийг оройлон арвитгахын тулд хувилгаан нэрт Түвдэн-Зопа би бээр нигүүлсэнгүй садны авир ёсыг дурдатган бодит

болсон явдал хийгээд шударга үнэнийг бишрэнгүйгээр айлтгах учир үл мэдэгчид хичээнгүйлэн болгоох хийгээд тачаангуй хорсол, уурын хирээр халдсан алагчаалалт оюунаар бус дурдал төгөлдөр шинжлэх оюунаар судлахыг хичээнгүйлэн хүсье.

Шүгдэнг шүтэгчид асар ариун номыг өөртөө анхааран авч шүтдэг байлаа ч, худалдаа арилжаа, ашиг орлого тэргүүтнийг бүтээхийн тулд шүтдэг байлаа ч ялгаагүй, үүгээр Төвд, Хятадыг дотор нь хагаралдуулан үйлдэж, Бурханы шашныг доройтуулан үгүй хийсэн ч энэ бүхний үр дүнд хор хохирол гарах ч, Шүгдэнг шүтсэн адил үлэмж их хэмжээний хор хохирол гарахгүй хэмээн сэтгэнэ.

Учир юуны тул хэмээвээс,

Шүгдэнг шүтдэг олон хүмүүс Дээрхийн Гэгээнтэн Далай Ламын дэргэдээс номын айлдвар, зарлигийн эрх авшиг айлтган ачит багш хэмээн шүтэж байсан ч хожим дайсанд үзэх болсон юм. Язгуурын багшаа дайсанд үзвээс муу заяаны зовлонг хязгааргүй ихээр амсах болохыг та бүхэн сайн мэдэх байх.

"Нууцын Хураангуйн Язгуурын Тантар"-аас (Сандүйн Жүд): *"Завсаргүй таван нүглийн үйлийг хураасан ч энэ насанд Бурханы хутгийг олох нь буй. Харин шүтсэн багшаа доромжлон басамжилваас энэ насанд Бурхан үл болно"* хэмээх зарлигласан мэт.

Өөрийн багшаа басамжилваас Ялгуулсан Бурхан бүгдийг басамжилсан болно. Эхэндээ багшийгаа шүтээд хожим шүтэх ёсоо буруудуулбаас маш их гэмтэй болох юм. Бурхан бүгдийн үйлс зохионгүй биднийг номхтгохын тулд багшийн дүрсэнд ургасан учраас Багш нь Бурхан бүгдийн үйлсийн хураангуй дүрс юм. Тиймээс үсэг уншихыг заасан багшаа ч болов далдуур зангах, муу хэлэн, басамжлан доромжилбоос арван зүгийн Бурхан бүгдийг басамжилсан болох юм. "*Рашааны шим*" хэмээх шастирт:

"*Буяны садан нугууд нь Бурхан бүгдийн үйлс*
*Өөрийн багшид ургасан ямагт мөн тул*
*Түүн дор үл биширвээс Бурхан бүгдэд үл биширсэн болохыг*
*Зарлигласны тул түүний тийн боловсрох үр нь хэт хүнд"* хэмээсэн хийгээд мөн

“*Тэр адилын өмөг дор санаад*
*Шавь нь болоод доромжилбоос*
*Бурхан бүгдийг басамжилсан болох бөгөөд*
*Тэр нь үргэлжид зовлонг олох”* хэмээн айлдсан байдаг.

Олон галавт багш буяны садан хийгээд Бурханы шашин их эрдэнэ лугаа үл учраад улмаар нэрвэшгүй тамд төрөн тоолшгүй олон галавт барагдашгүй зовлонг эдлэх болох юм.

Түүгээр ч үл барам өөрөө бодьсадва биш байж бодьсадвын хутгийг олсон нэгэнд агшин төдийд уурлах аваас мянган галавт хураасан буяны ёзоороо үгүй хийдэг болохыг Их бодьсадва Шива-Лха бээр,

“*Мянган галавт хураасан*
*Өглөг хийгээд Бурхадыг тахих тэргүүтэн*
*Магад сайн алин үйлдсэн тэдгээрийг ч*
*Уур хилэн даран үйлдэнэ”* хэмээн зарлигласан билээ.

Буян хураахын шүтээн болсон орны дотроос хэтэрхий их хүчтэй нь Бурхан юм. Түүнээс ч илүү хүч ихтэй нь өөрийн шүтсэн лам багш юм. Тиймээс, олон галавт буяны садан лугаа эс учирваас Бурханы шашинтай ч учрахгүй.

Өдгөө Шүгдэнг шүтэх нь тухайн хүнд асар их хорлол хөнөөлтэй бөгөөд цаашилбал, дэлхий ертөнц, бусад хүмүүс хийгээд Бурханы шашинд асар их хорлолтой гэдгийг санагтун.

Урьд Шүгдэн энэ нь бидний Бурхан Багш Шагжамүнийн шашинтай тангараг буруудаж, буруу ерөөл тавьсан болохыг өнгөрсөн ба ирээдүйг болгоосон нэгэн бээр айлдсан юм.

Шүгдэнг ихэд эрэмхийлэн шүтэгч олон хүмүүс эцэстээ өлзий бусаар нас эцэслэж байв. Жишээлбэл, Их хийд Сэра-Мэ дацангийн лам номонд мэргэн гэвш Ишванчүг бээр Павонка Ринбүүчийн хойд дүрийг Төвдөд урин залаад, Гомба -Са Ринбүүчигээс “Шүгдэнд амиа тушаах урилга” хийгээд “Дэмчиг Бурханы Биеийн Хот Мандлын” авшиг айлтгуулсан тэрбээр нэг өдөр машинд морилон явж нэгэн их давааны оройд хүрэх үед, хэдийгээр тэр машинд олон хүн байсан ч тэрээр ганцаараа машины цонхоор халил ангал уруу унаж нас барсан юм.

Мөн Шүгдэнг нууцаар ихэд тахин шүтэгч Доржжанцан хэмээх худалдаачин эдгэршгүй өвчинд нэрвэгдээд өөрийн эхнэртээ, “Шүгдэнд үргэлж тахил үйлддэг газарт минь очиж залбирал үйлд” хэмээн захижээ. Нөхрөө нууцаар Шүгдэнг шүтдэгийг үл мэдэх эхнэр нь арга мухардахдаа тэр газар очиж нөхрийнхөө хүссэн ёсоор Шүгдэнд үйлсээ даатган сэржим тэргүүтэнг өргөжээ. Үүний дараахан Доржжанцан, “*Шүгдэн өнөөг хүртэл миний толгойг эргүүлж байж. Хэрцгий албин болохыг нь саяхан л үзэв. Би бээр мэхлэгдсэн байж. Өнөөг хүртэл эндүүрсээр явж. Би багшаасаа уучлалт гуйн наманчилж байна”* гэж хэлж байжээ. Нас барах үедээ тэрээр хоолойгоо боолгуулж буй мэт болж, амнаас нь хөөс гарч байсан гэдэг. Тэрээр аймшигт үзэгдэл олныг үзсээр сүүлчийн амьсгалаа хураасан юм. Хожим цогцсыг нь үхээрийн газар аваачихад, хэдийгээр тас шувуу ирсэн ч түүний хүүрийг идээгүйгээр үл барам зугтан дайжиж байсан гэдэг.

Мөн гурван цагийн ялгуусан бүхнээс ч илүү ачтай, алдрыг нь дурдахуйяа бэрх, миний буяны их садан, Түвдэн-Еши багш маань Шүгдэнг шүтдэг байсан ч дээд оронд ажрахынхаа өмнө (таалал барахын өмнө) “*Шүгдэн үнэхээр асар арилсан бус байжээ”* хэмээн айлдаж байсныг миний бие багшийн лагшин ажрах тэр үед хамт байсны хувьд сайн санадаг.

Үүнээс өөр бусад явдлын тухай Төвдөөс илгээсэн захидлаас мэдэж болно. Энэ захидлыг уншаад алагчаалах сэтгэлээр хэн нэгэнд бурууг тохож үл болно. Харин энэ мэт доройтол, башрыг өдөөгч нь гагцхүү Шүгдэн юм. Захидалд бодит болсон явдлыг тодорхой өгүүлсэн буй. Та бүхэн Төвдөөс илгээсэн захидлыг уншина уу.

***Төвдөөс илгээсэн захидал***

“*Шүгдэнтэй холбоотой муу ёр бодитой гарсан түүх”-ийн цуглуулга.*

*Би бээр 2007 онд төрсөн нутаг Баатан уруу явах замдаа Баа аймгийн нутгийн доод хуваарь, Санва Хадод гэх газар байх 20 гаруй айл өрхтэй жижиг суурингийн иргэд*

*урьсан дагуу тэр сууринд буух үед тэндхийн иргэдээс Шүгдэнтэй холбоотой муу ёр бодитой гарсан түүх үүнийг сонссон юм:*

*Арван жилийн өмнө энэ суурингийн иргэд хур бороо цагтаа бууж, үр тарианы гарц сайн байлгахын тухайд засал гүрэм хэрхэн хийвэл тустай болохыг Баа-Лааха Ринбүүчийд айлтгасанд Ринбүүчи "Суурингийн хаанаас ч харсан харагдах газар суварга босгох хэрэгтэй" хэмээн айлджээ. Нутгийнхан Ринбүүчийн айлдвар дагуу суурингийн доод толгойн оройд суварга босготол огторгуйгаас аянга бууж суваргын нэг талыг эвдэлжээ. Нутгийнхан суваргаа зассанд аянга дахин бууж суваргын талыг дахин эвдэлсэн байна. Дараа нь дахин сэргээсэн боловч удалгүй суварга өөрөө суурьараа хазайсан явдал гарч. Энэ үест урьд Өмнөд Энэтхэгийн Брайбүн Гоман дацанд хэдэн жил ном үзсэн лам Гара Чойнпол хэмээгч энэ явдалд сэжиг төрж суваргын доторх сүншгийн зарлигуудыг гаргаж үзтэл дотор нь Шүгдэнгийн зурмал дүр байсанд бүгд сэжиглэн аянга буусны шалтгаан нь энэ зурмал дүр мөн хэмээн магадлаад тэр дүрийг галд шатаасан байна. Хожим сайтар шинжлэн үзэхүйд Шүгдэнгийн зурмал дүрийг хадгалж байсан өвгөн лам Санва Галсан Шүгдэнг шүтдэг байсан бөгөөд Дээрхийн Гэгээнтэн Далай Лам "Шүгдэнг шүтэж болохгүй" хэмээн удаа дараа зарлиг гаргасан учир тэрээр түр нэгэн зуур завсарласан боловч нууцаар тахин шүтсээр байж. Тэрээр Шүгдэнгийн зурмал дүр тэрийг нутгийн хар, шар олонд мэдүүлэхгүйгээр суваргын сүншигт хийсэн юмсанж. Өвгөн лам тэр ч нэгэн өдөр айлд уригдан гүрэм засал хийхээр очин, балингаа гаргаж байх зуураа гэнэт ухаан алдан унаж, ёр бусаар амьсгал хураасан гэдэг.*

*Тэр нутагт суваргыг дахин сэргээснээс хойш өнөөг хүртэл 6, 7 жилийн хооронд элдэв муу явдал гараагүй бөгөөд өдгөө хур бороо цагтаа бууж, үр тариа ч сайн гарч, нутаг даяараа нүнжигтэй сайхан байна хэмээн нутгийн хүмүүс бүгд нэгэн дуугаар өгүүлж байв. Урьд энэ суурингийн сүмд Шүгдэнгийн дүр байсныг нутгийн хүмүүс сүмийн гадна гарган нэгэн чулуун хороонд далд болгон тавьсныг би бээр Шүгдэнгийн дүрийг чулуун хороо сэлттэй нь үлдэгдэлгүй*

*нураасан билээ.*

*Өөр нэгэн түүхийг өгүүлэхэд: Дохамын Литан нутгийн Брарухa суурumind Санжод Дацан хэмээх нэгэн жижиг хийд байх. Урьд Өмнөд Энэтхэг дахь Сэра-Мэ дацангийн Бомра аймгийн лам, Шүгдэнг ихэд шүтдэг Лувсаннорвуу, хожим бага гэвшийн дамжаа бариад төрсөн нутагтаа буцаж ирэн, гэвшийнхээ нэрээр түрий барин уг хийдийн гол эзэн мэтээр суужээ. Нутгийн сүсэгтэн бүгд Шүгдэн шүтдэг хүмүүст дургүй байсан учир тэр гэвш шүтдэггүй мэт дүр эсгэж байсан ч дацангийн хамба лам асан Жамьян тэргүүтэн нутгийн хүмүүс бүгдээр түүнийг Шүгдэнг шүтдэг байх хэмээн сэжиглэдэг байв. Нэгэн удаа тэрээр олон нийтийг мэхлэн цуглуулахын тулд "Майдар Бурханы номын аймгийг номлох гэж байна" хэмээн их зар тараажээ. Тэр өдрийн эл үйл явдал завсарлах үед нэгэн нохой сүмийн шүтээн, адистид бүхий шавраар бүтээсэн Бурхадын дүрийн мутрыг хугалсан муу тэмдэг ёр үзэгдсэн аж. Удалгүй хийдийн дээр аянга бууж хийдийн ялгуулсан дуазыг дундуур нь хугалан дуганы өмнө унагасан байна. Энэ явдлын дараахан, нэгэн шөнө хийдэд юунаас болсон нь мэдэгдэхгүй гал гарчээ. Уг хийд суурингийн төвд байдаг хэдий ч гал гарсныг хэн ч мэдээгүй бөгөөд үүр хаяарахад хийдийн хананаас бусад нь бүгд үнс болтлоо шатсан муу ёрын явдал болжээ.*

*Бодитой болсон түүх эдгээрийг Дээрхийн Гэгээнтэн Далай Ламын Шүгдэн шүтэхийг хориглосон зарлигт өчүүхэн ч атугай тус болох болов уу хэмээн санаад 2011 оны 11 сарын 12-нд биширэнгүй мөргөл, залбирал сэлттэй хүргүүлэв.*

Дээрхийн Гэгээнтэн Далай Лам эхэндээ Шүгдэнг шүтдэг байсан ч олон жилийн турш ажиглан шинжлээд Шүгдэнг шүтэх нь шашин хийгээд амьтанд их хорлолтой болохыг тодорхой болгоож, "Шүгдэнг шүтэж болохгүй" хэмээн зарлиг сургаалаа хайрласанд хийд орны зарим их гэвш нар Дээрхийн Гэгээнтэнд гэм зүүн өгүүлж, гүтгэн гүжирдсэн ном товхимол олныг хэвлэж тараах тэргүүтэнг үйлдэж байв.

Саяхан Жанзэ дацангийн номд мэргэн гэвш Бради

бээр өмнө өгүүлсэн адилаар Дээрхийн Гэгээнтэнд гэм зүүн өгүүлсэн бичиг тэргүүтэнг үйлдсэнд дацангийн хуврагууд Дамжан-Чойжил сахиусандаа гэвшийг хуврагийн орноос хөөвөл хэрхэх болохыг айлтгасанд сахиуснаас хуврагийн орноос хөөвөл сайн болохын шинж тэмдгийг үзүүлсэнд шүтээд олон хуврагуудын дунд түүний Дээрхийн Гэгээнтэнд гэмийг өгүүлж бичсэн бичгийг дуудан сонордуулаад дацангаасаа хөөсөн юм.

Энэ мэтээр муу үйлийг хурааснаар олон галавт санаанд багташгүй их зовлонг эдлэх бөгөөд үүний үндэс ёзоор нь гагцхүү Шүгдэнг шүтсэний гэмээр уршигдаж байгаа юм.

Гурван цагийн Бурхад бүхнээс ч ханьцашгүй их ачтай, Ялгуулсны эрхт, Хамгийг айлдагч Дээрхийн Гэгээнтэн Далай Лам нь Ялж Төгс Нөгчсөн Бурхан Багшаас эш лүндэнтэй билээ. Урьд Бурхан Багш бээр Хязгааргүй Дээд Оюунт нэрт бодьсадвын ойрын нөхөр сэлтэд эш үзүүлсэн юм.

"Нууцын Хураангуйн Тантрын Сан"-д: Доржчан Бурхан бээр номын хаан Индрабуди тэргүүтэнд, "*Хязгааргүй олон бодьсадва нөхдийн дундаас Хязгааргүй Дээд Оюунт сонсохтун. Бодьсадва та болбоос амьтны их багш мөн болой. Орчлон зовлонт амьтдаар хоосрох тэр хүртэл та бээр амьтны аврал, өмөг болон орших болой. Ялангуяа Цастын Оронд дүрст лагшинг таалж, гурван аймаг савын номыг дэлгэрүүлэн үйлдэх бөгөөд амьтны тусад дурших болой. Хязгааргүй Дээд Оюунт аа, Цастын Орон энэ нь Их Бодьсадва, Махасадва, Хутагт Жанрайсигийн номхтгох орон болой. Цастын Орон энийг та бээр номхтгох болъюу. Бодьсадва Жанрайсиг-Хязгааргүй Дээд Оюунт аа, Та бээр гурван аймаг савын ном хийгээд дээр үгүй очирт хөлгөний номыг номлон машид гийгүүлэх болой*" хэмээн зарлигласан байдаг.

Энэхүү зарлигийн утгыг тодруулбал: Дээрхийн Гэгээнтэн Далай Лам, Сопа гэвшийн Бугат хүрээлэн (Deer Park) төвд морилон ном айлдаж байх үеэр тус номын төвд ажилладаг хүмүүс Дээрхийн Гэгээнтэнд бараалхсан юм. Тэд Дээрхийн Гэгээнтэнд "*Та үргэлжид 'Надад бодь сэтгэл хийгээд хоосон чанарыг оносон оюун төрөөгүй' хэмээн*

*зарлиглах. Хэрвээ Дээрхийн Гэгээнтэнд тэр мэт онолын эрдэм үгүй аваас эгэл бид итгэл горил лугаа хагацах буй за"* хэмээн айлтгасанд Дээрхийн Гэгээнтэн бээр таалал нигүүлсэхүйгээр (тэд бээр итгэл сүжгээ алдах вий хэмээн) үл тэвчин хайлж "*Урьд Хутагт Жагарын оронд Бурхан Багш Шагжтүвийн нөхөр бодьсадва байснаа санадаг"* хэмээн аман гэгээнээрээ тодорхой хариулан соёрхсон юм. Тиймээс Цастын орны төвд хүмүүс үнэхээр их хувь сайтай гэдгээ мэдэх хэрэгтэй юм.

Товчилбоос, зөвхөн Төвд төдийгүй энэ дэлхийн сая сая хүнийг олон галавт амар амгалан байлгах хийгээд тонилохуй нирваан болон бүхнийг болгоогч Бурханы хутагт хөтлөн зохиогч шашныг баригч бусад дээд төрөлхтөн лугаа адилгүй агуу их зохиол үйлсийг туурвигч Далай Багш бээр Бурхан бодитой биш хийгээд Хутагт Жанрайсиг бодитой биш болох юм бол энэ дэлхий дээр амьтны тусыг үйлдэгч Бурханы хувилгаан байхгүй болох бөгөөд хэрвээ тэр мэт болбоос бодийн сэтгэл хийгээд Бурханы шашны ном бүгд худал болох болой. Тиймээс Шүгдэнг шүтээд Бурханы шашны номыг үйлдэх нь өөр хоорондоо харшилсан хэрэг болно. Худлыг үнэн гэж үзээд анхааран авлага үйлдсэн хэрэг болох юм.

Их хийд Гоман Дацангийн нэгэн эрдэмтэй лам бээр Шүгдэнг ихэд шүтдэг байснаар үл барам Шүгдэнг шүтэхийг дэлгэрүүлэх үүргийг өөртөө хүлээж, Дээрхийн Гэгээнтэй харшилж, зарлигийг нь эвдсэн юм. Тэрээр нас эцэслэх үед зүрх нь хэдэн хэсэг болон хагарч, нүд нь гадагш сугарч гарсан гэдэг. Энэ нь өөр нэгэн жишээ юм.

Ямартай ч олон жилийн турш ажиглан шинжлээд Шүгдэнг шүтэх нь зохисгүй хэмээн хориглосон нь ганц Дээрхийн Гэгээнтэн Далай Лам биш юм. Наран мандаж харанхуйг гийгүүлдэг мэт шашин хийгээд амьтны тусыг агуу ихээр бүтээж байсан Гачэн Ишжанцан, Туган Лувсанчойжиням тэргүүтэн Гэлүгба ёсны билэг чанар төгс багш дээдэс нар Шүгдэнг шүтэхийг хориглож байв. Тэдгээр мэргэдийн зохиолуудыг үзвэл үүнийг мэдэж болно. Дээрхийн Гэгээнтэн тэдгээр зарлигуудыг цуглуулан эмхтгэсэн бөгөөд хэрвээ та бүхэн тэдгээрийг уншихыг хүсвэл Дээрхийн

Гэгээнтний хувийн албанд хандаж болох юм.

Мөн Шүгдэнг шүтдэг мэргэн гэвш, дээд лам нар ч гарч байв. Жишээлбэл, Аврал Богд Павонка Дэчиннямбуу бээр шашин хийгээд амьтанд агуу их тусыг бүтээж байсан ба түүний олон шавь нар багшийнхаа энэ адилын агуу их зохиол үйлс нь Шүгдэнг шүтсэнээр гарсан хэмээн эндүүрч, ажиглан шинжлэлгүйгээр мухраар Шүгдэнг шүтсэн байдаг. Олон хүмүүсийн хувьд Шүгдэнг шүтсэн учир шалтгаан нь ердөө л энэ юм.

Аврал Богд Павонка Ринбүүчи урьд Дамдин-Янсан Бурханы номын аймаг хийгээд Тавдугаар Далай Ламын "Арилсан Үзэгдлийн Номын Аймаг" тэргүүтэнг анхааран авч үйлддэг байсан ч хожим тэрхүү бясалгал бүтээлээ завсарласан юм. Нэгэн өдөр Павонка Ринбүүчи өөрийн сойвондоо, *"Маргааш нэгэн тарган лам надтай уулзахаар ирнэ. Түүнийг хэрхэвч дотогш оруулж болохгүй шүү"* хэмээн захисан ч маргааш өдөр өнөөх тарган ламыг ирэхэд сойвон нь багшийнхаа захисныг мартаад тэр ламыг дотогш оруулжээ. (Энэ нь Шүгдэнг шүтдэггүй хийгээд ялангуяа шүтдэг хүмүүст учирсан барцад саад байсан юм) Дараагаар сойвонг дотогш орох үед багшийн таалал амгалангүй байх намба байдлыг үзүүлж, Дамдин-Янсан Бурханы хөрөг тэргүүтэнг доош тавих зэргээр тааллаа урвуулан зохиосон гэдэг.

Аврал Богд Павонка Дэчиннянбуу болон Аврал Богд Тижан Ринбүүчи нар нь Бурхан бодитой мөн боловч Шүгдэнг шүтсэн нь бидэнд эглийн дүрийг үзүүлж буй хэрэг юм. Эглийн дүрийг үзүүлэх гэдэг нь гэмийг үзүүлэхийн нэр юм. Эглийн дүрийг үзүүлэх гэдэгт үүнээс өөр утга байхгүй. Эглийн дүр байдлыг үзүүлэлгүйгээр биднийг орчлонгоос аврахын аргагүй юм. Гэмт байдлыг үзүүлж биднийг Бурханы оронд хөтөлж байгаа нь тэр билээ. Энэ адил үзэгдсэн нь багш бээр бидэнд огторгуй дүүрэн зэндмэнэ эрдэнэ хайрласнаас ч илүү ачтай хэрэг юм. Ганц энэ төдий бус, багшийн зохионгүй гэмтэйд үзэгдэх нь олон бий. Жишээлбэл, Багш бээр лагшин чилээрхэхийн дүрийг үзүүлэх нь бидэнд ямар хоолыг идвэл хор болох, ямар хоолыг идвэл эм болохыг үзүүлж буй хэрэг юм. Мөн зам үгүй, халил газарт явж үл болохыг үзүүлэх

зэргээр багшийн дүр байдал гэмтэйд үзэгдэх нь олон буй. Багшийн зохионгуй гэмд ургахыг Бурханы хутгийг олохын шалтгаан болсон сүжгийг арвитгах буюу сэтгэл үндсэндээ буй сүжгийг доройтуулалгүй арвитгахын нөхөрт урвуулах нь маш их аньс ихтэй юм.

"*Гүр дуулал"*-д,

"*Алин ямагт Доржсэмба хэмээх*
*Алин тэр ямагтыг багшийн дүрээр санахтун*
*Амьтан бүгдэд туслахыг үргэлжид зорих*
*Алин тэрээр эглийн дүрээр оршиюу"* хэмээн зарлигласан мэт.

Бурхан багш цөвүүн цагт багшийн дүр байдлаар залрахыг зөвхөн арвис тарнийн ёсонд ч бус, судрын ёсонд ч мөн айлдсан байдаг. Өмнө зүгийн их өндөр уул хэмээхэд Бурхан багш бээр ном номлон ахуйд бодьсадва Үзэхүй Туст бээр *"Өдгөө бидэнд Бурхан Багш номоо номлон байгаа ч ирээдүйд Бурханы гэгээн гаслангаас гэтлэхийн ёсыг үзүүлсний хойно номыг номлогч үгүй болох буюу"* хэмээн сэтгэсэнд Бурхан Багш түүнд:

"*Аяа Үзэхүй Туст аа,*
*Хожмын цаг ирэхүйд*
*Би бээр хамбын биеийг үзүүлмүй.*
*Би бээр багшийн дүрсэнд оршмуй.*
*Аяа Үзэхүй Туст аа,*
*Амьтан нугуудыг номхтгохын тулд*
*Би бээр төрөх, өтлөх хийгээд*
*Өвдөх, үхэхийг машид үзүүлмүй"* хэмээн зарлигласан юм.

Лам багш бодитой Бурхан мөн боловч өөрийн зүгээс Бурхан хэмээн эс үзвэл гэм ямагтыг л олохоос бус ашиг тус үл гарах учрыг Гаадамбын буяны их садан Бодова "*Хөх Дэвтэр"* хэмээх зохиолдоо: *"Манзушир, Жанрайсиг бодитойгоор өмнө заларсан ч өөрөөс болоод ашиг тус аль нь ч гарахгүйн дээр харин ч гэмт болох нь буй"* хэмээжээ. Үлгэрлэвээс, Гэлэн Лэгбийгарма бээр бидний Бурхан багшийн дэргэд 22 жил ойр байсан ч тэр бүх хугацааны турш Бурхан багшийг жирийн нэгэн хууран мэхлэгч мэтээр үзэж байсан бөгөөд үүнийхээ үрд тэрээр муу заяанд, нэрвэшгүй халуун тамд галваар зовох хэрэгтэй болсон юм.

Багш хэдийгээр Бурхан бодитой биш байлаа ч Бурхан

бодитой мөн хэмээн үзвэл өөрт ашиг тус ямагт л гарахаас гэм үл гарна. Үлгэрлэвэл, нэгэн хөгшин эх бээр нохойн ясыг Бурханы шүд хэмээн үнэнхүү итгэн сүжиглэж байсны хүчээр Бурханы адистид бодитой оршин, нохойн яс Бурханы шарилын шүтээн (ринсэл) болон хувирсан мэт. Тэрчлэн шавь бээр энэ адилаар багшийгаа Бурхан бодитой хэмээн шүтсэнээр багшаасаа өмнө төгс гэгээрлийн хутгийг олж амьтны тусыг хотол чуулган үйлдэх нь ч байх хэмээн айлдсан байдаг.

Түүнчлэн V Далай Лам бээр,

"*Өөрийн сэтгэл буруу эндүүрлийн үзэгдэлд*
*Өөрийн гэм багшийн зохионгуйд ургах бүгдийг*
*Өөрийн гэмд мэдээд хойшид хор мэт тэвчихтүн"* хэмээсэн байдаг. Богд Зонховын ёсонд багшийн зохионгуйг гэмд үзэхийг сүжгийн нөхөрт урвуулах ёсыг дээрх зарлигууд өгүүлж байдаг. Эдгээр зарлигуудын утгыг сайтар тунгаагаарай.

Багшийн гэмийг харах нь: толинд туссан нүүрний дүрсэнд хар толбо байх аваас тэр нь өөрийн нүүрэнд л хар толбо байгаагийн тэмдэг болохоос толины гэм биш лугаа адил юм. Багш бээр хорыг таалбаас бид ч мөн дагаад хор идэх хэрэггүй юм. Энэ юу гэсэн утгатай болохыг бид шинжлэх хэрэгтэй. Тогос шувуу хор идээд улам өнгө зүс орж, амьд байж чаддаг шиг хор идээд амьд байж чадвал болж л байна. Хэрвээ бид хорыг рашаанд урвуулж чадвал хор идэхэд гэмгүй билээ.

А ЛА ЛА ХО
А ХО МАХА СУХА.

Ялгуусан Вэнсаба бээр,

"*Товчилбоос онол эрдэм их, бага алин төрсөн нь*
*Сүжиг их, багын алинг бясалгасны хүч мөн.*
*Шид бүтээл гарахын орон эрдэмт багшийн*
*Эрдмийг санаад, гэмийг үл үзэх*
*Увдис үүнийг сэтгэлдээ барин зохиогтун"* хэмээсэн билээ.

"*Бодь Мөрийн Зэрэг Рашааны шим"*-д,

*Муу үйлийн түйтгэрээс хагацах хүртэл*
*Хоцроолгүй Бурхан бүгд өмнө тань илтэд заларсан ч*
*Өдгөө үзэгдэх эглийн үзэгдэл энэ ямагтыг үзэхээс бус*

*Билэг найргаар чимэглэсэн дээдийн лагшинг үзэх хувь хаанаас байх"* хэмээсэн байдаг. Энэ нь өөрийн багшийг билэг найргаар чимэглэсэн дээдийн лагшингийн дүрээр үзэхийн тулд Их Хөлгөний таван мөрөөс Чуулганы мөр, Номын үргэлжлэлийн самадийг олох хэрэгтэй гэсэн утгатай юм.

Урьд зарим тэрсүүд Бурхан багштай учирч байсан ч Бурхан Багшийн тэргүүний үснир хийгээд лагшингаас нь цацрах гэрэл зэрэг билэг найргийн алийг ч үзэлгүй жирийн нэгэн хүн мэтээр харж байсан юм. Мөн Хутагт Асанга бээр Майдар Бурханыг бөгсөн бие нь өтсөн эм нохойн дүрээр харж байсан гэдэг. Түүнчлэн их бясалгаач Нагбу-Жодба болон гэцүл Цэмбүва нар ядам Доржбалму Бурханыг уяман өвчтэй эмэгтэйн дүрээр харж байв. Мөн мэргэн шидтэн Нароба болон нутгийн хүмүүс Их бүтээлчин Дилобаг Доржчан бурхан бодитой байсаар атал амьд загас шарж иддэг гуйлгачны дүрээр харж байсан гэдэг.

Дээрхийн Гэгээнтэн Далай Лам нэгэнтээ,

"*Цог төгөлдөр багшийн намтар дор*
*Агшин төдийд ч буруу үзлийг төрүүлэлгүй*
*Алин зохиосон бүхнийг сайнд үзэн биширснээр*
*Ачит багшийн адистид сэтгэлд орших болтугай"* гэх энэхүү ерөөлийн үгийг хүлээн зөвшөөрч үл чадна хэмээн айлдсан юм. Дээрхийн Гэгээнтний таалал оюун Авралт Богд Павонка Ринбүүчи болон Авралт Богд Тижан Ринбүүчи нарын таалал оюунтай нэг учир Дээрхийн Гэгээнтэн бээр тийнхүү зарлигласан юм. Энэ нь Авралт Богд Павонка Дэчиннянбуу бээр "*Ламыг Алсаас Урихуй"*-даа:

"*Бурхан бүгдийн билгүүн, их амгалант номын лагшин нэгэн мөн чанартай*
*Тэр ямагт нь ачит багш бүгдийн мөн чанар болой.*
*Багш-Номын лагшин дор зүрхний угаас соёрхол талбия*
*Энэ хойд хийгээд завсрын төрөл бүхэнд хагацалгүй дагуулан барихтун"* хэмээн айлдсантай утга нэг юм. Өмнө өгүүлсэн ерөөл нь муу үйлээр машид түйтгэрлэгдсэн, тийн атгагаар дүүрсэн над мэтийн эглүүдэд зориулагдсан юм.

Дээрхийн Гэгээнтэн Далай Лам болбоос энэ дэлхий дээрх Бурханы шашныг барин дэлгэрүүлэгч нарын эрхэм мөн тул Дээрхийн Гэгээнтний сургаалыг дагах нь маш чухал юм.

Энэ дэлхийд олон шашин байдаг ч ганц бидний Бурхан Багш Их нигүүлсэхүйт Шагжамүни бээр л "*Гэлэн нугууд аа, Та бүхэн алтыг үрж, хэрчиж, хайлуулж шалгадаг шиг миний сургаалыг ч мөн адил тэр мэт шинжлэхтүн. Зөвхөн сүжиг төдийгөөр бүү ханд"* хэмээн зарлигласан билээ. Тиймээс бид Бурханы номын анхааран авлага алинг үйлдэхнээ ч сайтар шинжилж байх хэрэгтэй юм. Үүнийг л Бурхан Багш бидэнд айлдсан хэрэг. Үүгээрээ Бурхан Багш бидэнд өөрийнхөө сургаалыг шинжлэх эрхийг өгсөн юм. Та бүхэн үүнийг сайтар ухаараарай.

Бүхнийг айлдагч Дээрхийн Гэгээнтэн Далай Ламын сургаалыг дагах нь хувь хүн хийгээд нийт Төвдүүд цааз ёсыг ариунаар сахиж, нэгэн үндсэнд хураад, эв найртай тайван амьдрахын тухайд юм.

Энэ нь төрлөөс төрөл тутамдаа ямар нэгэн бэрхшээлгүй байж, энэ дэлхийд жаргалын наран мандах хийгээд амар амгалан хотол чуулган байхын тухайд юм. Энэ дэлхийд Бурханы шашин хир үгүйгээр дэлгэрэх хийгээд ялгамжаатай Төвдийн Их Хөлгөний хиргүй шашин доройтолгүй дэлгэрч байхын тухайд Дээрхийн Гэгээнтэн Шүгдэнг шүтэхийг хориглосон зарлигаасаа буцахгүй байгаа билээ.

Зарим дээд лам, гэвш нар Дээрхийн Гэгээнтний энэхүү шийдвэрийг шүүмжилж, дайсанд үзэж байсан ч тэрээр таалал, зарлигаа өөрчлөөгүй юм. Энэ нь Цаст Төвдийг номхтгогч Хутагт Жанрайсиг бээр хэзээ ч ганц өөрийн тусыг үйлдэхгүй бөгөөд түүний зохиол үйлс нь гагцхүү бусдын тусын тулд л зоригддог болохыг харуулж буй хэрэг юм. Их бодь сэтгэлтэн, их нигүүлсэхүй сэтгэлтэн бээр арван зүгийн Бурхан бүгд лугаа адил зургаан зүйлийн хамаг амьтдыг нигүүлсэхүйгээр болгоож, гэгээрлийн замд хөтлөн, аврал өмөг ямагтыг зохиодог болохыг харуулж хэрэг юм.

Урьд би бээр Дээрхийн Гэгээнтэн Далай Ламд бараалхаж аймшиггүйгээр, дэлхий нийт хийгээд ялангуяа нийт Төвдийн ард түмнийг төлөөлж, зарим дээд лам, гэвш нар Дээрхийн Гэгээнтний шийдвэрийг эсэргүүцэн ном товхимол бичиж байсан ч Дээрхийн Гэгээнтэн бээр Шүгдэнг шүтэхийг хориглосон зарлигаа буцаагаагүй нь Дээрхийн

Гэгээнтэн юутай их хэмжээлшгүй зарлигийн ачтан билээ гэдгийг илтгэж буй хэрэг хэмээн айлтгаж байсан юм.

Энэхүү захидлыг уншаад таалал харшлах аваас их нигүүлсэнгүй Бурхан багш хорлолт нэгэнд тэвчээрийн чанадад хүрэхүйг анхааран авахыг сургасан мэт та бүхэн ч хүлцэнгүйг анхааран аваарай. Сэтгэл оюун амгалан байх нь амьдралд их чухал юм. Та бүхэнд маш их баярлалаа!

Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Олон Улсын Төвийн
номын тэргүүн Зопа Ринбүүчи

# ӨМНӨХ ҮГ

[<— Гарчиг руу буцах]

Энэхүү ном нь Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Ламын Шүгдэнг шүтэхийг хориглосон айлдваруудын эмхтгэл “Dolgyal sGor Lam sDon Ga-sLob kNyi-pa” (Шүгдэнгийн тухай зарлиг II) номын орчуулга юм.

Сүүлийн жилүүдэд Төвдийн Бурханы шашнаас шахагдсан тангаргийн буг Шүгдэнг шүтэгч нар Буддын шашны уламжлалт Монгол оронд байр сууриа бэхжүүлэхийн тулд ил далдаар хичээх болсон бөгөөд тангаргийн буг Шүгдэнг “Шарын шашны гол сахиус”, “Бурхан”, “Эдийн тэнгэр” мэтээр сүсэгтэн олонд таниулсаар байна. Мөн Дээрхийн Гэгээнтэн чухам ямар учраас Шүгдэнг шүтэхийг хориглох болсон нарийн учир шалтгааныг мэдэхгүй сүсэгтэн олон байгаа тул Дээрхийн Гэгээнтний айлдварыг орчуулсан билээ.

Монголчууд бид эртнээс үе үеийн Далай Лам нартай багш шавийн барилдлагатай байсаар ирсэн. Тиймээс энэ цөвүүн цаг үед шавь бид нар багш шавийн тангаргаа хичээж, Дээрхийн Гэгээнтний айлдсан хир үгүй сургаалыг танин барьж, авла орхилыг ёсчлон үйлдэх нь нэн чухал юм.

Энэхүү номыг бүтээхэд бидэнд үнэлж баршгүй сургаалаа хайрласан Монголын Бурханы Шашинтны Тэргүүн, Оройн Дээд Очирдарь - IX Богд Жавзандамба Хутагт, Гандан Ширээт Ризон Срай Ринбүүчи, Намжал Дацангийн Хансүр Жадо Ринбүүчи, Төвд Монголын Буддын Соёлын Төвийн тэргүүн Ажаа Гэгээн, Их Хөлгөний

Уламжлалыг Хадгалах Олон Улсын Төвийн номын тэргүүн Зопа Ринбүүчи хийгээд Гэлэн Рожер Гүнсэн ламтан, Хатагтай Мэри Пэттисон болон Монгол дахь Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Төвийн орчуулагч Д.Хулан нарын гайхамшигт билэг оюунд биширч байна.

Мөн номыг Монголын сүсэгтэн олонд хүргэх хязгааргүй их буянт үйлийг үйлдсэн “Жавзандамба Хутагт Төв”-ийн буянтан нарт маш их баярлаж, талархсанаа илэрхийлье. Эдгээр хүмүүсийн хязгааргүй их өгөөмөр сэтгэлийн хүчээр л Дээрхийн Гэгээнтний энэхүү нандин сургаал Уншигч Таны оюуны мэлмийд хүрч байгаа билээ.

Хутагт Жанрайсигийн эндүүрэл үгүй айлдварыг чадан ядан орчуулсан үүнд үг, утга, найруулгын алдаа байх аваас Мэргэн Уншигч Танаас саруул ухаандаа залруулан болгоохыг хичээнгүйлэн хүсэхийн ялдамд бидний үйлдсэн өчүүхэн буян хийгээд энэ Замбуутивийн олон амьтны тусын тулд төрөл дараалан заларсан Хамгийг Айлдагч Далай Лам, Оройн Дээд Очирдарь Богд Жавзандамба Хутагт тэргүүтэн дээд төрөлхтөн нарын таалал ерөөлийн хүчээр Их Монголын орноо амьтан бүхний амгалан жаргалангийн уг шалтгаан болсон Бурханы Шашин их эрдэнэ хир үгүйгээр дэлгэрэх болтугай хэмээн ерөөл тавин залбиръя.

Орчуулагчид

# ТАНГАРГИЙН БУГ ШҮГДЭН ГАРСАН ТҮҮХ

**<— Гарчиг руу буцах**

Алтан Хааны зээ хүү IV Далай Лам Ёндонжамц 1601 онд Төвдөд залагдан сууж байгаад 1616 онд тодорхой бус шалтгаанаар гэнэт таалал барсан юм. Түүнийг таалал барсны дараа Далай Лам болон Шарын шашныг эсэргүүцэгч, Төвдийн Зан аймгийн захирагч Дэсрид Пунцогнамжал (*1613-1642 оны хооронд Төвдөд эрх мэдлээ тогтоож байсан.*) "IV Далай Ламын хойд дүрийг тодруулж болохгүй" хэмээн хориг тавьж байв. Үүнийг мэдсэн Алтан Хааны удмын Гүр Хунтайж болон Лувсандaнзан нар 2000 цэрэг захиран 1621 онд Төвдийн Үй-Занд ирж Сономравданг (*Хожим V Далай Ламын туслах болсон.*) дэмжиж, Шарын шашныг устгах бодолтой байсан Дэсрид Пунцогнамжалд дарамт үзүүлэн, түүний гарт орсон Шарын шашны хийдүүдийг чөлөөлсөн гэдэг. Тэд IV Ванчин Богд Лувсанчойжижанцантай (*1567-1662*) Далай Ламын хойд дүрийг тодруулахаар зөвшилцсөнөөс хойш нэг жилийн дараа V Далай Лам Лувсанжамцыг тодруулж сэнтийд залсан билээ.

IV Далай Ламын хойд дүрийг тодруулах явцад дөрвөн хүүгийн нэр сүүлийн шалгуурт үлдсэн нь Нянбуу нутгийн Дүвчин Нахавын хувилгаан, Чонжай нутгийн хүү (*V Далай Лам Лувсанжамц.*), Гадхаса хошууны Дагважанцан, Сономравдангийн зээ хүү Нансо-Норвуу нар байв. Ванчин Богд болон Ядам Бурхадын таалал нэг зүгт буун Чонжай нутгийн хүүг V дүрийн Далай Ламаар тодруулжээ.

Энд өгүүлж буй Гадхаса хошууны Дагважанцан нь

тангаргийн буг Должал буюу Шүгдэнгийн өмнөх төрөл юм. Тэрээр 1619 онд Төвдийн Зан аймгийн Гадхаса хошуунд төржээ. Эцэг Намсрай нь нутаг усандаа эрх мэдэлтэй хошууны ноён хүн байв. Түүний эх Ла-Ажал башир арга хэрэглэн Дэсрид Пунцогнамжалын дэмжлэгтэйгээр өөрийн хүү Дагважанцангийн нэрийг Далай Ламын дүрийг тодруулах явцад шигшигдэж үлдсэн хүүхдүүдийн нэрэнд хавчуулж чадсан ч энэ зорилго нь бүтээгүйн дээр түүний гэр бүл Дэсрид Пунцогнамжалын талынх тул монголчуудад түйвээгдсэн гэдэг. Ийнхүү Далай Лам болж чадаагүй хүүгээ ээж нь Брайбүн хийдэд авчран Банчэн Сономгэлэгбалсангийн (*1594-1615*) хойд дүр хэмээн олонд ярьж, башир арга хэрэглэн нэлээдгүй хүмүүсээр хүлээн зөвшөөрүүлж, Брайбүн хийдийн дээд өргөөнд (*Хувилгаан Сономгэлэгбалсангийн өргөө.*) залуулж чаджээ. IV Ванчин Богд Лувсанчойжижанцан Дагважанцанг өөрийн багш Банчин Сономдагвын (*Банчин Сономгэлэгбалсангийн өмнөх төрөл.*) хойд дүр хэмээн зуун хувь хүлээн зөвшөөрдөггүй байсан гэдэг. Дагважанцан өөрийгөө эртний Төвдийн дээд төрөлхтөн Бүдон Ринбүүчи болон Шалү Лозова нарын хойд дүр хэмээн үзэж өөртөө Ванчин Богд болон V Далай Лам нараар өндөр дээд төрөлхтөн нарт зориулж тусгайлан зохиодог төрөл дарааллын залбирлыг зохиолгох хүсэлтэй байсан ч энэ хүсэл нь биелээгүй юм. Мөн тэрээр Шарын шашны дайсан Дэсрид Пунцогнамжалыг ил далдгүй дэмждэг байсан бөгөөд үүний нэг илрэл нь Дэсрид Пунцогнамжалын хүсэлтээр 1638 онд Гадхаса хошуунд очиж Төвдөд буй монголчуудыг дарахын тулд нууцаар хатуу үйл үлдэж байв. Энэ нууц хэрэг задарснаас болж монголчууд Гадхаса хошууг дахин түйвээсэн гэдэг.

Дагважанцангийн хийж буй энэ мэт үйлдлүүд IV Ванчин Богд тэргүүтэй Шарын шашны ихэс дээдэс нарын таалалд нийцдэггүй байв. IV Ванчин Богд 1642 оны Лхасын "Их Ерөөл" хурлын үеэр түүнийг хувилгааны сэнтийнээс буулган энгийн ламын суудалд суулгах шийдвэр гаргаж байв. Түүнийг хувилгааны сэнтийнээс буулгах шийдвэр гарсан тэр жил Монголын Гүүш Хаан Дэсрид Пунцогнамжалын төрийг унаган, V Далай Лам Лувсанжамцад Төвдийн гурван чуулгыг

(*Үй-зан, Амду, Хам.*) өргөн барьж, түүнийг бүх Төвдийн шашин төрийг хослон баригч эзэн хаанд өргөмжлөн, Далай Ламын өргөө Гандан-Потаныг Төвдийн засгийн газрын ордон болгосон түүхтэй.

Пунцогнамжалын нөмөр нөөлгөөс хагацсан хуурамч хувилгаан Дагважанцан шинээр байгуулагдсан Төвдийн засгийн газар Гандан-Потаны доор энгийн байдлаар амьдарч байгаад 1656 онд халдварт өвчнөөр өөд болов. Дагважанцанг хүндээр өвдөхөд V Далай Лам өөрийн шавь тул хөл хорьсон бясалгалаа орхин түүний өргөөнд морилж Гомбын жанан (*даган соёрхол*) хайрласан боловч засал авалгүй нас баржээ. Түүний биеийг чандарлан, чандрыг суваргад байрлуулсан шөнө суваргаас дүрсгүй ярих чимээ гарах зэргээр ад зэтгэр болсны шинж өлзий бусын олон муу ёр гарсан тул Найчүн сахиусны зарлиг дагуу Дагважанцангийн өргөөг нураалган, суурин дээр нь зуун гэлэнгээр ном уншуулж, суварган дахь чандрыг гарган голд хаяжээ. Дол нутгийн гол дагуу урсаж байсан түүний чандрыг үйл нь таарсан нэгэн бээр эрэгт гаргаснаас уршигдан Дол нутгийн Цагаан булагт хүн малын хижиг өвчин гарсныг V Далай Лам болгоон ад зэтгэр болсон түүнийг Цагаан булгийн савдаг болгон тахисан ч хорлол нь улам ихээр гарах болсон тул 1674 онд буруу ерөөлт тангаргийн буг түүнийг хатуу үйлээр дарахаар болж, Дорж Ловон Дондүвжамц, тарнийг баригч Лувсанчэнзэ зэрэг бүтээлчин нар Ямандаг болон Пүрэвийн үүднээс долоо хоног бүтээл үйлдэн ерөөл буруудсан тангаргийн буг Шүгдэнг нөхөд сэлттэй нь хамт жинсрэгийн галд шатаасанд хүүр шатсан үнэр бүгдэд үнэртсэн тухай V Далай Лам Лувсанжамцын намтар "*Дүгүлийн Гой-сан*"-д тодорхой гардаг.

Шүгдэн жинсрэгийн галд шатсанаасаа хойш 47 жилийн дараа буюу 1721 онд урьдын үйл, буруу ерөөлийн эрхээр дахин гарч ирэн өөрийн багшийн хийд болох Дашлхүнбэд ирсэнд Намсрай сахиус хийддээ оруулаагүй тул цааш Сажавын хийдийг зүглэн Сажавын дамжлагын эзэн Дагти Сономринчингийн өмнө ирсэнд Дагти Ринбүүчи, "Чи хэн юм?" хэмээн асуусанд дүрсээ үзүүлэн "Би Шарын шашинтай тангараг буруудсан буг байна." хэмээн хариулсан

гэдэг. Энэ үеэс эхлэн буг чөтгөр түүнтэй үйлийн барилдлагатай Сажавын зарим нэгэн лам нар анхлан түүнийг шүтэж эхэлжээ. Улмаар тэдгээр лам нартай номын барилдлагатай Шарын шашны лам нар шүтэх болсон гэдэг.

V Далай Лам Лувсанжамц, VI Ванчин Богд Балдан-Иш, VII Далай Лам Галсанжамц, Дэчин Агваанчогдон, Жанжаа Ролбийдорж, Туган Чойжинямаа, Ёнзон Ишжанцан, VIII Ванчин Богд Данбийванчүг, Пүржог Агваанжамба, XIII Далай Лам Түвдэнжамц зэрэг шарын шашныг номлол бүтээлийн үүднээс баригч дээдэс нар 200 гаруй жилийн турш буруу ерөөлт тангаргийн буг Шүгдэнг шүтэхийг хориглосоор ирсэн билээ.

Хожим Павонка Ринбүүчийд Шүгдэнгийн ёр гарсны улмаас тангаргийн буг түүнийг сахиусанд шүтэх болсон гэдэг. XIII Далай Лам Түвдэнжамц Павонка Ринбүүчийн энэ үйлдлийг хориглож “Шүгдэнг шүтэхгүй” гэсэн ам тангаргийг нь авсан ч Павонка Ринбүүчи бээр нийтийн үзэгдэлд XIII Далай Ламыг таалал барснаас хойш шарын шашинтан нарын дунд Шүгдэнг шүтэхийг ихээр дэлгэрүүлсэн юм.

1960 онд Найчүн сахиус Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Ламд “Шүгдэнг шүтэхийг хориглох хэрэгтэй.” хэмээн айлтгаж байсан ч Дээрхийн Гэгээнтэн Шарын шашинтан нарын дунд хагарал гарахаас эмээж Шүгдэнг шүтэхийг хориглоогүй гэдэг. Үүнээс хойш 10 жилийн дараа Шүгдэнг шүтэгч нар Бурханы шашинтан нарын дунд хагарал гаргах болсон тул Дээрхийн Гэгээнтэнд Ядам Бурхад, Балдан Лхам болон Найчүн сахиус нар “Шүгдэнг хориглохыг” сануулан эш үзүүлсэн дагуу Дээрхийн Гэгээнтэн бээр ажиглал шинжлэлийг олонтой үйлдсэний эцэст 1970 оноос хойш Шүгдэнг шүтэхийг хориглох болсон билээ.

# 2000 оны 3-р сарын 15-ний өдөр. Өмнөд Энэтхэгийн Мондгод дахь Төвд суурингийн ард иргэд Дээрхийн Гэгээнтэнд бат оршил өргөх үеэр Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Бат оршил өргөсөн бичигт "бид Шүгдэнг шүтэхгүй" гэж бичсэн байна. Маш их баярлалаа! Ихэнх төвдүүд Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг ойлгоод шүтэхээ больсон. Гэвч цөөхөн хэсэг нь өнөөг хүртэл шүтсээр байна. Тэдгээрийн зарим нь юугаа ч мэдэхгүй шүтсээр байгаа тул тайлбарлаж өгөх нь чухал юм.

Шүгдэнг дахин дахин судлах хэрэг надад гарч байсан. V Далай лам, Пүржог Агваанжамба, Дэчин Агваанчогдон, Ёнзон Ишжанцан тэргүүтэн олон мэргэд Шүгдэнг шүтэхийг хориглож байсан. Үүнийг та бүгд мэдэж байгаа байх. Хуучин ном, зохиолуудад Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгаан тодорхой гардаг. Шүгдэнг шүтэхийг хориглосон нь дан ганц миний бодол санаа биш юм шүү! *"Хуурамч хувилгаан Дагважанцан буруу ерөөл тавьж, тангараг буруудсан буг чөтгөр болсон"* гэж V Далай Ламын сүнбүмд маш тодорхой гардаг. Үүнийг бид бүгд мэдэх хэрэгтэй. Ямартай ч өмнөх Далай Лам нарын хослон барьж байсан Төвдийн шашин төртэй зөрчилдөн буруу ерөөл тавьж, тангараг буруудсан буг болсон түүний уршгаар үе үеийн Далай Лам нар болон Төвдийн засгийн газар Гандан-Потанд өлзий бусын олон муу ёр гарсан байдаг. XIII Далай Лам таалал барах үед Шүгдэн "29-ийг дуусгаад битүүнд өнгөрнө!" хэмээн баярлан орилж байсан гэдэг. XIII Далай Лам таалал барах гээд, Төвдийн ард түмэн уй гашууд автаж байхад Шүгдэн баярлан чанга дуугаар орилсон нь муу ёрын буг гэдгээ харуулж буй хэрэг

юм. Тиймээс Далай Лам нарын удирдаж байсан Төвдийн засгийн газар Гандан-Потанд сэтгэл итгэмжилж, тус санадаг хүн л бол эдгээрийг эргэцүүлэн бодох хэрэгтэй.

Нэлээн хэдэн жилийн өмнө Шүгдэнгийн нийгэмлэгээс гаргасан нэгэн бичигт “Төвдийн засгийн газар Гандан-Потантай тэмцэл хийнэ” гэж бичсэн байсан. Шүгдэнгийн энэ асуудал V Далай Лам Төвдийн засгийн газар Гандан-Потаныг байгуулсан тэр үеэс эхтэй. “V Далай Лам буруу ерөөл тавьж буг болсон Дагважанцангийн ордонг нураалгасан учраас тэмцэл хийнэ” гэж байгаа бол болох юм. Харин V Далай Ламаас авахуулаад Далай Ламын хойд дүрүүд, дээшлээд анхдугаар дүрийн Далай Лам нартай тэмцэлдээд байгаа нь хачирхалтай. Тэд үүнийгээ ямар нэгэн байдлаар тайлбарлаж болох юм. Ямартай ч энэ асуудлыг сайтар мэдэх хэрэгтэй. Өнгөрсөн түүхийг судалбал энэ асуудал улам тодорхой болно. Түүхийг судлахдаа хэн нэгний талд орж үнэнийг худал болгож, худлыг үнэн болгож гуйвуулалгүйгээр бодит байдлыг байгаагаар нь гаргах нь чухал. Хятадуудын ярьдаг шиг “сайныг нь авч, мууг нь хаях” байдлаар түүхэнд хандаж болохгүй.

Би нэг түүх ярья. Миний таньдаг Сэра-Мэ дацангийн Бомра аймгийн настай ламыг бага байхад Лхасын Тодэ Хансар хэмээх Шүгдэн тахидаг хийдийн дуганч лам түүнд, “*Нэг удаа хурал хурах үед Шүгдэнгийн онгод бууж, хурлын дунг аваад <<Шашны дайсан Гандан-Потаны орой дээр цохино!>> хэмээн орилоод дунгаараа газар цохиход гарсан мөр нь усны суваг шиг харагдаж байсан”* хэмээн ярьсан гэдэг. Энэ түүхийг надад ярьсан тэр лам одоо бараг 70, 80 орчим настай байх.

Нүдэнд цагаа унахад бүрэлздэг шиг мунхгийн эрхээр бодит байдлыг харж чадахгүй байгаа хүмүүс өрөвдөлтэй. Бодит байдлыг бүгдийг нь судалж мэдчихээд намайг эсэргүүцэн тэмцэж байгаа бол хамаа алга. Хувь хүний хэрэг. Төвдийн зургаан сая хүн, Нинмава, Сажава, Гаржүдба, Гэлүгба болон Бөө мөргөлтөн нарын дотроос Далай Ламыг эсэргүүцдэг ганц л бүлэг байдаг. Энэ нь Шүгдэнг шүтдэг бүлэглэл юм. Тэдний энэ эсэргүүцэл надад хорлож байна уу, тусалж байна уу гэдэг нь чухал биш. Харин нийт Төвдийн

ард түмний талаас авч үзвэл энэ нь үнэхээр гутамшигтай явдал юм. Энэ бүхнийг би урьдын түүхэнд тулгуурлан ярьж байгаа болохоос биш өөрийнхөө санаанд нийцүүлэн ярьж байгаа юм биш шүү! Та бүхэн сайн судлаад үнэн мөнийг тунгаагаарай!

Шүгдэн болон түүнийг дагагч хүн хийгээд хүмүүн бусын хүч чадал доройтож байгаа нь тодорхой. Ер нь энэ асуудлыг сайн судалбал Шүгдэн гэж юу болох нь улам тодорхой болно. Тиймээс та бүхэн сайн судалж үзээрэй! Мунхаглан утга учрыг мэдэхгүй явах нь сайн хэрэг биш шүү!

# 2000 оны 12-р сарын 6-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Дарамсалад хуралдсан Шарын Шашны II Их Хурал дээр Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

[<— Гарчиг руу буцах]

Зарим хүмүүс Шүгдэнг шүтэж болохгүй гэж ярихдаа "Далай багшийн зарлигийг дагах хэрэгтэй" гэж ярьдаг. Үүнийг би алдаа гэж бодож байна. Бид Бурхан Багшийн сургаалыг шинжилж үзээд, үнэн учир шалтгаанд нийцсэнийг нь хүлээн зөвшөөрч, нийцээгүйг нь тааллын өөр утгад тайлбарладаг. Тиймээс миний хэлснийг шинжлэлгүйгээр "Далай багшийн зарлигийг дагах хэрэгтэй" гэж яривал Бурханы шашин болон илүүтэйгээр Их Хөлгөний номын ёстой харшилна. Шүгдэнг шүтэж болох, болохгүй нь Далай Ламын зарлигийг дагах, дагахгүйн тухай асуудал биш. Өнөөг хүртэл тодорхой хугацааны турш бусдын төдийлөн анхаарч байгаагүй энэ асуудлыг ил гаргасны учир нь өнгөрсөн 300 гаруй жилийн турш үргэлжилж буй маргааныг эцэс болгохын тулд юм.

Өнөөдөр энэ тухай нэгэн шинэ зүйлийг нэмж хэлье. Гүнтан Ринбүүчийн зохиол "*Утга төгөлдөр магтаал"* (Додба дондан-ма) -д:

*Одоо цагт Богд Ламын шашин ариун байгаа ч*
*Цөвт мунхгийн тоосоор бүрхэгдсэн*
*Олон буруу буяны садан нугууд*
*Хүмүүсийг аймшигт халил газарт хөтөлнө* хэмээн бичсэн байдаг. Гүнтан Ринбүүчи Ёнзон Ишжанцан, Гончигжигмэдванбуу нараас ном сонсож байсан. Гончигжигмэдванбуу бол Жанжаа Ролбийдоржийн шавь. Ингээд бодоход тэр үед Шарын шашинтан хүн *Одоо цагт*

*Богд Ламын шашин ариун байгаа ч* хэмээсэн нь Гаржүдба, Нинмава, Сажавын тухай биш Шарын шашны тухай л хэлж буй хэрэг.

*Цөвт мунхгийн тоосоор бүрхэгдсэн*
*Олон буруу буяны садан нугууд*
*Хүмүүсийг аймшигт халил газарт хөтөлнө* хэмээн тэрээр Жанжаа Ролбийдорж, Гончигжигмэдванбуу, VII Далай Лам Галсанжамц нарын үед бичиж байв. Тэр үед Богд Ламын шашинд том ламын нэрийг барьж бусдыг буруу мөрд хөтлөгч хэн байв? Үүнийг бид мэдэх хэрэгтэй. Гүнтан Ринбүүчи ийн бичиж байсан үеийн түүхийг сөхөн үзвэл, тэрээр VII Далай Ламыг төр барьж байх үед гарсан ноёд түшмэдийн будлианыг, эсвэл Брайбүн хийдийн лам Лэлүн Шадвадоржийн тухай хэлсэн байж болох юм. Лэлүн Шадвадорж нь Шарын шашны Брайбүн хийдийн лам бөгөөд нууц тарнийн бясалгал бүтээл нь өндөр хэмжээнд хүрсэнд эрэмшин эхнэр авснаас улбаалан олон шавь нар нь түүнийг дуурайж, эмэгтэй хүнтэй холбогдон сахил санваараа алдах болсон тул Шогдонёдхайдүв, Пүржог Агваанжамба нар буруушаан, "*Одоо цагийн зарим лам нар ариун явдлаа цалгардуулж, хийд орныхоо олон хуврагийг гэргийтэн болгон уруу татаж, шашныг доройтуулж байна*" хэмээн зэмлэж байсан нь Пүржог Агваанжамбын намтарт гардаг.

Гүнтан Ринбүүчи үүнээс өөр зүйлийг хэлсэн ч байж болох юм. Пүржог Агваанжамба болон Дэчин Агваанчогдон нарын зохиолд Шүгдэнгийн нэрийг шууд өгүүлж, шүтэхийг хориглосон байдаг. Мөн Ёнзон Ишжанцан бээр "*Дашлхүнбэд шинэ сахиус гэгдээд байгаа энэ муу чөтгөр нэг л өдөр хуурна шүү!*" хэмээн айлдсан байдаг. Энд Дашлхүнбэ хийдийн хамба ирсэн байна. Тэр үед Дашлхүнбэ хийдэд юу болж байсныг судлах хэрэгтэй шүү! VI Ванчин Богд Балдан-Иш VII Далай Лам Галсанжамцын шавь байсан. Тэрээр Дэчин Агваанчогдонтой барилдлагатай байсан эсэхийг мэдэхгүй ч, Шүгдэнгийн тал дээр түүнтэй ижил бодолтой байсан нь тодорхой. VIII Ванчин Богд Данбийванчүгийг бага байх үед Дашлүнбэ хийдэд Шүгдэнгийн ёр гарахад ёр гарсан байшинг нураалгасан байдаг. VI Ванчин Богд Балдан-Ишийн үед Дашлхүнбэ хийдэд Шүгдэнг сахиусанд тахидаггүй байсан

байх гэж бодож байна. Учир нь Ёнзон Ишжанцан VII Ванчин Богд Данбийнямыг бага байх үед "*Дашлхүнбэд шинэ сахиус гэгдээд байгаа энэ муу чөтгөр нэг л өдөр хуурна шүү!*" хэмээн айлдсан. "*Шинэ сахиус*" гэж Цамба, Бэгз, Лхам сахиусыг хэлээгүй. Учир нь VI Ванчин Богд Балдан-Иш Цамба сахиусны тахилын уншлага олныг зохиож байсан. Бэгз сахиусны хувьд Жовучингарав бурхантай (*Жанрайсиг Бурхан*) нэг мөн чанартай хэмээн үзэж Анхдугаар Далай Ламын үеэс шүтэж ирсэн. Тиймээс "*шинэ сахиус*" гэж Шүгдэнг хэлсэн хэрэг. Ёнзон Ишжанцангийн айлдварыг харвал VII Ванчин Богд Данбийнямын үеэс Дашлхүнбэ хийдэд Шүгдэнг шүтэх болсон нь тодорхой байдаг. Дэчин Агваанчогдонгийн айлдварыг харвал Гандан хийдэд бүр өмнө нь шүтэж эхэлсэн байдаг. Дэчин Агваанчогдонгийн намтарт, "*Шүгдэн гэдэг маш хортой чөтгөр хүнд бууснаар шалтаглан хийх юмаа олж ядсан лам, хувилгаад хийд орондоо тахин Жанзэ ууланд (Шүгдэнгийн) сүм босгосныг зохисгүй гэж үзээд, <<Богд Зонховын үед ч Гандан хийдэд ертөнцийн эгэл тэнгэр, буг сэлтийг шүтэх журам байгаагүй. Хойшид ч гэсэн энэ мэт бугийг шүтэж болохгүй>> хэмээн хурлын дунд айлдаж, Жанзэ уулан дахь Шүгдэнгийн сүмийг нураалган чулууг нь чулуунд, шороог шороонд ялгасан*" хэмээн өгүүлдэг. Түүнчлэн Пүржог Агваанжамба "*Гандангийн Гарчиг*" номондоо: "*Богд Зонхов, өөрийг нь багаас нь сахидаг байсан нутгийнхаа савдаг Мачинг хүртэл хийдийн гадна байлгадаг байсан. Гэтэл одоо цагт лам хувцас өмсөж, өөрийгөө Богд Зонховын шавь хэмээн хөөрөмшсөн зарим нэгэн муу чөтгөр Дорж Шүгдэнд аврал одуулж байна. Тэдгээр хүмүүст хүсээгүй зүйл нь тохиолдоно*" гэж бичсэн байдаг. Эндээс үзвэл Гүнтан Ринбүүчи,

*Одоо цагт Богд Ламын шашин ариун байгаа ч*
*Цөвт мунхгийн тоосоор бүрхэгдсэн*
*Олон буруу буяны садан нугууд*
*Хүмүүсийг аймшигт халил газарт хөтөлнө* хэмээн Шүгдэнгийн тухай айлдсан ч байж болох юм. Урьдын түүхтэй холбоод сайн шинжилж үзвэл энэ бүхэн тодорхой болно.

Павонка Ринбүүчи нас сүүдэр дээр гараад Шүгдэнг шүтэж эхэлсэн байдаг. "Павонка Ринбүүчи залуудаа Чүсан ууланд Дамдин-Янсан Бурханы бясалгалд сууж, улаан үрэл олныг хийдэг байсан" тухай Тижан Ринбүүчи надад айлдаж байсан. Шүгдэнг шүтэж эхэлснээсээ хойш "Дамдин-Янсан Нинмавын Бурхан тул Богд Ламын чуулганы орны дотор зурах нь зохисгүй" хэмээн таалах болсон нь Павонка Ринбүүчийн намтарт тодорхой гардаг. Павонка Ринбүүчи залуудаа Төвдөд дэлгэрсэн Бурханы шашны бүх урсгалыг ялгалгүй анхааран авдаг байсан төдийгүй Нинмавын шашны "*Агуу Нууц"* (Санва Жажин) номыг үздэг байсан. Түүгээр ч үл барам дан ганц Нинмавын ном болох "*Хүслийг Хангагч Сайн Бумба"* (Доджой Бумсан)-г судлах бодолтой байсан гэдэг. Гэвч энэ үед Павонка Ринбүүчийд Шүгдэнгийн ёр гарсан тухай "Пагод Ламын Шаллүн" номд тодорхой өгүүлдэг. Ринбүүчи Шүгдэнг шүтэж эхэлснээсээ хойш Нинмавын шашныг цээрлэдэг болсон. XIII Далай Лам Павонка Ринбүүчийг анх ном эрдэмтэй хүн хэмээн ихэд таалдаг байсан. Тэр үед Мэрү хийдэд Богд Ламын суудалд сууж буй Гандан Ширээт лам л айлддаг байсан хаврын номыг Павонка Ринбүүчигээр айлдуулах гэхчлэн ихэд хүндэлдэг байв. Харин нас дээр гарсан хойно нь зэмлэх болсон. Үүнийг зарим нь атаархсандаа гэдэг ч үнэн хэрэгтээ Шүгдэнг шүтсэн учраас ингэх болсон юм. Шүгдэнг шүтсэн нь Павонка Ринбүүчийд тустай байгаагүй.

Зарим хүмүүс Павонка Ринбүүчи болон түүний шавь Тижан Ринбүүчи хоёрыг Шүгдэн шүтсэнээр нь шалтаглан "Шүгдэнг шүтсэн нь хоёр ламын зохиол үйлсийнх нь эрхэм байсан. Тиймээс Шүгдэнг шүтэх нь маш чухал" гэж ярьдаг. Энэ нь дэмий яриа юм. Павонка Ринбүүчийн зохиолуудыг уншвал тэрээр үнэхээр бодь мөрийн зэргийн их бясалгаач байсан гэдгийг мэдэх болно. Тижан Ринбүүчи багш маань ч мөн адил бодь мөрийн зэргийн эзэн хүн байсан. Би Тижан Ринбүүчи багшаараа бодь мөрийн зэргийн олон хөтөлбөр номыг заалгасан. Мөрийн зэргийг заах нь бусдаас үнэхээр онцгой. Илүүтэйгээр багш маань Дэмчиг Бурханы их бясалгаач байсан. Павонка Ринбүүчи болон Тижан Ринбүүчи хоёрын зохиол үйлсийн эрхэм нь бодь мөрийн зэрэг, Дэмчиг

Бурханы бясалгал анхааран авлага байсан болохоос биш Шүгдэнг шүтсэн нь зохиол үйлсийнх нь эрхэм байгаагүй юм шүү!

Би өмнө нь энэ тухай ярьж байсан. Дээдэс багш нарын зохиол үйлс нийт Бурханы шашны ёстой таарахгүй бол хэрхэн үйлдэх тухай Богд Зонхов бээр "*Их Бодь Мөрийн Зэрэг*" номдоо ийн айлдсан байдаг: "*Орхигдохууныг гол номтой тулган үз. Гол номыг хэзээ ч бүү орхи*". Би энэ айлдварыг дагадаг. Зарим нэгний тусгай увдис гэсэнд огтхон ч гайхдаггүй. Нагаржунай болон Асанга нараас илүү увдис номд боловсорсон хэн байна? Тэдгээрийн заагаагүй увдисыг гаргаж ирвэл сайны ёр уу? Муугийн ёр уу? Бодох л хэрэгтэй. Увдис номын гарвал эцэстээ Бурхан Багшид тулдаг. Бурхан Багшаас илүү увдисыг заагч үгүй. Бурхан Багшийн айлдсан увдисаас өөр илүү эрхэм увдис үзүүлнэ гэдэг боломжгүй зүйл. Судар тарнийн утгыг амар хялбараар ухааруулах аргыг увдис гэдэг. Жишээлбэл Майдарын Гэгээний зохиосон "*Илт Онохуйн Чимэг*" шастир нь судрын утгыг амар хялбараар ойлгуулдаг тул увдис юм. Хэрвээ судар, тарнийн утгаас өөр зүйлийг заасан бол түүнийг увдис гэхгүй.

Шүгдэнг хэн хэзээ шарын шашны сахиус гэж нэрлэв? Эрдэм чадал олсон дээдэс нараас хэн нь хэдий үед Шүгдэнг шарын шашны сахиусанд тушаав? Шинжлэх хэрэгтэй. Павонка Ринбүүчи лав тушаагаагүй. Өөр дээр нь улаан гараа далайн ирэхэд эмээн, судалж байсан номоо (Нинмавын ном болох "*Хүслийг Хангагч Сайн бумба*" /Доджой Бумсан/) орхисон нь яав ч сайн хэрэг биш. Рижаа Ринбүүчийн урьд дүр Шүгдэнг хүчтэй шүтдэг байсан. Тэр үед би ч гэсэн шүтдэг байсан. Ринбүүчи нэг удаа надад Шүгдэнгийн тухай уулга алдан: "*Энэ сахиус бусдаас нэг л өөр. Хувилгаад, гэвш нарын дундаас аль сайнууд нь шүтэх юм*" гэж хэлж байсан. Сүүлд Лавран хийд Шүгдэнг шүтэхээ больсны хойно, хийдийн чанзав ламаас "Рижаа Ринбүүчи багадаа Шүгдэнгийн хорлолоос болж өвдөөд, айсандаа шүтдэг болсныг" мэдэж билээ. Үнэхээр арга мухардсан хэрэг. Ертөнцийн тэнгэр зэргийг сүрээр дарж, дуудан ирүүлээд, ам өчгийг нь авч шашны сахиус болгон тушаадаг болохоос биш түүнээсээ айж сүрдээд номын сахиус гэж шүтэж болох уу

даа?

Шүгдэнг Богд Ламын шашны сахиус гэж хэн хэдийд тушаав? Богд Ламын суудалд сууж байсан Гандан Ширээт лам нар тушаагаагүй. Өмнөх дүрийн Далай Лам нар болон Ванчин Богд нар тушаагаагүй. Доод Амдугийн Дашчэлин хийдийн Гүнчэн Ламын дүрүүд ч тушаагаагүй. Гүнбүм хийдийн Донхор хувилгаад ч тушаагаагүй. Миний ах Дагцэр Ринбүүчи Гүнбүм хийдийн хамба ламаар олон жил суухдаа Шүгдэн гэдэг нэрийг ч сонсоогүй гэж хэлж байсан. Ямартай ч Шүгдэнгийн гарал ариун бус, анхнаасаа шашны сахиус гэж гарч ирээгүй нь тодорхой.

Тижан Ринбүүчийн тухай нэг түүх өгүүлье. Үүнийг Тижан Ринбүүчи багш өөрөө надад айлдсан юм. Гармаба Ринбүүчийн урьд дүр, Тижан Ринбүүчи хоёр дотнын нөхөд байсан. Нэгэн удаа Тижан Ринбүүчийн өргөөнд Гармаба Ринбүүчи гэнэт морилон ирж. Гармабааг морилсны маргааш Тижан Ринбүүчи надад, "Өчигдөр Гармаба Ринбүүчи гэнэт морилоод намайг сандаргаад" гэж айлдахад нь би "Та яагаад сандарсан юм бэ?" гэж асуухад Тижан Ринбүүчи, "Өчигдөр би Шүгдэнг тахих гээд балин тахилаа бэлдчихсэн сууж байтал гэнэт <<Гармаба морилж байна>> гэхээр нь балин тахилаа хурдан хураах хэрэгтэй болоод. Учир нь Гармаба Ринбүүчи Шүгдэнг таалдаггүй" гэж айлдаж байсан. Ингээд бодоход шарын шашны сахиусаа Гаржүдбын хувилгаанаас нуусан нь арга мухардсан хэрэг. Нуух хэрэгтэй билүү? Шарын шашинд Зургаан Мутарт Махгал, Дамжан-Чойжал зэрэг сахиуснууд байдаг. Гармабааг морилох үед Зургаан Мутарт Махгалыг тахиж байсан бол хамтдаа суугаад магтаал сэржмийг нь унших байсан.

Гармаба Дамжан-Чойжал сахиусыг таалдаг байсан эсэхийг мэдэхгүй юм. Дамжан-Чойжал сахиусыг "адгуусан толгойтой" гэж муулсан Нинмавын шүтлэгтний тухай дээр үеийн түүх байдаг: Ямандагийн бясалгаач Ала Жигмэдсамданг нямба бүтээлээ хийж байхад Рэвгон нутгийн Жавуу хэмээгч бүтээлчин хараал хийсэн гэдэг. Ала Жигмэдсамдан Ямандагийн хатуу үйлээр хариулга үйлдсэнд Жавуугийн шавь зүүдэндээ "багш нь мориндоо мордох зуур малгайг нь хэрээ зуун нисэхийг" үзээд багшдаа зүүдээ

айлтгасанд багш нь, “Шарын зүгээс хариулга хийсний шинж байна. Гэсэн ч миний сахиус Гүр Гомбыг бөхийлгөж чадахгүй. Адгуусан толгойтой сахиус намайг яаж дийлэх юм?” гэжээ. Удалгүй Рэвгоны Жавуу адгуусан толгойтой сахиусанд дэлсүүлж, цаг бусын үхлээр үхсэн гэдэг. Энэ түүхийг ярьснаараа би юуг хэлэх гэсэн бэ гэвэл, “Шарын шашинтан хэн ч бай өөрийн сахиусаа Гаржүдба, Нинмава, Сажава гээд хэний ч өмнө үзүүлэхдээ нүүр бардам байх хэрэгтэйгээс биш ум хумгүй нуух нь ичгүүртэй хэрэг шүү!” гэж хэлэх гэсэн юм.

Павонка Ринбүүчи Шүгдэнг шүтэхийг дэлгэрүүлж байсан. Түүнчлэн Тижан Ринбүүчи, Сон Ринбүүчи нар ч дэлгэрүүлж байсан. Энэ нь Шарын шашинд тустай байгаагүй. Шүгдэн шүтэхийг дэлгэрүүлснээс хойш Үй, Зан, Хам нутагт Шарын шашныг муулагч, дургүй хүмүүс олон болсон. Эш, онолын шашныг номлол бүтээлийн үүднээс арвитгахад Шүгдэн ингэж, ингэж тусалсан гээд заачихмаар юу ч гараагүй. Хэрэв тустай зүйл гарсан бол Брайбүн хийдийн хувилгаан Дэнма Лочой Ринбүүчийн урьд дүр, Буяны садан Донбон зэрэг Богд Ламын шашныг номлол, бүтээлийн үүднээс баригч дээдсүүд Шүгдэнг сайшаах ёстой байсан. Гэтэл харин ч эсрэгээр Шүгдэнг шүтэхийг хориглосон байдаг. Мөн Шүгдэнг шүтдэггүй лам нарын эрдэм ном суларч, сахил санваар нь доройтоод, Шүгдэнг шүтдэг лам нарын эрдэм ном дээшилж, сахил санваар нь ариун байсан гэх түүх ч алга. Ямартай ч Павонка Ринбүүчи, Тижан Ринбүүчи хоёр Шүгдэнг шүтсэн нь алдаа байсан. Шүгдэнг шүтсэн нь нийт Бурханы шашны ёстой зохилдоогүй. Энэ алдаагаар нь шалтаглан хоёр Их багшийн Бурханы шашин хийгээд ялгамжаатай Богд Зонховын таалалтай зохилдсон бодь мөрийн зэрэг, нууц тарни, Дэмчиг, Хажидын номын аймгийг агуу ихээр номлон дэлгэрүүлж, тэтгэж байсныг “буруу байсан, алдаа байсан” гэж хэн эсэргүүцэж чадах. Хоёр Их багшийн зарлигийн ач үнэхээр их юм шүү!

Ловон Сэнгээсамбуугийн зохиол *“Утгыг Тодруулагч Тайлбар”* (Дэлва Донсэл) шастирт: “*Амьтны тусыг үйлдэгч Ловон Егнин өөрийн бодлыг гол болгож Илт Онохуйн Чимэг шастирын утгыг Сэтгэл төдийтний үзлээр тайлбарласныг*

*Хутагт Намдолдэ бээр буруу хэмээн үзэн Төв үзлийн ёсоор тайлбарласан"* хэмээн өгүүлдэг. Хутагт Намдолдэ бээр Төв үзлээр л утга нь тайлагдах "*Илт Онохуйн Чимэг"* шастирын утгыг Сэтгэл төдийтний үзэлд тохируулан тайлбарласан өөрийн багш Ловон Егнингийн тайлбарыг буруу гэж үзээд "*Илт Онохуйн Чимэг"* шастирын утгыг Төв үзлийн ёсоор сайтар тайлбарласан. Үүгээр нь шалтаглан Хутагт Намдолдээг багшийг шүтэх ёсондоо алдаа гаргасан гэж хэлж болох уу? Хутагт Намдолдэ өөрийн багш Егнингээ хүндлээгүй гэж хэлж болох уу? Түүнчлэн Адиша Богд төв үзэлтэн хэдий ч өөрийн язгуурын багш сэтгэл төдийтний үзэлтэй Сэрлинбааг шүтэн байж бодийн дээд сэтгэлийг таалалдаа үүсгэсэн. Сэрлинба "Чиний төв үзэл баримталдаг чинь буруу шүү" хэмээн айлдах бүрд Адиша Богдын төв үзэл улам бүр батжиж байсан гэдэг. Шалгадаг ухаанд мэргэн Ловон Чоглан, түүний шавь Ловон Ванчүгдэ, түүний шавь Ловон Чойдаг. Ловон Чоглангийн зохиол "*Шалгадаг бүхнээс хураахуй"* (Цадма Гүнлэй Дүйба) хэмээх шастирыг Ловон Чойдаг гурвантаа сонсоод өөрийн багш Ловон Ванчүгдэгийн шалгадаг ухааны талаарх үзэл баримтлал буруу болохыг болгоож, зохиосон номлолд нь шүүмж зохиол бичсэн байдаг. Эдгээр мэргэд Бурханы шашныг хиргүй ариунаар хадгалж чадсан юм. Тиймээс өөрийн багш байсан ч хамаагүй Бурханы шашны таалалтай зохилдохгүй номлол гаргавал засаж, залруулах хэрэгтэй. Шавынхаа хэмжээнд тааруулаад номлосон ч бай, хэргийн тухайд номлосон ч бай ялгаагүй, буруу л номлол бол засаж залруулдаг нь мэргэдийн авир ёс. Тэгж байж л Бурханы шашныг доройтуулалгүй хадгалж үлддэг.

Гүнтан Ринбүүчи бээр:

"*Аяа, Шарын шашин үүний*
*Цог учрал ихэд арвидсан ч*
*Номлол, бүтээл багассаныг бодохоор*
*Зүрхний угаас уйтгар төрнө.*
*Эдүгээ цагт гүн дэлгэр номын утгыг*
*Эндүүрэлгүй сайтар номлогч нь ховор ч*
*Эндүүрлээс хагацсан таны зарлигийн ботиуд*
*Энэлгээг арилган сэтгэлийг сэргээх өглөгийн дээд"* хэмээн

айлдсан байдаг. Богд Зонхов бээр алжаал бэрхшээлийг үл хайхран, туйлшралын халилд уналгүйгээр сонсох, санах, бясалгах гурвыг үйлдэн байж Бурхан Багшийн тааллын утгыг эндүүрэлгүйгээр болгоосон. Ямар мэт болгоосноо шалгадаг ухаанаар нотлон буулгаад номлосон номлолыг нь бид нар л үзэхгүй байгаа болохоос биш сурвал сурч болохоор, утгыг нь санавал санаж болохоор, дадуулан бясалгавал бясалгаж болохоор номлосон номлол нь үнэхээр *энэлгээг арилган, сэтгэлийг сэргээх өглөгийн дээд* гэлтэй.

Кансар Доржчан жил бүрийн өвөл Жагсам ууланд морилж, Богд Зонховын бүх зохиол бүтээлүүдийг нягтлан үздэг байсан гэдэг. Үнэхээр биширмээр. Бид нар Богд Зонховын зохиол бүтээлүүдээс ганц хоёрыг нь л үздэг болохоос биш бүгдийг нь үзэж, судалдаггүй. Миний хувьд бүгдийг нь унших боломж ганц л удаа гарч байсан. Дахин бүгдийг нь унших боломж гараагүй. “Богд Зонховын 18 боть зохиолын эзэн нь байж чадвал Шарын шашны эзэн нь болж чадна” гэж би үргэлж хэлдэг.

Брайбүн хийдийн Буяны их садан Донбон бээр хийддээ Жодын номыг хориглож байсныг би зөв гэж боддог. Тэр үед Жодын номд суралцсан түүний зарим шавь нарт тус эрдэм гарч байсан. Жодын ном нь билэг брамидийн анхааран авлага ч мөн. Тус эрдэм нь ч санаанд багташгүй. Миний багш Лин Ринбүүчи Павонка Ринбүүчигээс Жодын номыг сонссон боловч чухам ямар номын хөтөлбөрөөр сонссоноо мартсан байсан тул надад дамжлагыг нь хайрлаагүй юм. “*Жод нь гайхамшигтай ном мөн боловч, тэр үед Брайбүн хийдэд Жодын номын ая дан, хонх дамар хаа сайгүй дуугараад ном үзэхэд саадтай болсон тул Донбон багш хийддээ Жодын номыг хориглосон.”* хэмээн Брайбүн хийдийн багш Нямаа хэлж байсан. Энэ нь ч цаана учиртай. Шарын шашинтан хүн Богд Зонховын 18 боть зохиолыг орхиод өөр увдис хайхын хэрэг байхгүй. Дээр үед Шарын шашинтан дотор, тодруулбал Жүмэ хийдийн зарим хуврагууд Сандуй, Дэмчиг, Жигжид гурвын зан үйлд суралцаад бурхан болох нууц мөрийн тухай ойлголт авч чадалгүй Хажидын номыг голлон үзэх болсон гэдэг. Хажидын ном чухал уу гэвэл чухал. Гэсэн хэдий ч Бурханы шашны аньс, шим бүхнийг хураасан Богд Зонховын

18 боть бидний амин зүрх мөн тул тэдгээрийг аль чадахаараа сонсож, санаж, бясалгах нь чухал юм шүү. Би үүнийг урьд нь ч хэлж байсан. Одоо ч гэсэн хэлье.

Өнгөрсөн 300 гаруй жилийн түүхийг судлаад би Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг мэдсэн. Улмаар Шүгдэнг шүтэхийг хориглосон. Зарим хүмүүс "Далай багшийн зарлигийг дагах хэрэгтэй", "Далай багшийн зарлигийг ёсчлон биелүүлэх хэрэгтэй" гэж ярьдаг. Далай Ламын зарлигийг ёсчлон биелүүлэхгүй бол дээрээс сэлэм бууж ирэх юм шиг хандаж хэрхэвч болохгүй. Ардчилсан нийгмийн үзэл баримтлалтай таарахгүй. Бурхан шашны үзэл баримтлалтай ч харшилна. Энэ асуудалд хандахдаа шударга байх хэрэгтэй. Яагаад, юуны учир Далай Лам Шүгдэнг шүтэхийг хориглов? Цаад учир шалтгааныг нь судалж мэдэх хэрэгтэй. Тижан Ринбүүчи болон Сон Ринбүүчийг нэг талд нь тавиад, Шүгдэнг шүтэхийг хориглож байсан Пүржог Агваанжамба, Дэчин Агваанчогдон, Жанжаа Ролбийдорж, Ёнзон Ишжанцан, XIII Далай Лам нарыг нөгөө талд нь тавиад энэ асуудлыг нягтлан шинжлэх хэрэгтэй. Эргэлзэж тээнэгэлзээд яавал ч яаг гээд зөнд нь орхиж болохгүй.

Павонка Ринбүүчийн язгуурын багш Дагбу Лама Ринбүүчи Жамбаллхүндэвжамц Шүгдэнд сэржим мэтийг өргөдөг байсан ч чухалчлан шүтдэггүй байсан. Түүний нутагт баруун зүүн гэж нэрлэгддэг хоёр хийд байсны нэг нь Шүгдэнг тахидаг, Дагбу Лама Ринбүүчийн өөрийнх нь суудаг нөгөө хийдэд Шүгдэнг тахидаггүй байсан. Тэр үед Дагбу Ламын хийдэд Шүгдэнг тахих тухай яриа гарахад Ринбүүчи өөрөө, "Шүгдэнг хийдийн дотор байлгаж болохгүй" гэж айлдаад хийддээ тахиулаагүй гэдэг.

Нэг удаа би Найчүн сахиуснаас "*Дагпү Доржчан өөрийн амиа Шүгдэнд өргөхөд арилсан үзэгдэл үзэгдсэн гэдэг нь үнэн юм болов уу?*" гэж асуухад Найчүн сахиус, "*Багш болон Ядам Бурхадын адистидаар үзэгдэх арилсан үзэгдэл болон хорлол, барцад саадын эрхээр үзэгдэх арилсан үзэгдэл гэж хоёр байдаг. Дагпү Доржчанд хорлолын эрхээр арилсан үзэгдэл үзэгдсэн байх*" гэж хариулсан. "*Дагпү Доржчангийн шавь нартаа айлдсан номон дотор бөөгийн хэсэг ном байсныг Павонка Ринбүүчи зохиолуудыг нь шүүж байхдаа*

*ялгасан*” гэж Лин Ринбүүчи надад айлдаж байсан. Ингээд бодохоор Дагпү Доржчанд хорлол, барцдын эрхээр арилсан үзэгдэл үзэгдсэн гэдэг нь бараг тодорхой юм.

Эдгээр учир шалтгаануудыг сайн шинжлэх хэрэгтэй. 300 гаруй жилийн түүхтэй Төвдийн засгийн газар Гандан-Потаны тухай ярихаа больё. Төвдөд дэлгэрсэн Бурханы шашны урсгал бүрийг алагчаалалгүй анхааран авдаг байсан V Далай Лам Шүгдэнгийн гарлын тухай хэрхэн бичиж байсныг ч ярихаа больё. Богд Түвхан Гэлэгжамцын шавь нарын эрхэм, мөрийн зэргийн номлол бүтээлийн эзэн, эрдэм чадал нь санаанд багташгүй Пүржог Агваанжамба болон Богд Ламын шашныг баригч дээд төрөлхтөн Дэчин Агваанчогдон нар Шүгдэнгийн тухай ямар айлдвар айлдаж, ямар зарлиг гаргаж байсныг мэдэхэд л бүх зүйл тодорхой болно.

Та нар сонссон байх. Зарим хүмүүс “Далай Лам Шүгдэнг шүтэхийг хорьсноороо шашин шүтэх эрхийг хязгаарлаж байна” гэж хэлдэг. Үүнтэй холбогдуулан өөрт тохиолдож байсан нэг явдлыг яръя. Би Күнү Лама Данзанжанцангийн зохиол “*Бодь Сэтгэлийн Магтаал”*-ыг уншаад өөрийн эрхгүй сүжиг төрж, Күнү Лама Ринбүүчигээс “*Бодь Сэтгэлийн Магтаал”* номынх нь эш хөтөлбөрийг сонссон. Мөн үүнээс өөр 13 номлолын эш хөтөлбөрийг урьд нь Лин Ринбүүчигээр хөтлүүлж байснаасаа үргэлжлүүлэн Куну Лама Ринбүүчигээр заалгасан. Тэр үед Лин Ринбүүчийд “Куну Лама Ринбүүчигээр Нинмавын дамжлагын “*Тантрын Нууц Шим”* номыг заалгах хүсэлтэйгээ” айлтгахад Лин Ринбүүчи, “*Олон яриа гарах тул заалгаагүй нь дээр байх”* гэж айлдсан. Нинмавын номыг сонсвол надад Шүгдэнгийн хорлол ирнэ гэж эмээсэндээ Лин Ринбүүчи тэгж айлдсан юм. “*Тантрын Нууц Шим”* нь Бүдон Ринбүүчийн хянасан ганжуурын “За”, “Ва”, “Ша” ботиудад байдаг тантрын шилмэл номлолуудын нэг юм. Ийм номыг сонсох хүсэлтэй байхад минь Лин Ринбүүчи “Олон яриа гарах тул заалгаагүй нь дээр байх” гэж айлдсан нь Шүгдэнгээс болсон хэрэг. Миний шашин шүтэх эрхийг Шүгдэн ингэж булааж байсан юм.

Тэр үеэс хойш би Шүгдэнг шүтэж болох уу, болохгүй

юу гэдгийг удаан хугацааны турш шинжилсэн. Эцэст нь гурилаар шинжиж үзээд (мэргэлээд) шүтэхээ больсон. Түүнээс хойш Төвдөд дэлгэрсэн Бурханы шашны олон урсгалын номыг чөлөөтэй судлах эрхтэй болсон. Гурилаар шинждэг тухай та нар дуулсан байх. V Далай Лам таалал барах гээд амьсгаа нь тасарсан байх үед Дэсрид Санжайжамц өмнө нь мөргөн, “Поталын ордныг барьж гүйцээгүй байна. Өөр шийдээгүй олон зүйл байна. Таныг таалал барчихвал би ганцаар юу хийж чадах?” хэмээн уйлан дуудахад V Далай Ламын тасраад байсан амьсгал сэргэж Дэсрид Санжайжамцад “*Бага зэргийн хэргийг чи өөрийн ухаанаар шийд. Их хэргийг Балдан Лхамын хөргийн өмнө гурилаар шинжээд шийдэж бай.”* хэмээн гэрээсэлсэн гэдэг. Тиймээс гурилаар шинжихийг их чухалчилдаг. Цаст Төвдийн орныг болгоогч Жанрайсиг Бурхан буюу Зуугийн гол шүтээний нэг Вадисамбуугийн дүрийг голд нь залаад урд нь II Далай Лам Гэндэнжамцын үеэс дамжигдаж ирсэн Балдан Лхамын хөргийг залдаг. Ингэж шинжихдээ би Лин Ринбүүчи багшаа залсан. Тэр үед Тижан Ринбүүчи багш маань Дарамсалад байгаагүй. Байсан бол залах байсан. Найчүн сахиусыг ч мөн залсан. Лин Ринбүүчи багш маань миний аврал айлтгах орон болсон хүн. Вадисамбуу бол Цаст Төвдийг болгоогч Жанрайсигийн дүр. Балдан Лхам бол Далай Ламын эхтэй адил. Анхдугаар Далай Ламаас авахуулаад бүх Далай Лам нарын гол сахиус байсан. Найчүн сахиус бол Төвдийн засгийн газар Гандан-Потаны сахиус. Тэдгээрийн өмнө залбирал үйлдэн чухал хэрэг шийдэх болсноо айлтгаад шинжсэн. Дан ганц багшийнхаа өмнө биш, ганц сахиусны өмнө ч биш, Багш, Ядам, Номын сахиус бүгдийн өмнө шинжээд шийдсэн. Үүнээс хойш би Пүрэвийн авшиг зэрэг Нинмавын шашны олон номыг сонсох эрхтэй болсон. Бусдын шашин ном шүтэх эрхийг боогдуулж байсан Шүгдэнг шүтэхийг хориглосноороо би шашин шүтэх эрхээ жинхэнэ утгаар олсон юм.

“Шүгдэнг шүтэхийг хориглосон шийдвэр маань бусдын шашин ном шүтэх эрхийг хязгаарласан уу?” гэвэл, Шүгдэнг шүтэж буй хүмүүс буруу ерөөлийн эрхээр тангараг буруудсан буг чөтгөр шүтэж байгаа учраас энэ нь ямар ч

шашин номын үйл болохгүй. Тиймээс шашин ном шүтэх эрхтэй огтхон ч хамаагүй. Шүгдэнг шүтэх нь буян номыг доройтуулах буруу номын үйл. Ертөнцийн эгэл тэнгэр, лус, савдаг, буг чөтгөрийг тахин шүтэх нь буян номын үйл огтхон ч биш. Бид нар Бурханы шашинтай хүмүүс. Бурхан, Ном, Хувраг гурвыг авралд барьдаг хүмүүс ертөнцийн эгэл тэнгэр зэргийг авралд барьж болохгүй. Хэрвээ ертөнцийн эгэл тэнгэр зэрэгт ажил үйлсээ даатгаж байгаа бол даатгаж болохуйц нэгэнд даатгах хэрэгтэй. Өмнө хэлсэнчлэн, эрдэм чадлын оргилд хүрсэн дээд төрөлхтөн бээр ам өчгийг нь аваад номын сахиусанд тушаасан ертөнцийн тэнгэр сахиусанд үйлсээ даатгах хэрэгтэй болохоос биш буг чөтгөрт ажил үйлсээ даатгаад, тахиж шүтэх нь буян номын үйл огтхон ч биш. Эдгээрийг сайн бодвол Шүгдэнгийн тухай асуудал шашин ном шүтэх эрхтэй ямар ч холбоогүйг ойлгоно. Гэсэн хэдий ч мэдсээр байж үүнээс зөрөөд Шүгдэнг шүтэж байгаа бол би хориглохгүй. Энэ бол хувь хүний хэрэг. Ямар тэнгэр сахиус шүтэх нь хувь хүний хэрэг. Учирлаж хэлсээр байхад сонсохгүй, хилэнц уруу нүдээ аниад орж байгаа хүмүүст миний зүгээс хэлэх зүйл байхгүй. “Хэлэх үгээ хэлсэн. Сонсох сонсохгүй нь таны дур” гэж би үргэлж хэлдэг. Магадгүй та нар дунд Шүгдэнгийн тухай сайн мэдэхгүй хүн байгаа байх. Далай Ламын нүүрийг харахаараа шүтдэггүй хүн шиг царайлж, санааныхаа мухарт шүтдэг хүн ч байж болох. Цаад учир шалтгааныг нь мэдэхгүй “Далай багшийн айлдвар”, “Далай Ламын зарлиг” гэж ярих нь тэнэг хүний яриа шүү!

“Төвдийн шашны урсгалууд өөр өөрсдийн хурлаа хийхдээ бусад урсгалын төлөөллүүдийг урьж оролцуулж байвал сайн” гэж би хэдэн жилийн өмнөөс хэлж байсан. Үүний хэрэг тус нь ч гарч байна. Бидний хэнд нь ч гэсэн далд хуралдах учир байхгүй. Бүгд ил тод байж, сайжруулж, хөгжүүлэх хэрэгтэй зүйлээ хамтдаа зөвшилцөж шийдэж байх хэрэгтэй. Анхдугаар хурал дээр зарим нэг хүн “Төвдөд дэлгэрсэн Бурханы шашны урсгалуудыг нэгтгэж Шарын шашны гэсэн нэг урсгал болгох хэрэгтэй” гэж ярьж байсан. Түүнчлэн Төвдөөс Энэтхэгт цагаачилж ирсэн хүмүүсийн ихэнх нь Үй-Зан аймгийнхан. Амду болон Хам нутгаас

цөөхөн хүн байдгаас болж цөөнх нь олонхдоо дургүйцдэг явдал гардаг. Шашин төрийн ямар ч хурал байсан ил тодоор хуралдаж, асуудлаа шийдэж байх нь чухал. Өнөөдрийн энэ хурал дээр бусад урсгалуудын төлөөллүүд ирсэнд би маш их баяртай байна. Та нар хэд хоног энэ хурлын үйл явцыг ажиглаж, гэрчээр суувал сайн байна.

# 2001 оны 8-р сарын 2-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Өмнөд Энэтхэг дэх Сэра-Мэ дацанд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Гандан-Шарзэ болон Сэра-Мэ дацанд Шүгдэнг шүтдэг лам нар байдаг учраас энэ тухай бага зэрэг яръя гэж бодлоо. Төвдийн ард түмний ихэнх нь Шүгдэнг шүтэхийг хориглосон миний шийдвэрийг дагаж, шүтэхээ больсон. Түүнчлэн Сэра-Мэ дацангийн ихэнх лам нар шүтэхээ больж, бид нар хоорондын багш шавийн тангараг ариун болсон. Гэвч Сэра-Мэ дацангийн Бомра аймгийн цөөн хэсэг лам Шүгдэнг өнөөг хүртэл шүтсээр байна. Шүгдэнг шүтэж буй хүмүүсийг ажаад байхад сайн сайхан явж, жаргаад байгаа зүйл ерөөсөө ажиглагддаггүй. Шүгдэнг тахиж шүтдэг Төвдийн зарим нутгаас Энэтхэгт шинээр цагаачилж ирсэн лам нар энд байгаа байх. Тэдгээр хүмүүс энэ асуудлыг тодорхой мэдэх хэрэгтэй. Та нар амь насанд халтай олон бэрхшээлийг даван туулж Энэтхэгт ирсэн. Энд эрдэм номд суралцахаар ирсэн болохоос биш тэнгэр, лус, буг тахин шүтэх гэж ирээгүй. Хэдхэн жилийн өмнө Төвдөөс лам хувцастай цагаачилж ирсэн Шүгдэнгийн бүлэглэлийн хэсэг хүмүүсийн гарт Цанидын сургуулийн багш хоёр шавийн хамт амь үрэгдсэн. Хүн алсан нь үнэхээр ичгүүр, сонжуургүй явдал. Шүгдэнг шүтдэг зарим хүмүүс намайг Тижан Ринбүүчи багшдаа сүжиггүй, багшийг шүтэх ёсоо буруудуулсан гэдэг. Би 6 настайгаасаа эхлэн Тижан Ринбүүчи багшийг таалал барах хүртэл нь шүтсэн. Тижан Ринбүүчи багш маань миний хувьд санаанд багташгүй их ачтай хүн. Багшийгаа би хэнээс ч илүү мэднэ. Миний бодол санаа, юу хийх гэж буйг маань ч Тижан Ринбүүчи багш

маань сайн мэддэг байсан. Намайг буруутгадаг хүмүүсийн ихэнх нь Тижан Ринбүүчи багштай нүүр учирч, ном заалгаж байгаагүй. Тэд хүмүүсийн толгойг эргүүлж буруу зүйлд ашиглахын тулд янз бүрийн л юм ярьдаг.

Шүгдэнгийн энэ асуудал V Далай Ламын үеэс эхэлсэн. V Далай Лам Шүгдэнг "ерөөл буруудсан тангаргийн буг" гэдгийг танин мэдээд хүчийг нь дарахын тулд жинсрэг цутгаж хатуу үйл үйлдсэн байдаг. Түүнчлэн номлол бүтээлийн эрдэм чадал агуу ихийг олсон мэргэд, дээд төрөлхтөн нар ч Шүгдэнг шүтэхийг хүчтэй хориглож байсныг хуучны ном судрыг нягталж үзвэл тодорхой мэдэж болно. XIII Далай Лам Шүгдэнг шүтэхийг хориглодог байсан. Би ч гэсэн жил дараалан нарийн судалгаа хийсний үндсэн дээр Шүгдэнг шүтэхийг хориглосон. Надад эрдэм чадал байхгүй ч өмнөх Далай Лам нарын дүр учраас энэ шийдвэрт маань өмнөх Далай Лам нарын дэмжлэг байгаа гэж боддог. Тиймээс би эцсээ хүртэл Шүгдэнг хориглосоор байна.

Та нар их үйл хэрэг бүтээх болбоос Богд Зонхов бээр сахисанд тушаасан гурван сахиусанд үйлсээ даатгаж, соёрхол тавьж бай. Тэдэнд бүтээж чадахгүй зүйл гэж байхгүй. Харин бага хэрэг бол хийдийнхээ сахиусанд даатгаж байх хэрэгтэй.

# 2002 оны 12-р сарын 2-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Өмнөд Энэтхэг дэх Бялакуппэгийн төвд суурингийн ард иргэдэд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Өчигдөр Шүгдэнгийн тухай цухас ярьсан. Далай Лам яагаад Шүгдэнг шүтэхийг хориглох болсныг та бүхэн мэдэх хэрэгтэй. Энэ маш чухал. "Далай Лам Шүгдэнг шүтэхийг хориглосон нь буруу" гээд намайг хэчнээн буруутгаж эсэргүүцсэн ч би шийдвэрээсээ буцахгүй. Нийт Төвдийн ард түмэн болон Бурханы шашны тусын тулд би Шүгдэнг шүтэхийг хориглосон. Хэн ч харсан гэм халдааж үл чадах Зөөлөн Итгэлт Ламын (Богд Зонхов) хир үгүй ариун шашин өмнө нь ямар байсан тэр чигээрээ оршиж байгаасай гэсэндээ би Шүгдэнг шүтэхийг хориглосон. Хориглох болсон нэг шалтгаан нь энэ юм.

Өмнө нь би өөрөө Шүгдэнг шүтдэг байсан. Хожим аажим аажмаар судалж үзэхэд бодит байдал тодорхой болсон. Шүгдэнг шүтэх нь нийт Бурханы шашин болон илүүтэйгээр Богд Лам, түүний шавь нарын таалалтай нийцдэггүй. Шүгдэн бол хүн бус, тангараг доройтсон буг. Түүнийг шүтдэг хүмүүс энэ насандаа сайн сайхан явах нь бэрх. Хойд төрөлдөө ч буг чөтгөр түүний нөхөр болж төрөх гэмтэй. Ер нь ягчис, албин чөтгөр зэргийг хүчтэй тахин шүтдэг хүмүүс хойд төрөлдөө урьд шүтэж байсан ягчисынхаа албат боол албин чөтгөр болж төрдөг.

Бурханы шашны сахиус, ялгамжаатай Богд Зонховын зарлигийн сахиус Зургаан Мутарт Махгал, Дамжан-Чойжал, Лайжи-Шинжэ зэрэг ертөнцөөс гэтэлсэн сахиусыг шүтвэл хуурмаггүй. Зургаан Мутарт Махгал гэхэд энэ насны барцад

саадыг арилгаад хойд төрөлд нь гэгээрлийн замд татаж чаддаг. Энэ адилын сахиусыг шүтэх хэрэгтэй болохоос биш энэ насны эд хөрөнгийг арвижуулдаг гэж итгэн буг чөтгөр шүтээд эцэстээ түүнийхээ боол нь болж төрөх үйлийг хураавал яав ч сайн биш.

Шүгдэнг шүтэхийг хориглохдоо би өнгөрсөн 300 гаруй жилийн түүхийг судалж, маш нарын шинжилгээ хийсний үндсэн дээр энэ шийдвэрийг гаргасан. Түүнээс биш ингээд хориглочихвол надад ийм ийм ашиг тус гарна гээд өөрийн сайн сайхны тулд энэ шийдвэрийг гаргаагүй. Ийм шийдвэр гаргавал олон хүмүүсийн хувьд амаргүй болно гэдгийг би мэдэж байсан. Гэвч Төвдийн шашин төрийн хэргийг үүрч байгаа учир "нийт Бурханы шашин хийгээд ялгамжаатай Богд Ламын шашин хиргүй ариун байгаасай" гэсэндээ энэ шийдвэрийг гаргасан. Миний үгийг сонсох сонсохгүй нь хувь хүний хэрэг. Надад энэ шийдвэрээсээ буцах шалтгаан байхгүй. Та бүхэн "Шүгдэнг шүтсэнээр Бурханы шашны байдал ямар болох уу? Бурханы шашинд ашиг тус гарах уу? Үгүй юу? Богд Ламын шашинд тустай байх уу? Үгүй юу? Өөрт ашиг тус гарах уу? Үгүй юу?" гэдгийг мэдэх хэрэгтэй. Шүгдэнг шүтэж байсан хувилгаадын хойд дүрүүдээс зохиол үйлс нь дэлгэрсэн сайн хүн гарна гэдэг бэрх. Нягтлан сайн шинжилбэл асуултын хариуг мэдэж чадна. Харин хэлгүй дүлий мэт хүчлэн шүтэж байгаа бол өөр хэрэг.

Ард иргэд, лам хувраг, илүүтэйгээр хийд орны хамба лам нарын дунд өмнө нь Шүгдэнг шүтэж байсан ч миний шийдвэрийг хүлээн авч, "Шүгдэнг шүтэх нь шашин амьтанд тусгүй" гэдгийг болгоож шүтэхээ больсон олон хүн байгаа. Тэдгээр хүмүүст "Маш их баярлалаа!" гэж хэлье. Түүнчлэн дацан, хийдүүдийн зүгээс их зүтгэл гарган шүтэхээ больсонд баярлаж байна. Мөн ард иргэд ч гэсэн миний энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрч, дэмжиж байгаад баярлалаа!

# 2002 оны 12 сарын 6-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Төвдийн засгийн газар Гандан-Потан байгуулагдсаны 360 жилийн ойн баярын арга хэмжээн дээр Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Өмнө ерөнхий сайдын хэлсэнчлэн Хамба Шиванцо, Хаан Тисрон Дэзан, Ловон Бадамжунай гурав хамт цугласан үеэсээ эхлэн Төвдийн шашин төр, тэнгэр хүмүүнийг тэтгэсээр ирсэн. Төвдийн засгийн газар Гандан-Потан, шашин төрийг тэтгэгч улаан, хар хоёр сахиус байдгийг та бүгд мэднэ. Миний хувьд Төвдийн засгийн газар Гандан-Потан болон улаан, хар хоёр сахиустай онцгой барилдлагатай. Ер шавь хүн тангараг ариун байх хэрэгтэйгээс гадна, тэнгэр сахиус ч мөн тангараг ариун байх хэрэгтэй. Энэ маш чухал.

Шашин амьтны тусын тулд би Шүгдэнг шүтэхийг хориглосон. Өмнө нь би өөрөө шүтдэг байсан. Хожим Шүгдэнтэй холбоотой олон бэрх асуудал тулгарч, улмаар сайтар шинжилж судалсны үндсэн дээр Шүгдэнг шүтэхийг хориглосон. Түүнээс биш хааш яаш, санаан зоргоороо энэ шийдвэрийг гаргаагүй. Энэ шийдвэрийг маань Брайбүн хийд болон Сэра-Жэ, Гандан-Жанзэ дацангууд хүлээн зөвшөөрч тус тусын хийд, дацандаа шүтэхийг хориглон, маш их хичээл зүтгэл гаргаж байсанд би их баярладаг. Гэвч өнөөг хүртэл Гандан-Шарзэ болон Сэра-Мэ дацанд Шүгдэнг шүтдэг лам нар байсаар байна. Тэдгээр хүмүүс сайтар бодох хэрэгтэй. Нийт төвдүүдийн хүчээр, ялангуяа засгийн газар Гандан-Потаны ачаар аж төрж буй нэгэн Гандан-Потаны эсрэг хэрүүл тэмцэл хийвэл тангараг буруудсан гэдгээ илтгэсэн хэрэг болно. Тиймээс та бүгд энэ тухай сайн бодоорой.

Мунхаглаж зөрөлгүй шударга оюуны үүднээс бодох нь маш чухал. Ингээд зүгээр мэлзэн суугаад байвал намайг шийдвэрээ өөрчилнө гэж бодож байгаа бол эндүүрэл шүү! Би энэ шийдвэрийг олон жил дараалан ил далдгүй шинжилж, учир шалтгааныг нь сайтар эргэцүүлж бодсоны эцэст гаргасан. Хоёр Ёнзон багшийгаа амьд сэрүүн байхад Шүгдэнгийн тухай учир байдлыг нарийвчлан айлтгаж, зөвшилцсөний үндсэн дээр энэ шийдвэрийг гаргасан. Лин Ринбүүчи багш маань зуун хувь дэмжсэн. Тижан Ринбүүчи багш маань Шүгдэнг сахиусанд шүтдэг байсан ч гурилаар шинжилж үзсэнийг минь болгоож “Гурилаар шинжихэд хуурмаг бууна гэж байх учиргүй. Үнэхээр нэг учир шалтгаан байгаа юм байна” гэж айлдсан. Зарим хүмүүс намайг энэ шийдвэрээ гаргахдаа “хоёр багштайгаа зөвлөөгүй, хоёр багшийгаа таалал барсны дараа шийдсэн”, эвсэл “бусдад зусардсандаа энэ шийдвэрийг гаргасан” гэж ярьдаг. Гэвч ч тийм биш. Та нар мэлзэн суулгүй бодит байдлыг нягтлан судалж, мэдэх хэрэгтэй.

“Төвдийн шашин төрийн тусын тухайд энэ шийдвэрийг гаргавал зарим хүмүүст таалагдахгүй байна” гэдгийг би мэдэж байсан. Гэвч надад Төвдийн ард түмэн, шашин төрийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага гэж байдаг учраас би энэ шийдвэрийг гаргасан. Энэ шийдвэрээсээ би хэзээ ч буцахгүй. “Хэрвээ Далай Ламыг эсэргүүцэн занал хийлбэл шийдвэрээ буцааж магадгүй” гэж бодож байвал эндүүрэл шүү!

Шүгдэнг шүтдэг зарим хүмүүс арга мухардахдаа ном товхимол гаргаж худал зүйл бичиж байна. Үнэндээ ингэх нь ямар ч тус байхгүй. Бичмээр байвал үнэн юм бичих хэрэгтэй. Худал хуурмаг юм яриад зогсохгүй өнгөрсөн жилүүдэд хүн алж, зодож нүдэн үймээн самуун гаргаж байв. Энэ нь ичгүүр сонжуургүй хэрэг болохоос биш Богд Ламын шашинд тусалж байгаа хэрэг огтхон ч биш. Тарааж буй ном товхимолд нь худал гүтгэлэг маш их байсан. Ингэснээрээ хүмүүсийн бодол санааг өөрчилнө гэж бодож байгаа бол том эндүүрэл. Зургаан сая Төвдийн 99 хувь нь үнэний хойноос дагахаас биш худал хуурмагийн хойноос дагах нь юу л бол. Тэдгээр хүмүүст хандаж хэлэхэд, та нар нийт төвдүүдээ дагавал сайн болохоос

биш үүнээс буцаад буруу замаар явж, цагаан хэрээ адил сууваас өөрсдөө зовохоос гадна энэ төрөлдөө ч сайн сайхан явахгүй. Хойд төрөлдөө ч тангараг доройтсон бугийн боол болж төрөх аюултай. Буруу ерөөлийн буг тахиж шүтээд үр дүнд нь түүнийхээ боол болж төрвөл яав ч сайхан байхгүй. Ерөөл буруудсан буг тахиж шүтэх нь Богд Ламын шашныг гутаахаас биш тусалж буй хэрэг огтхон ч биш. V Далай Лам шашин төрийг хослон барихаар таалж, засгийн газар Гандан-Потаныг байгуулсны 360 жилийн ойг баяртайгаар тэмдэглэх хирнээ, түүний "ерөөл буруудсан буг" гэж танин барьсан Шүгдэнг шүтээд суувал ичгүүртэй хэрэг биш гэж үү?

Шүгдэнгийн нийгэмлэгээс гаргаж буй ном товхимолд: "*Бидний хийх гол тэмцэл Төвдийн цагаачлалын төртэй биш, ардын зөвлөлийн хуралтай ч биш, V Далай Ламын байгуулсан засгийн газар Гандан-Потантай тэмцэнэ"* гэж бичсэн байсан. Энэ нь үнэний ортой юм. Бид энд Гандан-Потан байгуулагдсаны 360 жилийн ойг тэмдэглэж байна. Шүгдэнгийн нийгэмлэг V Далай Лам, түүний байгуулсан Гандан-Потантай тэмцэнэ гэдэг. "V Далай Ламын буруу, хувилгаан Дагважанцан ерөөл буруудсан тангаргийн буг чөтгөр болоогүй" гээд баримт нотолгоо гаргаж байгаа нь тэдний өөрсдийн хэрэг. Хар цагаан нь тодроод, нэг талдаа ялгарч байгаа нь сайн юм. Харин Далай Ламын нүүрийг үзэхээрээ тахиж шүтдэггүй дүр эсгээд үнэн хэрэгтээ тахиж шүтээд хоёр нүүр гарган явбал яав ч сайн хэрэг биш шүү! Миний зүгээс та бүхэнд өөр айлтгах зүйл алга аа. Баярлалаа!

# 2004 оны 1-р сарын 7-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Энэтхэг дэх Ориссагийн төвд суурингийн иргэдэд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Сайн ажиглах юм бол Төвдийн нийгэмд Бурханы ном үйлдэж байна гээд тэнгэр, лус тахих явдал их дэлгэрсэн байдаг. Өвдөж зовох үедээ “тэнгэр хорлосон байна, лус хорлосон байна” гээд тэнгэр, лус тахидаг. Зарим үед өчүүхэн хорлож болох ч, өвдөх үедээ эм, эмчилгээг голлож, биеэ сайн тордох хэрэгтэй болохоос биш тэнгэр, лус тахиснаар тус болохгүй. Нөгөө талаас тэнгэр, лус тахих хэтэрвэл аврал одуулахуйн сургаалтай харшилж нүгэл хураахаар үл барам чухаг дээд гуравт итгэх итгэлээ ч алдах гэмтэй. Ертөнцийн догшин тэнгэр, илүүтэйгээр ерөөл буруудсан тангаргийн буг Шүгдэн зэргийг тахиж шүтвэл энэ хойд нас болон өөр бусдыг гутамшигт хутгах муу үйлийг хураана. Авах гээхийг эндүүрэлгүйгээр тайлбарлаж таниулах нь миний үүрэг. Сонсох сонсохгүй нь хувь хүний хэрэг. Шүгдэнг шүтсэнээр Бурханы шавь нарын эе эв эвдэрч, өөр хоорондоо зохилдохгүй байдал үүсдэг. Бурхан Багш шавь нарынхаа оюуны төвшин, хүсэл зорилгод тааруулан ном сургаалаа харилцан адилгүй номлосон байдаг. Төвдөд дэлгэрсэн Бурханы шашны Нинмава, Гаржүдба, Сажава, Гэлүгба гэхчлэн бүх урсгалууд бүгдээрээ Бурхан Багшийн сургаал номыг дагадаг. Бүгдээрээ буддын шашны Их Хөлгөний номд сэтгэл итгэмжилж, төв үзлийг баримталж, судар тарнийн номыг хослуулан анхаарч авдгаараа ижил.

Шүгдэнг шүтэгчид танайх манайх хэмээн талцаж, хагарал үүсгэж байдгийг бид мэднэ. Нэлээн хэдэн жилийн

өмнө “Төвдийн төр засаг Шарын шашныг л харж үзэхээс биш бусад урсгалуудыг тоодоггүй” гэсэн худал цуурхал гарч байсан. Мөн тэр үед нас дээр гарсан Гармаба Ринбүүчийн лагшин чилээрхэж таалал барахад “Төвдийн засгийн газраас хорлосон” гэх ор үндэсгүй цуурхал ч гарсан. Үүний өмнө Төвдийн Бурханы шашны урсгалуудын төлөөлөл, хутагт хувилгаад оролцож Дарамсалад хуралдсан хурлын дараа Дүджом Ринбүүчийг буцаж морилох үед нэгэн шавь нь Ринбүүчийд хандан “Саяхуралдсан хурлаас Төвдийн Бурханы шашны урсгалуудыг нэгтгэж бүгдийг нь Гэлүгба болгоно гэсэн шийдвэр гаргасан гэсэн. Энэ нь яав ч зөв шийдвэр биш” хэмээн айлтгаж байсан гэдэг. Мөн “Дарамсалагийн их шүхрийн орой хазайж” хэмээн намайг егөөдөж байв (инээв). Эдгээр яриаг Шүгдэнгийн нийгэмлэгээс гаргаж байсан нь хожим тодорхой болсон юм.

Ерөөл буруудсан тангаргийн буг Шүгдэнг шүтэх нь Төвдийн Бурханы шашны урсгалуудын эв түнжин эвдэрч, хагарал гарахын гол шалтгаан болдгийг Шүгдэнгийн нийгэмлэгээс гаргасан “*Пагод Ламын Шаллүн”* номоос тодорхой мэдэж болно. Энэ номд “*Хэрэв Богд Ламын шашныг анхааран авч, бишир сүжиглэдэг нэгэн Нинмава гэхчлэн бусад урсгалын номыг анхааран авбал Шүгдэн сахиус амийг нь авна.”* хэмээн хүмүүст айдас төрүүлэхээр олон жишээ бичсэн байдаг. Мөн тэр үед Дарамсалагийн зарим айлууд “Шүгдэнгийн хорлол ирж магадгүй” хэмээн эмээж, Ловон Бадамжунайн дүр болон түүний айлдсан “*Баялаг Зарлигт Таван Аймаг”* (Гатан-Дэна) номыг гадагш хаях явдал гарч байв. Тэр үед надад Гадор дахь Нинмава болон Гаржүдбын хийдүүдэд зочилж номын барилдлага тогтоож, равнай өргөх боломж тохиосон юм. Намайг явсны дараа “Бидэнд Далай Ламаас ном сонсох сайхан хувь тохиолоо. Одоо түүний хойноос дагаж ирсэн муу чөтгөрийг гадагш гаргах хэрэгтэй” гэлцэн сан тавьж, арц уугиулж байсан гэдэг (инээв). Бутанчуудын дунд “Шарын шашны хувьд ярих юм байхгүй. Гэвч өнөө цагт Шарын шашныг муу чөтгөр дагадаг болсон” гэсэн ам дамжсан яриа байдаг.

Балбын Шарын шашны нэгэн хийдээс Нинмавын нэгэн лам нууц тарнийн Сандуй Бурханы талаарх номыг

сурахад “Бидэнд Сандуйн талаар мэдэх юм байхгүй. Харин Хажидын номыг сайн мэднэ” гэсэн гэдэг. Богд Зонхов Сандуй Бурханы номын аймгийг ихэд чухалчилдаг байсан. Түүний шавь Шаравсэнгээ Сандуй Бурханы номын аймгийг судлах Жүд дацанг байгуулсан. “Жүдийнхэн сэрэхдээ ч Сандуй, унтахдаа ч Сандуйг анхааран авдаг” гэсэн яриа ч байдаг. Шарын шашны хийд Сандуйн талаар мэдэхгүй байна гэдэг өрөвдөлтэй хэрэг биш гэж үү?

Би анхлан Шарын шашны номд суралцсан. Нинмава, Гаржүдба тэргүүтэн бусад урсгалуудын эш, авшиг, увдис олныг хүртэж, алагчлалгүй анхааран авдаг. Энэ нь надад үнэхээр тустай байдаг. Өмнөх Далай Ламын дүрүүдийг авч үзвэл Анхдугаар дүрийн Далай Лам Гэндүндүв Бурханы шашны урсгалуудыг алагчлалгүй анхааран авдаг байсан. II Далай Лам Гэндэнжамц мөн алагчлалгүй анхааран авдаг байсан учраас “алагчилдаггүй шар малгайт Гэндэнжамц” гэгддэг байв. III Далай Лам Содномжамц ч ялгаагүй Төвдийн шашны урсгалуудыг алагчлалгүй анхааран авдаг байсан. V Далай Лам Лувсанжамц Гаржүдбын увдис номыг анхааран авдаг байсан эсэхийг мэдэхгүй ч, Сажава болон Нинмавын номыг маш ихээр анхааран авдаг байсан. Шүгдэнг шүтдэг хүмүүс “Шарын шашинтан хүн дан ганц Шарын шашны номоо анхааран авах хэрэгтэй” гэж үздэг бөгөөд “Бурханы шашны бусад урсгалыг анхааран авбал тангараг бузартана” хэмээн бусад урсгалуудтай эв түнжинтэй байх барилдлагыг холдуулдаг. Төвдийн Бурханы шашны урсгалууд өөр хоорондоо эвдрэлцэж, Бурханы шашинтан нар бие биендээ дайсагналцаж байсныг өнгөрсөн түүхээс мэдэж болно.

“Банчин Сономдагвын хойд дүр” хэмээн хуурамчаар тодорсон Дагважанцан V Далай Ламын байгуулсан засгийн газартай тэмцэлдэн буруу ерөөл тавьсны эрхээр хойд төрөлдөө тангараг буруудсан буг чөтгөр болсон юм. Ямартай ч Төвдийн засгийн газар Гандан-Потантай үл зохилдох тангарагтай буг гэдэг нь тодорхой. Надтай уулзаж учирч байсан Шүгдэнг шүтдэг хувилгаад, гэвш нар насныхаа эцэст өлзий бусын олон зүйлтэй учирч байсан. Өмнөх үеийн түүхийг судалж, сайн нягтлан үзвэл та бүхэн бодит байдлыг бусдаар тайлбарлуулах шаардлагагүйгээр мэдэж чадна.

Өөр нэг зүйлийг хэлэхэд, Шүгдэнг шүтэх шүтэхгүй нь хувь хүний хэрэг ч Төвдийн цагаачлалын засгийн газарт алба хашдаг, засаг захиргааны ажил хийдэг бол Шүгдэнг шүтдэггүй байх хэрэгтэй. Бүгдэд ажиглагддаг нэг зүйл бол Шүгдэнг шүтдэг хүмүүсийн зан авир маш хэрцгий болдог. Хэдэн жилийн өмнө Цанидын сургуулийн багшийг арван зургаа хутгалж хөнөөсөн хэрэг гарсан. Хэргийг мөрдөх үед алуурчид цустай хувцсаа орогнож байсан байшингийнхаа дээвэр дээр шатаасан ул мөр олдсон. Гэмт этгээдүүд Делигээс Балбаар дамжин хятадуудын тусламжтайгаар Төвд уруу гарсан байдаг. Одоо ч гэсэн Шүгдэнгийн нийгэмлэгийн зарим хүмүүс гадаад дотоод хаана ч явсан Төвдийн төр засгийг эсэргүүцдэг бөгөөд Энэтхэг дахь Төвдийн сууринguудын дарга болон ядарсан энгийн ард иргэдийг зодож нүдэх зэргээр бусармаг хэрэг гаргасаар байна. Саяхан гэхэд Гандан хийдийн унзад ламыг утсаар сүрдүүлж дарамталсан явдал гарсан.

Шүгдэнгийн нийгэмлэгээс гаргасан нэгэн товхимолд намайг "XIII Далай Ламын хойд дүр биш, өмнөх Далай Лам нар Хутагт Жанрайсигийн хувилгаад биш" гэсэн утгатай зүйл бичсэн байсан. Миний нас 70 дөхөж байна. XIII Далай Ламын хойд дүр мөн үү, биш үү гэдэг нь надад чухал биш. Би өөрийгөө Төвдийн ард түмний эрх чөлөө, шашин төрийн тусын тулд аль чадахаараа зүтгэсэн гэж боддог. Намайг юу гэж хэлэх нь чухал биш. Шууд хэлэхэд Далай Ламыг сонгох уу, ерөөл буруудсан буг Шүгдэнг сонгох уу гэдгээ шийдэх хэрэгтэй. Хэрэв Шүгдэнг сонгож байгаа бол надтай номын барилдлага тогтоон гэлэн, гэцүлийн санваар хүртэх болон илүүтэйгээр нууц тарнийн авшиг хүртэж болохгүй. Багш шавийн тангараг ариун байх хэрэгтэй.

# 2004 оны 3-р сарын 26-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Дарамсала дахь Тэгчэнчойлин хийдэд Дэмчиг Бурханы авшиг хайрлах үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

[<— Гарчиг руу буцах]

Жанжаа Агваанчогдон Дэмчиг Бурханы номыг голлон анхааран авч бясалгадаг байсан бөгөөд түүнд Дэмчиг Бурханы зарлиг бууж байсан гэдэг. Тэрээр “Дэмчиг Бурханы гадаад хот мандал болон биеийн хот мандлыг бүтээх арга”, “Дэмчигийн авшиг өгөх зан үйл”, “Дэмчигийн авшгийн товч тайлбар” зэрэг олон ном зохиол туурвисан. Товчхондоо тэрээр Дэмчиг Бурханы их бясалгаач хүн байв. Түүний хойд дүрийн хувилгаан Жанжаа Ролбийдорж ч гэсэн Дэмчиг Бурханы их бясалгаач байсан. Түүний дараа үед гарсан Дэмчигийн их бясалгаач бол Павонка Ринбүүчи юм. Мөн түүний шавь нарын дундаас ахмад нь болох Тижан Ринбүүчи ч гэсэн Дэмчигийн дамжлагын эзэн, их бясалгаач байсан.

Гэсэн хэдий ч Павонка Ринбүүчи болон Тижан Ринбүүчи нар Шүгдэнг сахиусанд шүтсэн нь эндүүрэл байсан. Энэ нь жирийн нэг эндүүрэл байгаагүй. Үүнээс болж хоёр дээдсийн зохиол үйлсэд хорлол гарсан юм. Шүгдэнг шүтэж байснаар нь далимдуулан Павонка Ринбүүчи болон Тижан Ринбүүчи нарын зохиол үйлсийг буруутгаж хэрхэвч болохгүй. Мөн “өндөр дээд хувилгаан юм чинь” гээд зохиол үйлсийг нь мухар сохроор даган дуурайвал нийт Бурхан шашны ёсонд таарахгүй.

Өнөөдөр энд Дэмчиг Бурханы авшигт суухаар Жанжаа Ринбүүчийн хойд дүр морилсонд би их баяртай байна. Павонка Ринбүүчийн хойд дүр энд байсан бол би их баярлах байсан. Даанч Ринбүүчи муу нөхцөлийн эрхэнд орчихсон.

Тижан Ринбүүчийн (өмнөх Тижан Ринбүүчийн хойд дүр) хувьд нэгэн шинэ нөхцөл байдлын улмаас энэ зүгт морилж Дэмчигийн авшигт сууж чадахааргүй болсон. Үнэхээр харамсалтай.

"Өмнөх дүрийн Тижан Ринбүүчи Шүгдэнг шүтсэн нь түүний зохиол үйлсийн эрхэм байсан" гэж Тижан Ринбүүчийн хойд дүр айлдсан байсан. Энэ нь буруу юм. Бодь мөрийн зэргээр оюунаа судалж, Дэмчиг, Хажидын номыг анхааран авч байсан нь Тижан Ринбүүчийн зохиол үйлсийн эрхэм байсан болохоос биш Шүгдэнг шүтсэн нь зохиол үйлсийнх нь дээд байгаагүй юм.

Энэ удаад Дэмчигийн авшиг тавьж байгаадаа би их баяртай байна. Сон Ринбүүчийн хойд дүр энд морилсон байна. Лин Ринбүүчи багш маань Сон Ринбүүчийн өмнөх дүрийн тухайд "Судар тарни, уншлага гүрэм болон түүхийн ухааны өндөр мэдлэгтэй, ялангуяа чойрын номд нэвтэрхий хүн" гэж айлдаж байсан. Үнэхээр санаанд багташгүй эрдэмтэй хүн байсан. Худал зүйлийг тэвчдэггүй, шударга шулуун хүн байсан. Гэсэн ч Ринбүүчийн урьд дүр Шүгдэнг шүтэж, шүтэхийг дэлгэрүүлж байснаараа эндүүрэл гаргасан юм. Зохиол үйлс нь Төвдөд тийм ч их дэлгэрээгүй. Шарзэ хийдийн хамба байхдаа суудлаасаа хөөгдөж байсан гэдэг. Төвдийн Хам нутагт зохиол үйлс нь бага зэрэг дэлгэрч байсан ч цаашид дэлгэрэх чөлөө гараагүй гэдэг. Харин Энэтхэгт зохиол үйлс нь ихэд дэлгэрсэн. Хэдийгээр зохиол үйлс нь дэлгэрч байсан ч Сон Ринбүүчигээс болж Бурханы шашны урсгалуудын хооронд хэрүүл тэмцэл гарч байв. Тэр үед намайг Ориссад очих үед тэндхийн хүмүүс "Хуучин энэ газар хэрүүл тэмцэл гардаг байсан ч, тэр нь намжаад амар жимэр байсныг Сон Ринбүүчи ирээд сэргээчихлээ" гэж ярьж байсан. Бялакүппэд ч гэсэн ийм асуудал гарсан. Сон Ринбүүчи санаанд багташгүй эрдэмтэй хүн байсан ч Шүгдэнгийн тухайд эндүүрч байсан юм. Гэсэн ч Ринбүүчийн хойд дүр учир шалтгааныг тунгааж, хэнээс ч нууж хаалгүй "Бурхан Багшийн таалалтай зохилдон амьдрах нь зөв" хэмээн болгоож өнөөдөр надад Шүгдэнг шүтэхгүй гэдгээ батлан айлтгасан. Ринбүүчи өчигдөр гэлэнгийн санваар хүртэхээр ирсэн. Би ч тухайлан гэлэнгийн санваар хүртээсэндээ маш их

баяртай байна. Ринбүүчийд “баярлалаа” гэж хэлмээр байна. Та энэ зам мөрийг сонгосон нь их ач тустай хэрэг юм шүү.

Би нэг түүхийг ярья. Тижан Ринбүүчи багш маань өмнөх дүрийн Гармаба Ринбүүчитэй маш дотно нөхөрлөдөг байсан. Би Тижан Ринбүүчи багштайгаа байнга уулздаг байсан бөгөөд нэг өдөр багш маань надад “Өчигдөр Гармаба Ринбүүчи гэнэт морилоод намайг сандаргаад” гэхэд нь би “Та яагаад сандарсан юм бэ?” гэж асуухад Ринбүүчи: “Өчигдөр би Шүгдэнг тахих гээд балин тахилаа бэлдчихсэн сууж байтал гэнэт <<Гармаба морилж байна>> гэхээр нь балин тахилаа хурдан хураах хэрэгтэй болоод. Учир нь Гармаба Ринбүүчи Шүгдэнг таалдаггүй” гэж айлдсан юм. Шарын шашны сахиусаа Гаржүдба, Сажава, Нинмава гээд ямар ч урсгалын хутагт хувилгаан хэн ч заларсан нүүр бардам үзүүлэх хэрэгтэй болохоос биш ум хумгүй нуух хэрэгтэй билүү? Жалбуу Гүн-аа тахиж байсан бол хэнээс ч нуух шаардлага гарахгүй байсан. Гаржүдба нараас ч тэр. Гармаба Ринбүүчи Шүгдэнг тийм ч сайн мэддэггүй байсан байх. Учир нь Бутанд заларч байхдаа “Энэ заан унасан дүртэй нь Шүгдэн юм уу?” гэж асууж байсан гэдэг.

Мөн Цүрпү Гаржүдбынхан Гомбо-Бэрнаг сахиусыг голлон шүтдэг. Гомбо-Бэрнагийн доод биеийн өмсгөл нь хар өнгөтэй тул Цүрпү Гаржүдбынхан хар өнгөтэй шамтав (лам хүний доод биеийн өмсгөл) өмсөцгөөдөг. Бурхан Багшийн айлдсан винайн ёсонд лам хүний өмсөж болох хувцасны өнгийг айлдсан байдаг ч Цүрпү Гаржүдбынхан түүнээс илүү Гомбо-Бэрнаг сахиусаа эрхэмлээд винайн ёстой зохилдохгүй өнгөтэй хувцас өмсдөг. Түүнчлэн Бурхан Багш лам хүн цацагтай, ханцуйтай хувцас өмсөж болохгүй хэмээн айлдсан. Үүнийг мэдсээр байж Төвдийн Жанжаа болон Гүндэлин хутагт нар манжийн хааны илгээсэн цацагтай хувцсыг өмсөж байсан гэдэг. Энэ нь манжийн хааныг Бурхан Багшаас дээгүүр үзсэн хэрэг. Төвдүүдийн алдаа энэ юм.

Шарын шашны багш, ядам, сахиус алиныг ч, гадна дотнын хэний ч өмнө нүүр бардам үзүүлэх хэрэгтэй болохоос биш нууж хаах нь яав ч сайны шинж биш шүү! Өөр айлтгах зүйл алга аа.

# 2004 оны 12-сарын 10-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Энэтхэг дэх Сэра-Жэ дацангийн Жадэл болон Хардон аймгийн шинэ дуганы нээлтэн дээр Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Танай аймагт "*Сайн Номлолын Зүрхэн*" (Лэгшэд Нянбуу) номыг цээжилсэн 20 орчим лам байгаад би их баяртай байна. Гэрээс гарч лам хувраг болсон хүн Бурхан шашны эрхэм зарлигийг сонсох, санахыг үйлдэж, шашны үзэсгэлэнт чимэг болох бясалгал бүтээлийг ч хийх хэрэгтэй. Өөр хоорондоо эв найртай байж, сахил санвааpaa ариунаар сахих нь маш чухал.

Би "Бурханы шашин болон Богд Ламын шашныг хиргүй ариун байгаасай" гэсэндээ Шүгдэнг шүтэхийг хориглосон. Учир шалтгааныг нь сайтар нягтлан, эш лүнг шүүж, мэргэ төлгөөр шинжиж үзсэний эцэст баттай магадлалыг олоод хориглосон. Цаашид ч эцсээ хүртэл үргэлжлүүлэн хориглосоор байх болно. Урьд заларсан эрдэм чадал төгөлдөр олон дээд төрөлхтөн нар ч Шүгдэнг шүтэхийг хориглож байсан. V Далай Лам болон XIII Далай Лам Шүгдэнг шүтэхийг маш хүчтэй хориглодог байсан. Өмнөх Далай Лам нарын хойд төрөл учраас тэдний зохиол үйлсийг үргэлжлүүлэх нь миний үүрэг. Сэра-Жэ дацангийн Жадэл болон Лхова аймгийн цөөн хэсэг лам нар мэдэхгүйн эрхээр ч юм уу, эсвэл хэсэг хугацааны дараа энэ байдал намжина гэж бодсон уу, ямартай ч өнөөг хүртэл Шүгдэнг шүтсээр байна. Тэдгээр лам нарын нутагт одоо ч Шүгдэнг хүчтэй шүтсээр байна. "Энэ хойд хийгээд завсрын төрөл алинд ч Шүгдэн тусалж, аварч чадахгүй" гэдгийг би баттай хэлж чадна. Тиймээс Төвдийн шашин төр, илүүтэйгээр өөрсдийнхөө

ирээдүй хойчийг бодоод авла орхилыг эндүүрэлгүй үйлдэж, зөв шийдвэр гаргах нь чухал шүү!

# 2005 оны 8-р сарын 16-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Дели дэх Самялин хороололд Төвдөөс ирсэн цагаачидтай уулзах үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Төвдөөс шинээр цагаачилж ирсэн та бүхний дунд Шүгдэнг шүтдэг хэсэг лам нар байсан. Тэдний зарим нь “Шүгдэнг шүтэхгүй байж чадахгүй, үргэлжлүүлэн шүтнэ” гэдгээ илэрхийлээд тус тусынхаа хийд орон уруу явцгаасан. Ер нь би Шүгдэнг шүтдэг хүмүүстэй уулздаггүй. Санаа бодол таарахгүйн дээр тангараг ариун бус тул надтай уулзаад хэрэг байхгүй. Та нар дунд зарим нэг нь урьд Шүгдэнг шүтэж байсан ч “цаашид шүтэхээ больё” гэж шийдсэн хүмүүс байгаа. Маш сайн байна.

Урьд нь би ч гэсэн сайн мэдэхгүй, бусдыг даган дуурайж Шүгдэнг шүтдэг байсан. Хожим надад эргэлзээ төрж Шүгдэнгийн тухай сайтар судлах шаардлага гарсан юм. Судалж үзээд шүтэхээ больсон. Үүний дараахан Гандан-Жанзэ дацанд өлзий бусын олон муу ёр гарсан. Тэр үед Тижан Ринбүүчи багш маань амьд сэрүүн байсан. Энэ тухай Гандан-Жанзэ дацангийнхан Тижан Ринбүүчийд айлтгахад Ринбүүчи: “*Гандан-Жанзэ дацангийн Лхам сахиус хилэгнэсэн байна. Тиймээс сахиусаа тахих хэрэгтэй”* гэж айлсан.

Мөн Гандан-Жанзэ дацангийнхан надаас өлзий бусын ёрыг буцаах ямар арга байгааг шинжиж өгөхийг хүссэн. Би ч энэ асуудлыг чухалчилж гурилаар шинжиж төлөг буулгасан. Гандан-Жанзэ дацанд гарч буй өлзий бусын ёр сахиус хилэгнэснээс болсон эсэхийг шинжихэд сахиус хилэгнэснээс болсон гэж буусан. Гандан-Жанзэ дацан Шүгдэнтэй барилдлагатай байсан тул Лхам сахиус хилэгнэсэн нь үүнээс

болсон эсэхийг шинжихэд Шүгдэнгээс болж хилэгнэсэн гэж буусан. Энэ цаг үеэс хойш би Шүгдэнг шүтэхийг хориглож эхэлсэн. Тэр үед зарим хүмүүс "Далай Лам түр зуур, хэргийн тухайд Шүгдэнг шүтэхийн хорьж байна", "Нинмава нарт тал засахдаа Шүгдэнг шүтэхийг хориглож байна" гэх цуу яриаг Төвдөд тарааж байсан. Би Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг мэдээд хориглосноос биш улс төржөөд, эсвэл бусдад тал засах гэсэндээ хориглоогүй. Энэ шийдвэр маань үнэн учир шалтгаан дээр суурилсан гэж би зуун хувь баттай хэлж чадна. Цаашдаа ч Шүгдэнг шүтэхийг хориглосоор байна. Үүнээс болж Шүгдэнг тахиж шүтдэг хүмүүсийн зүгээс үймээн самуун гаргах болсон. Хүн алж зодож нүдэх гээд олон бэрх асуудал гарч байсан. Дели дахь Төвдийн Самялин хорооллын гудманд хүн зодож танхайрсан хэрэг хэд хэдэн удаа гарсан.

Өнгөрсөн 360 орчим жилийн турш энэ асуудал байсаар ирсэн. V Далай Лам Лувсанжамцын намтарт "*Дол нутгийн Цагаан булагт ерөөл буруудсан тангаргийн буг хүч чадал маш ихтэй нэгэн бээр шашин амьтан нийт болон зарим нэгэнд хүчир хорлох нь гал тахиа жилээс улам ихсэж эгэл ард аврал айлтгах нь олон гарсан ба надад хорлол ирээгүй гэх нь ховор болоход Дол нутгийн Цагаан булагт шороон тахиа жилийн адагт шинэ сүм барьж, гажа тэргүүтэн үнэртний хаан, тогтоох шүтээн зэргийг өргөж аргадан тахисан ч хорлол нь улам арвижиж, хар шар олонд хижиг өвчин гарч, нэг хоёр лам нас барах зэрэг гай барцад гарснаас үүдэн хийдийн лам нар нэгэн зэрэг хатуу үйл үйлдье хэмээсэнд шүтээд Очирт Долоджийн Дорж Ловон аграмба Дондүвжамц, Янсан Гарма-Дагбуугийн Дорж Ловон тарнийг баригч Лувсанчэнзэ нарын үйлдсэн тоон таслалаар хоёр бүтээл, Дорж Брагийн Ригзин хувилгаан, Номун хаан Дэрдаглинба, Үг-Жалүнба лам, Бригүн Хувилгаан, Аари Гончоглхүндүв, Балри Хувилгаан нар Лама Дагбуу, Эрлэгийн Эзэн, Пүрэв, Логдри тэргүүтний үүднээс долоон хоног бүтээл хийсний эцэст жинсрэг цутган тангаргийн буг ад зэтгэр нөхөд сэлтийг шатаахад шинж тэмдэг гайхамшигтай машид олон гарсан бөгөөд хүүр шатсан үнэрийг бүгд мэдэрч сэтгэл итгэмжилсэн ба олон амьтныг*

*айдсаас ангижруулснаар үл барам ад зэтгэр тэдгээрийн муу үйл нь улам дэлгэрч муу заяаны зовлон барагдашгүй ихийг амсах байснаас гэтэлгэж амгаланд байгуулав. Энэ үест тэдгээр ад зэтгэр өмөг түшгээсээ хагацсаныг гэрчлэх бичгийг зохиосон.”* хэмээн өгүүлдэг. V Далай Ламын гадаад, дотоод, нууцын гэсэн зарлигийн гурван эмхтгэл байдаг бөгөөд тэр “гэрч бичиг” нууц зарлигийн “Да” боть доторх олон төрлийн сахиусны даатгал, магтаалын тухай бичсэн хэсгийн 148-р хуудсанд байдаг. Тэр бичигт “*Гадхасагийн Ла-Ажалын хичээл зүтгэлээр хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр хэмээн хуурамчаар тодорсон тэрбээр (эцэстээ) ерөөл буруудан тангаргийн буг болоод олон амьтанд хүчтэй ихээр хорлох болсонд Доржтаг Хувилгаан хийгээд...”* хэмээсний *Гадхаса* гэдэг нь Дагважанцангийн төрсөн нутаг, *Ла-Ажал* гэдэг нь Дагважанцангийн ээж юм. *Сономгэлэгбалсан* бол Банчин Сономдагвын хойд дүрийн хувилгаан. Ла-Ажал нь их зальжин хүн байсан бөгөөд янз бүрийн башир аргаар өөрийн хүүг Банчин Сономгэлэгбалсангийн хойд дүр биш боловч хуурмагаар хойд дүрээр нь тодруулж чадсан учир *хойд дүр хэмээн хуурамчаар тодорсон* гэж бичжээ. Дагважанцан эцэстээ ерөөл буруудан тангаргийн буг болоод олон амьтанд маш ихээр хорлол хийсэн. “*Гэрч бичигт”*:

“*Зургаан мутарт Гомбо, Чойжоо, Лхам*
*Дөрвөн нигуурт Гомбо, Жамсран Бэгз тэргүүтэн*
*Тахиж шүтэн бүтээх тангарагт сахиус бүгдэд*
*Тансаг ундаан дээжийн тахил үүнийг өргөе.*
*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн болон шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун!”* хэмээн олон сахиусны алдрыг дуудан өгүүлсэн байдаг.

V Далай Лам “Дагважанцанг ерөөл буруудсан тангаргийн буг болсон” гэж танин барьсан. XIII Далай Лам Шүгдэнг шүтэхийг маш хүчтэй хориглож байсан. Урьд XIII Далай Лам Брайбүн хийдийн тарнийн дуганд морилох үед дотор нь Шүгдэнгийн дүр байсныг зарлиг буулган гаргаж хаяхыг тушааж байсан түүхийг настай лам нар ярьдаг. Мөн

XIII Далай Лам Павонка Ринбүүчийг Шүгдэнг шүтэж эхэлснээс нь хойш таалахаа больж, зэмлэл олныг хүртээж байсан тухай Павонка Ринбүүчийн бичээч Лувсандоржийн хэвлүүлсэн төвд барын намтарт нь тодорхой гардаг.

Ямартай ч миний хувьд Шүгдэнг шүтсэн нь алдаа байсан. Шүгдэнг шүтэхийг хориглосон маань харин алдаа биш. V Далай Лам "ерөөл буруудсан тангаргийн буг" хэмээн танин барьсан ад зэтгэрийг би шүтэж байсан. XIII Далай Лам "Хэрвээ шүтэх юм бол аврал одуулахуйн суртгаалтай харшилна" хэмээн хориглож байсан Шүгдэнг шүтсэн маань алдаа байсан юм. Винайн номд "Гэмээ гэмд үзэв үү?" гэхэд "Үзэв" гэж хариулдаг шиг би гэмээ гэм гэж үзээд шүтэхээ больсон. Төвдийн засгийн газар Гандан-Потаныг анх V Далай Лам үүсгэн байгуулсан. V Далай Ламтай тангараг буруудсан, Гандан-Потантай үл зохилдох бугийг гайхамшигтай гээд шүтэх нь шашин төрд хор болно уу гэхээс тус болохгүй. Тиймээс би Шүгдэнг шүтэхийг хориглосон юм. Хоёр дахь шалтгаан нь Төвдийн Бурханы шашны урсгалуудыг би ялгаж үздэггүй. Сажава, Нинмава, Гаржүдба гээд бүгдэд нь ялгалгүй сүжиглэж, бишрэнгүй ханддаг. Би Зөөлөн Итгэлт Богд Ламын (Богд Зонхов) гайхамшигтай номлолд шүтээд Бурханы Шашны номонд суралцсан. Мөн Бүхнийг айлдагч Лончэн Равжамба, Жигмэдлинба тэргүүтэн Нинмавын ихэс дээдсийн номлол, увдис дамжлагад суралцаж байсан. Энэ нь Бурханы номыг сэтгэлдээ дадуулахад маань ч тустай байсан. Нинмава зэрэг урсгалын номыг судалсан маань бусдад тал зассан хэрэг огтхон ч биш. Судар, тарни, төв үзэл, шүтэн барилдлагын тухай Богд Зонховоос илүү сайн номлол зохиосон хүнийг би мэдэхгүй. Богд Зонховын зохиосон номлолууд үнэхээр гайхамшигтай.

Ханьцашгүй дээд нууц тарнийн гэгээн очирт сэтгэл буюу язгуурын гэгээн гэрэл, Сандуйн номын аймагт өгүүлснээр бол бүхэн хоосорсон гэгээн гэрлийн номлолын тал дээр Гаржүдбын Махамутра болон ялангуяа Нинмавын Зогчэнгийн номд номлосон дагуу гэгээн гэрлийг ялган сэтгэлийг танин мэдэх нь Сандуйн номын аймагт номлосон бүхэн хоосорсон гэгээн гэрлийг нотлон буулгахаас илүү ойлголтыг өгдөг. Үүнийг ухаарснаар миний сэтгэлд сүжиг

төрсөн. Нинмава, Гаржүдба, Сажава гээд бүгдийг нь алагчлалгүй анхааран авах болсон учир шалтгаан маань энэ юм.

Урьд Төвдөд Бурханы шашны урсгал бүгдийг алагчлалгүй анхааран авдаг олон мэргэд, дээд төрөлхтөн нар гарч байсан. Мөн зөвхөн өөрийн уламжлал дамжлагаа илүүд үзэн бусдыг хориглодог хүмүүс ч олон гарсан. Мэргэд билэг ухаанаараа буруу номлолыг хоригловол тэр нь "Мэргэд мэргэдийн дундаа үзэсгэлэнтэй" гэдэг шиг учир утгатай хэрэг. Харин уур, шуналын сэтгэлд автаад бусдыгаа алагчлан гадуурхах нь үнэхээр гутамшигтай. Төвд үндэстэн ирээдүйд орших оршихгүй нь тодорхойгүй болсон энэ цаг үед шашны урсгалууд өөр хоорондоо эвтэй байх нь чухал. Би Энэтхэгт ирсэн цагаасаа эхлэн энэ тал дээр анхаарч ирсэн. Тэр үед Зэмэ Ринбүүчи надад их сайн байсан. Эрдэм номтой ч хүн. Гэвч тэрээр "*Пагод Ламын Шаллүн*" нэртэй ном зохиож, түүндээ "*Засгийн газрын зарим нэг ажилтан болон Шарын шашны зарим хувилгаад Нинмавын ном үзсэний улмаас Шүгдэн сахиус хилэгнэж, эцэстээ амийг нь авсан*" хэмээн янз бүрийн юм бичсэн байсан. Тэр үед үүнээс эмээж Дарамсалад Ловон Бадамжунайд буман тахил өргөх хуралд ани (эмэгтэй хувраг) нар ирээгүй. "Шүгдэнг шүтдэг бол зөвхөн Шарын шашинд л сүжиглэх хэрэгтэй. Бусад урсгалуудыг шүтэх нь хортой", "Шарын шашинтан хүн Нинмавын номыг үзэх нь бүү хэл гэртээ ч хадгалж болохгүй. Хэрэв тэгвэл Шүгдэн сахиус хорлоно" гэх мэт яриа тэр үед гарч байсан. Нэгэн жишээ дурдахад Ориссагийн нэгэн айл "Шүгдэнгийн бумбыг гэртээ хадгалбал эд хөрөнгө арвижна" гэдэгт итгээд бумбыг залахын тулд гэртээ байсан Ловон Бадамжунайн намтар "*Бадмын Баялаг Зарлигт*" (Бадамгатан) номыг өөр хүнд өгч байсан гэдэг.

Шүгдэнг шүтэх нь шашны урсгалуудын эв түнжинд хортой байдаг. Урьд Төвдийн олон мэргэд Шүгдэнг шүтэхийг хорьж байсан. Сажавын дотор Шүгдэн шүтдэг хүмүүс байдаг ч маш хүчтэй хориглодог. Нинмава болон Гаржүдба нар Шүгдэнг огтхон ч шүтдэггүй.

Шашны урсгал хоорондын эв эеийг эвдэж, хагарал гаргадаг учраас би Шүгдэнг шүтэхийг хориглодог. Хориглох

болсон нэг учир шалтгаан нь энэ юм. Өөр нэг учир шалтгаан нь Төвдөд дэлгэрсэн Бурханы шашин гайхамшигтай ч, биднээс болоод тэнгэр, сахиус тахидаг зан үйл төдийхөн болж байна. Илүүтэйгээр Жалбуу Гүн-аа, Дэнма Жү-ни шиг Ловон Бадамжунайн үеэс шашны сахиусанд тушаагдаагүй, уг гарал ариун бус Шүгдэнг Бурхан Багш мэт шүтэх нь яав ч сайн зүйл биш.

Шүгдэнг 300 орчим жилийн өмнө анх Сажавын дотор тахиж эхэлсэн. Аажмаар Гэлүгба нарын дунд бага зэрэг шүтдэг болсон ч ихэнх нь шүтдэггүй байсан. Амду нутагт маш цөөхөн хүн шүтдэг. Гүнбүм болон Дашчэлин хийдүүдэд тахидаг гэж дуулаагүй. Үй-зан нутаг, Гандан, Брайбүн, Сэра хийдэд өмнө шүтэж байгаагүй. Хийдүүдийн ганц нэг аймагт л тахидаг байсан. Анх гарсан цагаасаа хойш шашны сахиус мөн биш нь эргэлзээтэй байсаар ирсэн.

Энд би нэгэн түүхийг ярья. Лхасад Тодэ Хансар хэмээх Шүгдэнг тахидаг хийд байсан. Миний таньдаг Сэра-Мэ дацангийн Бомра аймгийн настай ламыг бага байхад тэр хийдийн дуганч лам түүнд “*Нэг удаа хурал хурах үед Шүгдэн бууж, хурлын дунг аваад <<Шашны дайсан Гандан-Потаны орой дээр цохино!>> гэж орилоод дунгаараа газар цохисон”* хэмээн ярьсан гэдэг. Төвдийн засгийн газар Гандан-Потантай таардаггүйгээсээ болоод буух болгондоо тэгж авирладаг эсэхийг нь мэдэхгүй ч тэр ламын яриагаар *<<Шашны дайсан Гандан-Потаны орой дээр цохино!>>* хэмээн дунгаар газар цохисон байдаг. Үүнийг надад ярьсан тэр лам одоо 70, 80 хүрч байгаа байх. Ямартай ч эндээс үзэхэд Шүгдэн Төвдийн засгийн газар Гандан-Потантай таарамжгүй гэдэг нь харагдаж байна.

Тиймээс миний Шүгдэнг шүтэхийг хориглох болсон нэгдүгээр шалтгаан нь Төвдийн шашны урсгалууд хоорондын эе эвийг эвддэг, хоёрдугаар шалтгаан нь засгийн газар Гандан -Потантай таардаггүй, гуравдугаар шалтгаан Бурханы шашин жирийн нэг тэнгэр сахиус тахидаг зан үйл төдий болж, тахиж буй тэнгэр сахиус нь ч шашны сахиус мөн биш нь эргэлзээтэй байж хэрхэвч болохгүй гэж үзээд Шүгдэнг шүтэхийг хориглосон. Та бүхэнд үүнийг хэлье гэж бодсон юм. Та нарын дунд өмнө нь Төвдөд байхдаа Шүгдэнг шүтэж

байгаад одоо шүтэхээ больё хэмээн шийдсэн хүмүүс байгаа нь сайн гэж хэлсний минь учир шалтгаан энэ юм. Та нар “Шүгдэн хорлоно” гэж айж эмээлгүй санаа амар байж болно. Шүгдэнг шүтэхийг хориглож эхэлснээс хойш олон хүн “Шүгдэнг шүтэхгүй” хэмээн ам авч байсан. Ганц Төвдөд ч биш, Ладак, Монбад ч гэсэн шүтэхгүй хэмээн ам авсан олон хүн гарсан. Тэдгээр хүмүүст Шүгдэнгийн хорлол гараагүй. Тиймээс та нар ч гэсэн тайван байж болно. Цөөн хэсэг хүмүүс үргэлжлүүлэн шүтсээр байгаа. Шашин шүтэх шүтэхгүй нь хувь хүний эрх. Ямар тэнгэр сахиус шүтэх нь ч хувь хүний хэрэг. Өөрөө мэдэж, шийдээд буруу зүйл хийж байгаа хүмүүст миний зүгээс хэлэх зүйл байхгүй.

# 2006 оны 1-р сарын 8, 9-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Энэтхэгийн Амараватид Дүйнхор Бурханы Их Авшиг тавих үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

[<— Гарчиг руу буцах]

Энд хуран цугласан хүмүүсийн ихэнх нь Шүгдэнгийн тухай мэдэж байгаа. Гэсэн ч шинээр номд суухаар цөөнгүй хүн ирсэн байгаа тул энэ талаар бага зэрэг яръя гэж бодлоо. Олон жилийн өмнөөс би Шүгдэнг шүтэхийг хориглосон. Энэ шийдвэрийг би зүгээр ч нэг гаргаагүй. Шүгдэн анх V Далай Ламын үед гарсан. Гарсан түүх нь V Далай Ламын гадаад намтар "*Дүгүлийн Гой-сан"* болон нууц намтар "*Санва Жа-жан"* дотор ч тодорхой гардаг. Дагважанцан болон V Далай Лам нарын хооронд үл зохилдох байдал үүсэж байсан нь тодорхой. Намтар "*Дүгүлийн Гой-сан"*-д "V Далай Лам хатуу үйл үйлдэж Шүгдэнгийн хүчийг дарснаа гэрчилж гэрч бичиг зохиосон" тухай өгүүлдэг. Тэр бичиг V Далай Ламын сүнбүмийн "Да" ботид байдаг. Гэрч бичигт: "*Гадхасагийн Ла -Ажалын хичээл зүтгэлээр хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр хэмээн хуурамчаар тодорсон тэрээр (эцэстээ) ерөөл буруудан тангаргийн буг болоод..."* хэмээн Дагважанцанг Банчин Сономгэлэгбалсангийн жинхэнэ хойд биш болохыг V Далай Лам өгүүлсэн байдаг. Сономгэлэгбалсан нь Банчин Сономдагвын хойд дүрийн хувилгаан. Харин Дагважанцан бол Банчин Сономгэлэгбалсангийн хойд дүр хэмээн хуурамчаар тодорсон хүн. Уг бичигт "Дагважанцанг эцэстээ ерөөл буруудсан тангаргийн буг болсон" гэж бичсэн байдаг. Ямартай ч урьд хураасан үйл, буруу ерөөл зэрэг дариудын олон нөхцөл шалтгааны улмаас ерөөл буруудсан тангаргийн

буг болсон гэдэг нь тодорхой. Мөн тэр бичигт:
“*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн болон шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун…”*
хэмээсэн хэсэг шүлэг байдаг. Хэдэн жилийн өмнөөс “*Гэрч Бичиг”* дахь энэ шүлгүүдийг Энэтхэг дахь Төвдийн сүм хийдүүд сахиусны тахилга уншлагад оруулж унших болсон.
Хэдийгээр олон жилийн өмнөөс Шүгдэнг шүтэхийг хориглосон ч зарим хүмүүс өнөөг хүртэл шүтсээр байна. Авла орхилыг хэрхэн үйлдэх нь хувь хүний хэрэг. “Эцгийн гэрээс, зүрхний үгээ хэлсэн. Сонсох эсэхээ өөрөө шийд” гэдэг шиг Шүгдэнг шүтэхийг анх хориглож эхэлснээсээ хойш энэ тухай би зөндөө тайлбарласан. Одоо ч тайлбарласаар байгаа. Миний үгийг сонсох сонсохгүй нь хувь хүний хэрэг. Хэдий тийм ч Шүгдэнг шүтэж болох эсэх, ашиг тус байгаа эсэхийг тайлбарлах нь миний үүрэг. Өөрийгөө бодоод яавал ч яаг гээд тайван сууж хэрхэв ч болохгүй. Зарим нэг хийдийн хамба, хувилгаад өөрсдийгөө бодоод “Балинг нь нохой идэж байсан ч нүдээ анин сууна. Хийдэд нь гал гарч байсан ч нүдээ анин сууна” гэдэг шиг авир байдал гаргаж байсан. Бүгдээрээ л шашныхаа төлөө санаа тавьж байх хэрэгтэй. Анхандаа би шашны сахиус мөн гэж итгээд Шүгдэнг шүтэж байсан. Аажмаар бодит байдлыг мэдэж, эндүүрч байснаа ухаарсан. Дараа нь элдэв асуудал гарч, өнгөрсөн түүхийг нягтлан үзэж байх үедээ өмнө өгүүлсэн V Далай Ламын “Гэрч бичиг”-ийг олсон юм. Мөн эрдэм чадал төгссөн олон мэргэд, дээд төрөлхтөн нар “Шүгдэнг тангаргийн буг” хэмээн танин барьж, шүтэхийг хориглож байсныг мэдсэн. Энд нэг зүйлийг хэлэхэд: хэрэв V Далай Ламын зохиосон “Гэрч бичиг”-т өгүүлснийг эндүүрэл хэмээн эш үндэс, баталгаа нотолгоотой тайлбарласан өөр тайлбар бичиг байгаа бол өөр хэрэг. Гэвч өнөөг хүртэл хэн ч V Далай Ламын бичсэнийг эндүүрэл байсан хэмээн эш үндэс, баталгаа нотолгоотойгоор тайлбарлаагүй. XIII Далай Лам болон Цастын орны шашин, амьтны тусыг агуу ихээр бүтээж байсан шашныг баригч олон мэргэд, дээд төрөлхтөн нар V Далай Ламын эцэслэн шийдсэнийг зөвшөөрч, Шүгдэнг

шүтэхийг хориглож байсан. Нэг хэсэг “Дагпү Бадмаабазар Шүгдэнд амиа тушааснаар арилсан үзэгдэл үзсэн” гэх яриаг Шүгдэнг шашны сахиус гэж үзэх баталгаа болгож байсан. Дагпү Ринбүүчийд арилсан үзэгдэл үзэгдэж байсан тухай өгүүлдэг модон бараар Төвдөд хэвлэгдсэн ном байдаг. Тэр номд Дагпү Бадмаабазар залуудаа олон арилсан үзэгдэл үзэж байсан тухай, мөн Павонка Ринбүүчитэй учирч байсан тухай болон хэдий үед ямар ямар ариун үзэгдэл үзэгдэж байсан тухай бичсэн байдаг. Үнэхээр Дагпү Бадмаабазар Шүгдэнд амиа тушааснаар өөрт нь арилсан үзэгдэл үзэгдсэн юм бол тэр номд өгүүлэх ёстой байсан ч энэ тухай нэг ч үг байгаагүй. Дагпү Бадмаабазар Шүгдэнд амиа өргөснөөр арилсан үзэгдэл үнэхээр үзэгдсэн эсэхийг шинжлэх хэрэгтэй. Энэ ном Төвдөд хэвлэгдсэн. Дагпү Бадмаабазар эрдэм чадал төгс дээд төрөлхтөн байсан гэдэг нь энэ номоос тодорхой харагддаг. Гэхдээ хүмүүсийн яриад байдаг шиг арилсан үзэгдэл үзэгдсэн тухай бичээгүй байсан. Тиймээс үүнийг шинжилж үзэх нь чухал.

Надад Шүгдэнг шүтэхийг хориглох болсон олон шалтгаан бий. Би V Далай Ламын замаар аль чадахаараа явахыг хичээдэг. Хүссэн, хүсээгүй нэг шалтгаан нь энэ юм. Өөр нэг шалтгаан нь Богд Ламын шашин. Зөөлөн итгэлт Богд Лам сайн номлолын гайхамшиг болсон 18 боть зохиол үлдээсэн. Тэдгээрийн дотор санаа саванд багташгүй судар тарнийн гайхамшигтай олон увдис байдаг. Энэ 18 боть Шарын шашинтан хүний гаднаа бахархах бахархал, дотроо нандигнах эрдэнэ юм. Эрхэмлэж нандигнах хэрэгтэй 18 ботио орхиод ерөөл буруудсан тангаргийн бугийг эрхэмлэвэл Богд Ламын шашинтан хүний хувьд гутамшигтай, ичгүүртэй хэрэг. Богд Ламын шашныг үнэхээр л илүү гэж үздэг хүн бол илүүд үзэж байгаа зүйлээ эндүүрэхгүй байх учиртай. Багшийг тахихуйн уншлага унших болон Шүгдэнг шүтэхийг Богд Ламын шашны зүрхэн эрдэнэ гэж үзэх нь алдаа юм шүү! Богд Ламын айлдсан 18 боть зохиолд эзэн сууж чадвал харин үнэхээр гайхамшиг. Төвдөөс ирсэн хүмүүсийн дунд болон мөн энд ерөөл хурж байгаа учраас Шүгдэнг шүтдэг хүмүүс ирсэн байж магадгүй. Сэра хийдэд Шүдгэнг шүтдэг хүмүүс байдаг. Брайбүн хийдэд бараг байхгүй. Ямартай ч Шүгдэнг

шүтдэг хүмүүс маргааш номд суухаар битгий ирээрэй гэж хүсэх байна. Шүгдэнг шүтэхийг хориглох болсон өөр нэг шалтгаан бол манай төвдүүдийн дунд тэнгэр, лус тахих явдал их дэлгэрсэн байдаг. Энэ нь маш том алдаа юм. “Өөрт ямар ч хэрэг тохиолдсон бай хамаагүй, Бурханы номтой холбоод тэнгэр, лус тахих нь маш том алдаа юм! Шашныг гутааж буй хэрэг юм шүү!” гэж хэлье. Мөн өөр нэг шалтгаан нь Шүгдэнг шүтсэнээс болж Төвдийн шашны урсгал, дамжлага хоорондын эв түнжин эвдэрч, тангараг тасрах явдал гардаг. Цаст Төвдийн оронд дэлгэрсэн Сажава, Нинмава, Гаржүдба, Гэлүгба, Жонон тэргүүтэн урсгал, дамжлагууд харилцан эвлэж чандмань эрдэнийн гэрэл мэт түгэх хэрэгтэй гэлцдэг. Энэ бол маш чухал юм. Урсгал, дамжлага хоорондын тангараг бат, суртгаал ариун, таалал зохилдонгуйгаар оршиход Должал буюу Шүгдэнгээс болж эс мэдсэн буруу бодол, атгаг сэжиг үүсэж өөр хоорондоо харшлах явдал гардаг. Урьд Төвдөд иймэрхүү явдал олон гарсан. Хожим Энэтхэг дахь цагаачдын дунд ч цөөнгүй гарсан. Ямартай ч Шүгдэнг шүтэх нь Бурханы шашны урсгал, дамжлагуудын эе эвд харшлах маш том шалтгаан болдог.

Өөр нэг шалтгаан нь Төвдийн шашин төр юм. Цастын оронд ач ихтэй засгийн газар Гандан-Потаны үндэс суурийг V Далай Лам анх тавьсан. V Далай Лам Төвдийн ард түмний өмнө маш их үүрэг хүлээж, шашин төрийн үндэс суурийг бататгаж өгсөн. Үүний ач тусыг үл хайхран буруу замаар явбал ачийг нь усаар хариулж буй хэрэг. Зөв бурууг тайлбарлаж таниулах нь миний үүрэг. Голлон эдгээр учир шалтгааны улмаас би Шүгдэнг шүтэхийг хориглосон юм. Үүний дараагаар Төвдийн Бурханы шашны урсгал, дамжлагыг баригч хутагт хувилгаад, хамба, номын мэргэд нар Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг ойлгон миний шийдвэрийг хүлээн зөвшөөрч, их сэтгэл гаргаж байсан. Гандан хийдийн Ширээт лам байсан Лувсанням, Брайбүн хийдийн Хамба байсан Дамбаданзан зэрэг олон хүмүүс шашны үүргийг үүрч, энэ тал дээр их хичээл зүтгэл гаргасан. Зарим нэг нь энэ асуудлыг төдийлөн ойшоож үздэггүй. Энэ нь надад чухал биш ч бид бүгдээрээ нийт Бурханы шашин хийгээд ялангуяа Богд Ламын шашны тусын

тулд маш ихээр санаа тавьж байх хэрэгтэй. Миний амьд байх хугацааны гуравны хоёр нь дууссан. Үхэлд ойртож байна. Намайг өнгөрсний дараа ороолон адил босохоор хүлээж суугаа хүмүүс хожим юу хийхийг залуу хүмүүс та нар бодох хэрэгтэй. Намайг өнгөрсний дараа ач үл санах тэр хүмүүс хагарал гаргах нь тодорхой. Эдгээрийг та нар сайтар бодох хэрэгтэй шүү! Ойлгосон уу?

# 2006 оны 3-р сарын 27-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн хаврын номд суухаар Төвдөөс Энэтхэгт ирсэн хүмүүст Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Энэ тухай урьд өмнө олон удаа ярьж байсан болохоор та нарын ихэнх нь мэдэж байгаа. Мэдэхээр ч барахгүй Лхасаас эхлэн Үй-Зан, Амдо, Хам нутгийн ихэнх хийдүүд болон ард иргэд Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг ойлгон шүтэхгүй гэдгээ баталж, илэрхийлсэн. Ямартай ч энэ нь нийт Бурханы шашинд тустай үйл хэрэг учраас учир явдлыг ойлгож шүтэхгүй гэдгээ илэрхийлсэн бүх хүмүүст "Баярлалаа!" гэж хэлье.

Шашны үйл хэрэг Хятадын засгийн газрын ажил шиг гэнэт их шавдуулж гарч ирээд эцэстээ сулран суларсаар аяндаа орхигддог байж болохгүй. Бид нар эхлүүлсэн ажлынхаа эцсийг үздэг байх хэрэгтэй. Би анх Шүгдэнгийн тухай ил байгаа асуудлыг өөрийн ухаанаар шинжиж, далд байгааг нь хуурмаггүй чухаг дээд гуравт аврал айлтган шинжиж үзсэн. Ерөнхийдөө энэ асуудал далд учир олон талаас сайтар нягтлан шинжлээд шийдвэрээ гаргасан. Та нар сэтгэл гарган авах гээхийн ухаанаар хандсанд баярлалаа.

Зарим нэг нь одоог хүртэл үүнийг ойлгохгүй байна. Мөн Шүгдэн шүтэхийг онцгойлон дэлгэрүүлж байгаа явдал ч байсаар байна. Тэдгээртэй холбогдож буй хүмүүс болгоомжтой байж, сайн бодох хэрэгтэй. Төвдийн Чавдо, Враг-Яв болон Мар-Хам нутгийн зарим хийдүүд одоо ч Шүгдэнг шүтэхийг хүчтэй дэлгэрүүлсээр байна. Мөн Дэнма нутагт Шүгдэнг шүтдэг хүмүүс байдаг. Мар-Хам болон Враг-Явын лам нар Лхасад ирж Нитан Раваагийн орчмоор Шүгдэн

шүтэхийг дэлгэрүүлсээр байна. Лхасын Рамочэнбу Жүд-дод дацанд Мар-Хам нутгаас ирж суралцдаг лам нарын дунд Шүгдэн шүтэхийг уриалдаг хүмүүс байдаг. Төрөл дараалан заларсан Далай Лам нарын ачийг үл санаж, сургаалыг нь басамжилж байгаа бол тэдэнд гомдох зүйл байхгүй. Гэвч миний зүгээс энэ асуудлыг хэрэг болгон онцгойлон тайлбарлаад байдгийн учир нь бодит байдлыг мэдэхүй, ойлгоогүйн эрхээр алдаж, эндүүрч байгаа хүмүүс болон мунхгийн эрхээр даган дуурайж буй хүмүүст ойлгуулахын тулд юм. Бид тэднийг нигүүлсэнгүйгээр барих хэрэгтэй. Мэддэг нь бусдадаа тайлбарлаж өгөх хэрэгтэй. Би үүнийг маш чухал гэж үздэг.

Шүгдэнг шүтэхийг хориглосон шийдвэрээ би өөрийн дур зоргоор гаргаагүй. Би Павонка Ринбүүчийн номын дамжлагыг баригч Тижан Ринбүүчийн шавь. Анхандаа би Шүгдэнг шүтдэг байсан. Хожим гадна дотно, ил далд болж байсан олон асуудлаас үүдэн эргэлзэх болсон. Улмаар өмнөх Далай Лам нарын зохиол бүтээлийг судалж байх үедээ Шүгдэнг шүтэж байгаа маань алдаа болохыг ухаарч шүтэхээ больсон.

Шүгдэнгийн тухай энэ асуудал V Далай Ламын үеэс эхтэй. V Далай Лам Шүгдэнг танин барьж, энэ асуудлыг хэрхэн эцэслэн шийдэж байсныг нягталж үзсэн. Түүнчлэн тэр үеийн Төвдийн номын мэргэд, дээд төрөлхтөн нарын зохиол бүтээл, намтар зэргийг судалсан. Пүржог Агваанжамбын зохиосон "*Гурван Хийдийн Түүх*" (Дэнса Сүм-жи Лоржү) номын Гандан хийдийн тухай өгүүлдэг хэсэгт Шүгдэнг шүтэхийг хориглож байсан тухай гардаг. VII Далай Лам Галсанжамцын ёнзон багш Дэчин Агваанчогдон бээр Богд Ламын суудалд сууж байхдаа Гандан хийдэд ертөнцийн эгэл тэнгэр, сахиусыг шүтэхийг хориглож байсан. Энэ тухай Түган Чойжинямын зохиосон Жанжаа Ролбийдоржийн намтарт "Дэчин Агваанчогдон бээр Гандан хийдэд ертөнцийн эгэл тэнгэр сэлтийг шүтэх нь зохисгүй" хэмээн Шүгдэнгийн нэрийг шууд хэлж шүтэхийг хориглон, гадагш гаргаж байсныг тодорхой өгүүлдэг.

VIII Далай Лам Жамбалжамцын багш Ёнзон Ишжанцан бээр VII Ванчин Богд Дамбийнямаад сургаал

айлдаж "*Дашлхүмбэд шинэ сахиус гэгдээд байгаа энэ чөтгөр нэг л өдөр хуурна шүү!*" хэмээн сануулж байсан гэдэг. VIII Ванчин Богд Данбийванчүгийн намтарт "*Дашлхүмбэ хийдэд дахих хэмжээнд хүрсэн сахиусыг л шүтэхээс биш Шүгдэнг шүтэж болохгүй*" хэмээн зарлиг гаргаж нийтэд тарааж байсан тухай тодорхой өгүүлдэг. Ямартай ч өмнөх Далай Лам нарын намтар болон Шарын шашныг баригч ихэс дээдэс нарын намтрыг судалж үзэхэд эрдэм бүтээлийн оргилд хүрсэн мэргэд, дээд төрөлхтөн нар Шүгдэнг шүтэхийг хориглодог байсан нь тодорхой харагддаг. Би тэдгээрийг дагадаг.

Тэдгээр мэргэдээс хойших үеийн байдлыг яривал, Павонка Ринбүүчи болон түүнтэй нэг үед амьдарч байсан Хансар Доржчан нар Шүгдэн шүтэхийг дэлгэрүүлж байсан. XIII Далай Лам энэ тухай мэдээд "Энэ сайны шинж биш" хэмээн санаа зовон өгүүлж байсан гэдэг. Павонка Ринбүүчи залуудаа Бурханы шашны бүх урсгалыг ялгалгүй анхааран авдаг байсан. Хожим Шүгдэнг шүтэж эхэлснээсээ хойш хэрхэх болсныг өгүүлэх юун. Дамдин-Янсан Бурханыг хүртэл "Богд Ламын чуулганы оронд оруулан зурж болохгүй" хэмээн айлдаж байсан нь Павонка Ринбүүчийн намтарт тодорхой гардаг. Тэр намтар Энэтхэгт биш Төвдөд хэвлэгдсэн. Шүгдэнг шүтэх болсноос нь хойш XIII Далай Лам Павонка Ринбүүчийг таалахаа больсон байдаг. XIII Далай Ламыг таалал барахын өмнө Павонка Ринбүүчийн шавь Шидээ Дасүр хэмээгчийн зүүдэнд Шүгдэн ирэн "29-ийг дуусгаад битүүнд өнгөрнө!" хэмээн баярлан өндөр дуугаар өгүүлснийг Павонка Ринбүүчийд айлтгасан гэдэг. Үүний дараа Төвдийн тооллын 10-р сарын битүүнд XIII Далай Лам таалал барж уй гашуу болж байх үед "*Урьд Шүгдэн <<29-г дуусгаад битүүнд өнгөрнө!>> хэмээсэн нь XIII Далай Лам таалал барахыг эш үзүүлж байжээ*" хэмээн Павонка Ринбүүчи айлдаж байсан тухай намтарт нь гардаг. Эш үзүүлэх нь болохгүй зүйл биш болов ч баярлаад өндөр дуугаар эш үзүүлж байсан нь хачирхалтай. Цаст Төвдийн шашин төрд зарлигийн их ачтай хүнийг таалал барахад баясаж байсан нь сайны шинж үү, муугийн шинж үү бодох хэрэгтэй.

XIII Далай Лам амьд сэрүүн байхдаа Павонка Ринбүүчийд олон зарлиг буулгасны нэг нь “Шүгдэнг шүтэж болохгүй” тухай зарлиг байсан. Энэ нь Павонка Ринбүүчийд тийм ч амар байгаагүй юм. XIII Далай Ламыг таалал барж, зарлиг буулгах хүн үгүй болсон тул эгэл шавь нарын үзэгдэлд Павонка Ринбүүчи XIII Далай Ламын зарлигийг эвдсэн юм. Бодитой байгаа түүхийг мэдээд шударга оюунаар зөв бурууг ялгаж салгах нь маш чухал.

Өмнө өгүүлсэн олон учир шалтгааны улмаас би Шүгдэнг шүтэхийг хориглосон. Зүүдний тэмдэг ч олон гарсан. Ер нь энэ асуудлыг та бүхэн сайн магадлах хэрэгтэй. Энэ талаар ном хэрэгтэй гэвэл олон ном байна. Мэддэг хүмүүсээс нь сурвал олдоно.

Амаравватид Дүйнхорын авшиг тавьж байх үедээ би хэлж байсан: Төвдөөс цагаачилж гарсан гэвш, хувилгаад голлосон номын нөхөд бид өөрсдөө энэ асуудлыг чухалчилж, дорвитой шийд гарган, авла орхилыг үйлдэхээс биш, бүх үүрэг ачааг Далай Ламд даатгачхаад надад л ашиг хонжоо гарч байвал боллоо, бусад нь хамаа алга гэх байдал гаргаад суухын арга алга. Ойлгосон уу?

Энэтхэгт шинээр ирсэн төвдүүдийн дунд Враг-Яв, Мар-Хам, Чавдо, Дэнма нутгийнхантай холбоотой хүмүүс байвал тэдэнд энэ бүхнийг ойлгуулах хэрэгтэй. Энэ нь та нарын үүрэг юм шүү! Миний нүүрийг харахаараа тайлбарлаж байгаа дүр үзүүлэн, үнэн хэрэг дээрээ амин хувиа бодон сууж болохгүй шүү! Ганц нийтийн морин дээрээ л хамаг ачааг үүрүүлээд эцэстээ морьгүй болчихвол хэцүү болно шүү! Ойлгосон уу?

Миний хувьд амьдралын маань гуравны хоёр нь өнгөрсөн. Үлдсэн жилүүдийг жаргалтай өнгөрөөж байгаад явах нь ойлгомжтой. Ямартай ч бид бүгдээрээ Төвдийн шашин төрийн тухай санаа тавих хэрэгтэй. Төвдийн ард түмэн намайг горилон харж байдаг. Надад ч гэсэн урьдын үйл, ерөөлөөр холбогдсон төвдүүдийн өмнө хүлээсэн үүрэг гэж бий. Тиймээс бодит байдал, сайн муу, авах гээхийг заах нь миний үүрэг. Сонсох сонсохгүй нь та нарын мэдэх хэрэг.

Сон Ринбүүчийн урд дүр Шүгдэнг шүтэхийг хүчтэй дэлгэрүүлж байснаас гадна өөрөө ч маш их шүтдэг байсан.

Тэр үед надад Сон Ринбүүчийд бичиг илгээх хэрэг гарч байсан. Одоо энд морилж буй Сон Ринбүүчийн хойд дүр сайн мууг ялган нийт Төвдийн шашин төрийн тусын тулд эндүүрэлгүй сонголтыг хийсэн. Ринбүүчийг зөв мөрөөр явж байгаад би их баяртай байна. Танд “Баярлалаа!” гэж хэлье.

Төвдүүд бид өнөө үед эх нутагтаа байгаа болон цагаачлан гарсан гэсэн хоёр хэсэг болчхоод байна. Төвдөөс ном сонсохоор ирсэн та бүхэн эх нутаг уруугаа буцахдаа баяртайгаар буцах байсан боловч эрх чөлөөгүй болсон нутагтаа буцаж буй тул та нарын сэтгэл гансарч байгааг би ойлгож байна. Бид хүнд хэцүү цаг үед амьдарч байна. “Энд цагаачлан амьдардаг төвдүүд бид тун удахгүй эх орондоо буцаж, элэг нэгт ахан дүүстэйгээ баяртайгаар учрах болтугай” гэж би үргэлж ерөөл тавьдаг. Та нар нутаг орондоо баяр жаргалтай буцах хэрэгтэй. Та бүхэнд баярлалаа! Өлзий хутаг орших болтугай!

# 2006 оны 12-сарын 20-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Энэтхэгийн Варанасид “*Бодь Сэтгэлийн Тайлбар*”, “*Үзэл Бүхний Эхийг Танин Барихуй*” зэрэг номын хөтөлбөр болон Жанрайсиг Бурханы авшиг хайрлах үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Өнгөрсөн хоёр өдөр "*Бодь Сэтгэлийн Тайлбар*" болон "*Үзэл Бүхний Эхийг Танин Барихуй*" зэрэг номуудыг тайлбарласан. Энэ хоёр номд голлон Бурханы ном гэж юу болох, Бурханы номыг хэрхэн анхааран авах тухай номлодог. Харин маргааш шавь нарт нууц тарнийн авшиг хүртээнэ. Нууц тарнийн авшиг, адис жанлав, санваар хүртээхэд багш шавь хоёрын сүжиг болон тангараг ариун байх хэрэгтэй. Хүчтэй хатуу бишрэлтэй байж адис жанлав, шид бүтээл олохоос биш энгийн яриа сонсож буй мэт, эс бөгөөс тээнэгэлзсэн атгаг бодлоор нууц тарнийн авшиг айлтгаж болдоггүй. Тийм учраас би тангараг ариун бус байхыг цээрлэдэг. "Номд сууж буй хүмүүсийн дунд Шүгдэнг шүтдэг хүн байвал маргааш авшиг өгөх үеэр ирж болохгүй шүү!" гэж онцолж хэлье. Тангараг ариун бусаар нууц тарнийн авшиг, санваар хүртэх зан үйлийг үйлдвэл багш шавь хоёр хоёулаа гэмтэй болохоос гадна, тангараг ариун бусын шалтгаанаас болж багшийн насанд цөв гардаг. Шавьд ч гэсэн тус эрдэм гарахгүй.

Судрын ёсны номыг энгийн яриа сонсох мэт байдлаар сонсоход болохгүй зүйл байхгүй ч нууц тарнийн авшиг, санваар авахдаа сүжиг бишрэлийг голлон барьж, авшиг айлтгах хэрэгтэй тул багш шавийн тангараг ариун байх нь маш чухал юм. Энэ удаа Төвдөөс ирсэн хүмүүсийн дунд Шүгдэнг шүтдэг хүмүүс байж болох. Тэдгээрийн зарим нь шүтэж болохгүйн учир шалтгааныг мэдэхгүйн эрхээр шүтдэг

байж болох тул энэ тухай тодорхой тайлбарлая гэж бодлоо.

Би олон жилийн турш Шүгдэнг шүтэхийг хорьж, шүтэж болохгүйн учир шалтгааныг тайлбарласаар ирсэн. Шүгдэнгийн энэ асуудал V Далай Ламын үед гарсан. Энэ тухай хамгийн сайн мэдэж байсан хүн бол V Далай Лам юм. Цаст Төвдийн оронд ханьцашгүй их тус хүргэсэн V Далай Лам жишихүйеэ бэрх айлдал, онолын эрдмийг эрхшээсэн эгэл бус хүн байсан. Маш хурц ухаантай, бодит байдлыг олон талаас нь маш тодорхой болгоодог хүн байв. Тэрээр ертөнцийн эгэл төрөлхтөн адил уур шуналын эрхэнд орсон нэгэн байсан бол өөр хэрэг. Гэвч V Далай Лам тийм хүн байгаагүй. Винайн ёсыг баригч, нийт Бурханы шашин бүгдийг тааллалдаа төгс эрхшээсэн, Төвдийн шашин амьтныг дагуулан баригч хүн байсан. Магад утгадаа V Далай Лам номын их хаан Тисрон Дэзангийн үйлсийн хувилгаан юм. Номын хаан Тисрон Дэзанг Манзушир Бурханы хувилгаан гэсэн эш лүн олон байдаг. Хаан Тисрон Дэзан бол Ловон Бадамжунай болон Ханчин Шиванцоог Төвдөд залан шашин төрийн суурийг байгуулж, Цастын орныг таалал нигүүлсэхүйгээр барин тэтгэж байсан ачтан. Түүний таалал ерөөл хийгээд төрөл дараалын эрхсийг баригч V Далай Лам юмс бүгдийн чанагуух мөн чанарыг мэдсэн үнэнхүү эрдэм чадал төгөлдөр хүн байсан учир худал зарлиг айлдахгүй нь тодорхой. V Далай Ламын намтар "*Дүгүлийн Гой-сан*"-д олон ардад Шүгдэнгийн хорлол, ёр гарсанд хатуу үйл үйлдсэн тухай болон түүнийгээ гэрчилсэн "гэрч бичиг" зохиосон тухай тодорхой гардаг. Тэр гэрч бичиг V Далай Ламын сүнбүмийн "Да" ботид байдаг. Бичгийн оршил хэсэгт: "*...Ла-Ажалын хичээл зүтгэлээр хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр хэмээн хуурамчаар тодорсон тэрээр (эцэстээ) ерөөл буруудан тангаргийн буг болоод олон амьтанд хүчтэй ихээр хорлон хар ёр гарсанд хатуу үйлийг үйлдэн зохиов*" хэмээсэн байдаг. Тэр бичигт сахиусанд үйлсээ даатгасан хэдэн бадаг шүлэг байдгийн дотор:

"*...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн болон шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун...*"

хэмээн Зургаан мутарт Махгал, Балдан Лхам, Жалбуу Гүн-Аа, Сэтав, Улаан сахиус тэргүүтний нэрийг дуудан үйлсээ даатгасан байдаг. Гэрч бичиг дахь шүлгүүдийн үг бүр хурц, тод байдаг. Миний хувьд V Далай Ламын хойд төрлийг баригч учир түүний зохиол үйлсийн хойноос дагахаас биш алдаж эндүүрсэн мөрөөр явах эрхгүй.

Эхэндээ би мэдэхгүйн эрхээр болон өөр бусад нөхцөл шалтгааны улмаас Шүгдэнг шүтэж алдаа гаргаж байсан. Хожим янз бүрийн асуудал гарах болж, улмаар өмнөх Далай Лам нарын намтар болон гадна дотно болж буй байр байдлыг жил дараалан судалсны дүнд алдсанаа ухааран Шүгдэнг шүтэхээ больсон. Тэр цагаас хойш өнөөг хүртэл өөрөө ямар мэт мэдсэнчлэн бусдад ч мөн тэр мэт Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг тайлбарласаар байна.

Энэ тухай хэрхэн судалж байснаа нэг нэгэнгүй ярих хэрэг байхгүй байх. Жил дараалан маш сайн судлан нягталж үзээд Шүгдэнг шүтэхийг хориглосон болохоос биш өөрийн дураар хааш яаш шийдээгүй юм шүү! Цаст Төвдөд заларсан олон мэргэд, дээд төрөлхтөн нар Шүгдэнг шүтэхийг хориглодог байсан. Дэчин Агваанчогдон Богд Зонховын суудалд сууж байхдаа "Гандан хийдэд хийх юмаа олж ядсан зарим хүмүүс Шүгдэнг тахин шүтэж, онгодыг нь буулгадаг байсныг зогсоож, шүтээнийг нь нураалган шороог шороонд, чулууг чулуунд ялгуулж байсан" түүх намтарт нь тодорхой гардаг.

Шүгдэнг шүтэх шүтэхгүй нь хувь хүний хэрэг. Гэвч надад хүлээсэн үүрэг хариуцлага байдаг учраас би энэ тухай тайлбарладаг. Илүүтэйгээр авшиг, даган соёрхол, сахил санваар хүртээх үедээ би Шүгдэнг шүтдэг хүмүүсийг номын суудалд суухыг зөвшөөрдөггүй. Тиймээс Шүгдэнг тахиж шүтдэг хүмүүс байвал маргааш авшиг хүртээх үед ирж болохгүй шүү!

# 2007 оны 9-р сарын 12-ний өдөр. Дээрхийн Гэгээнтний Шүгдэнгийн тухай айлдвар

[<— Гарчиг руу буцах]

Бодит байдлыг шинжилж үзэхэд Шүгдэн анх V Далай Лам Лувсанжамцын үед гарсан байдаг. V Далай Лам Шүгдэнг хэнээс ч илүү сайн мэддэг байсан гэж хэлж болно. Тэрээр "Шүгдэнг шашин амьтанд хорлодог ерөөл буруудсан тангаргийн буг" гэж танин барьсан. "*Дүгүлийн Гой-сан*" хэмээх V Далай Ламын намтар дахь гэрч бичигт:

"*...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн болон шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун...*"

хэмээн бичсэн байдаг. XIII Далай Лам Түвдэнжамц Шүгдэнг шүтэхийг хориглодог байсан. Тэр үед Павонка Ринбүүчи Шүгдэнг шүтдэг байсан. Павонка Ринбүүчийг залуу байх үед XIII Далай Лам түүнд сайн ханддаг байсан ч Шүгдэнг шүтэх болсноос нь хойш таалахаа больж, "*Ерөөл буруудсан тангаргийн буг Шүгдэнг шүтвэл аврал одуулахуйн сургаалтай харшилна*" хэмээн зэмлэж байсан нь XIII Далай Ламын зарлиг бичгүүдэд гардаг. Урьд Брайбүн хийдийн тарнийн дуганд Шүгдэнгийн дүр байсныг XIII Далай Лам гадагш нь гаргуулж байсан гэдэг. V Далай Лам ерөөл буруудсан тангаргийн буг хэмээн танин барьсан, XIII Далай Лам шүтэхийг хориглож байсан Шүгдэнг шүтэх нь буруу гэж үзээд би шүтэхээ больсон. Үүний дараахан зарим нэг дацан хийдэд бэрхшээлтэй асуудлууд үүссэн юм. Голлон Гандан-Жанзэ дацанд олон бэрхшээл тохиолдсон. Шүгдэнг анхлан

тахисан хийдүүдийн нэг нь Гандан-Жанзэ дацан юм. Жанзэ дацанд өлзий бусын олон муу ёс гарсан. Тэр үед Тижан Ринбүүчи Жанзэ дацангийн лам нарт "Танай дацангийн сахиус хилэгнэж байна" хэмээн айлдаж байсан. Дараа нь намайг шинжиж үзэхэд Жанзэ дацангийн Лхам сахиус Шүгдэнгээс болж хилэгнэсэн нь тодорхой байсан тул би "Ийм явдал гарч байгаа нь сайн хэрэг биш шүү" гэж Жанзэ дацангийн лам нарт хэлсэн. Үүнээс хойш олон хүмүүст эргэлзээ төрөх болсон тул энэ тухай тайлбарлах шаардлага гарсан юм. Энэ нь миний үүрэг. Юугаа шүтэх нь хувь хүний хэрэг. Өөрсдөө шийдвэрээ гаргаад шүтэж байгаа бол миний зүгээс хэлэх зүйл байхгүй. Гэсэн ч энэ тухай олон нийтэд тайлбарлах нь миний үүрэг учраас би тайлбарладаг. Намайг ингэж тайлбарладгаас болж Шүгдэнг шүтдэг хүмүүс нийгэмлэг байгуулан хүн алах, галдан шатаах, худал хуурмаг юм бичиж, ном товхимол гаргах зэргээр гүжир гүтгэлэг олныг үйлдсэн. Улмаар Шүгдэнгийн нийгэмлэг Төвд дахь Шүгдэн шүтдэг хүмүүстэй холбогдож, хамтран Хятадын засгийн газартай харилцах болсон. Ингээд Шүгдэн хятад чөтгөр болж, хятадууд ивээх болсон юм. Швейцар болон Балбад байдаг Шүгдэнгийн нийгэмлэг Хятадын засгийн газартай ил, далдаар харилцдаг. Төвдөд байдаг Шүгдэнгийн нийгэмлэгийн хувьд бүр ч ойлгомжтой. Үүнээс болж Шүгдэнгийн энэ асуудал улам хурцадсан.

Хоёрт Шүгдэнг шүтдэг лам, хувилгаан хэн ч бай, зан авир нь их хэрцгий догшин болдог. Гаадамбын дээдсүүд бясалгаач хүн араатан амьтны арьсан дээр суувал сэтгэл догшрох гэмтэй хэмээн цээрлэдэг байсан. Шүгдэнг шүтдэг хүмүүс хүн алж, зодож нүдэх, айлгаж сүрдүүлэх, худал хэлэх, гүтгэж гүжирдэх, хутган үймүүлэх мэтийн бусармаг үйлийг шантралгүйгээр үйлддэг. Төвдийн шашин төрийн эсрэг хийж буй тэдний бусармаг үйлдлийг та бүхэн мэдэх хэрэгтэй.

# 2007 оны 11-р сарын 10-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэнд Халимаг, Буриад, Тувагийн Бурханы шашинтнууд бат оршил өргөх үеэр Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Монгол туургатан та бүхэн мэдэх байх. Дээр үед Төвдөд шашны сахиус эсэх нь эргэлзээтэй догшин буг гарсныг V Далай Лам Лувсанжамц бээр ерөөл буруудсан тангаргийн буг хэмээн танин барьсан юм. Шарын шашны эрдэм чадал төгс олон мэргэд, дээд төрөлхтөн нар V Далай Ламын тангаргийн буг хэмээн танин барьсныг хүлээн зөвшөөрч нийт Бурхан шашны таалалтай зохилдох зохионгуйг туурвиж байсан. Мөн зарим нэгэн үүнийг өөрөөр тайлбарлах явдал ч гаргаж байв. Би анхандаа Шүгдэнг шүтдэг байсан ч хожим үнэхээр шашны сахиус мөн эсэхийг нь судлах шаардлага гарч шинжилж үзэхэд шашны сахиус биш байснаар үл барам шашин амьтанд хорлогч буг болохыг мэдээд шүтэхээ больсон юм. Олон нийтэд үүнийг тайлбарладаг маань ийм учиртай. Энэ тухай худал юм ярьж явдаг хүмүүс байдаг тул та бүхэн үнэн зөвийг мэдэх хэрэгтэй.

# 2007 оны 12-р сарын 24-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Монгол орноос ном сонсохоор ирсэн сүсэгтэн олонд “*Багшийг Тахихуйн Хөтөлбөр*” номыг номлож байх үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

“... *Бурхад, бодьсадва, баатар дагинас, шашны сахиус далай мэт хүрээлэн оршсон...”* хэмээсэн нь бадамлянхуа суурины гуравдугаар эгнээнд Дүйнхор Бурхан голлосон Ханьцашгүй дээд тантрын бурхад, удаах эгнээнүүдэд дараалан Иогийн тантар, Явдлын тантар, Үйлийн тантрын бурхад, Сайн цагийн мянган бурхан, Өөрөө ялгуусан, Сонсоод сонсгогч, Баатар дагинас, Номын сахиуснууд байна. Номын сахиусанд голлон Махгал, Намсрай, Дамжан-Чойжал гурвыг байрлуулдаг. Энэ гурав нь ертөнцөөс гэтэлсэн шашны сахиус тул бадамлянхуа суурин дээр оршдог. Харин дөрвөн Махаранз нь ертөнцөөс гэтлээгүй учир бадамлянхуа суурин дээр биш галбарваас модны дөрвөн талд үүл хөлөглөснөөр байрлуулдаг. Ертөнцөөс гэтлээгүй эглийн хилэнтэн нарыг чуулганы орны дотор байрлуулдаггүй ёстой. Дээр үед нэгэн хүн Ёнзон Ишжанцанд сахиусны дунд нь эгэл савдаг байрлуулж зурсан чуулганы орны зургийг үзүүлсэнд Ёнзон Ишжанцан бээр “*Савдагны оронд чандмань эрдэнэ зурвал сайн байжээ”* хэмээн айлсан гэдэг. Саяхан Италид ном тавих үеэр Ганжан лам болон Шүгдэнгийн нийгэмлэгээс сахиусны дунд нь Шүгдэнг байрлуулж зурсан багшийг тахихуйн чуулганы орны зургийг тарааж байсан. Хүмүүс “багшийг тахихуйн чуулганы орны зураг ийм байдаг юм байна” гэж бодох гэмтэй байсан учраас маргааш өдөр нь Томто Ринбүүчи номд сууж буй хүмүүст чуулганы орны зураг ямар байх ёстойг тайлбарлах шаардлага гарсан юм.

Англид байдаг Галсанжамц хэмээх төвд лам “Шүгдэнг ядам бурхан” хэмээн үздэг. Хэрвээ Шүгдэн ядам бурхан юм бол түүний тарнийн дамжлага болон тантрын аймгаас номлосон нямба бүтээлийг нь хийх арга, гурван лагшинг мөрд авах ядам бурханы иог зэрэг байх хэрэгтэй. Тиймгүй бол ядам бурхан гэж үзэж болохгүй.

Монголчууд та бүхэн ч гэсэн багшийг тахихуйн чуулганы орны зургийг эндүүрч мэдэх тул үүнийг сайн мэдэж аваарай. Шүгдэнгийн тухай гол зүйлүүдийг та бүхэн мэдэж байгаа. Өмнө нь ч тайлбарлаж байсан. Банчин игчааний нэг дацан (Гунгаачойлин) урьд нь Шүгдэнг сахиусанд тахиж байсан ч хожим тахихаа больсон нь сайшаалтай.

# 2007 оны 1-р сарын 11-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Өмнөд Энэтхэг дэх Сэра хийдэд хуран цугласан Төвдийн шашин төрийн сайд, хутагт хувилгаад тэргүүтэн ард иргэдэд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

“Молцог туулай зөөлөн арьстай, молтгор хоншоорыг нь ярих хэрэггүй” гэсэн хэлц үг байдаг. Бид нар өмнө нь туулайн зөөлөн арьсны тухай ярьсан. Одоо молтгор хоншоорынх нь тухай ярих хэрэгтэй байна. Сэра-Мэ дацангийн хамба, хансүр, номын багш, лам хувраг та бүхний ихэнх нь тангараг доройтоогүй ариун байгаа нь сайн хэрэг. Би Сэра-Мэ дацанд өмнө ирэхдээ *“Сайн Номлолын Зүрхэн”* номын эш хөтөлбөрийг хураангуйлан тайлбарлаж байсан. Өнөөдөр энд баяртайгаар ирсэн ч Сэра-Мэ дацангийн Бомра аймаг Шүгдэнг үргэлжлүүлэн шүтсээр байна. Бомра аймагт буян нүглийг ялган мэдээд тангараг ариун болсон лам нар олон байгаа. Тэд өнөөдөр энд ном сонсохоор ирсэн. Өчигдөр Жүмэ дацанд ном тавих үед “Бомра аймгийн олон лам нар ирсэн” гэж хамба лам надад хэлсэн. Гэсэн хэдий ч Бомра аймагт одоо ч Шүгдэнг шүтдэг хүмүүс байсаар байна. Тэдний зарим нь мэдэхгүйн эрхээр, зарим нь мэдсэн ч тоохгүй шүтэж байгаа тул өнөөдөр энэ тухай дахин тайлбарлая гэж бодлоо. Зарим нэгнийх нь чих хорсож магадгүй шүү. Энэ ажлыг би эхлүүлсэн. Эхлүүлсэн ажлынхаа эцсийг магадтай үзнэ гэж боддог. Эхлүүлэх учир шалтгаан байсан учраас эхлүүлсэн юм. Үүнийг эхлүүлбэл асуудал гарна гэдгийг ч би тодорхой мэдэж байсан. Шүгдэнг шүтэхийг хориглохоос олон жилийн өмнө Найчүн сахиус буухдаа Шүгдэнгийн талаар хэлж байсан. Тэр үед би Найчүн сахиусанд “Чимээгүй байвал сайн. Энэ их төвөгтэй хэрэг” гэж хэлсэн. Энэ явдал бараг гуч, дөчөөд жилийн өмнө

болсон. Үүнээс хойш Шүгдэнтэй холбоотой олон муу нөхцөл байдал үүсэх болсон. Анхлан Шүгдэнг шүтэхийг сайшаасан *"Пагод Ламын Шаллун"* нэртэй ном гарч байв. Энэ ном хэрхэн гарсан түүхийг нарийвчлан ярих хэрэггүй байх. Бэрхшээлтэй асуудлууд ар араасаа гарч байсан учраас олон талаас нь судалж үзэх шаардлага гарч нягталж, судалж үзсэн. Улмаар Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг мэдээд шүтэхийг хориглосон.

Өнөөдөр энд олон хүн цугласан байгаа тул Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг тодорхой тайлбарлая гэж бодсон юм. Би өөрийгөө хурц ухаантай гэж хэлэхгүй. Гэхдээ тийм ч ухаан муутай хүн бас биш. Юмсын цаад учир шалтгааныг судалж, мэдэх дуртай. Бурхан Багшийн гүн хийгээд агуу их номын ёсонд, цаад учир шалтгааныг мэдсэн сүсэг бишрэл төрүүлэхийн тулд Бурханы номыг судалж, шинжилж, ажиглах хэрэгтэй гэснээс биш аварч өршөө хэмээн өгүүлэх төдийгөөр болчихно гэж үздэггүй. Оюун ухаанаа ажиллуулж, учир шалтгааныг шинжилж, Бурханы номын гайхамшгийг мэдэх үед "Бурхан Багш үнэхээр бусдаас өөр, эгэлгүй нэгэн юм даа" гэсэн бишрэх сэтгэл өөрийн эрхгүй төрдөг. Бурханы номын гол увдис шим нь асрал нигүүлсэл, бодь сэтгэл болон хоосон чанарын үзэл юм. Сүртэй сахиусанд сэтгэл татагдсандаа Бурханы номыг гайхамшигтай гэж үзэж болохгүй. Эрт цагт Цогт Наландарын хийдийн номын дамжлагыг баригч дээдсүүд Нагаржунайн айлдсан *"Билгүүний Үндэс"* зэрэг номыг судалж мэдээд сэтгэл булаагдан, "Үнэхээр мэргэн бандида юм даа." хэмээн сүсэглэдэг байснаас биш "Нагаржунай ийм сүр хүчтэй ядам Бурханыг бясалгадаг байсан", "Нагаржунай тэр Бурханы талаар ингэж айлдсан" гэх төдийгөөр "мэргэн бандида юм даа" гэж сүсэглэдэггүй байсан. Бурханы номын гайхамшиг асрал нигүүлсэл, бодь сэтгэл, хоосон чанарын үзлээс гардаг болохоос биш сүр хүчтэй ядам Бурханаас гардаггүй. Асрал нигүүлсэл хийгээд бодь сэтгэлийг дээш арвитгах арга болгож ядам Бурхадын бүтээл, гүн ялгамжаат увдисыг бясалгадаг. Асрал нигүүлсэл, бодь сэтгэл, хоосон чанарын үзэл дээр суурилаагүй л бол ямар ч ядам Бурханы гүн ялгамжаа гардаггүй. Цаст Төвдийн орны Бурханы шашин

гайхамшигтай байдгийн учир нь, бидэнд Цогт Наландарын номын дамжлага, асрал, нигүүлсэхүй, бодийн сэтгэл хийгээд хоосон чанарын гүн нарийн үзлийн тухай гайхамшигтай номлол байдаг учраас тэр юм. Тиймээс л Цогт Наландарын номын дамжлагыг гайхамшигтай номын ёс мөн хэмээн өндөр дуугаар магтдаг. Урьд Төвдөд Цогт Наландарын хийдийн хир үгүй номын дамжлага доройтож байсан байх. Гаадамбын дээдэс нарын аман дамжлагад Адиша Богд бээр, *"Дан ганц мөрийн зэргийн номлолоор бололгүй нууц тарнийг ч гэсэн нэмж номлохгүй бол болохгүй нь, цалгардсан байна"* хэмээн айлдсан түүх байдаг. Бид нар асрал нигүүлсэл, бодь сэтгэл, хоосон чанарын утгыг тайлбарлахыг тухайлан ойшоолгүй ядам Бурханы нямба бүтээл, тэнгэр, лус тахихыг ихэд дэлгэрүүлсэн байдаг. Нууц тарнийн бясалгал бүтээл бүгд бүрдсэн бол сайн хэрэг. Тарнийн номыг бясалгахын өмнөх анхааран авлагыг бүрдүүлэхгүйгээр тарнийн мөрд орших нь ерөнхийдөө Бурханы шашин дэлгэрэхэд том саад тотгор болдог.

Бид нар Цогт Наландарын хиргүй ариун номын дамжлага үүнийг барилгүй, үндсийг нь орхиод мөчрийг нь барьж байгаа нь үнэхээр харамсалтай. Үүнийг би хүмүүст байнга хэлдэг. Өөрөө ч ийн анхааран авдаг. Сэра-Мэ дацанг харахад тахилын эд хэрэгсэл маш их байна. Ашиг тус нь үүнийг хийсэн урлаач болон оёдолчдод очихоос бус өөр тус өгөөжөөр хомс. Бурханы дүр бүтээх нь сайн хэрэг. Гэвч Бурханы дүр баримал ном номлодоггүй. Бурханы эрхэм зарлиг нь гагцхүү цаасан дээр бичигдсэн ном юм. Бурханы лагшин, зарлиг, тааллыг дүрсэлсэн дүр нь сүжиг төрүүлэхийн тулд байх ёстой. Бид анх цагаачлан ирээд хулсан байшинд сууж байхдаа ганц хоёрхон Бурханы жижиг дүртэй байдаг байсан. Түүнээс хойш томруулан бүтээсээр ирсэн. Энэ нь аяндаа бүтчихдэг бол сайн хэрэг. Бурханы дүр л бүтээхийг хүсээд, үндсийг орхиод мөчрийг барьж байгаа нь үнэхээр харамсалтай. Бурханы номыг хэвлэн гаргах нь чухал. Данжуур доторх Наландарын мэргэдийн номлолыг үзэж судлах нь чухал гэж ярьдгийн минь учир үндсийг нь орхихгүйн тухайд юм. Энэтхэгийн арван долоон их бандидын зохиолуудад хэнгэрэг цохих, дун үлээх, ганлин

аялгуулан татах аргыг огтхон ч номлоогүй. Гол үндэс нь хаана байна, түүнийг л барих нь чухал. Цогт Наландарын хир үгүй гайхамшигт номын дамжлага нэг л мэдэхэд тэнгэр лус тахих зан заншил мэт болчихвол үнэхээр харамсмаар хэрэг болно шүү.

Манай төвдүүдийн дунд тэнгэр, лус тахин шүтэх байдал их дэлгэрсэн байдаг. Ядам Бурханаас догшин сахиусыг илүүд үзэх нь эндүүрэл юм. Үүнийг би байнга хэлдэг. Манай хийд сүмүүдэд Бурхан Багшийн дүр залсны урд утаа баагьсан зул л өргөдгөөс биш “Цаглашгүй ачит Бурхан Багш бидний аврал итгэл, өмөг түшиг мөн шүү” гэсэн сүжиг бишрэл төрүүлдэггүй. “Энэ хойд насыг минь болгоо” гэх сэтгэл төрүүлдэггүй. Тэгсэн хирнээ тусгайлан барьсан байшин дотор янз бүрийн зураг, араатны дүрсийг оруулан зурсан догшин сахиусны хөргийн өмнө сэржим өргөж, тусад нь дуганч гарган тахиулдаг. Хүмүүс ч түүнд нь сэтгэл итгэмжлэн ерөөл тавьж, залбирал үйлддэг. Уг нь сэтгэл итгэмжилж аврал айлтгах орон нь Бурхан Багш байтал түүнд сэтгэл итгэмжлэлгүй доор нь буй сахиусанд итгэл, аврал айлтгадаг нь эндүүрэл юм шүү. Бидний энэ байдал үнэхээр хачирхалтай. Ямартай ч чуулганы оронд Багш, Ядам, Бурхад, Бодьсадва, Баатар, Дагинас, Номын сахиус зэрэг дараалсан байдагчлан номын сахиусыг доор нь байрлуулдаг. Павонка Ринбүүчийн бүтээлгэсэн Богд Ламын чуулганы орны дотор Шүгдэн битгий хэл Жалбуу Гүн-Аа сахиусыг ч оруулаагүй байдаг. Тижан Ринбүүчи, “Ертөнцөөс гэтэлсэн тэнгэр, сахиус хүний биед буудаггүй. Хүний биед буудаг нь ертөнцийн тэнгэр, сахиус юм” хэмээн айлдаж байсан. Шүгдэн нь ертөнцийн эгэл омогтны тоонд ордог.

Мэргэ төлгийн номд, цөв саад гарвал буцаах арганд тэнгэр, лус тахиулах хэрэгтэй гэж гардаг. Иймэрхүү номууд урьдын цаг үед тухайн үеийн хүмүүсийн бодол санаа, нийгмийн байдалд нийцүүлэн зохиогдсон байх нь олонтой. Хэрвээ Бурхан Багшаас асуусан бол “Үйлийн үрийг сана. Бодь сэтгэлийг бясалга. Хоосон чанарын үзлийг бод.” хэмээн айлдах байснаас биш “Баруун зүгээс лус хорлосон байна. Лус тахиул. Зүүн зүгийн тэнгэр хорлосон байна. Тэнгэр тахиул.” гэж айлдахгүй байсан. Үнэхээр Бурхан Багшийг дагагч сайн

шавь нь юм бол Бурханы таалалтай нийцсэн мөрөөр явах хэрэгтэй. Хувилгаад, лам нар үйлийн үр, хилэнц нүгэл наманчлах болон бодь сэтгэл дадуулах номыг заан сургаж байвал сайн. Тэгэлгүй мэргэ, төлөгнийхөө номыг уншаад “Тэнгэр тахиул. Лус тахиул. Буг тахиул.” гээд суувал сайн хэрэг биш шүү!

Би шашны урсгалууд хоорондын эв эеийн төлөө чармайн хичээж ирсэн. Ганц Бурханы шашин төдийгүй дэлхийн бусад шашин, шашны удирдагчдыг үнэн сэтгэлээсээ хүндэтгэдэг. “Шүтэн барилдлага”, “Би үгүй”-н үзлийг баримталдаг учраас бусад шашны номлолд сүжиглэдэггүй ч маш их хүндэлдэг. Учир нь тэдгээр шашнууд дэлхийн олон хүмүүст тусалж байна. Бусад шашинд Бурханы шашнаас илүү номлол байхгүй ч гэсэн, бусдад хорлолгүй зам мөрийн тухай сайхан сургаал сургадаг. Пали хэлээр дамжигдаж ирсэн Бурханы шашны номын дамжлагыг баригч нарыг би “Бурхан Багшийн ахмад шавь нар мөн” хэмээн нэгэн үзүүрт сэтгэлээр бишрч сүжиглэдэг. Цаст Төвдийн Сажава, Нинмава, Гаржүдба, Гэлүгба, Жононба гээд дамжлага бүгдэд бишрэн сүжиглэдэг. Мөн бөө мөргөл нь төвдүүд бидний өвөг дээдсийн шүтлэг мөн тул найр тавин хүндэлдэг. Сүүлд Бурханы шашны нөлөөгөөр бөөгийн номд хоосон чанарын үзэл болон бодь сэтгэлийн талаар номлодог болсон. Сажава, Нинмава, Гаржүдба, Гэлүгба, Жононба гээд Бурханы шашны дамжлага, урсгал хоорондын тангараг ус сүү сүлэлдсэн мэт байж, тус тусын мэргэд эв этэй, ариун сэтгэлийн үүднээс харилцан бие биенийхээ увдис, авшиг, эш хөтөлбөрөөс суралцаж анхааран авснаа бусдад заан сургаж байвал Бурханы шашин цэвэр ариун байх юм. Миний хувьд Энэтхэгт ирснээсээ хойш Сажава, Нинмава, Гаржүдба, Гэлүгба гээд Төвдийн Бурханы шашны дамжлага, урсгал бүгдийг чухалчлан анхаарч ирсэн.

Дарамсалад шилжин ирээд удаагүй байх үед Күнү нутгаас нэгэн настай хувраг надтай уулзахаар ирсэн юм. Их сайхан сэтгэлтэй хүн байсан. Тэр өвгөн лам надаас *“Зогчэнгийн Сэтгэлийн Хөтөлбөр”-ийг (Зогчэн-жи Сэмтид)* зааж өгөхийг хүссэн юм. Тэр үед би мэдэхгүй байсан учраас “Күнү Лама Ринбүүчийд айлтган заалгавал сайн. Би

мэдэхгүй" гэж хэлсэн. Дараа нь их гэмшсэн. Хөгшин настай хүн надад сэтгэл итгэмжлэн ирж байхад би түүний хүслийг гүйцээж чадаагүй. Өөрийнхөө мэдэхгүй эрдмийг хүнээс асууж сурч мэдэхээс бус хүнд худал хэлэн өөрт байхгүй эрдмийг зааж болдоггүй. *"Илт Онохуйн Чимэг"* номд: *"Амьтны тусыг үйлдэгч нугууд гэтлэхүйн мөрийг мэдсэнээр ертөнцийн тусыг бүтээн зохиодог"* хэмээн Бодьсадва нар Шарвага болон Брадигабуддын мөрийг мэдэх хэрэгтэйг айлдсан байдаг. Бодьсадва ямар ч хэрэггүйгээр Шарвага нарын дунд 7 хоновол бодьсадвын санваарт нь унал гардаг ч Шарвага болон Брадигабуддын номд суралцах хэрэгтэй байдаг. Тэдгээрийн номд суралцдагийн учир нь тэдгээрт туслахын тулд юм. Төвдөд Сажава, Гэлүгба, Нинмава, Гаржүдба гээд дамжлага урсгалууд дэлгэрсэн байдаг. Ийм нийгэмд туслахын тулд эдгээр Бурханы шашны дамжлага, урсгал бүгдийг мэдэх ёстой. Гэвч тэр үед надад тийм боломж байгаагүй. *"Илт Онохуйн Чимэг"* номын таалалтай зохилдон настай хүний хүслийг биелүүлж чадаагүйдээ би их харамссан.

Хоёр ёнзон багшаасаа өөр багшаар ном заалгах бүрдээ би Лин Ринбүүчи багшаасаа асууж зөвшөөрөл айлтгадаг байсан. Нэгэн удаа Лин Ринбүүчийд *"Тантрын Нууц Шим"* номын талаар айлтгасан юм. Энэ ном нь Нинмавын гол ном бөгөөд Сандуйн Жүд дэх "зургаан хязгаар, дөрвөн ёсны" тухай номлол энэ номд маш тодорхой гардаг тул Күнү Лама Ринбүүчийгээр заалгах хүсэлтэй байгаагаа айлтгахад багш маань, заалгаагүй нь дээр хэмээсэн юм. Шалтгаан нь ойлгомжтой байсан. Тэр үед "Шүгдэнг тахиж шүтдэг хүн Нинмавын (*Төвдөд Бурханы шашны түрүү дэлгэрэлтийн үед Ловон Бадамжунайгаас дамжсан тарнийн дамжлагыг голлон баригчдыг нинмава гэдэг. Орч.*) номыг сонсвол Шүгдэн сахиус хорлоно" гэсэн цуу яриа хүчтэй байсан. Багш маань үүнээс болгоомжилсон хэрэг. Тэр үед Күнү Лама Ринбүүчийгээр *"Тантрын Нууц Шим"* номыг заалгаж чадаагүй нь өнөө үеийн яриагаар бол надад "шашин шүтэх эрх" байхгүйн улмаас болсон хэрэг. *"Илт Онохуйн Чимэг"* номд айлдсанчлан ялгаварлалгүйгээр суралцсан бол сайн байх байсан боловч Шүгдэнгийн тухай атгаг бодол болон

“Шарын шашинтан Нинмавын номыг сонсвол Шүгдэн гэсгээнэ.” гэсэн цуу ярианаас болоод тэр үед би Нинмавын номд суралцах боломжоо алдсан юм. Шүгдэнг тахиж шүтдэг хүмүүс Бурханы шашны дамжлага, урсгалуудад ялгаварлалгүйгээр суралцах болон харилцан эв этэй, ус сүү сүлэлдсэн мэт оршиход саад болохоор үл барам жирийн нэгэн бодгаль Бурханы шашны дамжлага, урсгалд алагчлалгүй суралцаж, анхааран авахад хорлодог. *“Пагод Ламын Шаллүн”* номыг уншвал энэ бүгдийг мэднэ. Уг номд бидний өмнөх үеийн Шарын шашны лам, хувилгаад болон төрийн албан тушаалтнууд Нинмавын номыг судалснаар Шүгдэнд хорлогдож байсан түүхийг бичсэн байдаг. Үнэндээ тэр номд Бурханы шашны дамжлага, урсгал хоорондын эв эеийг эвдэхээс өөр тус байгаагүй юм.

Энд морилсон Сон Ринбүүчи Шүгдэнг шүтэж болохгүйн учир шалтгааныг ухаарч, их сэтгэл гарган авла орхилыг эндүүрэлгүйгээр ялган үйлдсэнд би их баярладаг. Сон Ринбүүчийн өмнөх дүр Энэтхэгт ирээд Шүгдэнд амиа тушаасан гэдэг.

Дээр үед хүмүүсийн дунд “Шүгдэнг тахиж шүтвэл эд хөрөнгө арвижиж, худалдаа наймааны ашиг ихэснэ” гэх олон цуу яриа байсан. Их мөнгөтэй болно гээд Шүгдэнгийн бумба тахиулах явдал суурин газруудад элбэг байв. Иймэрхүү ярианаас болж зарим айлууд *“Бадамгатан”* тэргүүтэн Нинмавын номыг шүтээндээ залж чадахгүйд хүрч бусдад өгөх гэхчлэн олон бэрхшээлтэй асуудлууд гарч байв. Ер нь Шүгдэн Бурханы шашинтнууд харилцан талцахгүй ах дүү мэт эв найртай оршиход маш том саад болдог.

Энэ ташрамд нэг түүх ярья. Та нар бараг мэдэж байгаа байх. Дарамсала дахь Тэгчэнчойлин хийдэд Бурхан Багш хийгээд нигуурыг нь зүүн зүгт Төвд үрүү хандуулан байрлуулсан Жанрайсиг Ранжүн-Аадан болон Ловон Бадамжунайн дүрийг бүтээлгэн залсан байдаг. Бурхан Багш шашны эзэн тул дүрийг нь шүтээний голд залсан. Хажууд нь Жанрайсиг Ранжүн-Ааданг залсан нь Лхасад соёлын хувьсгал гарахын өмнөхөн миний зүүдэнд шинж тэмдэг гарсан болон мөн Найчүн сахиус, “Дарамсалад Лхасын зүг харсан Жанрайсиг Ранжүн-Ааданг бүтээлгэж, равнай өргөх

хэрэгтэй.” хэмээн эш үзүүлсэн учраас залсан юм. Тэр зүүдэнд “Би Лхасын Зуугийн дуганд явж байсан. Жанрайсиг Ранжүн-Аадангийн дүрийн өмнө очих үед яг л амьд юм шиг над уруу мишээн харж “нааш ир” хэмээн дуудсан юм. Намайг өмнө нь очин хүзүүнээс нь тэврэх үед Жанрайсиг,

“*Хичээнгүйг туурвисны хичээлээр*
*Хойрго залхуурлын эрхэнд оролгүй*
*Хөрвөх үгүй бие сэтгэлийн хүчээр*
*Хичээнгүйн чанадад хүрэх болтугай* хэмээх шүлгийг

айлдахад би даган уншсан. Үүнээс хойш удалгүй Төвдөд соёлын хувьсгал гарах үед Жанрайсиг Ранжүн-Ааданг нураасан сэтгэл уйсам явдал болсон. Тэр үед би зүүдээ онцгойлон чухалчлаагүй ч дараа нь бодоход “Сэтгэлийн хүчээ бүү алд. Хичээх хэрэгтэй” гэсэн утгатай болохыг мэдсэн. Лхасын Зуугийн Жанрайсиг Ранжүн-Ааданг эвдэн буулгасан бутархайнаас Дарамсалад авчруулан сүншигт нь оруулж Тэгчэнчойлин хийдийн Жанрайсиг Ранжүн-Ааданг бүтээсэн юм. Бүтээхдээ хожим сууриас нь салган Төвд үрүү нутаг буцах үедээ авч явах боломжтойгоор бүтээлгэсэн.

Тэгчэнчойлин хийдэд Ловон Бадамжунайн дүрийг бүтээн залсны учир нь, Тисрон-Дэзан хаан төвдөд Ловон Бадамжунай болон Хамба Шиванцо хоёрыг залж Бурханы шашин бат орших суурийг тавьсан юм. Нийтийн үзэгдэлд Их Хамба Шиванцо шашныг анхлан дэлгэрүүлэхэд саад болж байсан Төвдийн тэнгэр, хүн хийгээд хар зүгийнхэн бүгдийг номхтгож чадахгүй байсан учир арвис тарнийг баригч Ловон Бадамжунайг залснаар Хамба, Ловон, Хаан гурав цугласан юм. Ловон Бадамжунай ном бусын хар зүгийнхнийг номхтгоход гол үүрэг гүйцэтгэсэн бол Хамба Шиванцо лам нарт сахил санваар хүртээх зэргээр шашны суурийг тавьсан. Ловон Бадамжунайн зохиол үйлсийн нэг нь, Хаан Тисрон-Дэзан тэргүүтэн онцгой шавь нартаа найман зарлигийн авшиг тэргүүтэнг хайрлаж, нууц тарнийн номын хүрдийг эргүүлэн зохиосон нь юм. Нөгөө нь, ном бусын хар зүгийнхнийг номхтгон зохиож Цаст Төвдийн оронд Бурханы шашны суурийг тавьж, дэлгэрүүлж чадсан нь юм. Ловон Бадамжунайн таалал ерөөл хар зүгийнхнийг сүрээрээ дарах байсан. Одоо ч гэсэн төвдүүд Ловон Бадамжунайд соёрхол

тавихыг аньс ихтэй гэж тооцдог. Тиймээс Ловон Бадамжунайн дүрийг бүтээлгэн залсан юм. Ловон Бадамжунайн дүрийг залах болсон өөр нэг шалтгаан нь: 1956 оны үед байх, Чэнзэ Чойжилодой Ринбүүчийг Лхасад морилох үед би Ринбүүчитэй Норвулингад уулзсан юм. Норвулингааг үзсэний дараа Ринбүүчи Симчүнд морилох үедээ “номын барилдлага тогтоох хэрэгтэй байна” гэж айлдсан учир Симчүнд морилсон эхний өдөр *“Төгс Баясгалант Олон Тэнгэр”* (Гандан Лхавжаама) номын эш хөтөлбөрийг хөтөлж өгөхийг хүссэн дагуу нь Ринбүүчийд хөтөлж өгсөн. Тэр үед анзаараагүй л болохоос Ринбүүчи Бурханы шашны дамжлага, урсгал бүгдийг алагчлалгүй анхааран авдаг нэгэн байсан. Түүний шавь Хамба Ринчинг настай хүмүүс мэдэх байх. Тэр хэдийгээр Сажавын лам ч гэсэн Чэнзэ Ринбүүчигээс увдис сонсож, Зогчингийн номыг анхааран авдаг нэгэн байсан. Төвдөд байхдаа Гэлүгбын *“Сайн Номлолын Алтан Эрхэс”* (Лэгшэд Сэрпрэн) номыг үзэж байсан бол Энэтхэгт ирээд *“Төв Үзлийн Тааллыг Машид Тодруулагч”* (Ум-гонбо Равсал), *“Билгүүний Үндсийн Их Тайлбар”* (Заши Тигчэн) зэрэг номуудыг үзсэн гэдэг. Тэрээр Сажавын, Нинмавын гээд бүх номыг номлож чаддаг нэгэн байв. Бурханы шашны дамжлага, урсгал бүрийг алагчлалгүй анхааран авах нь үнэхээр номын ёс юм.

Чэнзэ Чойжилодой Ринбүүчи Лхасад морилохдоо, “Цаг хэцүү болсон байна. Лхасын гол дуганы дөрвөн талд дөрвөн суварга босгож, Зуугийн дуганы хот мандлын тавцан дээр Ловон Бадамжунайн гурван ертөнцийг сүрээр дарсан дүрийг бүтээлгэн залбал шашинд тустай.” хэмээн айлдаж байсан. Тэр үед би, “Хам нутгаас ирсэн Нинмавын энэ хувилгаан ийн эш үзүүлсэн нь ямар учиртай юм бол доо” гэж бодсоноос биш суварга босгоогүй. Харин Ловон Бадамжунайн дүрийг бүтээлгэе гэж шийдээд Ловонгийн энэтхэг дүрийг бүтээлгэсэн юм. Дараа нь энэ тухайгаа Чэнзэ Чойжилодой Ринбүүчийд айлтгахад Ринбүүчи уулга алдан “Уул нь Ловон Бадамжунайн энэтхэг дүрийн оронд гурван ертөнцийг сүрээр дарсан дүрийг бүтээх хэрэгтэй байсан юм. Ноёд түшмэд нийлсэн цөөхөн хэсэг хүн л Энэтхэгт гарч чадах нь дээ.” хэмээн айлдсан юм. Би үүнийг бодох бүрдээ

гэмшдэг. Муу цагийг буцаахын тулд Бурханы лагшин, зарлиг, тааллын шүтээнийг бүтээх хэрэгтэй тухай Ловон Бадамжунайн эш лүндэн олон байдаг. Чэнзэ Чойжилодой Ринбүүчийн эш үзүүлсэнчлэн тэр үед Зуугийн дуганы хот мандлын тавцан дээр Ловон Бадамжунайн гурван ертөнцийг сүрээр дарсан дүрийг бүтээн залсан бол тус гарах нь магадтай байсан ч тэр дагуу бүтээж чадаагүй нь харамсалтай. Тиймээс Дарамсалагийн гол дуганыг босгох үед Ловон Бадамжунайн гурван ертөнцийг сүрээр дарсан дүрийг бүтээн залсан юм. Ловонгийн дүрийг залсны дараа надад "Делигээс хэдэн гэлүгбын шашинтан өргөлөө" гэсэн захидал ирсэн. Тэр захидалд, "гол дуганд Богд Зонховын дүрийг залах хэрэгтэй болохоос биш Ловон Бадамжунайн дүрийг залах нь зохисгүй" тухай бичсэнийг уншаад би өөрийн эрхгүй уулга алдсан. Би Гэлүгбын шашны тулд биш, Нинмавын шашны ч тулд биш нийт төвдүүдэд тустай хэмээн санаад Ловон Бадамжунайн дүрийг гол дуганд залсан. Гэвч иймэрхүү нэг зүг үрүү хэт туйлширсан эсэргүүцэл гарсан юм. V Далай Лам *"Арвисыг Барихын Язгуурыг Бүтээхүй"* (Ригзин Дүндүв) хэмээх шинийн аравны зан үйлийн номыг зохиож нийт Төвдийн шашин, амьтны тусын тулд төвд даяар дэлгэрүүлж шинийн аравны зан үйлийг үйлдүүлэх нь шүтэн барилдлага сайтай хэмээн таалж байсан ч тэр үед гарч байсан шашны дамжлага, урсгал хоорондын таарамжгүй байдлаас болж нийтэд түгээх таалал нь бүтээгүй юм. V Далай Лам энэ тухай *"Арвисыг Барихын Язгуурыг Бүтээхүй"*-номынхоо төгсгөлд, "Төвд орны тусын тулд Ригзин Дүндүвийн зан үйлийн үүднээс соёрхол тавих нь сайн хэмээн санаад бичсэн боловч нийтэд дэлгэж эс чадав. Гэвч ирээдүйд Төвдийн шашин төрд тустай хэмээн сэтгээд дуусган бичив." хэмээсэн байдаг. Тэр цаг үед ч Төвдийн шашны гол дамжлага, урсгалууд хоорондоо таарахгүй явдал гарч байсан. Ихийг харалгүй багахан юмны төлөө тэмцэлдэж байсан нь гутамшигтай.

Дарамсалагийн гол дуганы шүтээнийг залах үед бас л дургүйцсэн явдал гарч, Делигээс захидал ирүүлсэн. Тэр захидлыг Даглүн Врагийн унзад лам тэргүүтэй хүмүүс бичсэн байсан. V Далай Лам Төвд орны тусын тулд "Ригзин Дүндүв"-ийг зохиосон гэдгийг уншаад миний сэтгэл уйссан

юм. Төвдийн ард түмний тусын тулд зохиож, дэлгэрүүлье хэмээн бодож байсан нь бүтээгүй. Би ч гэсэн тустай хэмээн санаад Дарамсалад “Ригзин Дүндүв”-ийн үүднээс соёрхол тавих зан үйлийг үйлдүүлэх болсон. Үүнээс хойш бараг нэг, хоёр жилийн дараа шинийн аравны хуралд Ганданчойлин хийдийн ани (*Эмэгтэй хувраг. Орч.*) нар ирээгүй. Үүний шалтгааныг асуухад нэгэн шинэ ном гарсны дотор, “шарын шашинтан хүн Нинмавын номыг үйлдвэл барцад саад гарах” тухай бичсэнээс эмээгээд ирээгүй гэсэн. Тэр нь “Пагод Ламын Шаллүн” нэртэйгээр Делид хэвлэгдсэн ном. Ганданчойлингийн ани нэр тэр номыг уншаад маш ихээр айж, Шүгдэнг Ловон Бадамжунайгаас ч илүү хүчтэй хэмээн үзэн “Төвдийн шашин төрийн тусын тулд Ловон Бадамжунайн дүрийн өмнө “Ригзин Дүндүв”-ийн буман тахил өргөхөөр очвол Шүгдэн амийг тасална” хэмээн сэжиглээд хуралд ирээгүй. Үүгээр жишээлэн шашинд тустай байна уу, тусгүй байна уу гэдгийг бодох хэрэгтэй.

Төвдөд цаг өөрчлөгдөхөөс өмнө Сажавын зарим хийдийн хуврагууд Шүгдэнг шүтдэг байсан. Илүүтэйгээр Гэлүгбын хийдүүдэд Шүгдэнг олноороо шүтэх явдал гарч байсан. Энэ нь сэтгэл уйсмаар хэрэг. Должал буюу Шүгдэн, “Пагод Ламын Шаллүн” зэргээс болж шашны дамжлага, урсгал хоорондын эе эв эвдрэх, нийт Төвдийн ард түмний ашиг тусад харшлах явдал удаа дараа гарч байсан. Шүгдэнгийн энэ байдлаас болж миний шашин ном шүтэх эрх чөлөө боогдож байснаас гадна өөр хүмүүс ч гэсэн “шашны дамжлага, урсгалуудыг алагчлалгүй шүтвэл Шүгдэн амь тасална” гэсэн буруу ойлголтоос болж шашин шүтэх эрхээ хязгаарлуулж байсан нь тодорхой. Должал буюу Шүгдэн Төвдийн шашны дамжлага, урсгалууд эв этэй байж, чандмань эрдэнийн гэрэл адил түгэн дэлгэрэхэд харшилж, Төвдийн язгуур эрх ашигт хорлож байгаа учраас Шүгдэнг шүтэхийг хориглосон юм.

Бид Шүгдэн гэж ямар мөн чанартай, юу болохыг нь сайтар мэдэх хэрэгтэй. Шүгдэнг тахин шүтэгчид “Винайг баригч Дагважанцан догшин дүрийг таалсан” гэдэг. Энэ асуудал нь бидний хувьд шууд мэдэх боломжгүй далд зүйл юм. Тийм учраас онолын өндөр эрдэм олсон их бүтээлчин

хүн шинжлэн шийдэхээс биш бидний шийдчих асуудал биш. Винайг баригч Дагважанцанг хамгийн сайн таньж мэддэг хүн хэн байсан бэ гэвэл, V Далай Лам юм. V Далай Лам эгэл жирийн нэгэн ерөөс биш. Намайг Далай Лам гэдэг болохоор би магтаж байгаа юм биш. Аливаад шударга шулуун ханддаг хэнээс ч асуусан I-IV дүрийн Далай Лам нарыг Их Далай Лам гэж дууддаггүй. V Далай Ламыг л Их Далай Лам хэмээн дууддаг. Энэ нь бидний аман ярианд хэвшмэл болсон зүйл. V Далай Лам Цаст Төвдийн шашин, амьтныг тэтгэсэн их ачтан байсан. Тиймээс л Их Далай лам хэмээн өргөмжилсөн юм. Түүнчлэн V Далай Ламын гадна, дотно, нууцын зарлигууд дахь зохиолуудыг нь үзвэл, үнэхээр гайхамшигтай билэг ухаантай, Ядам Бурхадын адис оршсон, Ядам бурхантай хүн хүнтэйгээ уулзах адил зохионгуйг туурвиж асан бусдаас онцгой нэгэн байсныг мэдэх болно.

Төвдийн шашин төрийн үүргийг үүрч байсныг нь авч үзвэл, "Суваргын орой хагарсан ч бүслүүр үе нь эвдрэлгүй оршив" хэмээсэн мэт Төвд орны суурь нь эргэх мэт болсон энэ хэцүү үед нийт Төвдийн амьсгал тасраагүй оршин байгаа нь V Далай Ламын ач юм. Брайбүн хийдийн цогчин дуганд V Далай ламын зохиосон жаяг бичиг байдаг. Гэсгүй болгон эхнээс нь бага зэрэг уншаад орхидог байсан. Аман яриагаар бол тэр жаягт нарийвчлан зарлигласан зүйл их байдгийг цогчин гэсгүй нар мөрдүүлж чаддаггүй учраас уншдаггүй байсан гэдэг. Тижан Ринбүүчи тэр жаягийг бүгдийг нь уншсан, "Жаяг дотор Брайбүн хийдийнхэнд онцгойлон сургасан зүйл олон байсан" хэмээн айлдаж байсан. Магадгүй тэр бичиг гурван их хийдэд гурвууланд байдаг ч уншдаггүй байсан байж болох юм. Ямартай ч V Далай Лам Төвдийн ард түмэнд ханьцашгүй их ачтай хүн байсан.

Тухайн үед гарч байсан будлианы талаас яривал, Сажава, Жононба, Гаржүдбын гэхчлэн зарим нэг хийдүүдийг Гэлүгбын хийд болгож байв. Сажавын хамба Санжайданзан маш эрдэмтэй хүн. Тэрээр надад, "V Далай Лам Сажавын олон хийдийг Гэлүгбын хийд болгож байсан учир Сажавынхан V Далай Ламд сүжиглэдэггүй. Гэвч Гүнчин Чэнзэванчүгийн "Гэгээрэхүйн мөр, үрд суралцах тэмдэглэл бичиг"-ийг V Далай Лам гүйцээн зохиосон учир Сажавынхан

V Далай Ламд толгой бөхийн хүндэтгэл үзүүлэх хэрэгтэй" хэмээн ярьж байсан. Ямартай ч V Далай Лам өндөр хэмжээнд хүрсэн дээд төрөлхтөн байсан юм. Шашин, төрийн алинд ч мэргэн, санаанд багташгүй ухаантай нэгэн байв. Магад утгадаа V Далай Лам номын хаан Тисрон-Дэзангийн хувилгаан дүр юм. Машид далд зүйлийг ил болгон тодорхой үзүүлсэн түүний зарлигийг бид магадлаад сэтгэлдээ агуулах нь зохистой. Дагважанцан хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр биш гэдгийг V Далай Лам баттай хэлсэн. V Далай Ламын зохиосон "гэрч бичиг"-ийн өмнөтгөл хэсэгт Дагважанцан тангаргийн буг Шүгдэн болсноосоо хойш олон амьтанд хорлол, хөнөөл үйлдсэн учир хатуу үйл үйлдэж, "гэрч бичиг" зохиосон хэмээсэн нь өдгөө сахиусанд үйлс даатгахад хамт уншдаг тэр бичиг юм. Гэрч бичгийн эхэнд жижиг үсгээр товч тайлбар бичсэний дотор: "*...Гадхасагийн Ла-Ажалын хичээл зүтгэлээр хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр хэмээн хуурамчаар тодорсон тэрээр,* (эцэстээ) *ерөөл буруудан тангаргийн буг болоод..."* хэмээсний *Гадхаса* нь Дагважанцангийн төрсөн газрын нэр, *Ла-Ажал* нь Дагважанцангийн эхийн нэр юм. Ээж нь их зальжин, IV Ванчин Богд Лувсанчойжижанцанг сайн мэддэг нэгэн байсан бөгөөд янз бүрийн башир аргаар өөрийн хүүг Сономгэлэгбалсангийн хойд дүрд хуурамчаар тодруулж чадсан юм. Тиймээс V Далай Лам Дагважанцанг хувилгаан Сономгэлэгбалсангийн *хойд дүр хэмээн хуурамчаар тодорсон* гэж бичжээ. Үүний дараа Дагважанцанг ерөөл буруудсан тангаргийн буг болсон тухай бичсэн байдаг. *...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр...* хэмээн Шүгдэнгийн мөн чанарыг үзүүлсний дотор Дагважанцан нь Хувилгаан Сономгэлэгбалсангийн жинхэнэ хойд дүр биш хийгээд тэр нь ч шалтгаан нөхцөлийн эрхээр ерөөл буруудсан тангаргийн буг болсон хэмээн тодорхой айлдсан байна. Дагважанцан ерөөл буруудсан тангаргийн буг болоод үйл юуг үйлдсэн тухай *...Амьтан бүхэн болон шашинд хорлож үйлдвээс...* хэмээн шашин, амьтан бүхэнд хорлон үйлдэж буйг өгүүлээд дараа нь *...Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун...* хэмээн дарах хэрэгтэйг айлдсан байдаг.

V Далай Ламын эдгээр айлдварыг өмнө нь би мэддэггүй байсан. Сүүлд Шүгдэнгийн талаар олон бэрхшээлтэй асуудлууд гарсан хийгээд илүүтэй Шүгдэнг шүтэгч зарим хүмүүс, тэнгэр бээр хүнийг нааш аварч чадалгүй, хүмүүн бээр тэнгэрийг цааш аврах цаг иржээ хэмээн “Тэнгэрийг Хүн Сахин Аврах нийгэмлэг” гээчийг байгуулснаар үл барам мэдэгдэл бичиг олон гаргасны дотор V Далай Лам Шүгдэнг шүтдэг байсан тухай, мөн түүний зохиосон Шүгдэнгийн үйлс даатгал байдаг тухай, түүнчлэн миний бичсэн Шүгдэнгийн үйлс даатгалын тухай бичсэн байсан. Анхандаа би мэдэхгүй хийгээд өөр бусад шалтгаан нөхцөлийн улмаар Шүгдэнг шүтдэг байсан. Тэр үедээ үйлс даатгах залбирал бичсэн юм. Гэхдээ энэ бүхэн маань эндүүрэл байсан. Эндүүрлийг эндүүрэл хэмээн мэдсэн маань энэ.

Ямартай ч Шүгдэнгийн нийгэмлэгээс гаргасан бичигт V Далай Ламын зохиосон үйлс даатгал байдаг тухай бичсэн байсан. V Далай Ламын бүх сүнбүмүүд хадгалагдсан байдаг. Тэдгээрийг нэгд нэгэнгүй шалгаж үзэх үед Шүгдэнгийн нийгэмлэгийн өгүүлсэн шиг үйлс даатгах залбирлыг олоогүйн дээр харин ч эсрэгээр тэдэнд хэрэггүй “гэрч бичиг”-ийг олсон юм. “Гэрч бичиг”-т юу байсныг өмнө тодорхой хэлсэн. Дагважанцан амьд ахуй үедээ V Далай Ламтай дотно байсан мэт байдаг. Хожим төрөл арилжаад ерөөл буруудсан тангаргийн буг болсон. Эцэст нь V Далай Лам ерөөл буруудсан тангаргийн буг болсон хэмээн танин барьсан юм. V Далай Ламтай эн чацуу нэгэн V Далай Ламын айлдварын таалал утга иим, иим учраас ингэж зарлигласан гээд өөрийн үгэндээ өөрөө эзэн сууж чадах нэгэн гарах хүртэл V Далай Лам юу гэж эцэслэн шийдсэн байна, түүнийг нь дагах хэрэгтэй. V Далай Ламтай эн чацуу нэгэн Шүгдэнгийн тухай өөрөөр айлдсан бол өөр хэрэг. Гэтэл өнөөг хүртэл тийм хүн гараагүй байна.

Павонка Ринбүүчи Шүгдэнг хүчтэй шүтдэг байсан ч V Далай Ламтай эн чацуу лам байгаагүй. Сажавын зарим хувилгаад Шүгдэнг шүтэж байсан түүх байдаг ч шашин, төр алины талаас ч V Далай Лам лугаа эн зэрэгцэхгүй. Нийт төвдийн шашин, төрийн үүргийг үүрч, цаглашгүй ихээр

ачилсан V Далай Ламтай эн зэрэгцэх бэрх юм. Хэрэв XIII дүрийн Далай Лам энэ талаар өөр зүйл хэлсэн бол бодож үзэх хэрэгтэй ч өмнөх дүрийн Далай Лам харин ч түүнээс буцаад V Далай Лам юу гэж эцэслэн шийдсэн, түүнийг нь дагасан. XIII Далай Лам насныхаа эхэн үед Павонка Ринбүүчийд ихэд дотно ханддаг байсан. Жил бүрийн Мэрү хийдийн хаврын номыг Гандан Ширээт лам айлддаг уламжлал байдаг ч XIII Далай Лам зарим үед Павонка Ринбүүчийгээр айлдуулдаг байв. Павонка Ринбүүчи тийм ч өндөр дээд хувилгаан байгаагүй. Өмнөх дүрийн Далай Лам насныхаа эхэнд түүнд дотно, таалал ойр байдаг байсан ч хожим зарлиг зэмлэл олныг хүртээх болсон юм. Эдгээр түүхүүд Төвдөд хэвлэгдсэн Павонка Ринбүүчийн өөрийнх нь намтар, бичээч Лувсандоржийн бичсэн дотор байдаг. Тэгэх болсны учир шалтгаан нь: Шүгдэн шүтэхийг хүчтэй дэлгэрүүлж байсан нь өмнөх дүрийн Далай Ламын тааллд нийцээгүйгээр үл барам түүнд, “Шүгдэнг шүтэж, шүтэхийг дэлгэрүүлж үйлдвээс аврал одуулахуйн суртгаалтай харшилна” хэмээн зарлиг зэмлэл хүртээсэн түүх байдаг. Павонка Ринбүүчи тэр үед, “Эхийн талын удмынхан Шүгдэнг шүтдэг уламжлалтай байснаас болж шүтсэн. Үүнээс хойш шүтэхгүй.” хэмээн мутрын бичгээ өргөсөн байдаг. Гэвч хувилгаан байж өмнөх дүрийн Далай Ламыг таалал барсны дараа зарлигийг нь эвдэж Шүгдэнг шүтэхийг хүчтэй дэлгэрүүлсэн байдаг. Нийтийн үзэгдэлд л тэр адилын зохионгуйг туурвисан байж болох юм. Хэрэв өмнөх дүрийн Далай Лам V Далай Ламын эцэслэн шийдсэнийг шинээр авч үзсэн бол өөр хэрэг. Түүнээс бус жирийн нэг хувилгаан бээр V Далай Ламын зарлигийг өөрчилж чадах аргагүй юм. Миний хувьд V Далай Ламын зарлигийг үнэн гэж үздэг. Шүгдэнгийн бэрх асуудал анх гарах үед би уншиж судлах, мэргэ төлөг буулгах тэргүүтнээр ажиглал шинжлэлийг удаа дараа үйлдээд эцсийн шийдвэрээ гаргасан. Ялангуяа өмнө өгүүлсэн түүхэн бичиг сэлтийг олсны дараа гаргасан шийдвэртээ улам баттай сэтгэл итгэмжилж, V Далай Ламын тааллыг гүйцэлдүүлжээ гэж санаад сэтгэл амарсан. V Далай Ламын үйлс зохионгуйн цацрал учраас ч тэр үү, надад V Далай Лам баяссаны шинж тэмдэг ч олон үзэгдсэн.

Ямартай ч миний зүгээс хайлуулж, хэрчиж, үрэх (*Буддын шалгадаг ухааны гурван шинжлэлийн ёгт нэр. Орч.*) гурван шинжлэл хийгээд түүхэн баримт сэлт дээр тулгуурлан шийдвэрээ гаргаснаас биш нинмавынханд зусардсандаа, эсвэл улс төржсөндөө энэ шийдвэрийг гаргаагүй. Шийдвэрээ хэрхэн гаргасан тухайд ийм байна. Мунхраад буруу замаар явж байгаа хүмүүст зам мөрийг үзүүлэх хэрэгтэй болохоос биш мэдсээр байж буруу замыг сонгож байгаа хүмүүст миний зүгээс хэлэх зүйл байхгүй. Өмнө ч гэсэн хэлж байсан. Буян нүгэл, авла орхилыг заах нь миний үүрэг, сонсох сонсохгүйгээ өөрсдөө шийдэх хэрэгтэй. Буян нүглийг номлох төдийгөөр шашин ном шүтэх эрхийг булаадаггүй. Хэрэв тэр төдийгөөр л бусдын шашин шүтэх эрхийг хязгаарладаг бол Нагаржунай Гэгээн бодитойд өгүүлэгч (*Бодитойд өгүүлэгч гэдэг нь Бурханы шашны дөрвөн тогтсон тааллын доод хоёр тогтсон таалал буюу өвөрмөц өгүүлэгч болон судрын аймагтны үзлийг баримтлагчдыг хэлдэг. Нагаржунай Гэгээн хоосон чанарыг номлохдоо бодитойд өгүүлэгч нарын үзэл баримтлалыг үгүйсгэн номлосон байдаг. Орч.*) нарын үзлийг хүчтэй үгүйсгэсэн байдаг. Гэсэн ч Нагаржунай Гэгээн бээр бодитойд өгүүлэгч нарын шашин шүтэх эрхийг булаагаагүй. Богд Зонхов бээр "*Сайтар Номлолын Зүрхэн*" хэмээх бүтээлдээ эхнээсээ эцэс хүртэл "бусдаар хоосрох" үзлийг хүчтэй үгүйсгэсэн байдаг. Энэ нь Богд Зонхов "бусдаар хоосрох" үзлийг баримтлагчдын шашин шүтэх эрхийг булааж буй хэрэг биш юм. Үнэн мөнийг сайтар ялган номлох нь шашин шүтэх эрхийг булааж буй явдал огтхон ч биш юм.
Хайдүв Ринбүүчийн хоосон чанарын тухай зохиолд (*"Гүн Нарийн Хоосон Чанарыг Сайтар Ялгагч: Хувь Сайтын Нүдийг Нээгч". Төвдөөр Дон-түн Галсан-Мигжэд. Орч*) хоёр хоригийг баттай гарга хэмээн зарлигласан байдаг. Хоёр хоригийг гаргах үед хоосон чанарын жинхэнэ утга гардаг. Өмнө хэлсэнчлэн Шүгдэнг шүтсэнээс болж надад Бурхан шашны увдис дамжлагыг алагчлалгүй судлахад саад гарч байсан. Шашин номоо чөлөөтэй шүтэх эрх надад байгаагүй. Шашин ном чөлөөтэй шүтэхэд саад болдог харшлах нөхцөлийг арилгах нь шашин шүтэх эрхийг хамгаалж буй хэрэг юм. Хоёр хоригийг баттай гаргасан маань тэр. Ерөөл

буруудсан тангаргийн буг, энэ хойд нас хоёуланд хорлогч нэгнийг Төгс Буянтын Зөөлөн Итгэлт Ялгуусны (*Богд Зонхов. Орч.*) шашны сахиус мөн хэмээн толгой эргүүлж байна. Энэ нь маш том эндүүрэл юм шүү!

Шүгдэнг шүтэгчид нийгэмлэг байгуулж Шүгдэнгээ хамгаалж байна. Жишээ дурдахад, Цанидын сургуулийн нэгэн багш миний гаргасан шийдвэрийг хамгаалж нэлээд зүйл бичдэг байсан. Эцэстээ тэрээр бусдын гарт алуулсан. Түүнийг миний амьдардаг газраас нэг километрийн зайтай газар хороосон байсан. Гэмт этгээдүүд хятадаас ирээгүй, энэтхэгийн гэмт бүлэглэлийн хүмүүс ч биш байсан. Хуврагийн аймгаас гарсан хэдэн хүн байсан. Сэра-Мэ хийдийн Бомра аймаг болон Гандан хийдийн Докан аймгийн хувраг дүрстэй хүмүүс байсан. Тэд цанидын сургуулийн багшийг хороочхоод төвд уруу оргон зайлсан байдаг. Тэднийг төвдөд, Лхасын Ча-тэн хэмээх цайны газар байрлаж байхад нь Хятадын засгийн газартай холбоотой хүмүүс тусгайлан хүлээн авсан байдаг. Тухайн үед энэ хэргийг Дарамсалагийн цагдаагийн газар сайн мөрдөж чадсан. Алуурчид Делигээс хэзээ ирсэн, Делид байхдаа Шүгдэнгийн нийгэмлэгийн ажилтан Чимэд гэгчтэй утсаар хэрхэн ярьсан тухай баримтууд байдаг. Үнэхээр харамсмаар хэрэг. Сүүлд нь Шүгдэнгийн нийгэмлэгтэй холбоотой хүмүүс надад захидал явуулсан. Тэр захидалд, *Танд гурван хүний гэдсээр тахил өргөлөө. Одоо ч гэсэн зүгээр сууж чадахгүй бол дахин хүний гэдсээр тахил өргөж болно шүү* гэж бичсэн байсан. Шүгдэнг хамгаалж байна хэмээн хүчирхийлэл үйлдэн, хүн алж, зодож нүдэх явдал олон гарсан. Эндэхийн төвд суурингийн даргыг зодож алах шахсан байдаг. Эдгээр нь бодитой болсон хэргүүд. Ямартай ч тэдэнд хууртаж мэхлэгдэхгүй байх нь чухал. V Далай Лам болон өмнөх дүрийн Далай Ламтай тангараг буруудсан Шүгдэнтэй холбоотой хүмүүс надаас номын авшиг, сахил хүртэх нь сайн биш. Тиймээс би ном айлдах үедээ Шүгдэн шүтдэг хүмүүсийг номын суудалд суухыг хориглодог. Хориглож байгаа маань миний зүгээс тэдэнд хорон муу санаж байгаа хэрэг биш юм. Тэр хүмүүсийг би өрөвдөж, хайрладаг. Буруу атгагийн эрхэнд орсон тэдгээр хүмүүсийг хойд төрөлд нь

Шүгдэн зуурдын төрлөөс нь татаж чадвал сайн боловч энэ нь ямар ч боломжгүй зүйл юм. Миний зүгээс хэлэхэд эвгүй ч, Далай Лам Шүгдэнгээс сайн байна уу гэхээс муу бол биш шүү! Ойлгосон уу?

Би өмнө нь ч хэлж байсан. Шүгдэнг сонгох уу? Далай Ламыг сонгох уу? Дор дороо бодоод сонголтоо хийх хэрэгтэй. Шүгдэнг сонгосон нэгэнд би, надаас явах хэрэгтэй гэж хэлдэг. Одоо ч Шүгдэнгийн тухай энэ байдлыг мэддэггүй олон газар байна. Жишээлбэл, Сингапур, Тайвань, Хятад, Америк, Европын зарим орнуудад Шүгдэнг шүтэхийг дэлгэрүүлдэг хүмүүс байдаг. Баруун Европын зарим орнуудад Бурханы шашны жинхэнэ төв байгуулагдаж чадаагүй ч Англи дахь Галсанжамцын (*Шүгдэнг шүтэхийг дэлгэрүүлдэг төвд хүн. Орч.*) төвийн салбарууд байдаг. Тэдгээр орнуудад очих үед надад тийм төвүүд байдаг тухай хэлж байсан. Өнөөдөр энд Төвдөөс шинээр цагаачилж ирсэн хүмүүс байгаа, тэд үүнийг мэдвэл сайн. Төвдийн ард түмний ихэнх нь миний шийдвэрийн талд байж, сүжиг бишрэл урвалгүй ёс лугаа зохилдонгуй байгаад үнэхээр баяртай байна. Гэсэн ч Мар-хам, Враг-яв, Чавдо зэрэг зарим нутагт одоо ч гэсэн Шүгдэнг хүчтэй шүтдэг хүмүүс байдгийн дотор мэдсээр байж үл тоомсорлон шүтдэг хүмүүс ч байдаг байх. Надад ялгаа алга, ач үл санах санаа бодлыг агуулна уу, байна уу өөрсдийн мэдэх хэрэг. Дэнма нутагт Дэнма-Гонсарын (*Дэнма нутгийн ламын нэр. Орч.*) шавь, Шүгдэнг шүтэгчид их байдаг. Мөн гадаадад ч их байдаг. Яагаад Шүгдэнг хориглох болсон шалтгаан, бодит байдлыг өмнө нь би ярьсан. Авла орхилыг хэрхэн үйлдэх нь хувь хүний мэдэх хэрэг. Энэ асуудлыг ул суурьтай шинжилж чадвал сайн. Буруу атгаг хийгээд хууран мэхлэгчдийн эрхэнд орохгүй байх нь чухал шүү. Ойлгосон уу?

Шүгдэнгийн асуудлын тухай нэгэн шинэ зүйлийг ярихад, Хятадын засгийн газар Далай Ламын эсрэг ажиллагаагаа эрчимжүүлж буй энэ үед Шүгдэнгийн нийгэмлэг болон түүний холбоо сүлбээтнүүд Далай Ламыг эсэргүүцдэгийг Хятадын засгийн газар том олз хэмээн үзэж, Шүгдэнгийн нийгэмлэг болон тэдний зарим сүлбээтнүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, бусадтай холбоо тогтооход

туслах зэргээр ил далдаар дэмжих болсон. Зайлшгүй болгоомжлох хэрэгтэй нэг зүйл нь, энд, Сэра хийдэд Хятадын засгийн газартай сүлбээтэй хүн ирж байгаа явдал юм. Хийд орон нь төвдийн цагаачдыг удирдах институтийн харьяа юм. Гурван их хийд (*Сэра, Гандан, Брайбүн хийдүүд. Орч.*) ч гэсэн энэ газарт харьяалагддаг. Ийм газарт Хятадын засгийн газраар халамжлуулагч байгаа нь өрөвдөлтэйн дээр мөн их аюултай тул үүнд хар шаргүй бүгдээр анхаарал хандуулах хэрэгтэй. Одоо Гандангийн Шарзэ-д (*Шарзэ нь Гандан хийдийн хоёр том дацангийн нэг. Орч.*) байдал Сэра хийдээс ч дор байна. Сэра-Мэ дацангийн хамба, хансүрүүд аль чадахаараа хичээн ажиллаж байна. Харин Шарзэ-д тийм ч хүч гарган ажиллаж чадахгүй байна. Бүгдээрээ холыг харж, санаа бодлоо хандуулах хэрэгтэй. Холыг харалгүй, зөвхөн хаягагаа хараад байвал эцэстээ нийт төвдүүд хохирох болно шүү. Өнөөдөр Шүгдэнгийн тухай асуудлыг далдаар бус, Шүгдэнг шүтэгчид байдаг газар, учир шалтгаан, түүхэн баримт сэлттэй нь тодорхой тайлбарлах нь зөв гэж үзээд ярилаа. Та бүхэнд молтгор туулайн зөөлөн арьс болон молцгор хоншоор хоёулангийнх нь тухай яривал тустай байх гэж бодсон юм.

Варанаси, мөн энд өмнөд Энэтхэгт нийт гурван долоо хоног ном тавьснаар та бүхэнд өчүүхэн ч гэсэн тус болох байх хэмээн горилж байна. Бурхан Багшийн сайн шавь нар болоосой гэсэндээ аль тусалж чадахаараа ном тавилаа. Миний хувьд одоо далан нас хүрч байна. Хэзээ ч явсан надад харамсах зүйл байхгүй. Бүгдээрээ нийтийн тусын тулд зүтгэх хэрэгтэй. Төвд нийтийн төрийн асуудлын талаар маргааш ярина. Олон нийтээс сонгогдсон ерөнхий сайд (*Төвдийн цагаачлалын засгийн газар гэж байсны ерөнхий сайд. 2012 онд энэ байгууллага нэрээ өөрчилсөн. Орч.*) энд байна. Цагаач төвдүүдийн улс төрийн асуудлыг ерөнхий сайд голлон хариуцаж байгаа. Маргааш ерөнхий сайд энэ талаар ярих байх. Та бүхэнд баярлалаа!

# 2008 оны 1-р сарын 3-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Мондгод дахь Балдан Брайбүн хийдийн цогчин дуганд Жамбалцанжодын эш хөтөлбөрийг хайрлаж байх үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Би энэ тухай үргэлж хэлдэг. Жамбалцанжодын (*Хутагт Зөөлөн-Цогтын Алдрыг Өгүүлэхүй хэмээх нууц тарнийн ном. Орч.*) эш хөтөлбөрийг номлох нь зүгээр нэг дуун ухаан заахтай адилгүй юм. Дуун ухааныг заахад багш шавийн тангараг ариун, ариун бусын тухай ярих хэрэг байдаггүй. Өнөөдөр энд номлох Жамбалцанжодын тантрын тайлбар энэ нь их чухал тул багш шавийн тангараг доройтсон нэгэн номын суудалд сууж болохгүйг хэлье. Шүгдэнг шүтэгчид надтай тангараг доройтсон байгаа. Энэ тухай нарийн тайлбар хэрэгтэй бол дараа тайлбарлаж болно. Хийх юмаа олж ядсандаа би Шүгдэнг хориглоогүй. V Далай Лам бээр,

“*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн болон шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун”* хэмээн

гэрч бичигтээ айлдсан байдаг. Өмнө нь би Шүгдэнг шүтдэг байсан. Хожим нарийн судлах үедээ эндүүрч байснаа мэдсэн. Далай Лам гэгдэж, V Далай Лам хийгээд XIII Далай Лам нарын залгамж болж энэ суудалд би суусан. V Далай Лам болон өмнөх дүрийн Далай Ламтай үйлийн онцгой барилдлагатай болохоо зүүдэндээ мэдэрдэг. Тэр адилын үйлийн барилдлагатай хүн V Далай Лам хийгээд XIII Далай Лам нарийн хүчтэй хориглодог байсан нэгнийг шүтсэн нь маш том эндүүрэл байсан юм.

Би 1951 оноос Шүгдэнг шүтэж эхэлсэн. Хожим 1970-аад оны үед олон бэрх нөхцөл байдал үүсэхэд гадаад, дотоод, нууц гурвын үүднээс ажиглал, шинжлэлийг удаа дараа үйлдээд эцэст нь шийдвэрээ гаргасан. Тэр үед хоёр ёнзон багш маань амьд сэрүүн байсан. Ажиглаж шинжсэнээ ч хоёр багшдаа айлтгасан. Ёнзон Лин Ринбүүчи багш маань Шүгдэнг шүтдэггүй байсан бөгөөд гаргасан шийдвэрт маань сэтгэл хангалуун байсан. Тижан Ринбүүчи багш маань "Тэр адилын шинжлэл хуурмаг байна гэж байхгүй. Гарцаагүй нэг учир шалтгаан байна" хэмээн айлдсан бөгөөд таалалд нь ч нийцсэн. Хоёр ёнзон багшийгаа таалал барсны дараа Шүгдэнг хориглосон хэрэг огтхон ч биш шүү! Бодит байдал ийм юм.

V Далай Ламын ерөөл буруудсан тангаргийн буг, ад зэтгэр хэмээн танин барьсныг Бурханы шашны сахиус гэж үзээд шүтвэл V Далай Ламтай тангараг буруудах нь тодорхой юм. V Далай Ламтай тангараг буруудваас XIII Далай Ламтай ч мөн адил тангараг буруудах юм. Юуны учир гэвэл, XIII Далай Лам онцгойлон Шүгдэнг хориглосон байдаг. Тиймээс Шүгдэнг шүтэгчид V Далай Ламаас авахуулаад дараалан заларсан Далай Лам нартай тангараг буруудаж байгаа юм.

Миний хувьд энэ асуудлыг олон жилийн өмнөөс цэгцэлсэн. Тэр нь ч, гадна дотнын олон муу нөхцөл шалтгаантай учирч, тодорхой шийдвэр гаргах хэрэгтэй болсноос биш, би өөрөө шүтэхээ больсондоо бусдыг ч мөн шүтэхээ болихыг шаардсан хэрэг биш юм. Анх Шүгдэнг шүтэхээ больсноо би гадагш мэдэгдээгүй. Гандан-Жанзэ дацанд бэрх асуудал учраад түүнийг хэрхэн буцаахыг надаас асууж байсан. Гандан-Жанзэ дацанд Лхам сахиус хилэгнэсэн байна хэмээн тэр үед Тижан Ринбүүчи айлдсан. Гандан-Жанзэ дацангаас үзүүлэхээр өргөсөн зүйлийн дотор ч сахиус хилэгнэсний шинж тэмдэг байсан. Намайг шинжиж үзэхэд сахиус хилэгнэсэн байсан бөгөөд тэр нь ч Шүгдэнг шүтсэнээс болж хилэгнэсэн нь тодорхой буусныг Жанзэ дацанд хэлсэн. Улмаар гадагш мэдэгдсэнээр байдал улам тодорхой болсон. Энэ байдлын тухай нарийн, ширийнийг дараа цаг гарвал тайлбарлаж болно оо.

Энэ асуудалтай холбоотой олон нөхцөл байдал үүсэж

байсан. Шүгдэнгийн нийгэмлэг шинээр байгуулагдаж, тэндээс ном товхимол гаргах, хүн алж, зодож нүдэх, галдан шатаах зэрэг янз бүрийн бусармаг үйл ажиллагаагаа явуулж байсныг настай хүмүүс мэдэж байгаа. Хожим тэд Хятадын засгийн газартай холбогдох болсон. Хятадын засгийн газраас Далай Лам Шүгдэн шүтэхийг хориглосон нь шашин шүтэх эрх чөлөөг боогдуулж буй хэрэг юм гэж үздэг.

Энэ мэт учир шалтгааны улмаас Шүгдэнгийн асуудал улам хүндрэх болсон. Энд хэрвээ Шүгдэнг шүтдэг хүн байгаа бол, номонд суусны хэрэггүй гэж хэлье. Шүгдэнг шүтэх шүтэхгүй нь өөрсдийн мэдэх хэрэг. Хэрвээ мэдэхгүйн эрхээр шүтэж байгаа бол шүтсэний хэрэггүй. Мэдэхгүйн эрхээр биш, мэдсээр байж үл тоомсорлон шүтдэг бол энд номонд суусны хэрэггүй. Тангараг доройтсон нэгэн номын суудалд суувал багш, шавь хоёуланд хор болдог. Мөн гаднаа шүтдэггүй мэт дүр эсгээд дотроо шүтдэг бол сайн хэрэг биш шүү. Сэтгэлийн мухарт эргэлзээ тээнэгэлзээ, элдэв атгаг байгаа бол мөн номын суудалд суусны хэрэггүй. Та бүхэн ойлгосон уу? Тангараг буруудаад номын суудалд суувал ямар ч тус байхгүй. Бутаны Гүнлэг бээр, “Тантрын авшиг олныг айлтгав уу? Тангаргаа доройтуулж, газраар нэг асгав уу?” хэмээсэн мэт тангаргаа доройтуулж, газраар нэг асгавал ямар ч тус байхгүй: багшийн насанд цөв гарч, ажил үйлс ч сайнаар бүтэхгүй. Огтхон ч сайн биш. Ойлгосон уу?

# 2008 оны 1-р сарын 5-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Монгод дахь Балдан Брайбүн хийдийн цогчин дуганд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Шүгдэнгийн тухай асуудлын нарийн ширийнийг өмнө Самдон Ринбүүчи ярьсан. Би ч гэсэн боломж гарвал энэ тухай тайлбарлая гэж бодож байлаа. Цаг бага байгаа тул энэ тухай дэлгэрэнгүй ярих хэрэггүй байх.

Ямартай ч хийх ажил минь багадсандаа Шүгдэнг хориглоогүй юм шүү. Өнгөрсөн түүхэнд энэ их будлиантай асуудал байсан бөгөөд үүнд ямар ч ач тус байгаагүй юм. Анх би Шүгдэнг ихэд шүтдэг байсан. Шүгдэн буухдаа ч надад их дотно ханддаг байв. Гэсэн ч удаа дараалан шинжилж үзэхэд, Шүгдэнг шүтсэн маань эндүүрэл байсан. Далай Лам гэгддэг нэгэн V болон XIII дүрийн Далай Лам нарын хориглож байсан бугийг шүтэх нь эндүүрэл гэж үзээд, маш ихээр гэмшин, наманчилж үйлдээд шүтэхээ больсон. Гэсэн хэдий ч үүнийгээ нийтэд зарлаагүй юм.

Үүний дараа Жанзэ дацанд бэрхшээлтэй нөхцөл байдал үүсэж, энэ байдлыг надаас асуухад нь би ч ихэд чухалчлан төлөг буулгаж үзэхэд Жанзэ дацанд Балдан Лхам сахиус хилэгнэсэн байсан бөгөөд Шүгдэнг шүтсэний улмаас Балдан Лхам хилэгнэсэн нь төлгөнд тодорхой буусан. Тэр үед Сэргон Цаншав Ринбүүчи болон Жанзэ дацангийн хансүр Жа-Ү гуай (*Намжал данцангийн анхны хамба байсан Жэвзүн Лувсандондов.*) хоёрыг дуудуулаад, төлөг хэрхэн буусныг хэлээд, Жанзэ дацанд илгээх хариу бичигт үүнийг тодорхой бичсэнгүй. Гэхдээ та хоёр дацангийн холбогдох хүмүүст төлөг хэрхэн буусныг хэлээрэй гэж захисан юм.

Үүний дараа энэ байдлын тухай мэдээ аажмаар гадагш түгэх болсон. Сүүлд нь Шүгдэнгийн нийгэмлэг байгуулагдсан. “Тэнгэрийг Хүн Сахин Хамгаалах Нийгэмлэг” гэж тэнгэр нааш хүнийг аврахын оронд хүн бээр тэнгэрийг цааш аврах хэрэгтэй болсон хэмээгээд, аварч байгаа нь тэр гээд хүн алж, зодож нүдэх, галдан шатаах, эцэс төгсгөлгүй худал хуурмаг ярих зэргээр алив л муу аргыг хэрэглэсэн. Энэ мэтээр тэнгэрээ аварч байгаа нь зүй бусын муйхар явдлаас цаашгүй. Ийм муйхар зүйл үйлдсэнээрээ тэд асуудлыг улам л томсгож байгаа хэрэг юм. Илүүтэйгээр төвдөд хүмүүсийн толгойг эргүүлэн, Далай Лам Шүгдэнг шүтэхийг хориглож байгаа нь нинмавынхад тал засаж, улс төржсөндөө хориглож байгаа болохоос биш, энэ нь Далай Ламын өөрийнх нь магад санаа биш гэх мэтээр худал хуурмагийг үйлдэж байна. Би бусдын эрхэнд орж Шүгдэнг шүтэхийг хориглоогүй. Өөрөө ажиглан шинжилж үзээд хориглосон. Эш, ухаанаар батлаад эцэслэн шийдсэн учир, Далай Ламын өөрийнх нь магад санаа биш, хуурч мэхлээд бусдад зусардсандаа энэ шийдвэрийг гаргасан гэх мэтийг үгүйсгэхээс өөр арга байгаагүй тул миний зүгээс энэ асуудлыг улам тодорхой гаргаж, тайлбарлах шаардлагатай болсон. Асуудлыг тодорхой тайлбарлах болсны эцэст, энэ Далай Лам нь санаатайгаар Бурханы шашин хийгээд илүүтэйгээр Зөөлөн Итгэлт Богд Ламын (*Богд Зонхов. Орч.*) шашныг сөнөөхөөр төрсөн. Жинхэнэ Далай Лам биш гэгдэх болсон. Энэ нь надад хамаагүй. Чөтгөр гэсэн ч надад хамаагүй.

Урьд төвдөд соёлын хувьсгалын үеэр, Далай Лам бол номын хувцас өмссөн чоно мөн гэсэн ухуулгыг Хятадын засгийн газраас хүчтэй хийдэг байсан. Надад ямар ч нөлөө байгаагүй. Тэд нар намайг чоно гэснээр би чоно болж хувираад хонь барьж идэн, дөрвөн хөллөөд явах хэрэг байгаагүй. Би хүн л хэвээрээ сууж байсан. Далай Лам шашныг сөнөөхийн тулд төрсөн гэж хэлсэн ч надад хамаагүй. Өнөөг хүртэл би шашны тусын тулд зүтгэсэн. Шашин сөнөсөн, сөнөөгүйг та бүхэн нүдээрээ харж, чихээрээ сонсвол тодорхой мэднэ. Тэд л хууран мэхлэгч гэгдэхээс биш, надад ямар ч нөлөө үзүүлэхгүй. Гэсэн хэдий ч гүжир гүтгэлгийг үйлдэж багаа тэдэнд үргэлжлүүлэн үнэнийг тайлбарлахаас

өөр арга алга. Тиймээс их хийдүүдэд V Далай Ламын баттай буулган хайрласан замын зургийг бариулснаар би энэ ажлыг эхлүүлсэн. Эхлүүлсэн ажлынхаа эцсийг ч үзнэ. Ойлгосон уу? Өнөөдөр ч гэсэн энэ байдал тэгсхийгээд намжина гэж боддог хүмүүс байдаг бололтой. Зарим нь ойлгоогүй юм шиг дүр үзүүлж, үргэлжлүүлэн энэ янзаараа байвал дээр гэж бодоод суугаад байвал Шүгдэн шүтэж буй хүмүүстэй ялгаагүй. Ярихдаа худал яривал явдал мөр нь ч худал байдаг гэдэг шиг надтай уулзахаараа болж байна, бүтэж байна гэх хирнээ бодит байдал дээр тийм биш байна. Энэ асуудал ч гэсэн тиймэрхүү л байна. Сэра-Жэ дацангийн олон хуврагууд тусгайлан хичээл зүтгэл гаргаж, энэ тал дээр сайн ажиллаж байна. Та нар ч гэсэн тэр мэт хичээл зүтгэл гаргах нь их чухал шүү. Энэ нь нийт төвд, Бурханы шашны тусын тулд болохоос биш, миний тусын тулд биш юм. Та нар бүгд хөл толгойгоо солиод буруулан явсан ч надад ялгаа үгүй. Далай Ламын нэр болон нийт төвдийн ард түмний итгэл надад байгаа учир Бурханы шашин хийгээд төвдийн нийт ард түмнийг төлөө зүтгэхгүй байхын аргагүй. Тиймээс та бүхэн энэ асуудлыг сэтгэлдээ сайтар тунгаагаарай!

# 2008 оны 1-р сарын 7-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Брайбүн Лосалин дацанд хамба, хансүр, багш нарт Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

[<— Гарчиг руу буцах]

Шүгдэнгийн тухай ярья гэж бодлоо. Энэ асуудал шашин, номын тал дээр ямархуу байгааг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа учир дахин давтаж ярих хэрэггүй байх. Хэдэн жилийн өмнөөс коммунист хятадын зүгээс энэ асуудлыг онцгойлон сонирхох болсон. Швейцарт байдаг Дэнма-Гонсарынханы (*Шүгдэнг шүтдэг төвд лам. Орч.*) суудаг газрыг авч үзвэл, Хятадын засгийн газрын төлөөлөгчид Швейцарт айлчлахдаа тэдний байдаг газраар зочилж, хийд орноор нь ордог гэсэн. Хийдийн зүгээс ч хөл алдан тусгайлан хүлээн авдгаас үзвэл тэдний хооронд онцгой харилцаа байгаа нь тодорхой. Ганжан Ринбүүчи ч гэсэн Хятадын засгийн газартай тусгай харилцаатай бөгөөд Төвдийн шашин, соёлын чуулга уулзалт болоход тэрээр өөрийнхөө мэдлэг чадвар ямар гэдгээс үл хамааран төвдийн шашин, соёлыг төлөөлдөг. Хятадын засгийн газар ч түүнийг овжин ашигладаг.

Мөн Балбад Шүгдэнгийн нийгэмлэгийн ресторан байдаг ба тэрийг удирдан ажиллуулдаг хүний хөлсийг Хятадын засгийн газраас төлдөг байсан тухай, мөн сүүлд ресторханыг бүхэлд нь худалдан авахад Хятадын засгийн газраас мөнгө гаргасан тухай яриа байдаг. Энэ нь тав, зургаан жилийн өмнөх яриа.

Саяхан би төвдөөс ирсэн зарим хүмүүстэй уулзсан юм. Эхэлж уулзсан хүн маань коммунист намын гишүүн, Хятадын засгийн газарт ажиллаж байгаад саяхнаас тэтгэвэртээ гарсан хам-ба (*Төвдийн хам нутгийн хүн. Орч*)

хүн байсан. Миний зүгээс түүнтэй нээх юм яриагүй. Тэрээр надад хандаж, удахгүй Бээжинд болох олимпын үеэр Далай Ламыг эсэргүүцэх нийгэмлэг байгуулж байгаа. Үүнийг Би Хувилгаан (*Өөрөө хувилгаан биш ч, өөрийгөө "би хувилгаан мөн" гэсээр "А Хувилгаан" нэртэй болсон төвд хүн. А гэдэг нь төвдөөр би гэсэн утгатай. Орч.*) гэгч удирдаж байгаа гэж хэлсэн. Би "Аан" гэснээс өөр юм яриагүй.

Мөн Голу нутгаас ирсэн нэгэн лам надтай уулзсан. Тэрээр надад, Шүгдэнгийн нийгэмлэг Бээжинд бас нэгэн нийгэмлэг байгуулан, Далай Ламыг эсэргүүцэхэд сайтар бэлдэж байгаа тухай дуулсан гэж байсан. Мөн тэрээр өөрийн мэддэг Голу нутгийн хийдийнхэнд, та нар тэр хувилгаан болон түүнтэй барилдлагатай хүмүүстэй харилцаж болохгүй шүү гэж аль чадахаараа хэлсэн гэсэн.

Өөр нэгэн хүнтэй уулзахад, Бээжинд Шүгдэнгийн нийгэмлэгийнхэн жижиг, жижиг бүлэг байгуулан, үүнд оролцсон хүн бүрд арав, арван мянган юань өнгө гэцгээж байсан гэсэн. Ямартай ч эндээс Далай Ламыг эсэргүүцэгчдийн нийгэмлэг байгуулагдаж байгаа нь мэдэгдэж байна.

Ингэлээ, тэглээ гэсэн дам ярианаас гадна, бодит байдалд юу болж байна вэ гэвэл, Хятадын засгийн газартай бид гурав дахь удаагаа уулзалт яриа хийх үед Хятадын засгийн газар Далай Лам салан тусгаарлах үйл ажиллагаа явуулж байна хэмээн олон зүйл тоочин, гучин долоон зүйлийг сонинд гаргасны дотор Далай Ламын засгийн газрын зүгээс юу ярьсан тухай ганц ч үг байгаагүй. Нэгэн зүйлд нь, өнгөрсөн түүхэнд Төвд тусгаар улс байсан тухай ярихдаа англи хэлний *occupation,* төвд хэлний *булаан эзлэгдсэн* гэсэн үгийг заримдаа хэрэглэдэг. Энэ мэтээр Төвд нь Хятадын нэг байсныг хүлээн зөвшөөрөхгүй байвал, нэг удаадаа яриа хэлэлцээр хийсэн ч, ирээдүйд Төвдийн энэ байдал дахин сөхөгдөнө. Хожим Төвд Хятадаас тусгаарлах тухай яриа хэзээ ч ярихгүй байх үүргийг хүлээх хэрэгтэй гэж бичсэн байсан. Тиймээс тав дахь удаагийн уулзалтын үед Далай Лам ирээдүйд Төвдийн тусгаар тогтнолын төлөө тэмцэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Тэр үед бид их баяртай байсан. Энэ нь 2006 оны II сарын үед юм. Хятадын засгийн газар,

ирээдүйд Далай Лам салан тусгаарлах тэмцэл хийхгүй гэдгийг тодорхой ойлгосон нь бидний өнөөг хүртэл уулзалт-яриа хийсний үр дүн юм гэж бодож байсан.

Үүний дараа дөрөв, тавдугаар сарын үед Төвдөд байдал улам хурцадсан. “Одоо Төвдөд томилогдсон шинэ төлөөлөгч Төвдөд очоод салан тусгаарлах үйл ажиллагаа явуулагчдыг хатуу цээрлүүлэх болно. Алах хэрэгтэйг нь ална. Шоронд суулгах хэрэгтэйг нь шоронд суулгана.” хэмээн нийт хурал дээрээ шууд мэдэгдсэн. Хуралд сууж байсан Төвдийн төлөөлөгчдийн нэг нь, нийт хуралд олон удаа сууж байсан ч, алах хэрэгтэйг нь ална, шоронд суулгах хэрэгтэйг нь шоронд суулгана гэсэн ийм айдас төрүүлэм ширүүн мэдэгдэл ерөөсөө хийж байгаагүй гэсэн. Тэдгээр төлөөлөгчдийн дотроос энэ тухай бидэнд мэдээ хүргэж байв. Ямартай ч Төвдөд хатуу бодлого барьж, намайг салан тусгаарлах үзэлтэн, тусгаар тогтнолын төлөө тэмцэгч хэмээн буруутгаж байгаа нь тодорхой байна. Хятадын засгийн газартай хийсэн тав дахь удаагийн уулзалт-ярианы үеэр тэд биднийг засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй ч үнэн хэрэгтээ энэ уулзалт төрийн хэмжээний уулзалт байсан. Төрийн хэмжээний уулзалт хийн, тэдний зүгээс Далай Лам тусгаар тогтнолын төлөө тэмцэл хийхгүй гэж мэдэгдсэн ч, дараа нь тусгаар тогтнолын төлөө тэмцэж байна хэмээн үргэлжлүүлэн зохион байгуулалттайгаар ярих болсон. Энэ нь учир байдлыг нарийн ойлгоогүйн улмаас мэдэлгүйгээр буруутгаж байгаа хэрэг биш юм. Тэд, одоо Далай Ламыг ямар ч хамаагүй аргаар эсэргүүцэн буруутгахаас өөр арга зам үлдээгүй гэж бодсон бололтой.

Саяхан буюу Хятадын Коммунист Намын Арван долдугаар Их Хурал хуралдахад ойртсон үед Хятадаас миний таньдаг нэг сэтгүүлч Делид ирсэн юм. Тэр үед би ч гэсэн түүнтэй их харилцдаг байсан. Маргааш нь би барууны нэг орон уруу явахаар төлөвлөсөн байсан. Надад тэрээр компьютероор дүрст ярилцлага хийх хэрэгтэй байна гэж хэлсэн. Энэ удаад ирсэн нь Бээжинд хуралдах их хуралтай холбоотой бөгөөд их хурлыг зохион байгуулагчид түүнийг илгээсэн гэсэн. Мөн тэрээр, энэ удаагийн их хурлаар Төвдийн тухай хэлэлцэж чадвал их хурлаас хойш, дараагийн

хэдэн жилийн хооронд Төвдийн байдлыг цэгцэлж болох бөгөөд хэрвээ энэ удаагийн хурлаар Төвдийн асуудлыг хэлэлцэж чадахгүй бол ойрын нэг, хоёр жилдээ цэгцэлж чадахгүй гэж ярьсан. Мөн Хятадын дээд удирдлагууд хоёр өөр байр суурьтай байгаа бөгөөд нэг хэсэг нь, одоо Далай Ламтай яриа хийж, Төвдийн асуудлыг хэлэлцэх хэрэгтэй гэж үздэг ч, ийм бодолтой хүмүүс цөөхөн байгаа гэж хэлж байсан. Ихэнх нь Далай Ламтай яриа хийх хэрэггүй, энэ удаагийн их хурлаар ч хэлэлцэх хэрэггүй гэдэг. Тэдгээр цөөхөн хүмүүсийн дотор их хурлын дарга байдаг гэж ярьж байсан.

Энэ удаагийн Далай Ламтай хийсэн ярилцлагын бичлэгийг Хятадын дээд удирдлагуудад үзүүлнэ. Ингэснээр Далай Ламд дургүй тэр хүмүүс Далай Ламын Бээжингийн олимпыг дэмжиж байгаа болон салан тусгаарлах үйл ажиллагаа хийхгүй тухай ярьсан шууд ярилцлагыг үзэх юм хэмээн тэрээр ихэд чухалчлан хэлж байсан. Үүнд итгэсэн, итгээгүй ялгаа алга. Бид нар үргэлж нээлттэй, ил тодоор ярьдаг болохоос далдуур юм хийдэггүй. Түүнтэй нэг удаадаа уулзахад ямар ч харшлах зүйл байхгүй гэж бодоод уулзсан. Гэхдээ сая хуралдсан их хурлын үеэр Төвдийн тухай нэг ч үг яриагүй. Одоо Төвдөд үргэлжлүүлэн хатуу бодлого барьсаар байна.

Миний таньдаг нэг хятад эмэгтэй байдаг. Тэрээр сэтгүүлч бөгөөд Төвдөд барьж буй Хятадын бодлогыг ихэд шүүмжилдэг нэгэн. Тиймээс нэгэн үе Хятадын засгийн газарт хавчигдаж, бэрх асуудалтай учирч байсан. Хожим байдал дээрдэх үед надтай нэг удаа уулзсан. Тэр эмэгтэй өөр бусад сэтгүүлчдийн хамт Хятадын Коммунист Намын даргатай их удаан, дөрвөн цагийн турш ярилцлага хийсэн байсан. Тэрээр ХКН-ын даргад Далай Ламтай уулзалт яриа хийх хэрэгтэй гэж хэлэхэд, ХКН-ын дарга, Далай Ламтай ярилцах хэрэг байхгүй. Төвд бидний гарт байна гэж хэлсэн байсан. Асуудлын гол нь энд байна. Төвдийг эзлэн сууж байгаа тэдэнд төвдүүдийн сэтгэлийн зовлон сонин биш. Төвдүүдийг адгуусанд тооцон, бид нар гартаа барьж байгаа учир ямар ч яриа хийх хэрэггүй хэмээн хятад дарга ярьсан байсан.

Түүнчлэн манай төлөөлөгчид зургаа дахь удаагаа

уулзалт яриа хийх үед Хятадын засгийн газраас юу ярьсан бэ гэвэл, Төвдийн асуудал гэж ямар ч хэрэггүй зүйл ярих хэрэггүй. Энд ямар ч асуудал байхгүй. Энэ нь Далай Ламын хувийн асуудал гэж маш ширүүн хандсан. Тэр үед намайг буруутгаж байсан нэг зүйл нь, Далай Лам шашин шүтэх эрхийг боогдуулж, Шүгдэнг шүтэхийг хориглож байна гэсэн. Буруутгаж байгаа байдал нь, "Манай коммунист үзэлд шашныг үгүйсгэдэг ч, Далай Лам шашин шүтэх эрхийг үгүй хийж байгаа учраас бид нар - шашингүй үзэлтнүүд ч гэсэн шашны тухай ярих хэрэгтэй болж байна" хэмээн намайг буруутгасан. Хятадын засгийн газраас Шүгдэнгийн нийгэмлэгийн тухай буюу намайг Шүгдэнг шүтэхийг хориглож байгааг хэлж байсан. Өнөөдөр Шүгдэнгийн энэ асуудал ямар цар хүрээг хамарсан байна? Хятадын засгийн газар цаад талаас нь олон жилийн турш дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд манай төлөөлөгчидтэй уулзах үедээ, намайг буруутгадаг зүйлүүдийнхээ нэгэнд үүнийг тоочдог. Саяхан би Лхасаас ирсэн хэсэг хүмүүстэй уулзсан. Дотоодыг хамгаалах байгууллагын ажилчид Лхасаас Сэра (*Төвд дэх Сэра хийд. Орч.*) хийдэд ирж, Шүгдэнг шүтдэг лам нартай уулзалт хийн, Далай Лам шашин шүтэх эрхийг та нарт өгөхгүй, харин ч шашин шүтэх эрхийг үгүйсгэж байна. Манай коммунист төр засаг та нарт шашин шүтэх эрхийг чинь өгч байгаа учир та бүхэн Шүгдэнгээ заавал шүтэх хэрэгтэй бөгөөд Шүгдэнг шүтдэг хувилгаадаас ном сонсохоор явах, эсвэл Энэтхэгээс тэр адилын хувилгааныг залах хэрэгтэй болбол бид нар та бүхэнд тусалж, онцгойлон бэлтгэл ажлыг ч хийх болно хэмээн ухуулж байна гэсэн.

Мөн олонд Жагра Хувилгаан Лувсанданзан гэж алдаршсан тэрээр Шүгдэнг хүчтэй шүтдэг бөгөөд Хятадын төрд ихэд талтай ханддаг нэгэн. Хятадын төр ч түүнийг өндрөөр үнэлдэг. Тэрээр Шүгдэнг шүтэхийг сайшаан сурталчлахаар Сэра хийдэд ирдэг хийгээд түүний явуулгаар ийм юм болдог тухай сонсож байсан. Ямартай ч үүнийг төвд хүн хийж байгаа нь ойлгомжтой. Юу хийж байна вэ гэвэл, Самялин хийдийн (*Ловон Бадамжунайн байгуулсан төвдийн Бурханы шашны анхны хийд. Орч.*) гол дуганы зүүн баруун талд байдаг Ловон Бадамжунайн том дүрүүдийг нураасан

байсан. Мөн үүнээс хойно, хоёр, гурван сарын дараа, Амдо нутгийн нэг газарт байдаг, би зургийг нь үзэж байсан: хойноосоо урагш сунасан мэт том уулан дээр Ловон Бадамжунайн их том лагшин дүр байсныг Хятад цэргүүд тэсэлж нураасан. Нураах өдрөө цэргүүд уулыг бүслэн хамгаалалтад авч зураг тэргүүтэн авах ямар ч боломжгүй болгоод Ловон Бадамжунайн лагшин дүрийг нураасан байсан. Хятадын коммунистууд шашныг эсэргүүцэн, лагшин дүрийн шүтээнийг нурааж байгаа бол Бурхан Багшийн лагшин дүрийг ч нураах хэрэгтэй. Гэсэн ч Ловон Бадамжунайн дүрийг зориудаар нурааж байгаа нь, Шүгдэнгийн нийгэмлэг хятадын төртэй холбоо тогтоосныг тодорхой харуулж буй хэрэг юм. Нөхцөл байдал ийм дээрээ хүрсэн учраас би Шүгдэнг шүтэхийг үргэлжлүүлэн хориглосоор байна.

Сүүлийн үед их хийдүүд нийтээрээ маш сайн байсан. Сэра-Мэгийнхан (*Энэтхэг дэх Сэра хийдийн хоёр том дацангийн нэг. Орч.*) та бүхний хувьд Бомра аймгаас бусад Сэра-Мэгийн нийт аймгийнхан гарын үсгээ зурж, надад Шүгдэнг шүтэхгүй гэдгээ батлан илэрхийлсэн. Гандан-Шарзэгийн (*Энэтхэг дэх Гандан хийдийн Шарзэ дацан. Орч*) хувьд одоо ч гэсэн Шүгдэнг шүтдэг лам нар байсаар байна. Делид хуралдсан Шүгдэнгийн нийгэмлэгийн хуралд Гандан-Шарзэ дацангийн зарим аймгийн төлөөлөгч мөн хэмээн гарын үсэг зурсан баримт Дэсрүнд (*Төвдийн цагаачлалын засгийн газрын дэргэдэх аюулаас хамгаалах байгууллага. Орч.*) байсан. Би Лхова аймгийн нэг гэвштэй уулзаад түүнээс танай аймагт хэдэн лам байдаг вэ гэж асуухад, зуун дөч, тавин лам бий гэсэн. Шүгдэнг шүтдэг хэдэн лам байдаг вэ гэж асуухад, гуч орчим бий гэсэн. Тиймээс Шарзэ дацангийн олон аймгуудад Шүгдэнг шүтдэг болон шүтдэггүй лам нар одоо ч холилдон сууж байгаа нь бодит байдал. Хамбын үүргийг тушаахад Шүгдэн шүтдэггүй нэгэн хэрэгтэй байсан тул Хамба таныг (*Шарзэ дацангийн хамба. Орч.*) шүтдэггүй байх хэмээн санаад их итгэл найдвар хүлээлгэж энэ суудлыг тушаасан. Гэсэн ч олон хүн таныг энэ асуудал дээр их эргэлзээтэй ханддаг гэж ярьдгийг дууллаа. Чадахаар бол хамбын үүргээ үүр. Чадахааргүй байвал чөлөө эр, ойлгосон

уу? Сэра-Мэ дацангийн Хансүр (*Хамба байсан хүнийг хансүр гэдэг. Орч.*) бээр маш сайн ажилласан. Түүнчлэн Жалрон Хансүр ч маш сайн ажилласан. Би сайшаан, даган баясаж байна. Жилийн өмнөөс Лади Ринбүүчи Шарзэ дацанд "*Төв Үзлийн Дөрвөн Зуун Бадагт*" (*Ума Шивжаба*) шастирыг номлож өгөхийг надаас олон удаа хүссэн. Хамбын зүгээс ч олон удаа хүссэн. Олон хуврагуудын нүүрийг харвал, тэгэлгүй яах вэ хэмээн зөвшөөрч болох ч Шүгдэнг шүтдэг хүмүүстэй холилдон байгаа учраас өмнө хэлсэнчлэн ном номлож, сонсоно гэдэг хөгжим бүжиг хийхтэй адилгүй. Хөгжим бүжиг бүжиж байгаа бол хамаа алга. Тийм биш учраас, багш шавь хоорондын тангараг ариун байх хэрэгтэйг номд номлосон байдагчлан, багш шавийн тангараг ариун байна уу, үгүй юу гэдгийг бодох хэрэгтэй болохоос биш, миний зүгээс тал тохой засах мэтээр ном номлож, та нарын зүгээс ч тал тохой зассан маягтайгаар сонсвол огтхон ч сайн биш. Тэр мэт үйлдвэл дээдийн номоор тоглосон болох бус уу? Тангараг лугаа төгөлдөр байх хэрэгтэй гэсэн номын үгийг бид хэрэгжүүлэх хэрэгтэй. Бид нар л хэрэгжүүлэхгүй бол Хятадын коммунистууд хаанаас хэрэгжүүлэх? Тиймээс тангараг лугаа төгөлдөр байх хэрэгтэй гэснийг бодох хэрэгтэй. Тангараг доройтсон нугуудад ном номлосон ч тус гарахгүй.

Сэра-Мэ дацанд номын барилдлага тогтоосон нь, тус дацангийн Бомра аймгаас бусад бүх аймгийн нийт хуврагууд багш шавийн тангараг ариун гэдгээ илэрхийлсэн учраас тэр юм. Бомра аймагт таны шавь нар болон Госог Ринбүүчийн шавь нар Шүгдэнг шүтдэггүй. Шүтдэг хүмүүс нь тусдаа байдаг. Ихэнх нь Шүгдэнг цээрлэн тэвчсэн нь сайн болсон. Хамба лам (*Сэра-Мэ дацангийн хамба. Орч.*) та бээр энэ асуудлын тухайд зарлиг буулган, бага зэрэг хориг тавьсан. Үүнээс болж танд аюул учирч байсан. Шавь, туслагчгүй бол горьгүй. Хамбад ч гэсэн бие хамгаалагч хэрэгтэй болсон цаг ирж. Энэ мэтийг ч ярих хэрэгтэй болж байна.

Шарзэ дацан тийм ч сайн харагдаагүй. Жанзэ дацангийн хувьд ерөнхийдөө сайн байна. Гэсэн ч эргэлзээтэй юм байх шиг байна. Хамба лам бид нар уулзах үед, маш сайн байгаа гэдэг ч, дээрээсээ доор хүртэл зуун хувь сайн байгаа

нь юу л бол? Эргэлзээтэй байгаа тул няхуур хандах хэрэгтэй. Над уруу хандсан Шүгдэнгийн асуудал улс төрийн аястай болсон. Бидний байгуулсан цагаачлалын удирдах газрыг устгах нь Хятадын засгийн газрын үүрэг юм. Адаглаад Далай Ламыг үгүй хийхийн тухайд хятад туршуулууд эмнэлгүүдэд ажиглалт явуулах зэргээр Далай Ламыг эм, эмчилгээний талаас нь үгүй хийх аргыг хайдаг. Мөн хоол хүнсээр дамжуулан хороох аргыг ч хайдаг. Зуун хувь үнэн эсэхийг хэлж мэдэхгүй ч, уржнан Амараватид Дүйнхорын Вангийн (*2006 оны 1-р сард Энэтхэгийн Амараватид тавьсан Дүйнхорын Ван. Орч.*) үеэр хоёр хүн явуулсан яриа байдаг. Төвд ажилчин гэсэн. Нэгнийх нь үүрэг, Далай Ламын сэнтий хаана, ямар хэмжээнд байгааг мэдэх, нөгөөх нь сэнтий доор бөмбөг тавих үүрэгтэй байснаас эхний хүн хэмжээгээ авч чадсан ч нөгөө хүн нь бөмбөгөө тавьж чадаагүй. Далай Ламыг үгүй хийж, Төвдийн цагаачдын нийгмийг цусанд хутгах нь хятадын улс төрийн нэг зорилго бөгөөд үүнийгээ гүйцэлдүүлэхийн тулд үйл ажиллагаа ч явуулж байгаа нь баттай байна. Шүгдэнгийн нийгэмлэг Далай Ламыг эсэргүүцэгч цөөн хэдэн хүмүүсийн бүлэг болсон тул Хятадын зүгээс үүнийг маш том олз хэмээн үзэж, тэдэнд засгийн газраасаа тусгайлан дэмжлэг үзүүлж, намайг шууд буруутгах болсон. Асуудлыг ийм байдалтайгаар зөнд нь орхих арга алга. Ойлгосон уу? Үүнийг тоолгүй өнөөг хүртэл их хийдүүдэд, “Тэд нар Шүгдэнг шүтдэг. Бидэнд арга алга.” гэсэн аястай тэднийг байлгасаар ирсэн. Ийм байдлаар нэг жил, таван жил, арван жил байлгавал болно гэж бодохгүй байна. Шүгдэнгийн нийгэмлэг надад уурлахаас өөр юм бодохгүй. Цааш сөгөөсөн учраас нааш уурлах нь аргагүй. Гэсэн ч надад уурласнаа учир шалтгаанд үйлдээд хятадын коммунистуудад толгойгоо тушаах нь утгагүй хэрэг. Төвдийн Бурханы шашныг сөнөөн үйлдэгч нь хятадын коммунистууд. Таван зуун мянга орчим төвдүүд алуулж, таван зуун мянга орчим төвдүүд шоронд тарчилж үхсэн. Үүнийг хятадын коммунистууд үйлдсэн. Надад уурлаад Төвдийн уламжлал соёлыг үндсээр нь устгагч нартай нийлсэн нь хэрээс хэтэрч байна. Надад гэм зүүн өгүүлж байгаа нь хамаа алга. Шүгдэнгийн нийгэмлэгээс намайг алах оролдлого хэд хэдэн

удаа хийсэн. Энэтхэгийн Аюулгүйн Албанаас, Энэтхэгт Далай Ламын амь насанд хамгийн ихээр аюул учруулж болох бүлэглэл нь Шүгдэнгийн нийгэмлэг байна гэж Дэсрүнд бичиг илгээсэн байсан. Үүнээс шалтгаалж Дарамсала дахь миний суудаг газрыг тойруулан нэмж торон хүрээ татсан.

Мөн намайг Сэра хийдэд очих үед Бомра аймгийг энэтхэгийн цагдаа нар хамгаалж байгаа мэт байсан. Гандан хийдэд очих үед ч тэр мэт байсан. Энэ нь сайны шинж биш. Иймэрхүү байдалтайгаар та нар миний өмнө болж байна, бүтэж байна гэж ярин, балинг нь нохой зуугаад явсан ч мишээн сууна, дуганд нь гал гарсан ч мишээн сууна гэдэг шиг суугаад байвал сайхан байна уу? Намайг өмнөд Энэтхэгт ирэх бүрд Шүгдэн шүтэгчид нь уурлаад, бусад хүмүүс нь ч гэсэн сэтгэл амгалангүй байгаад байвал ямар ч хэрэг алга. Өчигдөр ярьж байсанчлан багшийгаа залсан. Багш нь ч ирээд ном номлож байна. Гэсэн ч сэтгэл амгалангүй ингээд цааш үргэлжлээд суувал сайн биш. Ойлгосон уу? Би өмнө нь ч хэлж байсан, Шүгдэнг сонгох уу? Далай Ламыг сонгох уу? Шүгдэнг сонговол хувь хүний хэрэг. Гэхдээ миний дэргэдээс ном сонсож, сахил хүртэхээр битгий ирээрэй гэж хэлдэг. Миний зүгээс Шүгдэнг шүтэгчид байдаг газар ном тавивал тангараг лугаа харшилна. V Далай Ламыг эсэргүүцэгч тэр хүмүүсийг шавиа гэж үзэх үндэс алга. Тиймээс, та нар Шүгдэнтэй барилдлагатай бол, хойшид Далай Ламд сүжиглэхгүй, Далай Лам хэрэггүй гэж эцэслэн шийдсэн бол ганц Шүгдэнгээ л шүт. Оюуныхаа мухарт хоёр өөр юм бодоод суух хэрэггүй. Ойлгосон уу?

Саяхан нэг явдал гарсан. Жангүнчойны (*Их хийдүүдийн хуврагууд цугларч шалгадаг ухааны номын утгыг хэлэлцэхийг жангүнчой гэдэг. Орч.*) үеэр Сэра-Жэ дацангийн хуврагууд, Шүгдэнг шүтдэг хүн дамжаанд суувал бид нар ном хаялцахгүй гэсэн байна. Ингэх хэрэгтэй гэж тэдэнд хэн ч сануулаагүй. Дэсрүнгээс ч, биднээс ч, хамба нараас ч үүнийг хий гэж хэлээгүй. Энэ явдал гэнэт болсон учир та нарын зарим нь сандарч, мэгдсэн нь аргагүй. Одоо байдал намжиж, тайван болсон байна. Гэсэн ч байдал намжсан гээд орхиж болохгүй. Нийт олонхын үүсгэсэн энэ явдлыг гүйцээх нь чухал. Ойлгосон уу?

Мөн саяхан Дели дэх Шүгдэнгийн нийгэмлэгийн хүмүүс Энэтхэгийн Гадаад Явдлын Яаманд, биднийг хамгаалах хэрэгтэй гэсэн бичиг өргөсөн байсан. Энэтхэгийн Гадаад Явдлын Яам үүнд анхаарал хандуулах хэрэгтэй болж байна. Үнэн хэрэгтээ Шүгдэнгийн нийгэмлэгийн хүмүүс хүн алж, зодож нүдэх, галдан шатаах, заналхийлэх зэргийг удаа дараа үйлдэж байснаас биш бидний зүгээс тийм бусармаг явдал огтхон ч хийгээгүй. Нөхцөл байдал ийм болсон. Энэтхэгийн Гадаад Явдлын Яамнаас тэдэнд өгсөн хариу бичигт, Мисурын (*Өмнөд Энэтхэг дэх цагаач төвдүүдийн оршин суудаг Мисур дүүргийн төв. Орч*) холбогдох газарт хүсэлтийг авч үзэхийг даалгасан гэж бичсэн байсан. Ямартай ч энэ асуудал Энэтхэгийн засгийн газартай холбогдож байна. Энэтхэгийн засгийн газартай холбогдсон учраас Энэтхэгийн засгийн газар биднээс тодруулга хүсэж, бидний зүгээс ч нөхцөл байдлыг тайлбарлах хэрэгтэй болсон.

Жангүнчойны үеэр болсон явдал бол, сэтгэл санааг нь удаан хугацааны турш зовоож байсан зүйлээс салах гэж, сэтгэл доторх өвчнөө гадагш нь гаргасан олон хуврагуудын хүсэл байсан. Нэгэнт эхэлчихсэн энэ хэрэг явдлын тухай бодох хэрэгтэй. Ойлгосон уу? Шашны хэрэг эрхлэх газар (*Төвдийн цагаачлалын засгийн газрын харьяа байгууллага. Орч.*) энэ явдлын тухай хэлэлцэх хэрэгтэй. Ринбүүчийд ч гэсэн (*Төвдийн цагаачлалын засгийн газрын тэргүүн Самдон Ринбүүчи. Орч.*) хамаатай болж байна. Холбогдох хүмүүс нь цугларч хэлэлцвэл нэг арга олдоно. Шүгдэн шүтэгчдийн хувьд бол тухайн хүний эрх. Би анхнаасаа л хэлж байсан, Шүгдэнг шүтэх эсэх нь хувь хүний эрх. Шүгдэнг шүтвэл ийм, ийм гэм бий гэж авла орхилыг ялган хэлэх нь миний үүрэг. Сонсох эсэх нь өөрсдийн шийдэх хэрэг гэж анхнаасаа хэлж байсан. Одоо ч гэсэн мөн адил. Тэд нар Шүгдэнг шүтэхээ болихгүй, үргэлжлүүлэн шүтнэ гэж байгаа бол, өмнө нь та нар хэлж байсан: хоёр ялгарах хэрэгтэй гэж. Одоо тэгж ялгарах цаг нь болсон. Хэрхэн яаж үйлдэх тухай та бүхэн хуралдаж шийдэх хэрэгтэй. Өөр айлтгах зүйл алга аа.

# 2008 оны 1-р сарын 8-ний өдөр. Дээрхийн Гэгээнтний Брайбүн Лосалин дацанд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Та бүхнийг цай зооглож байх хооронд нэг зүйлийг ярья. Өчигдөр биднийг хуралдаж байхад Сэра-Жэгийн гэвш Шүгдэнгийн тухай ярьсан. Тэр гэвш хаана сууж байна? Өчигдөр дэхор хамба аялгаар (*Төвдийн баруун хязгаар дэхор нутгийн аялга. Орч.*) ярьж байсан болохоор таны бүх яриаг сайн ойлгоогүй ч, таны ярьсан хоёр зүйлийг засаж ярих хэрэгтэй гэж бодлоо. Та их сэтгэл гарган ярьсан. Гэвч *сахиус шүтэхийн тухайд* гэж ярьсан. Ер нь ингэж ярьдаг хүмүүс байдаг. *Сахиус шүтэхийн тухай* гэж ярьж байгаа нь эндүүрэл шүү. Сахиус мөн бол ингэж ярьж болно. Сахиус гэж туслагч, сахин хамгаалагчийг хэлдэг. Жишээлбэл, Анхдугаар Далай Лам Гэндүндүвийн намтарт, гэлүгбын гол сахиус нь Дамжан-Чойжал мөн тул Гомбо сахиусыг шүтэх нь сайн биш гэсэн яриа гардаг. Гэсэн ач Анхдугаар Далай Лам Гэндүндүв өөрийн туршлага, анхааран авлагын үүднээс тэр адилын гэм ерөөсөө байхгүй хэмээн зарлигласан байдаг.

Гомбо сахиус нь Сажавын гол сахиус юм. Тижан Ринбүүчи багш маань надад ийн айлдаж байсан, Жалцав хийгээд Хайдүв Ринбүүчи хоёрын Жалцав Ринбүүчи багш, Хайдүв Ринбүүчи шавь нь байсан. Жалцав Ринбүүчи Богд Зонховтой ном хаялцахаар Үй-д (*Төвдийн төв Үй нутаг. Орч.*) морилон, Богд Зонховын ном айлдаж буй газар ирэн сэнтий дээр бандида малгай асаан суухад Богд Зонхов номоо үргэлжлүүлэн айлдсаар байсан гэдэг. Жалцав Ринбүүчи шударга оюунаар оршигч, мэргэний эрхт нэгэн байсан тул

Богд Зонховын ном номлохыг сонсоод, энэ лам бусад лугаа адилгүй нэгэн байна хэмээн таалж малгайгаа буулган суусан хийгээд аажмаар өөрийн эрхгүй Богд Зонховт сүжиглэн сэнтийнээсээ бууж мөргөл үйлдээд, “Тантай ном хаялцахгүй. Одооноос таны шавь больё” хэмээн шавь орсноор Богд Зонховын хөвгүүдийн ахмад нь болсон. Сажавын (*Төвдийн Бурханы шашны дөрвөн том дамжлага, урсгалын нэг. Орч.*) мэргэдийн манлай болсон нэгэн Богд Зонховтой ном хаялцахаар морилсон ч сүүлдээ Богд Зонховын шавь нь болсон учир, тэр үед Сажавынхан Гүр-Гомбо болон Дөрвөн Мутарт Гомбо сахиусаа гэсгээхээр илгээсэн гэдэг. Гүр-Гомбо болон Дөрвөн Мутарт Гомбо голлосон Цогт Сажавын зарлигийг сахигч, шашны сахиус тэдгээр нугууд Сажавын их хийдээс Үй зүгт морилохдоо хилэнт хаан аймшигт болохын ёсоор морилсон гэдэг. Урьд Сажавын зарлигийг хүлээж, сахихаар ам авсан учир тэр адилын ёсоор морилсон гэлцдэг. Тэгээд сажын уулын хамрыг давсан дариудаа их сүрийг үзүүлж явсан сахиуснууд номхон дүрээр Лхас хийгээд Гандан хийдэд морилсон гэдэг. Өнөөх хоёр сахиус Хайдүв Ринбүүчийд хандан, Сажынхан турхиран явууллаа. Урьд Сажавын ихэс дээдсүүдийн зарлигийг сахина хэмээн тангараг тавьсны учир энэ хүртэл ирэх хэрэгтэй болов. Балин нэгийг хайрлана уу хэмээгээд, Та энд Богд Зонховын шашныг барьж, тэтгэн арвижуулж байгаа учир даган баясахаас биш танд хорлол, хөнөөлийг үйлдэхийн учир шалтгаан үгүй хэмээн айлтгасан түүхийг Тижан Ринбүүчи айлдаж байсан.

Анхдугаар Далай Ламын намтарт Гэлүгбын шашинд Дамжан-Чойжал гол сахиус учир Гомбо сахиусыг шүтвэл сайн биш гэсэн яриаг ор үндэсгүй зүйл хэмээсэн байдаг. Зан нутагт Анхдугаар Далай Ламыг мэндлэх үед нутагт нь дээрэм ирсэнд гэрийн хүмүүс бүгд зугтахдаа дөнгөж төрсөн нярай хүүгээ нэгэн нүхэнд нуугаад зугтсан гэдэг. Дээрэмчид явсны дараа эцэг эх нь ихэд санаа зовсоор буцаж ирэх үед их сүртэй хар хэрээ хүүг нь сахиад сууж байж. Хожим Анхдугаар Далай Ламд Гомбо сахиус, би таныг мэндэлсэн цагаас чинь сахисан хэмээн айлтгаж байсан гэдэг. Товчхондоо, Гэндүндүв Богд Зонховын шавь мөн бөгөөд Дамжан-Чойжал сахиусыг голлон шүтдэг байсан ч Гомбо сахиусыг хамтад нь

шүтдэг байсан. Багаасаа Гомбо сахиустай барилдлагатай байсан. Тиймээс *сахиус шүтэх тухайд* гэж энэ адилын байр байдлыг л хэлдэг. Ойлгосон уу?

Өчигдөр таны *сахиус* хэмээн ярьсан чинь Шүгдэнгийн тухай байсан. Шүгдэн гэж юу юм бэ гэвэл, түүнийг хамгийн сайн мэддэг хүн нь V Далай Лам байсан бөгөөд V Далай Ламын үед Шүгдэн гарсан байдаг. V Далай Лам Шүгдэнгийн тухай юу гэж зарлиглаж байсан бэ гэвэл,

*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг, ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс* хэмээх

гурван мөр үүгээр Шүгдэн гарсан шалтгаан хийгээд Шүгдэнгийн мөн чанар, Шүгдэнгийн хийдэг үйл гурвыг үзүүлсэн байдаг. *Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх Буруу ерөөлт* хэмээхээр шалтгаан: буруу ерөөлийн эрхээр гарсан болохыг айлдсан байна. Тэгвэл мөн чанар нь юу гэвэл, *буруу ерөөлт тангаргийн буг, ад зэтгэр* болохоос *сахиус* биш. Би танд үүнийг хэлэх хэрэгтэй гэж бодсон юм. *Буруу ерөөлт тангаргийн буг, ад зэтгэр* хэмээн шалтгаан: буруу ерөөлийн эрхээр төрсөн бөгөөд мөн чанар нь *тангаргийн буг, ад зэтгэр* болохоос хүн биш. Ер нь хүн бусын буг олон байдаг. Ад зэтгэр түүний хийдэг үйлийнх ялгамжаа юу вэ гэвэл, *амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдэх* юм. Энэ мэт Шүгдэнгийн гарсан шалтгаан, мөн чанар, үйлийнх нь ялгамжаа сэлтийг дээрх гурван мөрөөр үзүүлсэн байдаг. *Буруу ерөөлт тангаргийн буг, ад зэтгэр энэ бээр Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс* хэмээн заригласан тул энэ нь сахиус буюу шүтэж болох тэнгэр-сахиус бус, шүтэж үл болох буг юм. Шүгдэнг шүтэгчид нь буг шүтэгчид бөгөөд Шүгдэн нь ерөөл буруудсан тангаргийн буг юм. Тангаргийн буг болохоо Шүгдэн өөрөө ч хэлж байсан. Бараг Тижан Ринбүүчийн зарлиг дотор байдаг. Шүгдэн Брайбүнаас ерөөл буруудан буг болж төрснөөсөө 65 жилийн хойно, анх Дашлхүмбэ хийдэд ирэхэд Дашлхүмбийн Намсрай сахиус найман нөхрийн хамт хийдээ хамгаалан хүрээлсэн тул орж эс чадаад цааш догшин дүрээр Сажавын хийдийн Их Лам Сономринчингийн өмнө ирэхэд Сономринчин, чи хэн юм хэмээн зарлигласанд, би Гэлүгбын тангаргийн буг байна

хэмээн өөрөө хэлсэн байдаг. Ер нь ертөнцийн дүрс үгүй эгэл омогтон тэдгээрийн дунд, би буг хэмээн өөрийгөө хэлдэг ад, зэтгэр байдаг тухай яриа байдаг. *Би Гэлүгбын тангаргийн буг* байна хэмээн хэлсэн нь энэ яриатай таарч байна. Тиймээс V Далай Лам бээр, *...Буруу ерөөлт тангаргийн буг, ад зэтгэр* хэмээн зарлигласан хийгээд Шүгдэн өөрөө, *би Гэлүгбын тангаргийн буг байна* гэж хэлсэн хоёр яг таарч байна. Тангаргийн буг ч болдог, сахиус ч болдог юм байх уу? Сахиус гэж сахин хамгаалагчийг хэлдэг. *Би тангаргийн буг* гэж хэлсэн тэр нь сахиус огтхон ч биш юм. Тиймээс би үүнийг хэлье гэж бодсон юм.

Мөн та ингэж ярьсан, Павонка Ринбүүчи хийгээд түүний шавь нарын үед Шүгдэн тусалдаг байсан ч, зарим эм эхлээд тустай байгаад сүүлдээ хор болдог хэмээн жишээ авч ярьж байсан. Тийм үү, үгүй юу? Дэхор хамба аялгатай ярьсан болохоор бүгдийг нь би сайн ойлгоогүй. Жанзэ Цорж Ринбүүчийн яриаг бас ойлгоогүй. Ринбүүчи, та их сэтгэл гарган зарлиг хайрлаж байсан. Баярлалаа!

Павонка Ринбүүчи хийгээд түүний шавь нарын үед Шүгдэн тусалдаг байсан гэдгийг шинжлэх хэрэгтэй. Ер нь ерөөл буруудсан тангаргийн бугийг шүтсэнээр тус гарна гэдэг эргэлзээтэй. Павонка Ринбүүчи залуудаа их алдартай хувилгаан байсан. Өмнөх дүрийн Далай Лам тусгайлан тэтгэж, дотно ханддаг байсан. XIII Далай Ламтай чөлөөтэй уулзаж болдог байв. Мэрү хийдэд жил бүр болдог номын айлдварыг цаг үргэлж Богд Зонховын суудалд сууж буй Гандан Ширээт лам айлддаг байсан ч нэг удаа XIII Далай Лам бээр Павонка Ринбүүчийг онцгойлон, Мэрү хийдийн номын айлдварыг Гандан Ширээт ламаар айлдуулахын оронд Павонка Ринбүүчигээр айлдуулах зэргээр ихэд хүндлэн, онцгойлж үздэг байв. Гэсэн ч, хожим Павонка Ринбүүчийд XIII Далай Лам зарлиг зэмлэл олныг хүртээх болсон. Үүнд олон шалтгаан байдаггүй: Шүгдэнг шүтсэнээс болсон юм. Тиймээс өмнөх дүрийн Далай Лам түүнийг тэтгэж байх нь сайн байсан уу, зарлиг зэмлэл хүртээж байх нь сайн байсан уу гэдгийг бодох хэрэгтэй. Шүгдэнгээс болж XIII Далай Лам түүнийг зэмлэх болсон. Үнэндээ Шүгдэнг шүтсэн нь Павонка Ринбүүчийн зохиол үйлсэд хор болсон уу, гэхээс тус

болоогүй. Павонка Ринбүүчийн ойрын шавь Жүрмэддовжай гэж байсан. Бид нар Төвдөөс хамтдаа цагаачилж ирсэн учраас их дотно байдаг байв. Тэрээр надад нэг удаа ийн ярьсан юм: Павонка Ринбүүчи XIII Далай Ламаас зарлиг зэмлэл олныг хүртээд таалал нь ихэд эмээн сууж байх нэг өдөр XIII Далай Ламтай дахин уулзах боломж тохиож. Тэр үед XIII Далай Лам Павонка Ринбүүчигээс, Ринбүүчи одоо юу хийе гэж бодож байна хэмээн асуусанд, Павонка Ринбүүчи, "Их сайхан боломж тохиов. Хэсэг хугацаанд *Бодь Мөрийн Зэргийн* ном айлдаж чадалгүй удсан. Одоо нааш зарлиглан асуусан тул энэ тухайгаа айлтгах нь зохистой" хэмээн санаад, Бодь Мөрийн Зэргийг айлдаж өгөхийг хүссэн хүмүүс олон ирэх болсон тул Мөрийн Зэргийн ном тавьдаг юм билүү гэж бодож байгаа хэмээн айлтгасанд, урьд XIII Далай Лам Мэрү хийдийн номыг Гандан Ширээт лам айлддаг байсны оронд Павонка Ринбүүчийгээр айлдуулж байсан ч, тэр үед Павонка Ринбүүчийд, "Одоо Мөрийн Зэргийг номлох хэрэггүй. Барилдлага байхгүй болсон." хэмээн айлдсан байдаг. Шүгдэн шүтсэн нь Павонка Ринбүүчийн зохиол үйлсэд хортой байсан юм. Эдгээрийг та сэтгэлдээ магадлах хэрэгтэй. Тантай ижил бодолтой олон хүмүүс энэ байдлыг сайн ойлгохгүй байх шиг байдаг. Шүгдэнг шүтсэн нь Павонка Ринбүүчийд тустай байсан уу, хортой байсан уу гэвэл, хортой байснаас биш тустай байгаагүй. Шүгдэн нь тангаргийн буг, ад зэтгэр. Буруу ерөөл тавьсны эрхээр шашин, амьтанд хорлон үйлддэг нэгэн. Гаднаа шашинд туслах, шашныг сахих мэт байдал үзүүлдэг ч үнэн хэрэгтээ туслахаасаа хорлох нь их юм. Адаглаад, Павонка Ринбүүчи нас дээр гарсан үедээ XIII Далай Ламаас зарлиг зэмлэл олныг хүртэн эмээн суух болсон хийгээд Павонка Ринбүүчийн хуучин чанзав лам (*Ажил үйлсэд туслагч лам. Орч.*) Шүгдэнг шүтсэнээсээ болж галзуурах шахан, Дашчойлингийн их дарцаг (*Шашин ном мандан бадрахыг билэгдсэн их дарцаг. Орч.*) зоосон газарт уналгын морины хонх дуугарахыг сонсоод ихэд айн сандарч юу хийхээ ч мэдэхээ больж байсан гэдэг. Ойлгосон уу? Эдгээр нь Павонка Ринбүүчийн намтарт гардаг. Тижан Ринбүүчи хожим Энэтхэгт ирээд Павонка Ринбүүчийн намтрыг хянаж, заримыг нь хураангуйлж, заримыг дэлгэрүүлж бичсэн байдаг.

Миний хэлж буй намтар Төвдөд хэвлэгдсэн: Балдан гэгч бээр анх модон баранд буулгасан яг тэр чигээрээ хэвлэгдсэн хоёр боть бий. Тэр хоёр ботид XIII Далай Ламаас ямар ямар зарлиг ирж байсан хийгээд зарлигийн хариу айлтгалыг хэрхэн өргөж байсан тухай бүгд гардаг.

Павонка Ринбүүчийн шавь Шидэ-Дасүр гэгч нэгэн байсан. Монголын долдугаар сард Шидэ-Дасүр Лхасад байх үед үүрийн зүүдэндээ буян номд шамдан байхуйд, Шүгдэн буусан нэгэн лам бээр ихэд баярласан өндөр дуугаар “Хорин еснийг дүүргээд битүүнд шүү!” хэмээн хоёр удаа тодорхой өгүүлсэн нэгэн гарсанд, Шидэ-Дасүр бээр үүнийг Павонка Ринбүүчийд даруй айлтгаж асууя хэмээн санаад тэр өдрийн өглөө Дашчойлинд очин, Павонка Ринбүүчигээс асуусанд Ринбүүчи, одоо ийм тийм хэмээн хэлэхэд бэрх ч дараа шинжлэх хэрэгтэй хэмээгээд Шидэ-Дасүрт энэ шинж тэмдэг хэрхэн хэзээ гарсныг мутрын бичигтээ тэмдэглэн үлдээсэн гэдэг. (*Төвдөд хэвлэгдсэн Павонка Ринбүүчийн намтрын 519-р хуудасны ар талд тодорхой бий.*) Тэр сарын битүүний өдөр XIII Далай Лам таалал төгсөхөд Павонка Ринбүүчи, урьд Шидэ-Дасүрт Шүгдэн, “Хорин еснийг дүүргээд битүүнд” хэмээсэн нь гэгээнтэн нирваан болох цагийг эш үзүүлжээ хэмээн айлдаж байж. (*Өмнө өгүүлсэн Павонка Ринбүүчийн намтрын 524-р хуудасны ар талд бий.*) Баярласан өндөр дуугаар сайн мэдээг дуурсгадаг. Богд Зонховын Бодь Мөрийн Зэрэгт, “Төв үзэлтнүүд нь шалтгаан нөхцөлд шүтэн гарсан тэдгээр бүхэн өөрийн мөн чанараасаа бүтээгүй хэмээн өндөр дуугаар дахин дахин дуурсган үйлдэх болой.” хэмээн зарлигласан байдаг мэт, тэр адилын сайн зүйлийг баярласан өндөр дуугаар өгүүлдэг болохоос гашуудлын мэдээг баярласан өндөр дуугаар дуурсгах ёс үгүй.

Шүгдэн XIII Далай Ламын таалал барах өдрийг мэдчихээд баярлан өндөр дуугаар, “Хорин еснийг дүүргээд битүүнд шүү!” хэмээн өгүүлсэн хийгээд энэ тухайд Павонка Ринбүүчи бээр, Шүгдэн тэр адил эш үзүүлсэн нь гэгээнтний нирваан болох өдрийг хэлж байж хэмээн зарлигласан байдаг. XIII Далай Лам таалал барахыг горилж байсан нь Павонка Ринбүүчийг Шүгдэн шүтлээ хэмээн зэмлэж байснаас болсон хэрэг.

Өмнөх дүрийн Далай Лам - хөгшин гэлэн түүнийг бодох үед надад харамсах, өрөвдөх сэтгэл төрдөг. Төвдийн шашин төрийн тусын тулд хэчнээн их зүтгэсэн? Их хийдүүдийн сургалтыг сайжруулахын тухайд, мөрийн зэргийн номлол сайн ч, эхлээд номоо сайн үзэх нь маш чухал хэмээн хориг тавьж байв. Ном үзсэн гэвш нараас шалгалт авах зэргийг өмнөх дүрийн Далай Лам эхлүүлж байв. Тэр хөгшин зарлигийн ачтай нэгэн биш гэж үү? Мөн гэлэн, гэцүлийн сахилыг үргэлжид хайрлаж байсан нь Бурханы шашныг сууриас тэтгэсэн хэрэг. Өглөөнөөс үдэш хүртэл Төвдийн шашин, төрийн тусын тулд зүтгэж, маш их үүргийг үүрч байсан. Хөгшин гэлэн түүнийг нирваан болох үе нь Цаст Төвдийн орны тэнгэр, хүмүүн нийтээр гаслан, нулимс унагаах цаг болохоос, сайн мэдээг дуурсгах үе огтхон ч биш юм. Үүнийг сайн мэдээ хэмээн дуурсгасан нь буруу ерөөлт тангаргийн буг, шашин амьтанд хорлогч гэдгээ харуулж буй хэрэг юм. Ойлгосон уу? Тиймээс Шүгдэн сахиус биш тул энэ нь сахиус шүтэх эсэх тухай асуудал огтхон ч биш юм.

Ер Бурханы шашинтан хүн бээр ертөнцийн эгэл тэнгэр, бугийг шүтэх хийгээд, илүүтэйгээр шарын шашинтан хүн буруу ерөөлт тангаргийн буг, шашин амьтанд хорлогчийг авран хамгаалах тэнгэр сахиус, Зөөлөн Итгэлт Богд Ламын шашны сахиус гэж шүтэх нь эндүүрэл юм шүү! Шүгдэн Павонка Ринбүүчи хийгээд түүний шавь нарийн нас сүүдэр, зохиол үйлсэд нь хорлож байснаас тусалж байгаагүй. Павонка Ринбүүчи тэргүүтэнд анхандаа тусалж байгаад сүүлдээ хилэгнэн хор хүргэх болсон гэдэг тэр адил биш шүү! Анхнаасаа буруу ерөөл тавьсны эрхээр тангаргийн буг, ад зэтгэрийн мөн чанарт төрөл авсан бөгөөд шашин, амьтанд хорлон үйлддэг нэгэн юм. Тэр ч анх V Далай Ламын үед гарснаасаа хойш мөн чанар нь хувираагүйг та мэдэж үйлдвэл сайн. Энэ тухайд би ч гэсэн анхандаа эндүүрч байсан. Энэ нь мэдэхгүй хийгээд чухалчилж үзээгүйгээс болсон хэрэг. Тижан Ринбүүчийд буруу байхгүй. Павонка Ринбүүчийн шавь учир багшийгаа даган шүтсэн. Павонка Ринбүүчи ч олон нөхцөл шалтгааны улмаас шүтэх болсон. Өмнөх дүрийн Далай Ламаас нас дээр гарсан үедээ зарлиг зэмлэл олныг хүртэх болсон учир Павонка Ринбүүчи санаа зовнин, таалал

эмээн суух хэрэгтэй болсон. XIII Далай Лам нирваан болох үед Шүгдэн баярлан, үүнийг сайн мэдээнд тооцон, баярласан өндөр дуугаар дуурсгасан байдаг. Павонка Ринбүүчи ч эгэл шавь нарын нийтийн үзэгдэлд, Шүгдэнг хориглож байсан XIII Далай Лам таалал барахад аюулаас гэтэлсэн мэт хүндэтгэлийн бус хэлээр хэлбэл, бага зэрэг үл тоомсорлон нирваан болсныг нь боломж хэмээн ашиглан Шүгдэнг шүтэхийг хүчтэй дэлгэрүүлсэн юм. Үүнийг учир шалтгаанд үйлдээд, Павонка Ринбүүчийг буруутгах уу гэвэл, Шүгдэнг шүтэж, дэлгэрүүлсэн энэ үйл нь буруу болохоос биш, эрдэм номынхоо талаас санаанд багташгүй нэгэн. Мөрийн зэрэг хийгээд оюун судлахуйн номын эзэн, үнэхээр санаанд багташгүй эрдэмтэй хүн байсан. Миний хувьд, миний дамжлагын багш мөн. Нэгэн үзүүрт сэтгэлээр сүжиглэдэг. Гэсэн ч сүжигтэй гэдгээ учир шалтгаанд үйлдээд туурвисан үйл бүхнийг нь сайн гэж ярих утгагүй. Ялгах хэрэгтэй.

Жишээ болгон өөртэйгөө холбоотой нэг түүх ярья. Та нар Сэра-Жэ дацангийнхан битгий эмзэглээрэй. Радэн Ринбүүчи бол миний багш. Зарим үед Радэн Ринбүүчийг зүүдэлдэг. Нэгэн үзүүрт сэтгэлээр ч сүжиглэдэг. Радэн Ринбүүчи, Дагтаг Ринбүүчийн дэргэдээс ном сонсож байсан хүн. Сүүлд нь төрийн эрхийн тухай бэрх асуудал үүсэх үед Нюүннай Лам хийгээд Хардо нар арга мухардан Дагтаг Ринбүүчийг хороох ажил хийсэн байдаг. Эхэндээ Радэн Ринбүүчи Радэн хийдээс Лхасын дөрвөн хороонд бичиг илгээж, тэгж болохгүй хэмээн зарлиг буулгасан байдаг. Хожим Радэн Ринбүүчийн буулгаж байсан зарлиг бичиг сэлтийг үзэхэд, Радэн Ринбүүчийн өөрийн мутраар бичсэн нэгэн бичигт “Хөгшин ламыг алдаж болохгүй. Болгоомжил.” хэмээн бичсэн байсан. Хөгшин лам нь Дагтаг Ринбүүчи юм. Дагтаг Ринбүүчийг хөнөөх тэдний төлөвлөгөө нь тэсрэх бөмбөг байсан. Радэн Ринбүүчи билэг чанар бүрдсэн хувилгаан байсан. Өмнөх дүрийн Далай Лам түүнийг эндүүрэлгүй танин барьж тодруулсан юм. Радэн Ринбүүчи намайг багад харж ханддаг байсан. Юу ч болсон, миний ном сонссон багш. Надад уншиж, бичихийг зааж байсан багш маань учраас би нэгэн үзүүрт сэтгэлээр сүжиглэдэг. Сүжиг маань ч хувирахгүй. Тэр бичгийг үзэх үед би, шавь нарын

нийтийн үзэгдэлд ийм явдал болж дээ хэмээн бодсоноос биш багшдаа сүжиг алдраагүй. Радэн Ринбүүчийд сүжиглэдгээ учир шалтгаанд үйлдээд, өөрийн багш Дагтаг Ринбүүчийг хороох явдалд оролцон “Хөгшин ламыг алдаж болохгүй. Болгоомжил.” гэснийг нь би зөв гэж хэлж чадахгүй. Тэр нь алдаа байсан юм. Үүн шиг Павонка Ринбүүчи санаанд багташгүй эрдэмтэй хүн. Үнэхээр мөрийн зэрэг хийгээд оюун судлахуйн номын эзэн, Дэмчиг Бурхан бодитой мөн. Тижан Ринбүүчи багшийн маань хувьд, би зүүдэндээ Тижан Ринбүүчи багшийг Жовужэ Балдан Адишагийн лагшин, зарлиг, тааллын хувилгаан болохыг тодорхой үздэг. Санаанд багташгүй эрдэмтэй хүн. Гэсэн ч Шүгдэнг шүтсэнийг нь эндүүрэл байсан гэхээс сайн зүйл байсан гэж хэлэх аргагүй. Та ойлгосон уу? Дараа бусад хүмүүст энэ тухай ярих бол ор үндэсгүй тийм зүйл битгий яриарай! Өчигдөр таны ярьснаар бол, сахиус мэтээр, тэр нь Павонка Ринбүүчи тэргүүтэнд маш ихээр тусалдаг байсан хийгээд хожим Далай Лам болохгүй, бүтэхгүй гээд шүтэж болохооргүй болсон мэтээр ярьж байсан. Та сэтгэл гарган, тийн ариун санаагаар ярьж байсныг чинь би ойлгосон. Та бүгд Сэра-Жэ дацангийн олон хуврагууд тийн ариун санаагаар Далай Ламын заан үзүүлсэн зам, мөрийг баттай барьж, авла орхилыг эндүүрэлгүйгээр ялгасан. Тиймээс, тийн ариун санаагаар, сэтгэл гарган ярьсныг тань би сайн ойлгож байна. Гэхдээ таны яриа бидэнд, Далай Ламын зарлигийг дагаад Шүгдэнг хориглож байгаа юм шиг ойлгогдсон. Энэ нь ухаан дорой нэгний л дагах ёсон. Бид тийм биш. Шүгдэнгийн тухай хамгийн сайн мэдэж байсан хүн бол V Далай Лам. V Далай Ламыг энгийн яриагаар яривал, худал хуурмаг хийгээд уур, шуналын эрхэнд орсон өчүүхэн нэгэн байгаагүй. Билэг чанар төгссөн хувилгаан байсан. Онолын өндөр эрдэмтэй байсан тул гурван язгуурын Ядам Бурхадын нигуурыг үргэлж болгоодог байсан. Түүнчлэн мэргэ төлөг хийгээд зурхайн ухаан зэрэг олон зүйлд мэргэн байсан. Тэр мэт харилцан адилгүй арга ухааны үүднээс ажиглан шинжилж чадагч, гурван язгуурын Ядам Бурхадын эшийг илтэд олсон нэгэн бээр, “Ерөөл буруудсан тангаргийн буг болой.” хэмээснийг би хуурмаггүй зарлиг мөн гэж боддог. Анхандаа би үүнийг мэддэггүй, олж

үзээч үгүй байсан. Тижан Ринбүүчи багш маань ч мөн энэ тухай мэддэггүй байсан. V Далай Ламын энэ зарлиг нууц, далд хадгалагддаг байсан. Тэр үед Дагважанцангийн бүх байр байдлыг сайн мэддэг хүн нь V Далай Лам байсан. Дагважанцан амьдарч байх үедээ V Далай Ламтай дотно харилцдаг хийгээд V Далай Ламаас олон ном сонссон шавь нь байсан гэдэг. Дагважанцангийн зохиол хоёр боть ном байдгийг би уншиж үзсэн: их сайн зохиол байсан. Тэр адилын нэгэн эцэстээ нас барсныхаа дараа ерөөл буруудсан тангаргийн буг болсон гэж тухайн үеийн байдлыг үнэн мөнөөр нь V Далай Лам зарлигласан хэрэг. Тиймээс тайлбар олныг хийх хэрэггүй байх:

*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг, ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товрого болгогтун!* хэмээсэн мэт түүх нь ч мөн энэ адил юм.

Түүхийг нарийн судалж, урьдын олон намтраас хураан түүвэрлэж бичсэн зүйл байгаа. Түүнийг дараа цаг гарвал үзүүлнэ ээ. Та бүхнийг цай зооглож байх хооронд, өчигдрийн гэвшийн ярьсан ярианд эндүүрэл байсныг тодорхой тайлбарлая гэж бодож байснаа ярилаа.

# 2008 оны 1-р сарын 9-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Брайбүн Лосалин дацанд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Одоо та бүхнийг цай зооглож байх энэ хооронд би бас нэг зүйл ярья. Дараа нарийвчилж ярья гэж бодож байсан ч өнөөдөр энд олон өглөгийн эзэн хүрэлцэн ирсэн байгаа бөгөөд тэдний зарим нь өнөө орой болон маргааш буцах гэж байгаа юм байна. Тийм учраас одоо бүх хүн цугласан байгаа дээр нь бага зэрэг тайлбарлаж яривал сайн гэж бодлоо. Хятад, англи хэлээр орчуулаарай. Та нар бүгд Шүгдэнгийн тухай сонссон. Энэ нь хэдэн зууны өмнөөс эхлэн өнөөг хүртэл үргэлжилж буй будлиантай асуудал юм. Өнөө үед энэ асуудлыг хятадын засгийн газар ч сонирхох болсон. Саяхан манай хүмүүс хятадын засгийн газрын төлөөлөгчидтэй зургаа дахь удаагаа уулзалт хийх үеэр намайг буруутгаж байсны нэг зүйл нь үүнтэй холбоотой. Тэд, Далай Лам Шүгдэн шүтэхийг хориглож байгаа нь шашин шүтэх эрхийг үгүй хийж байгаа хэрэг гэж үзсэн. Хэдийгээр хятадын коммунизм шашныг үгүйсгэдэг ч Далай Ламын хийж буй үйлдлүүдээс болж бид нар шашин шүтэх эрхийн тухайд үүрэг хүлээх хэрэгтэй болж байна хэмээн намайг Шүгдэн шүтэхийг хориглосноор шашин шүтэх эрхийг үгүй хийж байна гэж шууд засгийн газрынхаа зүгээс буруутгасан. Хятадын засгийн газар Шүгдэнгийн тухай түүхийг мэдэх нь юу л бол? Энэ асуудлыг хятадын засгийн газар улс төрийн зорилгоор ашиглан намайг буруутгадаг. Намайг буруутгах нь чухал биш. Харин Төвдөд Шүгдэнг шүтэгчдийг тусгайлан дэмжиж, хөрөнгө мөнгөөр туслах болсон бөгөөд хийд орноор явж, “Шүгдэнг шүтэх

хэрэгтэй, шашинд сүжиглэх нь эрх чөлөө юм. Далай Лам шашин шүтэх эрхийг үгүй хийж байна. Та бүхэн Шүгдэн шүтэх хэрэгтэй" хэмээн ухуулга хийж байна. Илүүтэйгээр, хийж буй нэг муйхар зүйл нь, бараг Шүгдэнг шүтэгчдийн явуулгаар ийм зүйл хийж байгаа нь тодорхой: Самялин хийдэд шинээр босгосон Ловон Бадамжунайн лагшин дүрийг нураасан хийгээд өөр энэ адилын олон дүрийг нураасан явдал гарсан. Ловон Бадамжунайн дүрийг их хүчтэй хориглох болсон. Амдо нутгийн олон сүсэгтнүүдийн босгосон Ловон Бадамжунайн нэг том дүр байдгийг хятадын цэргүүд нэг ч хүн оруулахгүйгээр хамгаалалтанд авч байгаад, энэ нь зураг авч, бичлэг хийхээс болгоомжилсон хэрэг байх: дараа нь Ловон Бадамжунайн дүрийг тэсэлж нураасан байдаг. Тиймээс байдал бага зэрэг хүндэрсэн.

Байдал энэ янзаар үргэлжлээд байвал олон бэрх асуудал учрах болно. Саяхан Шүгдэнгийн нийгэмлэгээс Энэтхэгийн засгийн газарт хандан, Шүгдэн шүтэгч нарын шашин шүтэх эрхийг Далай Лам хорьж байна. Тиймээс, бидэнд аюултай байгаа тул Энэтхэгийн засгийн газрын зүгээс биднийг хамгаална уу гэж хүсэлт гаргасан. Энэтхэгийн Гадаад Хэргийн Яам ч тэдний хүсэлтэд хариу өгсөн байгаа. Тиймээс энэ байдал хүнд шатандаа хүрсэн. Өнөөг хүртэл би гэм тусын тухай ярьсан. Өөрийнхөө амссан туршлагаар гэмийг нь үзсэн. Мөн олон дээд төрөлхтөн нарийн зарлигийг баримт болгон, шүтвэл ийм, ийм гэм байна гэж хэлсэн. Ингэх тайлбарлаж хэлэх нь миний үүрэг. Сонсох, сонсохгүй нь харин хувь хүний эрх, өөрсдийн бодож шийдэх хэрэг болохоос биш шүтэж болохгүй гэж хэлдэггүй. Анхнаасаа л би, "Эцгийн гэрээс, зүрхний үгээ хэлсэн. Сонсох, сонсохгүй нь өөрийн чинь хүсэл." гэдэг шиг хэлж байсан. Тиймээс сонсох, сонсохгүйгээ өөрсдөө шийдэх хэрэгтэй. Миний хэлснийг сонсох хэрэгтэй гэж би урьд нь ч хэлж байгаагүй. Одоо ч хэлэхгүй. Гэсэн ч, юу ч болоогүй юм шиг зүгээр суухын арга байхгүй тул одоо асуудлыг тодорхой шийдэх хэрэгтэй байна. Винайн номд, тэмцлийг номын зүгт амирлуулах тухай долоон хэсэг зүйл айлдсан байдаг. Үүнийг нэгэнд, өвс хийгээд ёст модыг тараах хэмээн айлдсанчлан одоо бид ёст модыг тараах цаг ирсэн байна. Өнөө цагийн

ардчиллын ёсоор олон нийт нь үгээ хэлэх цаг ирсэн. Энэ номын айлдварын дараа их хийдүүдийн хуврагууд өөр өөрсдийн хийд орондоо буцна. Тиймээс та бүхэн тус тусынхаа газар очоод, Шүгдэнг шүтэх хүсэлтэй, хүсэлгүй гэдгээ илэрхийлж гарын үсгээ зураарай. Шүтэх хүсэлгүй байгаа бол шүтэхгүй гээд гарын үсгээ зур. Ойлгосон уу? Шүгдэнг шүтэгчидтэй хамт байж, ном хийгээд эд хэрэгслээ хамтдаа хэрэглэхийг хүсэж байвал хүсэж байна гээд, хүсэхгүй бол хүсэхгүй байна гэдгээ илэрхийлж гарын үсгээ зур. Олны саналыг ав. Энд хэний ч дарамт орохгүй. Бий ч та нарыг "шүтэхгүй, хамт байхгүй гэж зур" гэж хүчлэхгүй. Олонхын 60 хувиас дээш нь Шүгдэнг шүтнэ гэж үзвэл тэр өдрөөс хойш би Шүгдэнгийн тухай нэг ч үг дуугарахгүй. Ойлгосон уу? Түүнээс хойш үүний хариуцлагыг та бүхэн өөрсдөө үүрэх болно. 60-70 хувь нь Шүгдэнг шүтэхгүй, Шүгдэнг шүтэгч нартай ном хийгээд эд хэрэгслээ хамт хэрэглэхгүй гэвэл энэ тухай бодож үзэх хэрэгтэй. Үнэндээ Шүгдэнг шүтэгчид Энэтхэгт ирэхийн хэрэг байхгүй. Бидний Энэтхэгт ирсний учир нь хятадын төрийн бодлого буруу байна, болохгүй байна гээд энд ирсэн. Шүгдэнг шүтэгчдийг хятадын засгийн газар онцгойлон тэтгэж, тусалдаг. Хятадын засгийн газраас дэмжсэн тусгай бодлого ч явуулдаг. Тиймээс тусгайлан харж үздэг хүмүүсийнхээ газар уруу явчихвал сайн юм. Энд суугаад байхын хэрэг үгүй. Олонх Шүгдэнг шүтнэ гэж шийдвэл, за гэхээс биш, миний зүгээс өөр хийх зүйл байхгүй. Анхандаа би шүтдэг байсан. Энэ нь эндүүрэл байсан юм. Дээдэс багш нарынхаа өмнө уучлал эрж, эндүүрлээ засан авла орхилыг ёсчлон үйлдсэн. Олонх шүтнэ гэвэл, хүний эрх тул миний зүгээс юу ч хэлэхгүй. Ойлгосон уу? Айж эмээгээд, Далай Ламд бялдуучлах хэрэггүй. Бодит байдлыг бүгдийг нь мэдэн үйлд. Маргааш үдээс хойш өмнө өгүүлж байсан намтруудаас хураангуйлж бичсэн эмхтгэлээ тараана. Тэнд, V Далай Ламын үеэс авахуулаад олон дээд төрөлхтөн нар Шүгдэнгийн тухай юу зарлиглаж байсан, юу гэж үздэг байсан, хэрхэн хориглож байсан тухай өгүүлдэг. Одоогоор цөөн тоогоор хэвлэсэн. Дараа нэмэх зүйл байгаа. Та нар санал хураахаасаа өмнө Шүгдэнг хорьж байсан V Далай Ламын үеэс эхлээд өөр хэн хэн хорьж байсан байна, бүгдийг

нь мэдэх хэрэгтэй. Шүгдэн шүтэгчид ч гэсэн Шүгдэнг шүтэх хэрэгтэйн учир шалтгаан хийгээд шүтвэл ямар тус байгааг үзүүлсэн ном товхимол олныг гаргасан. Эдийн тэнгэр тул Шүгдэнг шүтвэл мөнгө их олно гээд анханд Шүгдэнгийн бумбыг бүтээдэг. Улмаар Шүгдэнд амиа тушаах хийгээд сарын тахил зэргийг үйлддэг. Шүгдэнг шүтвэл баян болох бөгөөд ажил үйлс бүтдэг гэж Тагом Ринбүүчийн гаргасан номд бичсэн байдаг. Тиймэрхүү ном товхимол олон байгаа. Шүгдэнг шүтэгчид, Шүгдэн шүтвэл ийм, ийм ашиг тус байгаа гэж ярьсан бүгдийг нь ч мэдэн үйлд. Мөн Шүгдэнг шүтвэл гэмтэй гэж хорьсон хүмүүс, юу гэж хориглосныг нь ч мэд. Тэгээд хүнд хөнгөнийг нь хэмжиж үзэх хэрэгтэй: шүтвэл тустай гэж айлдсан хүмүүсийг нэг талд тавиад, шүтэж болохгүй гэж хорьсон хүмүүс буюу голлон V Далай Лам, Дэчин Агваанчогдон, Жанжаа Ролбийдорж, Пүржог Агваанжамба, Ёнзон Ишжанцан тэргүүтэнг нөгөө талд нь тавиад сайтар бодож үзэх хэрэгтэй. Өглөгийн эзэд та бүхэн ойлгосон уу? Ямартай ч, ам сахал хоёрыг ялгах хэрэгтэй гэж өмнө нь хэлж байсан. Одоо ялгах цаг нь ирж. Хятадын зүгээс хүчтэй дэмжлэг үзүүлсэн бодлого хэрэгжүүлээд ирэхээр Шүгдэнг шүтэгчид хүн алж, зодож нүдэх, занал хийх зэрэг үйлдлийг хийж байсан. Энэ нь хамаа алга гэж бодсон ч хятадын коммунистуудад толгойгоо тушаасан нь хачирхалтай. Бид нар хятадын төрийн бодлогыг эсэргүүцдэг. Бид салан тусгаарлах гэж байгаа юм биш. Хятадын төрөөс бидэнд жинхэнэ автономит эрх олговол бид БНХАУ-ийн бүрэлдэхүүнд байх болно. Хятадын төр Төвдөд юу дуртайгаа хийж байгааг бид эсэргүүцдэг. Ингэж эсэргүүцэж байх энэ үед хятадын төрийн талд орж байгаа нь харамсмаар. Тэр нь ч, шашин номын нэрээр түрий барьж, шашин шүтэх эрхийг үгүй хийж байна гэдэг. Үнэн хэрэгтээ энэ нь шашин ном шүтэх тухай асуудал огтхон ч биш. Өчигдөр ярьсанчлан хүмүүн бусын буг шүтэж буй хэрэг юм. Ямандагийн уншлага номд, *буг, ролон* гэж гардаг:

*Ялж төгссөн номын Богд Зөөлөн-Эгшигтийн мэлмийн өмнө*
*Шулмыг номхтгож, шашныг сахина хэмээн нигуураараа таалсан*
*Зарлигийг сонсогч буг, ролон зардсын чуулганд* хэмээсэн

байдаг хийгээд үүний хойно, *Гадаад дотоодыг тэтгэх тангарагтны бие дор* хэмээн *тангарагтан* гэж зарлигласнаас биш *тангараг доройтсон* гэж зарлиглаагүй.

Тиймээс тангараг лугаа төгөлдөр тангарагтан л бол буг байсан ч болох, ролон байсан ч болох. Харин буг хирнээ тангараг доройтсон бол сайн биш. Зарим нэг нь ингэж бодож магадгүй: бугд муу зүйл юу байх вэ, Ямандагийн өөрийн үүсгэлийг унших үест,

*Зарлигийг сонсогч буг, ролон зардсын чуулганд*
*Би бээр горилохын сэтгэлээр сөгдөн мөргөе* гэж гардаг.
Тиймээс бугд буруу юм алга гэж бодож магад. Буг л бол буг шүү дээ. Үүний доор *зарлигийг сонсогч тангарагтан* хэмээн өгүүлсэн байдаг. Шүгдэн тангарагтан бус тангараг доройтсон буг юм. Энэ тухай өчигдөр ярьсан.

Дараа энэ тухай нарийвчлан ярьж болно. Өөр айлтгах зүйл алга аа. Эмхтгэл бичгийг удахгүй тараана. Ямартай ч 360 гаруй жилийн будлиан, ойрын 30 жил үргэлжилсэн үймээнийг хятадын коммунист төр онцгойлон сонирхох болсон энэ үед бид ч гэсэн анхаарлаа хандуулж, хэрхэн яаж шийдэх тухай бодох хэрэгтэй. Ам сахал хоёр шиг ялгаж үйлдэх үү, эсвэл холилдон суух уу гэдгээ шийдэх хэрэгтэй. Хоёр талын байр байдлыг мэдэж, шинжилж үзээд олонхоороо санал хураагаад шийд. Хамба, гэсгүй гээд холбогдох хүмүүс ойлгосон уу? Өглөгийн эзэд ойлгов уу? Асуудлыг зүгээр орхих арга алга. Винайн номд, үзэл таарахгүй байдал үүсвэл хуврагуудад ёст мод тараан санал хураан шийдэх тухай номлосон байдаг мэт бид нар ч гэсэн санал хурааж шийдвэл сайн. Барууны лам нар та бүхэн санал хураахад оролцох уу, яах уу? Тус тусынхаа хийдэд очоод энэ асуудлын тухай бүгдийг мэдэж, сайтар бодож үзээд дараа нь санал хураах хэрэгтэй.

# 2008 оны 1-р сарын 14-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Брайбүн Лосалин дацанд Шүгдэнгийн тухай урьдын түүхэн баримт сэлтийн талаар айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Өмнө тараасан Шүгдэнгийн түүхийг тайлбарлаж ярья. Шүгдэн анх V Далай Ламын үед гарсан байдаг. Тэр нь ч:

Эхний хэсэг. V Далай Ламын намтар "Дүгүлийн Гой-сан" буюу "Сахорын банди Агвааанлувсанжамцын энэ насны эндүүрлийн үзэгдэл наадмыг онол өгүүлэхийн ёсоор байгуулсан Дүгүлийн Гой-сан" хэмээхийн II ботийн 173-р хуудасны ар талын 5-р мөрөнд: "*Долын цагаан булгийн Дийлэгчийн* (*Шүгдэнгийн өөр нэр нь Долын Дийлэгч буюу Должал юм. Орч.*) *хорлол ихсэх болсон хийгээд өөр бас догшин чөтгөрийн рид чадал үзэгдсэнд зоригдон дацангийн Очирт Ловон Врагна Цоржийн үйлдсэн* хэмээхийг гүйцэд унших хэрэггүй байх. *Долын цагаан булгийн Дийлэгч* хэмээсний *Дол* нь нутгийн нэр бөгөөд *Долын цагаан булгийн Дийлэгч* гэсэн нь Шүгдэнг хэлж байна. Мөн 257-р хуудасны эхний мөрөнд: *...Долын цагаан булагт ерөөл буруудсан буг хүч чадал машид ихтэй нэгэн бээр шашин амьтан нийт болон зарим нэгэнд хүчир хорлох нь гал тахиа жилээс улам ихсэж эгэл ард аврал айлтгах нь олон гарсан ба надад хорлол ирээгүй гэх нь ховор болоход Долын цагаан булагт шороон тахиа жилийн адагт шинэ байшин барьж, гажа тэргүүтэн үнэртний хаан, тогтоох шүтээн зэргийг өргөж аргадан тахисан ч...* хэмээн анхандаа газар орны эзэн савдаг мэт үзэж тахих байшин барьсан байдаг. *...хорлол нь улам арвижиж, хар шар олонд хижиг өвчин гарч, нэг хоёр лам нас барах зэрэг гай барцад гарснаас үүдэн дацангийн лам нар нэгэн зэрэг*

*хатуу үйл үйлдье...* хэмээн хатуу үйл үйлдсэн тухай зарлигласан байна. Жинсрэг цутгаснаар буюу *...түлэх галын үйлд оруулан үйлдэж тангаргийн буг ад зэтгэр нөхөд сэлтийг шатаахад шинж тэмдэг гайхамшигтай машид олон гарсан бөгөөд хүүр шатсан үнэрийг бүгд мэдэрч сэтгэл итгэмжилсэн ба олон амьтныг айдсаас ангижруулснаар үл барам ад зэтгэр тэдгээрийн муу үйл улам дэлгэрч муу заяаны зовлон барагдашгүй ихийг амсах байснаас гэтэлгэж амгаланд байгуулав...* хэмээсэн мэт, V Далай Ламын намтарт Дагважанцан ерөөл буруудан тангаргийн буг болж төрснийг хатуу үйлд оруулан жинсрэг цутгаж гэтэлгэсэн баримт байдаг.

Мөн V Далай Ламтай харилцан багш шавийн барилдлагатай байсан Дэрдаглингийн Тарнийг Баригч Жүрмэддоржийн зарлигийн үргэлжлэлд (*ам дамжсан ярианд. Орч.*), "Дагважанцан ерөөл буруудан Шүгдэн болж төрсөн тэр одоо байхгүй болчихсон. Одоо Шүгдэн нэртэй хуурамч нэгэн байдаг байх." гэсэн нэг түүхийг сонсож байсан. Цааш *...Энэ үест тэдгээр ад зэтгэр өмөг түшгээсээ хагацсаныг гэрчлэх бичгийг зохиосон бөгөөд...* намтарт тэр үед гэрч бичиг бичсэн гэж зарлигласан нь тэр гэрч бичгийн тухай хэлж байна.

Хоёрдугаар хэсэг. V Далай Ламын зохиолуудын гадаад ботийн "Да"-д, "*Төрвөл үгүй ид хав, хүч чадал төгөлдөр тангарагт номын сахиус далай мэт олны илт онол, тахил өргөл, тааллыг баясгах, наманчлал, магтаалын чуулган тэргүүтэн тийн дөрвөн үйлсийг аяндаа бүтээгч хэмээх*"-ийн 148-р хуудасны урьд талын 6-р мөрөн дэх гэрч бичигт: *Гадхасагийн Ла-Ажалын хичээл зүтгэлээр* хэмээсний *Гадхаса* нь Додлүнгийн Гадхаса хэмээн алдаршсан Дагважанцангийн төрсөн нутаг юм. *Ла-Ажал* нь Дагважанцангийн ээж нь мөн бөгөөд тэрээр их зальжин башир аргатай нэгэн тул IV Ванчин Богд Лувсанчойжижанцанд айлтган, хутган үйлдэх тэргүүтнээр хичээсэнд шүтээд *...Хувилгаан Сономгэлэгбалсангийн...* хэмээсэн нь Брайбүний дээд өргөөнд залардаг байсан Банчин Сономдагвын хоёрдугаар дүр юм. Цааш нь *...хуурамчаар*

*тодорсон...* хэмээн Хувилгаан Сономгэлэгбалсангийн жинхэнэ хойд дүр биш ч Ла-Ажалын хичээл зүтгэлээр хойд дүрд тодорч чадсан учир хуурамчаар тодорсон гэжээ. Эцэстээ *...ерөөл буруудан тангаргийн буг болоод олон амьтанд хорлох нь ихэссэнд Дорж Врагийн Хувилгаан...* хэмээн хатуу үйл үйлдэгчдийн нэрийг бичсэн байдаг. Гэрч бичгийн шүлэгт:

*"...Зургаан Мутарт Гомбо, Чойжоо, Лхам*
*Дөрвөн Нигуурт Гомбо, Жамсран Бэгз тэргүүтэн*
*Тахиж шүтэн бүтээх тангарагт сахиус бүгдэд*
*Тансаг ундаан дээж тахил үүнийг өргөе.*
*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн болон шашинд хорложүйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун..."*

хэмээх тэргүүтэнг зарлигласан бөгөөд *...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан...* хэмээсэн нь өчигдөр ярьсанчлан дээд төрөлхтөн Хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр биш байж хойд дүрд нь хуурамчаар тодорсон түүний нэрийг Дагважанцан гэх бөгөөд тэрээр шалтгаан: буруу ерөөл тавьсны эрхээр, мөн чанар нь: тангаргийн буг болж төрөөд, үйлддэг үйл нь: шашин хийгээд амьтан бүхэнд хорлол үйлддэг болохыг зарлигласан байна.

V Далай Лам гадаад боть дахь зарим зүйлээ хэргийн тухайд зарлигласан байж болох. Түүний зарлигууд дотор жинхэнэ утга нь тийм биш байх гэмээр зүйлүүд байж болох юм. Гэхдээ энд өгүүлж буй зүйлүүд V Далай Ламын зарлиг, зөвхөн төвдөд хэвлэгдсэн нууцын тамгатай хорин таван хэсэг зүйл байдгийн нэг нь юм.

Гуравдугаар хэсэг. "Нууц Тамгат"-ын лянхуагаар билэгдсэн бумбын тамгатын 8-р хуудасны ар талын 2-р мөрөнд: *...Брайбүнгийн ха-гийн сар хаг хогийн...* гэж байгаа нь нууцлан хольж бичсэн үгс бөгөөд хольж бичихэд нэгээр холих, хоёроор холих, гурав, дөрвөөр холих зэрэг олон янз бий. Дээрх дохио үгсийг тайлж уншихад: *Брайбүнгийн дээд өргөө* хэмээн Дагважанцангийн суудаг газрыг хэлсэн байна. *Брайбүнгийн дээд өргөөний туурин дээр жинсрэг цутга.*

*Төвдийг амаржуулахын арганд лусын унааг боо. Лусын шүтээн босго...* гэж Брайбүнгийн дээд өргөөг нураасны туурин дээр жинсрэг үйлд хэмээн эш үзүүлсэн байдаг. Энэ нь нууц тамгатын доторх үг юм.

Дөрөвдүгээр хэсэг. Мөн "Нууц Тамгат"-ын гавал хутган тамгатын 1-р хуудасны 2-р мөрөнд: *...шороон эм тахиа жилийн шинийн нэгний өдөр Брайбүнд уулын чинээ том, хар өнгөтэй эмэгтэй нэгэн бээр баруун өлмийгөө дээд өргөөний дээр тавиад...* тэр үест Брайбүнд долоон дацан байсны дотор Чойнхорлин гэж байсан. *...зүүн өлмийгөөрөө Чойнхорлингийн дээр гишгэж даран үйлдсэнээр шороо тоос манаран босох нэг гарсан...* хэмээсэн үгээр, дээд өргөөг Балдан Лхам бээр сүрээр даран зохиосныг өгүүлсэн байна. Эдгээрийг V Далай Ламын нийтэд алдаршсан гадаад, дотоод, нууцын зарлиг бүгдэд нэгэн ижлээр өгүүлсэн байдаг бөгөөд хувилгаан Дагважанцан гэгч нь ёс бусын буг болсон хийгээд Балдан Лхам бээр хилэгнэж байсан зэргийг энд тодорхой өгүүлсэн байдаг.

Тавдугаар хэсэг. Пүржог Агваанжамбын зохиосон *"Дөрвөн их хийд хийгээд Тарнийн дээд, доод дацан байгуулагдсан ёс – Цагаан лянхуан эрхэс"* хэмээхийн 13-р хуудасны ар талын эхний мөрөнд: *Тэр адил болбоос Богд* (*Богд Зонхов. Орч*) *өөрөө бодитой оршиж байх үед тантраас номлосон тангарагтан сахиус нугуудаас өөр ертөнцийн хорт чөтгөр, хилэнтэн алин унтууцан үйлдэхнээ ч шүтээн хийд орон үүнд оруулсан нь огтхон ч үгүй бөгөөд түүний хүчээр багш шавь бүгдийн таалал зохилдож номлол бүтээл нь арвидаж байсан. Төрсөн нутгийнхаа тэнгэр Мачэнг хүртэл хийдийнхээ гадна байлгадаг байсан. Гэтэл өнөө үед номын гурван хувцсыг өмсөн, өөрсдийгөө Богд Ламын* (*Богд Зонхов. Орч*) *шавь хэмээн хөөрөмшигч, авралын орныг чөтгөрөөс эрэгч нугуудад хүсээгүй зүйлүүд дээрээс нь буух болж байна. Тиймээс хувраг бид нар сахил санваараа ариунаар сахиваас урьд Бурханыг үзсэн тангарагтан сахиус нугууд бээр үйлс бүтээх нь эргэлзээгүй болой...* хэмээн Гандан хийдэд өмнө нь ертөнцийн эгэл хилэнтэнг шүтэгч

огтхон ч байдаггүй байсан бөгөөд өнөө үед биедээ номын гурван хувцсыг өмсөөд авралын орныг чөтгөрөөс эрэгч нар байгаа тул үүнээс болж хүсээгүй элдэв зүйл тохиолдож байна хэмээн зарлигласан байдаг. Дээрх хэсэгт *авралын орныг чөтгөрөөс эрэгч* хэмээсний чөтгөр нь юу болох тухай тодорхой гардаггүй.

Зургадугаар хэсэг. VII Далай Лам Галсанжамцын ёнзон багш амдо Дэчин Агваанчогдон нь Радэн Ринбүүчийн анхдугаар дүр юм. Пүржог Агваанжамба Сэра-Жэ дацанд ном үзэж дүүргээд гэвшийн дамжаа барьж байх үед Дэчин Агваанчогдон амдогаас Сэра хийдэд шавилахаар ирсэн бөгөөд Сэра Тэгчэнлинд шавилж, номын хүрээнд оршсон нь энэ юм. Эхлээд Пүржог Агваанжамба, дараа нь Дэчин Агваанчогдан ирсэн байдаг. Дэчин Агваанчогдонгийн намтар *"Төгс буянтын ширээт их эрдэнэ ачит номын хааны намтар Хажидыг бүтээхийн яруу үг – Тэнгэрийн их хэнгэрэг"* хэмээхийн 66-р хуудасны ар талын 5-р мөрөнд: *Урьд хаан чөтгөр хортон нэгэн Враг-Сов хүрээний нэгэн хүнд эрэмшин буусанд түүнийг хийх юм нь ихэдсэн хуучин ширээт лам болон зарим аймгаас соёрхол, тахилыг үйлдэн шүтсэн хийгээд Жанзэйн уулын оройд сүм нэгийг ч босгосон байсан нугуудыг машид зохисгүйд болгоогоод Богд Зонхов эцэг хөвгүүдийн үеэс авахуулаад хийд орон энд ертөнцийн эгэл тэнгэр сахиус элдвийг шүтэх ёс байгаагүй тул хойшид ч тэр мэтийг огтхон ч үйлдэж болохгүй хэмээн хурлын дунд айлдсан бөлгөө. Сүм тэрийг ч нураалган чулууг чулууных нь газар, шороог шорооных нь газар хүргүүлж, дүр шүтээн тэрийг ч хөндийд оршуулж, буух үед нь хойшид буух газар үгүй хэмээн зарлигласанд, Ширээт Их Эрдэнэ бээр тэр адил зарлигласнаас хойш одоо явахаас өөр аргагүй хэмээгээд буухаа өргөсөн бөгөөд хаан чөтгөр тэр хусны үзүүрийн бэл уруу зугтав...* хэмээсэн энэ нь Пүржог Агваанжамбын зарлигласантай яг таардаг. Гандан хийдийн хийх юмаа олж ядсан хуучин ширээт лам хийгээд зарим аймагт шүтэн сүм хүртэл барьсан байсанд Дэчин Агваанчогдон хойшид шүтэж болохгүй болгосон тухай өгүүлсэн байна.

Долдугаар хэсэг. Туган Чойжинямын зохиосон Жанжаа Ролбийдорж буюу Жанжаа Ишдамбийдонмэйн намтарт ч энэ адил зарлигласан байдаг. Жанжаа Ролбийдорж нь Дэчин Агваанчогдонгийн шавь хийгээд мөн VII Далай Лам Галсанжамцын нийт бусын шавь (*онцгой шавь. Орч.*), санаанд багташгүй эрдэмтэй нэгэн байсан. Түүний намтар *"Түгээмлийн эзэн Базарсадын мөн чанарт цог төгөлдөр дээд багш Ишдамбийдонмэбалсанбуун намтрыг товч төдий өгүүлсэн төгс буянтын үзэсгэлэнт чимэг"* хэмээхийн 221-р хуудасны ар талын 3-р мөрөнд: *Мачэнгийн сүмийн дэргэд морилоод, Богд Лам эцэг хөвгүүд бээр ертөнцийн тэнгэр сахиусыг шүтэн зохиогоогүй тул нутгийн тэнгэр Мачэнгийн сүмийг ч хийдийнхээ дотор багтаагаагүй бөгөөд урьд Гандан ширээт зарим лам нар Шүгдэнг шүтсэнээр өлзий бусын олон ёр гарсныг Дэчин Очирдарь (Агваанчогдан. Орч) бээр түүний сүм тэргүүтэнг нураалгаад хийдээсээ хөөсөн түүх тэргүүтэнг тодорхой зарлигласан...*хэмээсэн нь Пүржог Агваанжамбын, *биедээ номын гурван хувцсыг өмсөөд авралын орныг чөтгөрөөс эрэгч* хэмээсний чөтгөр тэр нь Шүгдэн байсан нь эндээс тодорхой мэдэгддэг.

Зарим нэгэн V Далай Лам хийгээд Шүгдэн хоёр хоорондоо таардаггүй байсан. Учир нь V Далай Лам нинмавын номыг анхааран авдаг байснаас болсон хэрэг хэмээн гэмийг цайруулах мэтээр ярьдаг. Пүржог Агваанжамба зөвхөн гэлүгбын ёсыг л анхааран авдаг байсан. Дэчин Агваанчогдан, Жанжаа Ролбийдорж нар ч ялгаагүй зөвхөн гэлүгбын ёсыг дагадаг байсан. Жанжаа Ролбийдоржийн намтрын 221-р хуудасны 5-р мөрөнд: *...тэндээс үргэлжлэн цааш морилоход мөргөлийн замын дээд доод бүхэнд өөрөө гарсан Бурханы дүр, номын үсэг элдэв хийгээд чулуун дээр мутар болон өлмийн мөр гарсан олон байсан нугуудын түүхийг нууц тарнийг бясалгагч нэгэн гэвш бээр нарийн айлтгаж байв. Ялгуусан Галсанжамц (VII Далай Лам. Орч) морилох үед шинээр гарсан гэгдэх чулуун дээр тодорч гарсан Богд Зонховын лагшин дүр ихэд тод нэгийг ч үзүүлэв. Хэнийх нь үл мэдэгдэх нэгэн өлмийн мөр таарах үед Богд Багш (Жанжаа Ролбийдорж. Орч.) бээр тоглоом наадмын ёсоор өлмийн мөр энэ нь нэгэн нинмава хүнийх тул*

*Пүржог Агваанжамбын шавь нар цээрлэвэл зохистой хэмээн зарлиглаад Зонхов Богдын их хийдэд нинмава хүн өлмийн мөрөө үлдээж чадсан юм чинь Диваажингийн эрдэнийн хөрсөн дээр бид нар ч гэсэн хөлийнхөө мөрийг гаргах байх хэмээсэнд бүгд инээлдэх болсон...* гэж нинмаваag егөөдөн ярилцсан байдаг. Тиймээс Пүржог Агваанжамба хийгээд Дэчин Агваанчогдан, Жанжаа Ролбийдорж нар зөвхөн гэлүгбын ёсыг дагадаг байснаас биш нинмавын ёсыг анхааран авдаггүй байв. V Далай Лам нинмавын ёсыг анхааран авдаг байсан тул нинмаваag егөөдөж ярихгүй байх байсан болов уу. Тэд зөвхөн гэлүгбын ёсыг л дагадаг байсан юм.

Наймдугаар хэсэг. VIII Далай Лам Жамбалжамцын зохиосон Ёнзон Ишжанцангийн намтар *"Богд тойн, дээд багш түгээмлийн эзэн Базарсадын мөн чанарт ёнзон номын хаан их бандида Ишжанцанбалсанбуу дор намтрын үүднээс соёрхол талбисан Чадагчийн шашны үзэсгэлэнт лянхуа"* хэмээхийн 187-р хуудасны 2-р мөрөнд: тэр үед VI Ванчин Богд Балдан-Иш таалал төгссөний хойд дүр VII Ванчин Богд Данбийнямын лагшин балчир үедээ Зан нутгаас Үйгийн зүг морилон VIII Далай Лам Жамбалжамц хийгээд Ёнзон Ишжанцан лугаа дээд ордны Диваажин өргөөнд золгох үед Ёнзон Ишжанцан, *...Өөр бас Ванчин Их Эрдэнийг дагалдагч, бараа болооч нугуудад гэгээнтний сонсох, суралцах үйл хэрэгт бүгдээрээ нэгэн үзүүрт сэтгэлийн үүднээс чармайн үйлдэх хэрэгтэй. Түүнээс бус тэр Бурхан мөн тул эгэл хүний адил бэрхшээлийг зохиохын хэрэг үгүй гээд тааваар нь орхиж болохгүй. Бурхан мөн ч гэсэн эглийн дүр ёсыг барьснаас хойш эрдэм бүгдэд ч эгэл хүн адил суралцах хэрэгтэй. Эс суралцсан мэргэн хийгээд эс бясалгасан бүтээлийг олсон хүн шашин амьтны тусыг хуурамч төдий хийхээс цаашгүй тул гэгээнтний сонсох суралцах үйл хэрэгт бүгдээрээ анхаарах хэрэгтэй...* хэмээн сургаал хайрласан байдаг. Түүний дараа Шүгдэнгийн тухайд, *...түүний дотроос Дашлхүмбэд шинэ сахиус гэгдээд байгаа энэ нь гутааж байгаа тул Ванчин Лувсанчойжижанцан (IV Ванчин Богд. Орч.) бээр алинг сахиусанд шүтэж байсан түүгээр болохоос*

*бус муу чөтгөрийг шинээр шүтвэл сайн бусын их суурийг үйлдэх тул та бүгд бээр анхаарах хэрэгтэй хэмээн дотно сэтгэлийн зарлигаа ч олонтой хайрласан...* хэмээсний шинэ сахиус гэж хэнийг хэлсэн юм бол? Дашлхүмбэд Жалбуу Нисэрра хэмээх нэгэн байдаг бөгөөд тэр нь бүхнийг болгоогч Гэндүндүв *(Анхдугаар дүрийн Далай Лам. Орч)* өөрөө зарлиг буулган сахиусанд тушаасан нэгэн бөгөөд Дашлхүмбийн зарим лам нар магтаж Нисэрра сахиус Богд Гэндүндүвтэй таалал үндэс нэг гэцгээдэг. Ямартай ч Богд Гэндүндүв бээр зарлиг буулган, сахиусанд тушаасан нэгэн юм. Дашлхүмбийн ертөнцөөс гэтэлсэн сахиуснууд нь голлон Балдан Лхам хийгээд Хилэнт Жамсран нар юм. Тиймээс *шинэ сахиус* гэсэн нь Шүгдэнгээс өөр нэгнийг хэлээгүй. Үүнийг нарийвчлан судлах хэрэгтэй.

Есдүгээр хэсэг. Үлчү эцэг хөвгүүн (*Багш шавь. Орч.*) хоёр бол Богд Зонховын чихнээс чихэнд дамждаг увдис дамжлагын эзэн, санаанд багташгүй мэргэд байсан. Багш шавь хоёр Хажидын номын анхааран авлагыг голлон үйлддэг байсан бөгөөд тэр нь сажагаас нааш дэлгэрсэн дамжлага юм. Тиймээс би, багш шавь хоёр Шүгдэнтэй барилдлагатай байсан болов уу гэж боддог байв. Хажидын дамжлагын лам нарын нэг Цогт Сажавын Морчэн нь санаанд багташгүй эрдэмтэй нэгэн байсан. Тэрээр мөн Жэдорын (*Нууц тарнийн Жэдор Бурханы номын аймаг. Орч.*) дамжлагын лам нарын нэг юм. Морчэн нь сажава бөгөөд Шүгдэнг хүчтэй шүтдэг байсан мэт байдаг. Тэр нь ч, тухай үеийн түүхийг өгүүлсэн нэг номд, Шүгдэн шүтэж байгаа чинь сайн биш хэмээн Морчэнд сануулж байсан нэгэн хүний тухай өгүүлсэн байдаг. Тиймээс Морчэнгоос дамжсан Хажидын номын дамжлагыг баригч Үлчү эцэг хөвгүүд Шүгдэнг шүтдэг байсан байж болох юм гэсэн эргэлзээ үүссэн тул Үлчү Дармабадраагийн намтрыг үзсэн. "*Гурван цагийн Бурхан бүгдийн ерөнхий дүрс, зарлигийн гурван ач төгөлдөр Богд тойн багш, Бүхнийг болгоогч Дармабадраабалсанбуун намтар Шарын шашны үзэсгэлэнт чимэг*" хэмээхийн 34-р хуудасны 4-р мөрөнд: *...Тэр үед хүрээ хийдийн эхэнд дүрс үгүй чулуу шидэгч өдөр шөнө ээлжлэн гарсанд хийдээс Лочэн Ринбүүчийд шинжиж*

*өгөхийг айлтгасанд, Шүгдэнгийн хорлол мөн тул хурлын уншлагад Ганданлхавжаамааг уншуулваас сайн гэж буусанд шүтээд унзад Шарав гуайгаас Мэргэн бүтээлч Агваандоржийн мутраараа бичсэн Гандалхавжаамын нэг хуудсыг хайрлаад, чи бээр бичиг мэдэх тул хуулан бич хэмээн зарлигласанчлан тэр даруй мутраараа бичин гүйцээх лугаа хамт цээжилж чадсан...* хэмээсэн мэт ямартай ч, Шүгдэнгийн хорлол гарсныг хорихын тулд мигзэм тоол гэж зарлиглаж байснаас биш Шүгдэнг их чухал мэтээр үзэж, үйлс даатгалыг нь унш гэж зарлиглаагүй байна.

Аравдугаар хэсэг. VII Ванчин Богд Данбийнямын хойд дүр VIII Ванчин Богд Данбийванчүгийн намтар "*Богд тойн Лувсанбалданчойжидагва Дамбийванчүгбалсанбуугийн намтар сүжиг төгөлдөр лянхуан цэцэрлэгийг мишээлгэгч нарны гэрэл*" хэмээхийн 223-р хуудасны ар талын эхний мөрөнд: *...Зургааны өдөр Симчүний сахиусны өрөөнд дүү лам болон бараа болооч сэлтэд зарлиг буулган, Их амгалант ордны дээд давхрын өргөөнд өдгөө Шүгдэн бээр элдэв ёр үзүүлж байгаа тул есний өдөр өргөө тэрийг эвдэн нурааж, хураах хэрэгтэй...* хэмээсэн мэт, VII Ванчин Богд Данбийнямын лагшин балчир байх үед Ёнзон Ишжанцан бээр, *шинэ сахиус гэж шүтсэн догшин чөтгөр тэр нь Дашлхүмбийг гутамшигт хутгахаар байна* хэмээн зарлигласан *шинэ сахиус* буюу догшин чөтгөр тэрийг Дашлхүмбийнхэн шүтсээр байсан бөгөөд VIII Ванчин Богдын үед Шүгдэн Их амгалант ордонд элдэв ёр олныг үзүүлж бэрхшээл үүсгэж байсан нь эндээс тодорхой харагдаж байна.

Арван нэгдүгээр хэсэг. Үндэсний хэвлэлийн хорооноос хэвлэсэн VIII Ванчин Богд Данбийванчүгийн өөрийн зохиосон Дашлхүмбийн хуврагуудын авла, орхилыг үзүүлэн сургасан жаяг бичиг "*Цогт их амгалант Дашлхүмбэ, зүг бүхнээс тийн ялсан тивийн олон хуврaг хийгээд дотоод лавран тэргүүтэн лугаа сэлт бүх нийтээр магадлах хэрэгтэй бичиг - Хоёр журмын амийг нийлүүлэгч машид жавхлант алтан очрын буулга*" хэмээхийн 121-р хуудасны сүүлийн

мөрөнд: *...Завсар үест хийдийн шавь нарын дундаас хорт чөтгөрийг судлынхаа хөндийд буулгагч зарим нэгэн гарсаар байна...* гэсэн нь хийдийн дотор хорт чөтгөрийг өөр дээрээ буулгагч гарсан болохыг хэлж байна. Цааш нь *...Хойшид Ламу сахиус тэргүүтэн тусгай сахиуснаас өөр хаа хамаагүйг буулгаж болохгүй. Сахиус нь ч билэг билгүүний мэлмий лугаа төгөлдөр очирт сахиус байхаас биш Шүгдэн тэргүүтэн огторгуйгаар гүйгч бирд, муу чөтгөрийн язгуурт соёрхол тавин үйлдэж, аврал одуулваас Бурханы шашинд орохын үүд аврал одуулахуйн суртгаалтай харшлах тул бүү үйлд! ...* гэх мэтээр тодорхой зарлигласан байна. Ламу сахиус гэдэг нь ертөнцийн хилэнтэн юм. *Ламу сахиус тэргүүтэн* гэсний *тэргүүтэн* гэдэг үгээр юуг хураасан юм бол? Ламу сахиус бууж болох хэмээсэн хийгээд бараг Жалбуу Гүн-Аа, Найчүн, Гаадон зэргийг *тэргүүтэн* гэдгээр хурааж хэлсэн байх. Яг Дашлхүмбийнхэн юу гэж үздэгийг би мэдэхгүй. *Ламу сахиус тэргүүтэн тусгай сахиуснаас өөр...* хэмээн Шүгдэнгийн нэрийн шууд өгүүлж *...Шүгдэн тэргүүтэн огторгуйгаар гүйгч бирд, муу чөтгөр...* хэмээн зарлигласан байдаг.

Арван хоёрдугаар хэсэг. Энэ нь хожим Төвдөд, хөх нуурын үндэсний хэвлэх хорооноос хэвлэсэн Ала Цэдангийн бичсэн Ала Жигмэддамчойн намтар юм. Ала Жигмэддамчой нь *"Сайн Номлолын Зүрхэн"*-д (*Богд Зонховын зохиол бүтээлүүдийн дээд Лэгшад Нянбуу. Орч.*) хоёр боть тайлбар бичсэн хүн. Түүний шавь Ала Цэдан буюу Жигмэдлодой бээр багшийнхаа намтрыг эмхтгэсэн байдаг. *"Мэргэний эрхт Жигмэдригбийлодойн бүтээлүүдийн нэгдүгээр боть",* 395-р хуудасны дээрээсээ хоёр дахь мөрөнд: *...Энэ үед буяны аймгийг боловсруулах Шо-Зонсар хийдээс нинмавын шашныг гийгүүлэн зохиогч ханьцашгүй Жамьян Чэнзийн хувилгаан мэргэний эрх баялагт Чойжилодой бээр урьд танихгүй болович бэлэг сэлттэй хамт захиа илгээсний дотор...* хэмээн энд хүндэтгэлийн үгээр бичсэн байна. Жамьян Чэнзэванбуу нь сажавын лам юм. Гэсэн ч урсгал, дамжлага бүгдийг алагчлалгүй анхааран авдаг нэгэн байсан юм. Түүний хойд дүр Чэнзэ Чойжилодой ч гэсэн өөрөө сажава болович нинмавын зогчэнг голлон үйлдэж, гаржүдба болон гэлүгба

тэргүүтний номыг ч алагчлалгүй анхааран авдаг байв. Чэнзэ Чойжилодойн чанзав Энэтхэгт цагаачилж ирсэн бөгөөд Энэтхэгт удаан амьдарч байгаад саяхан таалал барсан. Чанзав лам бээр, Чэнзэ Чойжилодойн хийдэд очиход гэлүгбын шар малгай, сажавын улаан малгай, нинмавын малгай, гаржүдбын малгай зэрэг адилгүй олон малгайгаар дүүрэн хайрцаг байдаг байсан. Гэлүгбын шашинтан хүнд төгс буянтын гол номлолын хөтөлбөр хайрлахдаа шар малгай таалдаг, сажавынханд сажа ёсны зарлиг ном хайрлахдаа саж малгай, гаржүдба нарт зарлиг уламжлалын ном айлдахдаа гаржүд малгай таалдаг байсан тул би хайрцаг дүүрэн малгай авч явдаг байв гэж тэрээр надад ярьж байсан. Ямартай ч тэрээр урсгал дамжлага бүгдийг алагчлалгүй анхааран авдаг их эрдэмтэй нэгэн байсан юм. Түүнтэй би Лхас эзлэгдэхээс өмнө 1957 онд нэг удаа уулзаж Ганданлхавжаамын эш хөтөлбөрийг өргөж байсан.

Тэрээр захиандаа: *...Бодитой уулзах хүсэл байвч үйлийн эрхээр бие чилээрхэх нь их, газар хол тул дэмий л мөрөөдөх бөгөөд соёрхол, ерөөл, өлмий бататгахын барилдлагыг сэтгэлдээ үргэлжид үйлдсээр сууна...* захиа бичсэн хэрэг нь: *...Павонка Ринбүүчийн зарим нэгэн шавь нар шинэ хийгээд хуучин тогтсон тааллыг тэмцэлдүүлж, Бадамжунайн лагшин дүр хийгээд амарлингуй, догшин Бурхадын дүрийг эвдэх, Базар гүрү (Ловон Бадамжунайн зүрхэн тарни. Орч.) уншихад тус эрдэм байхгүйн ёс, Бадмагатан тэргүүтэн номыг гал усанд үйх тэргүүтэн буруу номын явдал олныг гаргаж, мөн бас маанийн хүрд эргүүлэх, өөд болоочид долоон тасалбарыг барих тэргүүтэн хэрэггүйн ёс олныг номлож төрөлхтөн нугуудыг буруу үзлийн оронд байгуулсан хийгээд чухаг дээд гурав бүхний хураангуй хаан Шүгдэнг авралын дээдэд барь хэмээн ухуулах хийгээд өмнийн дамжлагат зарим нэг жижиг хийдийн олон лам нарт Шүгдэн бууж байна хэмээн зүг бүхэнд галзууран гүйж, шүтээний гурван орныг эвдэж нураах тэргүүтэн гэм олныг үйлдэж байгаа бөгөөд хоёрдугаар Ялгуусан Богд Зонховын шашинд том шарх гаргаж буй учир нийтэд туслах захиа бичиг нэгийг зохион хэвлээд Үй, Зан, Хам гуравт түгээвэл шашны хямралыг арилгах дор ач ихтэй болохыг айлтгая.*

*Мөн бидэнд өөрийн зохиосон "Догдүн Жүдийн тайлбар"-ийг таалан хайрлахыг болгоохтун...* хэмээн бичсэн байдаг. Хам нутагт Павонка Ринбүүчийн шавь нарын дотроос бусдыг үгүйсгэж, зөвхөн гэлүгба гэсэн ялгаварлах үзэл гаргаж элдэв зохисгүй үйл үйлдсэн хийгээд илүүтэйгээр Шүгдэн бууж, Шүгдэн би бээр нөхөд сэлтийн хамтаар ирлээ хэмээн Ловон Бадамжунайн лагшин дүрийг усанд хаях тэргүүтэн элдвийг үйлдсэн байдаг.

Урьд Чавдо нутгийн хувилгаан Пагвалхагийн аав нь Энэтхэгт гарч чадалгүй үлдэж, ээж нь цагаачилж ирсэн байдаг. Түүний ээж нь, Чавдо хийдээс холгүй нэг хийдэд Шүгдэн нөхөд сэлттэйгээ буудаг хэмээх нэгэн хүн ирсэн. Шүгдэн түүнд буугаад хийдийн дотор орж, Ловон Бадамжунайн дүрийг усанд хаях зэргийг үйлдэж байсан гэж ярьсан юм.

Арван гуравдугаар хэсэг. Павонка Ринбүүчийн намтар *"Язгуур хийгээд далай мэт хот мандлын түгээмлийн эзэн Цогт Хэрүга Бурхан эл шараар бүжссэн цэнгэл, гагц аврал Павонка Дэчиннямбуубалсанбуун намтар – Утга төгөлдөр Эсрэнгийн яруу эгшиг"* хэмээхийн 466-р хуудасны 2-р мөрөнд багшийг тахихуйн чуулганы орныг зурах байдлыг зарлигласан нь: *...Эхний айлдвартаа дамжлагын багш тэргүүтнийг өчүүхэн хураасан бөгөөд Ядам Бурхадын дунд Дамдин-Янсан байхгүй бөгөөд Дамдин-Янсанг багшийг тахихуйн чуулганы оронд байгуулах нь Богд Лам Очирдарь (Павонка Ринбүүчи. Орч) ямагтын жинхэнэ таалал огтхон ч биш юм. Учир нь анхны чуулганы орныг зурахад Ядам Бурхадын дунд оруулаагүй хийгээд Дамдин-Янсан Бурхан нь нинмавын ядам, бүтээхгүй бэрх наймын нэг Бадам зарлигийн Бурхадын гол нь мөн хийгээд Ядам Янсангийн хувилгаан ч мөн хэмээдэг. Ямартай ч Сэра-Жэ дацангийн харьяат гэлүгбын хувилгаан, хувраг хийгээд хийдүүдийн үзэл нь тийм ч цэвэр бус гэж зарлигласан адил нийтэд алдаршсан хийгээд хожим Богд Зонхов жаран дөрвөн сүүдэр зооглох үед Дагбу Шаддүвлинд зарлиг, зохиолын үүдийг ямар адил хайрласан тэргүүтнээс ч магад баттайгаар мэдэж чадах юм. Гэсэн ч сүүлийн хоёр зурагт Дамдин-Янсанг оруулан зурсан нь ямар*

*учиртай юм бэ гэвэл, Сэра-Жэ дацангийн хувилгаад болон маш олноор хурсан хуврагийн чуулга нугуудын ихэнх нь Богд Зонховын зарлигаас төрсөн шавь нар мөн бөгөөд тэд нар ч бүгдээрээ Ядам Янсанд таалын шунал ихтэй хийгээд тэр үед бичээч, туслах нь байсан Сэра-Жэ Лхова аймгийн Чамдо бичээч болон Түвдэнсүнрав тэргүүтэн бээрч, нийтэд тэгш хандан тэр адил зурвал сайн болох ёсыг айлтган сануулснаар буюу шавийн хүсэл санаанд тааруулан сүүлийн хоёр зургийн эхнийхэд нь Дамдин-Янсанг оруулан зурсан нь тэр юм. Хоёр дахь зургийг зуруулахын тухайд аман зөвлөгөө хайрлах тэр үед Дээрхийн Гэгээнтнээс... хэмээсэн нь XIII Далай Ламыг хэлж байна. ...зарлиг зэмлэл элдэв олон буусан үе мөн тул чуулганы оронд Дамдин-Янсанг хэвээр нь үлдээн урьдын зураг адил зуруулсан болохыг Чамдо бичээч бээр өөрөө бидэнд урьд хойно олон удаа айлдаж байсан болой...* хэмээсэн үүнд бодож үзэх зүйлүүд гарч байна. Павонка Ринбүүчи лагшин залуу үедээ нинмавын "Санва Жажин" номыг үзэж байсан бөгөөд бараг урсгал дамжлага бүгдийг алагчлалгүй анхааран авах таалалтай байсан. Чүсан ууланд Дамдин-Янсангийн бясалгалд сууж гүйцээд жинсрэг өргөх үедээ улаан үрэл олныг хийн хатааж байх тэр үед Тижан Ринбүүчи ч мөн Чүсан ууланд хамт байсан бөгөөд нас сүүдэр бага байсан тул тоглож наадан, нааш цааш гүйх үед Павонка Ринбүүчи улаан үрэл олныг хийчихсэн, энэ нь Дамдин Янсангийн жинсрэгний ялгамжаатай зай юм хэмээж байсныг Тижан Ринбүүчи надад айлдаж байсан. Павонка Ринбүүчи лагшин залуу үедээ Дамдин Янсангийн нямба үйлдэж, "Санва Жажин"-г ч үздэг байв. Тийм хүн хожим багшийг тахихуйн чуулганы орны дунд Дамдин-Янсанг зурж болохгүй, Дамдин-Янсан нь нинмавын Бурхан хэмээн зарлиглаж алагчлах үзэлтэн болсон байдаг. Яагаад тэгэх болсон бэ гэвэл, тэр нь бараг Ринбүүчийн өөрийнх нь таалал байгаагүй юм. Шүгдэнг шүтсэний шалтгаанаар буюу түүний эрхээр тийм байдалд хүрсэн нь бараг тодорхой байдаг. Намтарт нь Шүгдэнгийн ёр гарах үед Ринбүүчи нинмавын "Ринчэн Дэрзод" номын уг язгуур болох "Доджой Бумсан"-г үзэхээр зэхэж байх үед Шүгдэнгийн ёр: улаан гар гарч ирээд суудлыг нь эргүүлэх тэргүүтэн гарсан тухай намтарт нь өгүүлдэг. Эндээс үзэхэд

Шүгдэнгийн ёр гарсны шалтгаанаар буюу тэр үеэс эхлэн нинмавын номыг таалахаа бараг больсон байдаг.

Ринбүүчи сургаал зөвлөгөө айлдах хийгээд ном номлох үедээ нэг хуруу төдий хэмжээнд зарлигласныг шавь нар нь төө урт болгон буруу ойлгоцгоосон байдаг. Энэ нь Жигмэддамчойгийн намтарт гарсантай яг таардаг.

Тиймээс миний зүгээс, Шүгдэнг шүтэх нь Бурханы шашны урсгал дамжлагуудыг алагчлалгүй үзэж, дэлгэрүүлэхэд саад болдог гэж үргэлж хэлдгийн минь учир энэ юм.

Мөн намтрын 467-р хуудасны эхний мөрөнд: *...Урьд жил Дээрхийн Гэгээнтнээс (XIII Далай Лам. Орч.) зарлиг зэмлэл буусанд шүтээд номын хүрдийг эргүүлэх хийгээд гэлэн, гэцүлийн санваар тэргүүтнийг хайрлахад амар биш байсан. Хол ойрын сүсэгтнүүд, бараалхахаар ирсэн олонд хүссэн бага сага номыг нь номлох хийгээд гэргийтний санваар тэргүүтэнг олонтой хайрлаж байсан үе...*Өчигдөр ярьсанчлан XIII Далай Ламд бараалхах үедээ, мөрийн зэргийг номлож өгөөч гэж хүссэн хүн олон байгаа тул мөрийн зэргийг номлох бодолтой байгаагаа айлтгахад нь, хэсэг хугацаанд заахгүй байвал сайн гэж XIII Далай Лам зарлиглаж байсан тухай энд гарч байна.

Тэр ч, XIII Далай Лам Павонка Ринбүүчийг лагшин залуу үед ихэд онцгойлон үзэж, өчигдөр ярьж байсанчлан Гандан Ширээт лам айлддаг байсан номыг Павонка Ринбүүчигээр айлдуулж, таалал дотно байсан ламыгаа хожим зэмлэж, ном бүү номло гэж зарлигласан нь Шүгдэнгээс болсон хэрэг. *...нэг өдөр дахин Норвулингагаас зарлага ирж, Ламтан та маргааш нар уулын үзүүрт тусахаас хэтрэлгүй Норвулингагын үүдэнд морилон ирэх ёс тэргүүтнийг урьд мэт айлтгасанд Богд багш бээр маргааш өдөр нь Норвулингад морилох үед өргөөний үүдэнд Донэр Чэнмо бээр Дээрхийн Гэгээнтний (XIII Далай Лам. Орч.) зарлиг зэмлэл хүнд хатууг дамжуулан сонордуулсан бөгөөд...* Донэр Чэнмо Дамбадаржаа гэдэг хүн байсан. Зургийг нь би харж байсан. Цагаан сахалтай өвгөн байсан тул Их цагаан сахалт хэмээн дууддаг байсан гэдэг. Түүнд өмнөх дүрийн Далай Лам их дотно ханддаг байсан. Түүнийг таалал барахын өмнө хэвтэрт

байхад нь XIII Далай Ламд бараалхуулж байсан бөгөөд тусгайлан асарч тэтгэдэг байж. Мөн түүнийг XIII Далай Лам дэмждэг учир тэрээр их эрх мэдэлтэй нэгэн байсан гэдэг. Тэр үед Лхасад жоохон хүүхдүүд уйлж эцэг эхийнхээ үгийг сонсохгүй байвал Донэр Чэнмо ирж байна гэж хэлэхээр уйлахаа больдог байсан гэлцдэг. Цааш нь: *...Тэнд хэрхэн загнуулсан бүгдийг айлтгалын бичигт бүгдийг нь бичсэн байгаа тул энд давталгүй орхиё. Зарлиг зэмлэлийг сонордож гүйцээд Дашчойлинд буцан залраад урт биш хариу бичин Норвулингад морилж өргөн зохиосон бичигт нь, Бишрэнгүй албат Павонка нэрт бээр айлтгах нь: нигүүлсэнгүй Донэр Чэнмогийн дамжуулан хайрласан зарлиг, тааллын утгыг...*хэмээснийг гүйцээн унших хэрэггүй байх.

Мөн намтрын 469-р хуудасны хоёрдугаар мөрөнд: *...Дашчойлинд зарлага дахин тухайлан ирж, Богд тэр Норвулингаад зарлиг хүлээх лугаа барилдуулан Донер Чэнмогаар дамжуулан хайрласан асуулга хийгээд хариулт сэлтэд урьд адил хариулснаас...* үүний дараа өмнө нутгийн дамжлагын мөрийн зэрэг хийгээд Дэмчигийн биеийн хот мандал тэргүүтний тухай бичсэн байна.

Мөн 471-р хуудасны 2-р мөрөнд: *...Бас түүний дараахан гарсан нь, Бишрэнгүй албат Павонка нэртээс айлтгасан хийгээд Нигүүлсэнгүй Донэр Чэнмогийн дамжуулсан зарлигийн таалал утга нь: Урьд жилийн арван хоёрдугаар сарын хорин хоёрны өдөр өргөсөн айлтгал бичигт: (Павонка Ринбүүчийн XIII Далай Ламд өргөсөн бичиг. Орч.) ...алдаа буйг үг бүрчлэн зарлигласан зарлигийн ач их хийгээд бишрэнгүй албатад өөрийн алдаанаас өөр зөв гээд айлтгах зүйл хувь төдий ч байхгүй тул хойшид зарлигийн утгыг хэзээ ч осолдуулалгүй зүрхнийхээ угт хадгалах болно. Өнөөг хүртэл айлдвараас зөрсөн юу байгаа бүхнийг тэнгэр та таалалдаан болгоож өршөө хэмээн бичсэн.*

*(XIII Далай Ламаас Павонка Ринбүүчийд хайрласан зарлиг бичигт: Орч.) ...Энд өгүүлсэн гурван хэргийн тухайд өдгөө ч эш, ухааны маргаан хир хэмжээтэй нэг байгаа ч, хэсэг зуур тэр төдий хийгээд урьд аврал одуулахад шамдаж байна хэмээн та бээр Шүгдэнг голлон шүтсэн хийгээд урьд жил тэргүүтэнд номын аймаг Брайбүн хийдэд мөрийн*

*зэргийн хөтөлбөрийг номлох лугаа барилдуулан шавь нугуудад Шүгдэнг шүтэхийг ихэд дэлгэрүүлсэн тул эрт үед Брайбүн хийдийг анх байгуулсан Жамьян Цоржоос орон түүнийг сахин тэтгэхээр зарлиг тушаал хүлээсэн Найчүн номын хаанаас Брайбүний Цогчинд шашныг урьдаас саарулахад одуулсан ёс зэрэг таалал харшлах урьд хойно гаргасан зэрэг гэмд тулж байгаа бөгөөд илүүтэйгээр ертөнцийн эгэл хилэнтэнг энэ насны нөхөрт эрснээр аврал одуулахуйн суртгаал лугаа харшлах үзэгдсэн тул эс мэдэхийн мунхгаар түйтгэрлэгдэн алдаа гаргаж, мэдсээр байж ном бусын мөрд та өөрөө оршсон бөгөөд бусдын эрхээр тэр мэт болсноос зүрхнийхээ угаас үйлдээгүй гэсэнтэй чинь дотроо харшилсан нь илт тул энэ юу болохыг айлтгах хэрэгтэй хэмээн зарлиг буусанд, (Павонка Ринбүүчийн хариу айлтгал: Орч.) бишрэнгүй албатын хөгшин эх тэр ямагтаас Шүгдэнг эхийн удмынхны шүтдэг тэнгэр хэмээсэн учир өнөөг хүртэл шүтэж байсан. Хойшид өөрийн алдаанд гэмшиж, тэвчихийг хатуугаар үйлдэн тахин шүтэх зэргийг хэзээ ч үл үйлдэхийг зүрхнийхээ угаас батлан тангараглаж буйгаа бишрэнгүйгээр айлтгая. Найчүн номын хааны тааллыг хилэгнүүлсэн хийгээд аврал одуулахуйн суртгаал лугаа харшлах гарсан тэргүүтэн өчүүхэн миний өнөөг хүртэл гаргасан осол юу байгаа бүхнийг үлэмж нигүүлсэхүйт итгэлт дээд та бээр их нигүүлсэхүй, асрахуйгаар уучилж өршөөхийг болгоохтун хэмээн соёрхол талбин, хадаг хийгээд таван лан мөнгийн хамт их бишрэнгүйгээр өргөе хэмээсэн энэ ямагт мөн бөгөөд хойно нэгэнд Богд багшаас надад...* үүнийг бичсэн хүн нь дэнма нутгийн бичээч Лувсандорж юм. *...зарлиг энэ адилыг хайрласан юм: тэр үед Дээрхийн Гэгээнтний таалал хилэгнэснийг мэдэлгүй зарлигийн хариуг үнэнээр бичиж өргөсөн ч түүний дараа олон хүмүүс бэрх болсон гэж хэлж байсан адил огтоос баясахгүйн байдал тодорхой байсан тул гаржүдбын зарим лам нарын намтарт, өөрийн багш бээр наран баруунаас гарав хэмээн зарлигласан ч...* хэмээсэн энд юу айлдсаныг зарлигчлан бүтээх тухай өгүүлсэн байна.

Мөн намтрын 519-р хуудасны ар талын эхний мөрөнд: *...Монголын долдугаар сарын үед Шидэ-Дасүр Лхасад байх үедээ үүрээр буян номд шамдаж байх үест өмнө нь Шүгдэн*

*буусан болов уу гэмээр нэгэн ламын дүрс урган баярласан өндөр дуугаар, "Хорин еснийг дүүргээд битүүнд шүү!" хэмээн хоёр удаа тодоор хэлэх нэгэн гарсанд Дасүр бээр тэр даруй, өнөөдөр Богд багшийн дэргэдэд тухайлан бараалхаж энэ тухай юу болохыг даруй айлтгах хэрэгтэй хэмээн бодоод тэр өдрөө эрт Дашчойлинд очиж Богд багшид тэр тухайгаа айлтгасанд, Богд ямагтаас, одоо ийм тийм гэж хэлэхэд хэцүү ч хойно шинжлэх хэрэгтэй хэмээгээд өмнө нь Дасүрт юу тохиолдсон ёс нугуудын өдөр сарыг тодорхой бичиж, мутрын тэмдэглэлдээ буулган зохиосон...* хэмээсэн хийгээд мөн 524-р хуудасны ар талын 3-р мөрөнд: *...тэр сарын битүүнд Дээрхийн Гэгээнтэн, Дээд Ялгуусны Эрхт бээр таалал номын агаарт шингэх ёсыг үзүүлсэн тул урьд Шидэ-Дасүрт Шүгдэн сахиус бээр зарлиглан хорин еснийг дүүргээд хэмээсэн нь ч энэ үестэй таарч байгааг тааллалдаа магадлаад, есдүгээр сар дүүрээд аравдугаар сарын битүүнд Дээрхийн Гэгээнтэн таалал барахыг хэлж байж хэмээн зарлигласан...* энд өмнөх дүрийн Далай Лам таалал барсан түүнд гашуудсан түүх огтхон ч байхгүй бөгөөд Шүгдэн бээр ч "Хорин еснийг дүүргээд битүүнд шүү!" хэмээн эш үзүүлэхдээ баярласан өндөр дуугаар хэлсэн байдаг. Сайн мэдээг баярласан өндөр дуугаар дуурсгаж, муу мэдээг гунигтай нам дуугаар хэлдэг болохоос баярласан өндөр дуугаар дуурсгадаггүй.

Арван дөрөвдүгээр хэсэг. Шүгдэнгийн тухай судалгаа хийдэг хүмүүс энэ баримтыг олсон юм. Үүнийг би ч сайн мэдэхгүй. Чойгон Хувилгааны долдугаар дүр Чойжининжэдийн зохиосон Бутаны Дэчой Ёнзонгийн тавдугаар дүр Ишдүвийн (1781-1835) намтар *"Дээд Адистат Бумбын Сан"* хэмээхийн 8-р хуудасны тавдугаар мөрөнд: *...Тэр мэт бясалгалд оршиж байх үест Шүгдэн хэмээх машид хэрцгий чөтгөр тэр бээр онолын илчийг цагдах бөгөөд хорлох чөлөө эрэхийн тулд Ялгуусны Эрхт Врүгбад хувилаад олон удаа ирэхэд нь хэсэг хугацаанд хайхралгүй тэгш агуулан зохиосон...* Тижан Ринбүүчи надад Шүгдэнгийн тухай, XIII Далай Ламын зүүдэнд нэг удаа Хааны (*Шүгдэнгийн. Орч.*) ёр ирсэн хэмээн айлдаж байсан. Намтарт нь ч гэсэн тэгж гардаг.

Тангаргийн бугийн төрлүүд багш нарын дүрээр ирж хорлодог нь аюултай. *...Хэр төдий азнаад судар хийгээд тарнийн мөрийн номын ёс элдвээр гэсгээн зохиосны эцэст дүрсээ бодитой үзүүлэхийг тушаасанд омогтон тэрээр ч, таны хөвгүүд, шавь нараас биднийг тахиж үйлдвэл нөхдийн дунд маш хэрцгий буг олон байгаа тэдгээр нугууд бээр хорлол хөнөөл үйлдэх болох тул тахин зохиох хэрэггүй. Үйлс алин бүтээх хэрэгтэйг би бээр бүтээн үйлдье хэмээн ам аваад өөрийн орондоо одсон болой...* хэмээн бичсэн байна.

Энд өгүүлж буй бүх түүхүүд Төвдөд хэвлэгдсэнээс биш бид нар энд Дарамсалад үг үсгийг нь хольж солиод хэвлэсэн юм огт байхгүй. V Далай Ламын үеэс хойш 370 орчим жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд олон хутагт хувилгаад *Шүгдэн* гэж зарлиглаж байснаас *сахиус* гэж зарлигласан нь алга. Зөөлөн Итгэлт Ялгуусны шашны сахиус гэж зарлигласан хүн ч алга. Эхэндээ би үүнийг мэддэггүй байсан.

Өөрт тохиолдсон түүхээ бага зэрэг яривал зүгээр байх. Бүүр нарийвчилж ярих хэрэггүй болов уу. Ерөнхийдөө түрүү жил Сэра-Мэ дацанд ярьж байсан. Анхандаа би Шүгдэнг шүтдэг байсан. 1950 оноос шүтэж эхэлсэн. Тэр нь ч Дому Дунгар хийдэд сууж байхдаа барилдлагатай болсон бөгөөд 1970-аад он хүртэл шүтсэн. Урьд Найчүн бээр Брайбүнд эш үзүүлэхдээ, Шүгдэнг Асай-къямбу (*А-гийн тэнүүлч хөвгүүн. Орч.*) гэж хэлж байсан. Тэр үед Найчүн, Асай-къямбууг шүтэж болохгүй гэж хэлсэн юм. Энэ нь 1960-аад оны үед болсон явдал. Тэр үед би Найчүнд “Чимээгүй суу. Асай-къямбу гэж Шүгдэнг хэлж байгаа бол одоо үед Шүгдэнг шүтдэг хүн олон байгаа тул асуудал гарна. Чимээгүй суувал сайн.” гэж хэлсэн. Түүнээс хойш Найчүн энэ тухай нэг ч үг дуугараагүй. Олон жил өнгөрсний дараа Дарамсалад бум цог (*Буман тахил. Орч.*) хурах үед, урьд нь Дарамсалагийн ани нар (*Эмэгтэй хувраг. Орч.*) ирдэг байсан ч, тэр өдрийн бум цог хуралд нэг ч ани ирсэнгүй. Юу болсныг асуусанд, нэгэн шинэ ном гарсны дотор гэлүгбын шашинтнууд нинмавын номыг үйлдвэл Шүгдэн гэсгээх болно гэж бичсэнээс болж. Тэр нь Даглүн Врагийн унзад ламын хэвлүүлсэн “Пагод Ламын Шаллүн” хэмээх ном байсан. Энэ явдал надад тийм ч

таатай санагдаагүй. Би Найчүнийг чимээгүй суувал сайн гэж хориглосон бөгөөд Найчүн ч чимээгүй байсан. Цаад талаас "Пагод Ламын Шаллүн" хэмээх янз бүрийн юм бичсэн ном гарч, олон хүнийг айдаст автуулж байхад наад талаас Найчүний амыг хорих нь шударга бус байсан. Нэг өдөр Найчүнийг залах үедээ, "Урьд та Асай-къямбууг шүтэж болохгүй гэж хэлэхэд би чимээгүй сууж, энэ тухай ярихгүй байвал сайн гэж хэлж байсан. Түүнээс хойш та тэр тухай нэг ч үг хэлээгүй. Одоо Шүгдэнг шүтдэг хүмүүсийн зүгээс ярих хэрэггүй юм ярьж байна. Дамжлага урсгалуудыг ялгаварласан хачин зүйл ярьж байна. Тиймээс та урьд Шүгдэнг шүтэж болохгүй гэж хэлснийхээ учрыг хэлнэ үү" гэж хэлсэн. Тэр үед Найчүн Шүгдэнгийн тухай олон зүйл ярьсны нэг гол зүйл нь, Шүгдэнг шүтвэл Балдан Лхам хилэгнэдэг гэж хэлсэн. Балдан Лхамыг Анхдугаар Далай Лам Гэндүндүвээс авахуулаад бүх Далай Лам нар онцгойлон шүтдэг байсан. Найчүн сахиустай II Далай Лам Гэндүнжамцын үеэс барилдлагатай болсон. Илүүтэйгээр III Далай Лам Содномжамц Найчүн сахиусыг онцгойлж үздэг байв. V Далай Лам Балдан Лхам болон Жалбуу Гүн-Ааг онцгойлж шүтдэг байв. Тиймээс Найчүний айлдсанд нэг учир шалтгаан байна гэж бодсон юм.

Шүгдэнг шүтвэл Балдан Лхам хилэгнэдэг хэмээсэн учир, би ч гэсэн Балдан Лхамыг голлон шүтдэг. Тиймээс үүнийг шинжилж үзвэл сайн гэж бодоод шинжсэн. Шүгдэнг шүтдэг, үйлс даатгалыг нь хураангуйгаар өдөр бүр тасралтгүй уншдаг байсан тул үйлс даатгалыг нь уншихаа аажмаар болих уу, эс бөгөөс яг одооноос эхлэн уншихаа болих уу, эсвэл маш нууцаар шүтэж байх уу гэсэн гурван зүйлийн аль нь сайныг шинжсэн. Шинжиж үзэхэд нууцаар шүт гэж буугаагүй. Аажмаар шүтэхээ боль ч гэж буугаагүй. Яг одооноос шүтэхээ боль гэж буусан. Тэр үеэс эхлэн би шүтэхээ больсон.

Мөн өчигдөр ярьж байсанчлан Жанзэ дацангаас шинжиж өгөхийг хүссэн юм. Тэр үед би мэдчихсэн байсан учир Жанзэ дацанд Балдан Лхам Шүгдэнгээс болж хилэгнэсэн үү, өөр шалтгаанаас болж хилэгнэсэн үү гэж шинжиж үзэхэд Шүгдэнгээс болж хилэгнэсэн гэж буусан.

Дараа нь энэ тухайгаа Жанзэ дацанд хэлсэн.

Тэгээд Ганданд очих үед, миний тодорхой санаж байгаагаар, тэр үед би Гандан-Шарзэ дацангийн дээд өрөөнд байрлаж байсан. Үүрээр их хачин зүүд зүүдэлсэн юм. Зүүдийг анхаарч үзэх хэрэг байдаггүй ч хачин зүүд байна гэж санаад эрхээр мэргэлж, энэ зүүдийг шинжилж үзэх хэрэгтэй эсэхийг шинжихэд, шинжилж үзэх хэрэгтэй гэж буусан. Тэр өдөр Гандангийн цогчин дуганд ном айлдаад, дараа нь өдрийн хоол өнгөрөөгөөд дээш Лин Ринбүүчи багшид бараалхчихаад Брайбүн хийд уруу явах төлөвлөгөөтэй байсан. Гандан-Шарзэд байхдаа шинжиж үзсэн маань тэр юм.

Би тэр үеийн байдлыг их тодорхой санадаг. Энд байгаа Гончогцэрэн тэр үед цогчин дуганы гадна алгаа хавсарчихсан ерөөл тавиад сууж байсан. Таныг алгаа хавсраад ерөөл тавьж суухад би дотор гурилаар шинжиж байсан юм. Тэр үед Гандангийн цогчин дуганы Чойжоо сахиусны өргөөнд байсан Шүгдэнгийн дүрийг хураах, эсэхийг шинжихэд, хураах хэрэгтэй гэж буусан. Ойрмогхон Гандангийн цогчин дуганыг засаж янзлах гэж байсан тул тэр үед нь хураах уу, эсвэл ерөөл хурсны дараа хураах уу, нэг бол одоо шууд хураах уу гэж шинжихэд, одоо шууд хураах хэрэгтэй гэж буусан. Тэр үед Гандангийн хамба хийгээд холбогдох хүмүүсийг дуудуулаад, өнөөдөр би ийм, ийм зүйлийг шинжиж үзлээ. Өглөө хачин зүүд зүүдлээд эрхээрээ мэргэ буулгахад зүүдээ шинжих хэрэгтэй гэж буусан. Тэгээд шинжиж үзэхэд ингэж буулаа гээд хэлсэн. Гандан-Шарзэгийн дээр шинжиж, эцэслэн шийдчихээд Лин Ринбүүчи багшид бараалхмагцаа, өнөөдөр би буруу юм хийлээ гэж айлтгасан. Багш, юу хийснийг асуухад өмнө болсон зүйлүүдийг айлтгасан. Тэгэхэд Лин Ринбүүчи багш маань, “болсон байна аа” гэж зарлигласан.

Үүнээс өөр олон түүхийг ярьж болох ч тэдгээрийг энд ярих хэрэггүй байх. Намайг Шүгдэнг хорих үед Дарамсалад лам хувраг, хар шар нийлсэн олон хүн гол дуганд цугларсанд тайлбарлаж өгсөн юм. Тайлбар хийсэн шөнө Тижан Ринбүүчи багштай ав адилхан өндөр биетэй, бага зэрэг бөхийсөн гурван хүн хамтдаа морилон ирээд, сэнтийнд

залрангуутаа, “Өнөөдөр Шүгдэнг хориглосон чинь маш сайн болсон.” хэмээн зарлигласан. Мөн хоёр өдрийн дараа Нямаа багшийг зүүдэлсэн. Нямаа багш, “Гурван их хийдэд Шүгдэнг хориглосон нь маш сайн боллоо.” гэж зарлигласан. Зүүдийг нээх чухалчлах шаардлагагүй ч тийм зүүд зүүдэлсэн юм.

Эхэндээ би энд бичсэн зүйлүүдийг мэддэггүй байсан. Эдгээрийг судалдаг хүн ч байдаггүй байв. Шүгдэн V Далай Ламын үеэс үл зохилдох нэгэн байсан, Брайбүн хийдэд шүтэхийг бага зэрэг цээрлэдэг гэж сонсож байснаас биш яг нарийн ширийнийг нь мэддэггүй байв. Хожим Шүгдэнгийн нийгэмлэг байгуулагдаж, ном товхимол маш олныг гарган, V Далай Ламын зохиосон Шүгдэнгийн үйлс даатгал байдаг гэхчлэн ярих болсон тул тийм үйлс даатгал байдаг эсэхийг мэдэхээр V Далай Ламыг гадаад, дотоод бүх зарлигуудыг шүүж үзэхэд, V Далай Ламын зохиосон үйлс даатгалын оронд айдас хүрмээр гэрч бичиг олсон юм. Өнгөрсөн түүхийг судалж эхлэхэд одоо энд үзүүлж буй бичгүүд дараалан гарч ирсэн. Энэ намтруудыг санаа саванд багташгүй эрдэм чадалтай, дээд төрөлхтөн, мэргэн бүтээлчид зохиосон юм. Тэдгээрийн олонх нь зөвхөн гэлүгбын ёсыг анхааран авдаг хүмүүс байсан. Тэдэнд бага зэрэг ч гэсэн итгэх хэрэгтэй байх. Шүгдэнг шарын шашны сахиус хэмээн өргөмжлөгч нь бараг Павонка Ринбүүчи байсан байх. Шүгдэнг шүтсэний улмаас Павонка Ринбүүчийд олон бэрх зүйл учирч байсан. Найчүн сахиус Шүгдэнтэй холбоотой олон зүйл айлдсаны нэг нь Павонка Ринбүүчийн тухай байсан. Павонка Ринбүүчийг Найчүн *Гүшав* (*Гэгээн гэсэн утгатай хүндэтгэлийн үг. Орч.*) гэж дууддаг бөгөөд *“Гүшав Павонка Ринбүүчи залуудаа маш сайн байсан. Нас дээр гараад Шүгдэнгийн шалтгаанаар сайн болоогүй. Тиймээс, Хаан Бихар би хилэгнэсэн. Гүшав Дэчиннянбуугийн хойд дүрүүдийн нас сүүдэр, зохиол үйлс нь сайнаар болохгүй”* хэмээн Найчүн бээр итгэлтэй хэлж байсан. Ингэж хэлсэн нь ч таарч байгаа мэт байдаг.

Асуудлыг судалж, шинжлэх үед олдсон баримтууд нь эдгээр юм. Өчигдөр хэлсэнчлэн Шүгдэнг хорьж, хорт чөтгөр, ерөөл буруудсан тангаргийн буг хэмээн танин барьж байсан хутагт хувилгаадыг нэг талд нь тавиад, гол нь Павонка Ринбүүчи хийгээд сажавын зарим лам нар Шүгдэнг шашны

сахиус мэт үздэг байсан. Тэднийг нөгөө талд нь тавиад хэмжвэл эхнийх нь хүнд жин татна уу гэхээс удаах нь хүнд жин татах нь юу л бол.

Ямартай ч V Далай Ламын эцэслэн шийдсэнийг гэлүгбын олон хутагт хувилгаад зөвшөөрч дагасан. Тэдгээрийн зарлигийг өөрчлөх хэрэгтэй гэвэл V Далай Ламтай эн чацуу нэгэн бээр л өөрчилж чадахаас биш бид нар шиг эгэл төрөлхтөн өөрчилнө гэдэг боломжгүй юм. Шүгдэнг хориглосны минь учир шалтгаан ч энэ юм. Баримт нь ч энэ юм.

Урьд энэ тухай бичиг, товхимол тарааж байсан ч энэ адилын нарийн судалгаа гарч байгаагүй. Энэ удаад их олон баримтууд байгаа тул маш нарийн судлагдсан гэж үзэж болно. Та бүхэн ч гэсэн эдгээрийг судалж үз. Шинээр ирж байгаа лам нарт ч гэсэн энэ байдлыг тайлбарлаж өг. Шүгдэнг шүтдэг хүмүүст ч гэсэн ийм ийм баримтууд байна, тиймээс тахин нэг бодож үзээрэй гэж хэлэх хэрэгтэй. Энэ баримтуудыг бүгдийг нь үзэж, мэдчихсэн хирнээ Шүгдэнд итгэсээр байгаа бол хувь хүний өөрийнх нь мэдэх хэрэг. Мэдэхгүй, бусдыг даган дуурайж шүтэж байгаа бол ийм ийм түүх байна, их будлиантай юм байна хэмээн хэлж байх хэрэгтэй. Төвдөд, Чавдо, Враг-яв зэрэг Дэнма Гонсар Цоржийн байдаг нутаг оронд Шүгдэнг хүчтэй шүтдэг мэт байдаг. Тэдгээрийн олонх нь мэдэхгүйн эрхээр шүтдэг. Энд гаргасан түүхэн баримт бүгдийг тэд нарт мэдүүлэх нь чухал шүү. Ойлгосон уу? За боллоо. Одоо өндөрлөе. Өлзий хутаг орших болтугай!

# 2008 оны 7-р сарын 2-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн симчүн хүлээн авалтын танхимдаа Сэра-Мэ дацангийн Бомра аймгийн гэвш Түвдэнсампил хийддээ эргэн орж болох тухай хийгээд үүнд нь туслагч Дарамсала дахь Литан Жэдүг нийгэмлэгийн тэргүүн Дашцэрэн, Бялакуппэ дэх Литан нутгийнхны төлөөлөгч Лувсанпунцог болон гэвш Лувсанжигмэд нарт айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Надад онцгойлж хэлэх юм алга аа. Урьдын явдал өнгөрсөн. Хойшид шүтэхгүй байх болно гэсэн бичиг ирсэн. Мөн олон хүний гарын үсэг зурсан бичиг ч хамт ирсэн. Тэдний талаас тийн ариун санаагаар хойшид шүтэхгүй байх болно гэвэл, бодож үзэх хэрэгтэй юу гэсэн асуулт бүх бичигт байсан. Тэднээс, номын тусад буцааж оруулж өгнө үү гэсэн бичиг ирэх үед номын тухайд гэсэн ч болохгүй байна гэдгийг тайлбарлуулахаар хоёр төлөөлөгч явуулсан. Миний зүгээс тушаал гаргаж, шууд буцаагаад оруул гэж хэлэхэд хэцүү. Бид нар ардчилсан нийгэмд амьдарч байна. Ардчилал гэж байгаа нь ч ил тод ардчилал болохоос биш хуурмаг ардчилал биш. Жишээлбэл, саяхан Төвд хүртэл алхаж явах эсэргүүцлийн алхааг зохион байгуулагч таван нийгэмлэгийн удирдагчидтай энэ өрөөнд уулзсан юм. Тэр үед би тэдэнд хэлсэн: та бүхэн Төвд хүртэл алхаж чадсан ч хятадын засгийн газрыг хөдөлгөж чадах нь юу л бол. Дэлхий нийтэд бага зэрэг мэдээлэл түгэх байх. Үүнээс илүү үр дүн гарахгүй. Энэтхэгт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх байдаг учир Энэтхэгт жагсаал, цуглаан хийхэд хориглох юм байхгүй. Төвд хүртэл алхаж явна гэдэг чинь буруу гэж хэлсэн. Төвд хүртэл алхаж явна гэдэг чинь буруу гэж хэлж байгаа болохоос биш төвд уруу алхаж явж болохгүй гэж би тушааж байгаа юм биш. Сонсох сонсохгүйгээ та нар өөрсдөө бодох хэрэгтэй гэж хэлсэн. Зохистой, зохисгүйг хэлж таниулах нь миний үүрэг. Тиймээс та нарт үүнийг хэлж байгаа юм гэж хэлсэн.

Түүнчлэн та нарын тухайд саяхан төлөөлөгч буцаж ирээд их тодорхой ярьсан. Би шууд буцааж оруулах хэрэгтэй гээд тушааж чадахгүй. Хэсэг хугацаанд тайван суувал, хэдэн сар, жилийн дараа гэхэд та хоёр ил далдгүйгээр тийн ариун санаагаар үйлдэж байгаа эсэх чинь хүмүүст мэдэгдэх болно. Тэгээд хойшид Шүгдэнг шүтэхгүй гэдэг нь үнэн юм байна гэсэн сэтгэл итгэмжлэл хүмүүст төрвөл ажил хийхэд хялбар болно. Би өмнө нь, буцаагаад оруулчихвал сайн гэж нэг удаа хэлсэн ч тэгж болохгүй байна гэсэн хариу ирсэн. Та нар тэгэх хэрэгтэй гээд би шууд тушааж болохгүйн дээр, тэгж тушаах ч хүсэлгүй байна. Тиймээс хэсэг хугацаанд энэ хэвээр нь байлгахаас өөр арга алга. Та хоёр тийн ариун санаагаар үйлдэх нь маш чухал шүү. Шүгдэнгийн тухай будлианы эхэн, дунд, адаг гурвуулангийнх нь талаар би их зүйл мэдэж авсан. Үүнийг бүгд мэдэх байх. Анх би ч гэсэн Шүгдэнг шүтэж байснаа нийтэд хэлдэг. Домуд (*Төвдийн Дому нутгийн нэр. Орч.*) байх үеэсээ эхлээд Шүгдэнг мэднэ. Дому Дунгар хийдэд Шүгдэн догшин, амарлингуй хоёр дүрээр буудаг. Буухдаа ч их сайн буудаг байсан. Тэндээс Лхасад ирсний дараа Чойнхор Янзэрийн Шүгдэн буухад түүн лугаа барилдлагатай болсон. Шүгдэнтэй барилдлагатай болсон маань тэр юм. Тижан Ринбүүчи онцгойлон шүтдэг байсан. Нэг жил Шүгдэнгийн эш үзүүлснээр тэр жилийн цагаан сарын шинийн гурванд дэлгэрэнгүй тахилга үйлдсэн. Тэр жилээс эхлээд жил бүрийн цагаан сарын шинийн гурванд дэлгэрэнгүйгээр тахидаг болсон хийгээд хожим Тижан Ринбүүчийд Шүгдэнд амиа тушаах тухай айлтгасан юм. Тижан Ринбүүчи ч үүнд бэлдэн, “Амь тушаах үест *Их Бодь Мөрийн Зэрэг* хэрэгтэй байдаг тул Гандангийн хуучин барын *Их Бодь Мөрийн Зэргийн* номыг амь тушаах үед ашиглана гэж айлдаж байсан. Тэр үед надад Шүгдэн шүтэж болохгүй гэсэн сэжиг төрсөн юм. Тэр нь ч Найчүн бээр Шүгдэнг Асай-къямбу хэмээн хэлэх үед би Найчунд, “Сажава хийгээд Гэлүгбад Шүгдэнг шүтдэг хүмүүс олон байдаг. Сахиус та Шүгдэнгийн тухайд Асай-кьямбу хэмээх үг тэрийг хэлж болохгүй. Будлиан гарна. Чимээгүй суу.” гэж хэлсэн юм. Найчүн ч гэсэн ойлголоо гээд тэр цагаас хойш Шүгдэнгийн тухайд нэг ч үг хэлээгүй. Гэсэн ч зүүд тэргүүтэн олон

зүйлийн үүднээс надад сэжиг төрөх болсон. Тэр үед Зэмэ Ринбүүчи "*Пагод Ламын Шаллун*" хэмээн ном бичиж, түүндээ, Бурханы шашны дамжлага, урсгалууд хоорондоо эвдрэлцэхэд хүргэх олон зүйлийг өгүүлсэн байсан. Түүнээс болж Шүгдэнг шүтэгчид хамаагүй зүйл ярих болсон хийгээд Найчүнгийн амыг хорьсон нь буруу юм байна гээд Найчүнг залаад, Найчүн юу хэлмээр байна, тэр бүхнээ хэл гэхэд Найчүн бээр, Шүгдэнг шүтвэл Балдан Лхам сахиус уурлана хэмээн их олон түүхийг ярьсан. Павонка Ринбүүчийг Их тарнийг баригч гэж дууддаг. Их тарнийг баригч, санаанд багташгүй эрдэмтэй хүн ч гэсэн Балдан Лхам сахиус хилэгнэсний уршгаар лагшин сүүдэр, зохиол үйлс нь эцэстээ хүрээгүй. Павонка Ринбүүчийн дараа дараагийн дүрүүдийн лагшин сүүдэр, зохиол үйлс нь ч эцэстээ хүрэхгүй хэмээн их нухацтайгаар олон зүйл ярьсан. Тэр үед Жанзэ дацанд өлзий бусын ёр гарсан юм. Жанзэ дацанд Балдан Лхам хилэгнэсэн байна хэмээн Тижан Ринбүүчи зарлиг хайрласан байсан. Тэр үед Балдан Лхам юунаас болж хилэгнэсэн нь мэдэгдэхгүй байсан. Тиймээс би Балдан Лхам юунаас болж хилэгнэсэн, түүнийг арилгах арга бий, үгүйг шинжсэн. Тухайн үед Сэргон Ринбүүчи, Намжал дацангийн хамба Лувсандондүв хоёр байсан. Ерөнхийдөө чухал зүйлийг шинжихдээ би гурилан үрлээр шинждэг учир тэр үед ч мөн гурилаар шинжсэн. Тэр нь ч, эхлээд Балдан Лхам хилэгнэсэн эсэхийг шинжихэд хилэгнэсэн гэж буусан. Хилэгнэсэн нь Шүгдэнг шүтсэний уршгаар уу, эсвэл өөр шалтгааны улмаас уу гэж шинжихэд Шүгдэнг шүтсэний уршгаар хилэгнэсэн гэж буусан. Тэр үед би Жанзэ дацанд илгээсэн хариу бичигтээ энэ тухай юу ч бичээгүй. Балдан Лхам хилэгнэж байгаа тул Балдан Лхамын тахилга, наманчлалыг үйлдэх хэрэгтэй гээд, Сэргон Ринбүүчи, хамба Лувсандондүв хоёрыг тусад нь дуудаад, "*Гандан-Жанзэ дацанд өлзий бусын ёр гарсан тэр нь Шүгдэнг шүтсэний уршгаар Балдан Лхам сахиус хилэгнэснээс болсон нь гурилаар шинжихэд маш тодорхой буулаа. Гэсэн ч Жанзэ дацанд илгээсэн хариу бичигтээ би энэ тухай бичсэнгүй. Та хоёр Жанзэ дацангийн холбогдох хүмүүстэй уулзаад энэ тухай хэлбэл сайн байна*" гэж хэлсэн. Үүний дараа би, Найчүн бээр, Балдан Лхам хилэгнэдэг

хэмээн айлдсан учир сайны шинж биш, чухалчилж үзэх хэрэг гэж санаад жил бүрийн цагаан сарын шинийн гурванд тахихаа болиод далд байдлаар үргэлжлүүлэн шүтэх үү, эсвэл бүр шүтэхээ болих уу гэдгийг шинжиж үзэхэд огт шүтэхгүй байх хэрэгтэй гэж буусан. Тэр өдрөөс эхлээд би Шүгдэнгийн тарнийг уншихаа больсон. Мөн V Далай Ламтай Шүгдэн таардаггүй. Гандан-Потаныг (*V Далай Ламын байгуулсан Төвдийн засгийн газар. Орч.*) V Далай Лам байгуулсан бөгөөд Шүгдэн Гандан-Потантай таардаггүй тодорхой түүх байдаг. Тийм учраас төрийн ажил хийж байгаа хүмүүс Шүгдэнтэй холбоогүй байх хэрэгтэй гэж би тэр үед сайд нарт тодорхой хэлж байсан. Өөрөөр энэ тухай нийтэд зарлаагүй. Ойлгосон уу? Би та нарт худал хэлээгүй. Хятадын коммунистууд хийгээд танай Шүгдэнгийн нийгэмлэг Далай Ламыг худал ярьж байна гэдэг. Намайг худал ярьж байна гэж бодоод итгэхгүй байж болно. Итгэж байгаа бол миний ярьж байгаа зүйл үнэн бодит байдал болохоос биш худал хуурмаг биш. Улмаар байдал нийтэд тодорхой болсон бөгөөд Шүгдэнгийн нийгэмлэг байгуулагдаж намайг эсэргүүцэх болсон. Шүгдэнгийн нийгэмлэг, V Далай Лам хийгээд Шүгдэнгийн хооронд нийтийн болон нийт бусын холбоо байсан гэдэг. Ёнзон Лин Ринбүүчи багш маань ч тэгж айлдаж байсан. Лин Ринбүүчи Шүгдэнг огт шүтдэггүй байсан. Шүгдэнг шүтэхээ больсноо Лин Ринбүүчийд айлтгах үед багш маань, “Болсон байна. Сэтгэл амарлаа.” гэж айлдсан.

Павонка Ринбүүчийн дэргэдээс Лин Ринбүүчи олон ном сонсож байсан ч, азаар Шүгдэнгийн амь тушаалгыг айлдах үед нь сонсох боломж гараагүй гэдэг. “Хэрвээ тэр үед амиа тушаасан бол хэцүү болох байж. Гэхдээ Шүгдэнгийн нямба бүтээлийн эшийг бараг сонссон байх. Түүнээс өөр Шүгдэнтэй холбоотой юм байхгүй.” гэж айлдаж байсан. Намайг Шүгдэн шүтэхээ больсон тэр өдөр Лин Ринбүүчи олон шинэ зүйлийг айлдсан юм. Тэр хүртэл буюу Шүгдэн шүтэхээ болих хүртэл маань Лин Ринбүүчи энэ тухай юу ч айлддаггүй байсан.

Лин Ринбүүчи нэг удаа Павонка Ринбүүчийд бараалхах үедээ, Брайбүн хийдийн настай лам нарын ярианд, “Шүгдэнг шүтвэл Найчүн сахиус хилэгнэдэг” гэсэн яриа

байдаг. Энэ нь үнэн юм болов уу гэж асуухад Павонка Ринбүүчи, хувилгаан Дагважанцанд догшин дүр таалахыг сануулагч нь Найчүн сахиус юм шүү дээ. Тиймээс тийм зүйл хаанаас байж болох хэмээн айлдсан гэдэг. Павонка Ринбүүчигээс мэдэхгүй зүйлээ асуух болгонд хариултууд нь эргэлзээг арилгадаг байсан ч тэр өдрийн айлдвар миний эргэлзээг арилгаагүй гэж Лин Ринбүүчи айлдаж байсан. V Далай Лам Шүгдэнтэй таардаг байсан: V Далай Лам мутрын зарлигаа Шүгдэнд өгөхөд Шүгдэн гараараа тосож аваад тэргүүндээ хүргэсэн түүх байдаг гэдэг.

Ямартай ч V Далай Лам Шүгдэнтэй ямар нэг холбоотой байсан гэдэг нь мэдэгддэг байсан. Шүгдэнгийн нийгэмлэгээс, V Далай Лам Шүгдэнгийн үйлс даатгал зохиосон бөгөөд Шүгдэн болон V Далай Лам хоёрын хооронд таарахгүй зүйл байхгүй гэдэг. Тиймээс, V Далай Ламын бүх зохиол бүтээлүүд бүгд бүрэн бүтнээрээ хадгалагдаж байдаг учир тэнд Шүгдэнгийн үйлс даатгал байгаа эсэхийг шалгаж үзсэн юм. V Далай Ламын бүтээлүүд болох *дотоод таван боть, гадаад хорь гаруй боть, нууцын хоёр боть* зохиол байдаг. Тэдгээрийн дотор Шүгдэнд Балдан Лхам хилэгнэдэг эсэх тухайд хоёр зүйл байсан. Ямартай ч бүх бүтээлүүдийг нь шалгаж үзэхэд *гадаад Да боть* доторх *V Далай Ламын зохиосон номын сахиусны үйлс даатгал* хэмээхийн дотроос *гэрч бичгийг* олсон юм. *Гэрч бичиг* зохиосон тухайгаа өөрийн намтар "Дүгүлийн Гой-сан"-д бичсэн байдаг: *Дол нутгийн цагаан булгийн Дийлэгчид эхлээд зөөлөн хандсан ч улам хорлох болсон тул эцэстээ хатуу үйлээр хөөв. Тэр үед гэрч бичиг нэгийг зохиосон* гэж тодорхой гардаг. Шалгаж байх үед V Далай Ламын зохиосон Шүгдэнгийн үйлс даатгал гэгчийг олоогүй бөгөөд харин түүний оронд *гэрч бичгийг* олсон юм. Гэрч бичгийн эхэнд жижиг үсгээр бичсэн өмнөтгөлийн хэсэгт: *Гадхасагийн Ла-Ажалын хичээл зүтгэлээр Хувилгаан Гэлэгбалсангийн хойд дүрд хуурамчаар тодорсон тэрээр ерөөл буруудсан тангаргийн буг болоод...* гэсэн үгсийг бичсэн байдаг. Гадхаса гэдэг нь Дагважанцангийн төрсөн нутаг. Ла-Ажал гэдэг нь түүний ээж юм. Ээж нь их зальжин хүн байсан бөгөөд V Далай Ламын дүр тодроогүй байсан тэр үед өөрийн хүү

Дагважанцанг V Далай Лам гэж тодруулахын тухайд будлиан гаргасан байдаг. Дагважанцанг доод өргөөний хувилгаанд (*Брайбүн хийдэд дээд, доод гэж хоёр өргөө байсны доод өргөө буюу Гандан-Потанд Далай Ламын дүрүүд, дээд өргөөнд Банчин Сономдагвын дүрүүд залардаг байв. Орч.*) тодруулж чадаагүй тул дээд өргөөний хувилгаан Сономгэлэгбалсангийн (*Банчин Сономдагвын хойд дүр. Орч.*) хойд дүрээр тодруулахаар арга башир хэрэглэн эцэстээ дээд өргөөнд залуулж чадсан байдаг. Тиймээс гэрч бичигт: *Гадхасагийн Ла-Ажалын хичээл зүтгэлээр Хувилгаан Гэлэгбалсангийн хойд дүрд хуурамчаар тодорсон тэрээр ерөөл буруудсан тангаргийн буг болоод...* хэмээн бичсэн байдаг. Сахиусны үйлс даатгал дотор нь:

*Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товрого болгогтун!* хэмээн Зургаан Мутарт Махгалаас Сэтав хүртэлх номын сахиус тэдгээрийн алдрыг тус тусад нь дуудаад үйлсээ даатгасан байдаг.

Энд Шүгдэн гарсан шалтгаан, түүний мөн чанар, үйлддэг үйл гурвыг нь үзүүлснээс *Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх* гэсэн нь Дээд төрөлхтөн хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр биш боловч хуурамчаар хойд дүрд нь тодорсон учир *Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх. Ерөөл буруудсан тангаргийн буг ад зэтгэр энэ бээр* хэмээхээр шалтгаан буруу ерөөлийн эрхээр гарсан болохыг танин барьсан бөгөөд *тангаргийн буг ад зэтгэр энэ бээр* хэмээхээр мөн чанарыг үзүүлсэн байдаг. Ойлгосон уу? Ерөөл буруудан тангаргийн буг болж төрсөн ч хорлол үйлддэггүй байсан бол гэмгүй. Тэр ганцаараа ерөөл буруудсан тангаргийн бугаараа суугаад байж болно. Үүнд нээх ялгаа алга. Үйлддэг үйл юу юм бэ гэвэл, *Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс* хэмээх энэ үг ямар мэт байна? V Далай Лам худал юм бичих үү? Миний хувьд V Далай Ламд сэтгэл итгэмжилж, сүжиглэдэг. Цаст Төвдийн оронд маш их ачтай хүн. Өнөөг хүртэл байсаар ирсэн, хятадын төрийг эсэргүүцэгч Гандан-Потан үүнийг V Далай

Лам байгуулсан юм. Төвдийн Бурханы шашны дамжлага урсгалуудыг алагчлалгүй тэтгэн зохиодог байсан бөгөөд илүүтэйгээр Гэлүгбын Сэра, Гандан, Брайбүн гурван их хийд өргөжин тэлсэн нь V Далай Ламын ач юм. Нинмавын хийд байсан эсэхийг мэдэхгүй ч сажа, гаржүд, жононгийн олон хийдүүд гэлүгбын хийд болсон байдаг. Тиймээс сажавын олон хүмүүс V Далай Ламд таалал ойр байдаггүй.

Миний язгуурын багшийн нэг сажавын хамба Санжайданзан "*Мөрийн Үр*" (Лам Брай) номыг зааж байхдаа, " *Мөрийн Үрийг* гүйцээн зохиосон нь V Далай Лам юм. Ер нь сажавын хувилгаад V Далай Ламд дургүй байдаг. Яагаад гэвэл, сажын олон хийдийг гэлүгбын хийд болгосон учраас тэр гэдэг. Гэсэн ч *Мөрийн Үрийг* зааж байхдаа V Далай Ламын гүйцээн зохиосон хэсэгт ирээд, за одоо V Далай Ламд толгойгоо бөхийлгөх хэрэгтэй шүү гэж хэлцгээдэг" хэмээн айлдаж байсан. Ямартай ч V Далай Лам гэлүгбын шашинд маш их ачтай хүн. Тэрээр худал хэлэхгүй. V Далай Лам ухаан дорой, тэнэг хүн огтхон ч байгаагүй. Маш их хурц ухаантай хүн байсан. Гурван язгуурын багш, ядам бурхад, номын сахиус нарын нигуурыг маш олонтой болгоодог байсан. Түүнчлэн мэргэ, зурхай гээд гадаад, дотоод, нууц гурвыг шинжилж чаддаг нэгэн байсан юм. Тийм хүн хаа хамаагүй янз бүрийн юм зарлиглахгүй. Ойлгосон уу? Тийм хүн, шалтгаан буруу ерөөлийн эрхээр мөн чанар нь тангаргийн буг болж төрөөд, үйлддэг үйл нь шашин хийгээд амьтан бүхэнд хорлогч гээд танин барьсан нэгнийг Гэлүгбын номын сахиус гэж хаанаас хэлж болох. V Далай Лам тэгж заригласан ч тэр нь өөр утгатай, өгүүлж байгаа шигээ утгыг илэрхийлж байгаа юм биш гээд V Далай Ламтай эн чацуу нэгэн бээр айлдсан бол өөр хэрэг. Жишээлбэл, V Далай Ламыг тийн зарлигласнаас хойш гэлүгбын дээдсүүдийн дотроос Дэчин Агвааначогдон Гандан Ширээт лам байхдаа, Гандан Жарзэ болон Шарзэ хийдийн зарим хамбын нөлөөнөөс болж Шүгдэнг тахин үйлдэх болсон хийгээд Шүгдэнгийн дүрийг бүтээсэн байсныг тэрээр Гандан ширээнд суусныхаа дараа үндсээр үгүй болгоод Шүгдэнг шүтэхийг болиулсан байдаг. Түүгээр үл барам Шүгдэнгийн сүм байсныг нураалгаж, шороог нь шороонд, чулууг нь чулуунд ялгуулсан байдаг.

Шүгдэнг тэгж хорьсон гэдгийг нь яаж мэдсэн бэ гэвэл, Дэчин Агваанчогдон тэр адил зарлиглаж байсныг тухайн үед Жанжаа Ролбийдорж бээр Гандан хийдэд саатаж байхдаа сонсож байсан тухай Туган Лувсанчойжинямын бичсэн Жанжаа Ролбийдоржийн намтарт гардаг. Намтарт нь *Шүгдэн* гэж бичсэн байсан. Үүнийг Дели дэх Шүгдэнгийн нийгэмлэг үгүйсгэдэг: Тэнд *Шүгдэн* гэж бичсэн нь хожим Энэтхэгт хэвлэхдээ *Шүгдэн* гэж шинээр оруулснаас биш тэр нь Шүгдэнг хэлж байгаа хэрэг биш гэсэн мэдэгдэл гаргасан. Үүнд нь би бас эргэлзээд Амдуд хэвлэгдсэн Жанжаа Ролбийдоржийн намтарт юу гэж бичсэнийг шалгаж үзэхэд *Шүгдэн* л гэж бичсэн байсан. Харин *Должал* буюу *Шүгдэн* гэхийг *Дойжал* гэж бичсэн байсан: энд даган орох *Ла* дагаврын оронд *Са* дагавар бичсэнээс биш Шүгдэнг хэлж байгаа нь ижилхэн, тодорхой байсан. Дэчин Агваанчогдонгийн намтар болон VIII Далай Ламын зохиосон Ёнзон Ишжанцангийн намтарт ч гардаг. VII Ванчин Богд Данбийням өвлийн ид хүйтний үеэр Дашлхүмбээс Лхасад морилсон бөгөөд VIII Далай Ламтай уулзсаны дараа дээд өргөөнд Ёнзон Ишжанцанд бараалхах үед Ёнзон Ишжанцан бээр Ванчин Богдын бараа бологч нарт хандан, "Та бүхэн өндөр дээд хувилгаан юм гээд тусгайлан хандаж болохгүй. (*Тухай үед Ванчин Богд Данбийням нас сүүдэр бага байсан. Орч.*) Нэгэнт л эглийн дүрийг үзүүлж байгаа болохоор жирийн хувраг хүн шиг л сургаж боловсруулах хэрэгтэй. Тусгайлан хандаж болохгүй" гэж сургаал айлдаад дараа нь, "Дашлхүмбэд шинэ сахиус гэгдээд байгаа тэр чөтгөр нэг л өдөр хуурна шүү!" хэмээн айлдсан байдаг. Шинэ сахиус гэж юуг хэлэв? Цамбыг эртнээс шүтдэг байсан. Шинэ сахиус гэж Шүгдэнгээс өөр нэгнийг хэлээгүй. Дашлхүмбэтэй яаж яваад барилдлагатай болсныг нь би мэдэхгүй. VIII Ванчин Богд Данбийванчүгийн намтарт, Гүнчавлинд Шүгдэнгийн ёр гарсан гэж бичсэн байдаг. Пүржог Агваанжамбын зохиосон "Гурван Их Хийдийн Гарчиг" доторх Гандан хийдийн түүхийг өгүүлдэг хэсэгт, *"Урьд энэ хийдэд Богд Зонховын зарлигаар тушаагдсан гурван төрөлхтөнг* (*Богд Зонховын шашныг сахихаар ам авсан Зургаан Мутарт Махгал, Дамжан-Чойжал, Лайжи-Шинжэ гурав. Орч.*) *сахиусанд*

*шүтдэг байснаас биш өөр янз бүрийн юм шүтдэг ёс байгаагүй. Богд Зонхов өөрийг нь багаас сахидаг байсан савдаг Мачэнг хүртэл хийдийнхээ дотор байлгалгүй, гадна сүмийг нь засcан байдаг. Гэсэн ч хожим Гандангийн их хувилгаад гэгдэгч гадна биедээ номын гурван хувцас өмссөн ч дотоод оюуныхаа мухрыг чөтгөрт тушаасан нугууд...*" хэмээн зарлигласан байдаг. Энд *чөтгөр* хэмээн Шүгдэнгээс өөр нэгнийг хэлээгүй. Бодит байдал ийм байна. Урьд нь би үүнийг мэддэггүй байсан. Зөөлөн Итгэлт Ялгуусны (*Богд Зонховын. Орч.*) шашны сахиус гэж эндүүрээд шүтдэг байсан. Би Шүгдэнг шүтэхээ болих шийдвэрээ Найчүн сахиусны амыг дагаж гаргаагүй. Өөр хэн нэгний үгийг ч дагаж шийдээгүй. Өөрөө шинжиж үзээд шийдсэн. Ингэж шинжихийн тухайд: би арван зургаан настайдаа шашин төрийн хэргийг үүрсэн. Өнөөг хүртэл буюу 74 нас хүртлээ шийдэх чухал асуудал гарвал гурилаар тэр мэт шинждэг байсан. Огтхон ч хуурмаг бууж байгаагүй. Ойлгосон уу? Тижан Ринбүүчи гурилаар шинжих үүнд маш их сэтгэл итгэмжилдэг байсан. Би шинжиж үзсэнийхээ дараа Ёнзон Лин Ринбүүчийд айлтгасан. Тэр үед багш маань энэ түүхийг айлдсан юм: V Далай Лам таалал төгсөж, амьсгал нь тасарсан байх үед Дэсрид Санжайжамц бээр, "Та нирваан болов гэж үү? Улаан ордонг барьж дуусаагүй байна. Таныг явчхаар би ганцаар юу хийж чадах?" хэмээн сэтгэл машид гансарч, энэлэн дуудах үед V Далай Ламын тасраад байсан амьсгал нь сэргээд, "Их хэргийг шийдэхдээ Ялгуусан Гэндүндүвээс (II Далай Лам) дамжсан Балдан Лхамын хөргийн өмнө гурилаар шинжиж шийдвэл хуурмаггүй. Бага хэргийг чи өөрийн ухаанаар шийдэж үйлдвэл ухаан хүрэхгүй гэх зүйл үгүй." хэмээн сургаал хайрласан гэдэг. Тийм учраас Балдан Лхамын хөргийн өмнө шинжих үүнд хуурмаг зүйл огтхон ч үгүй бөгөөд Найчүн сахиусны хувьд Лин Ринбүүчи, "Хэцүү бэрхшээл тулгарах үед ч хуурмаггүй байдаг" хэмээн айлдаж байсан. Мөн багш маань, "Шүгдэн Найчүнтай таардаггүйг сонсож байснаас Балдан Лхам хилэгнэдгийг сонсож байгаагүй юм байна. Гэхдээ гурилаар шинжих үүнд хуурмаг зүйл огтхон ч үгүй: үнэн байдаг." хэмээн айлдаад таалал амгаланг зохиосон юм. Ойлгосон уу?

“Далай Лам насныхаа дундаас хоёр ёнзон багшийнхаа таалалтай үл зохилдон, багшаа шүтэх ёсоо буруудуулсан” гэж танай Шүгдэнгийн нийгэмлэгээс гаргасан номд бичсэн байсан. Хоёр ёнзон багш маань надад зүйрлэшгүй их ачтай. Би хоёр багшдаа Шүгдэнгийн энэ асуудлын эхэн, дунд, эцэс гурвын байр байдал бүгдийг нь айлтгахад багш нар маань таалалдаа тунгаагаад, “Болсон байна” хэмээн айлдсан юм. Араар, далдуур нь юу ч хийгээгүй. Та нарын тэр яриа миний сэтгэлд бага зэрэг туссан. Өөрөөр юу гэж ч ярьсан та нарын эрх. Өнөө үед хятадын засгийн газар надад гэм зүүн өгүүлж, хүчтэй буруутгадаг. Танай Шүгдэнгийн нийгэмлэг ч гэсэн Далай Ламыг хуурамч гэдэг. Юу ч гэж хэлсэн надад хамаагүй. Урьд Ало Чойнзод бээр, “Далай Лам энэ нь гэлүгбын шашныг санаатайгаар сөнөөх ерөөлтэй төрсөн.” гэж бичиж байсан. Байдал ерөнхийдөө ийм байна.

V Далай Ламын эцэслэн шийдсэний хойноос Дэчин Агваанчогдон зэрэг олон мэргэд дагаж, V Далай Ламын зарлигийг үнэнд тооцож Шүгдэнг хорьж байсан. XIII Далай Лам ч мөн адил хориглодог байсан тодорхой түүх энэ байна гээд надад ярих зүйл бий. Урьд Брайбүн хийдийн тарнийн дацанд Шүгдэнгийн дүр байсныг XIII Далай Лам Шүгдэнг хорьдог учраас, гадагш нь гарга хэмээн тушааж байсан түүхийг XIII Далай Ламын сайд асан Нэүшар бээр надад ярьж байсан.

Мөн Зэ сургуулийн багш, Миндоллингийн нэг лам байсан. Нэрийг нь би мэдэхгүй. Тэрээр үе үе XIII Далай Ламд бараалхаж уулздаг байж. Нэг өдөр сургуулийнх нь бичээч нэгэн хөрөг түүнд өгөөд, Далай багшаар равнайлуулж өгөөч гэж гуйсан юмсанж. Тэрээр нэг өдөр өнөөх хөргийг авч яваад XIII Далай Ламтай уулзах үедээ үзүүлж, равнайлж хайрлана уу хэмээн айлтгасанд, XIII Далай Лам хөргийг дэлгэж үзмэгцээ нүүр нь амарлингуй бус болж, үүнийгээ хурдан аваад гар хэмээсэн гэдэг. Өнөөх лам машид эмээж, хөлс нь цутгасаар гарч ирээд хөргийг үзэхэд доод хэсэгт нь Шүгдэнг зурсан байж. Энэ түүхийг Миндоллингийн тэр ламаас өөрөөс нь сонссон хүн надад ярьсан юм. Тиймээс өмнөх дүрийн Далай Лам таалдаггүй байсан нь тодорхой. Жирийн нэг газар орны тэнгэр, савдаг, ад дон мэтэд үздэг бол зүгээр орхиж

болох ч, тэгэлгүй Зөөлөн Итгэлт Ялгуусны шашныг сахигч хэмээн гэлүгба нийтээрээ шүтэх хэрэгтэй мэт болж байгаа нь хирээс хэтэрсэн хэрэг. Би шинжиж үзсэнийхээ дараа Тижан Ринбүүчи багшдаа ийн айлтгасан юм: "Шарзэ дацан Агваанцүлтэмээс авахуулан шүтдэг байсан. Голлон Павонка Ринбүүчи шүтдэг байсан. Үүнд болохгүй зүйл үгүй ч Балдан Лхамыг ээж мэт, Жалбуу Гүн-Ааг түүний шадар туслах мэтээр, Шүгдэнг Жалбуу Гүн-Аагийн туслах мэтээр шүтвэл сайн. Түүнээс өөрөөр Шүгдэнг голлож шүтвэл үйлс зохиолд тань барцад гарахаар байна хэмээн айлтгасан. Тижан Ринбүүчи багш маань ч үүнийг таалалдаа болгоогоод, "тэр мэт үйлдэх болно" хэмээн зарлигласан юм. Ойлгосон уу? Шүгдэнг хориглосон маань бодлогогүй хийсэн зүйл огтхон ч биш юм шүү! Би бодлогогүйгээр юу хийсэн бэ гэвэл, Шүгдэнг шүтсэн маань бодлогогүй хэрэг байсан.

V Далай Ламын эцэслэн шийдсэний араас XIII Далай Лам дагаж Шүгдэнг хориглосных нь эцсийг одоо би гүйцээж байна. Та нар олноороо Шүгдэнд амиа тушааж даатгадаг. Үнэндээ бол догшин хилэнтнийг боол болгохдоо амийг нь егүзэр бээр зүрхнийхээ Хум буюу Хум үсгийн доор байрлуулдаг. *"Гомбын Нигуурын Нууц Хөтөлбөр"*-т (Гомбу Шалжи Сантид) номын сахиус нугуудын амийг Хум үсгийн төрх байдалтайгаар татаад хүйснийхээ хөрөнгө үсгийн доод дэвсгэрт шингээх тэр адилын зоригдлоор үйлддэг. Энэ нь сахиусны амыг нааш хурааж буй хэрэг юм. Та нар харин өөрийнхөө амийг цааш тушааж сар бүр тахиж үйлддэг. Сарынхаа тахилыг тасалбал Шүгдэнгийн хорлол ирнэ гэж маш ихээр айцгаадаг. Бурхан Багш бол бидний Багш, Ядам, Чойжон юм шүү! Ойлгосон уу?

*Алин бээр таалал нигүүлсэхүйгээр ойр бариад*
*Алимад буруу үзэл бүхнийг тэвчүүлэхийн тулд*
*Аугаа дээдийн номыг үзүүлэн зохиогч*
*Ачит Гоодам түүнд мөргөмүй* хэмээсэн энэ нь бидний *Багш* юм. Онцгой багш бол Зөөлөн Итгэлт Их Богд Зонхов юм. Бид нарт тэнгэр, лус, буг чөтгөр, албин савдгийн аль нь ч хэрэггүй. Ойлгосон уу? Дамжан-Чойжал, Зургаан Мутарт Махгалын магтаал сэржмийг нь уншвал үүнд болохгүй зүйл байхгүй. Балдан Лхам, Дамжан-Чойжал, Махгал сэлт бээр

тоохгүй гэсэн бол Богд Зонхов бээр ч тоохгүй. Ойлгосон уу? Хүнд хэцүү үе тохиолдоход сахиусны сэржим уншихаас биш мигзэм уншдаг хүн ховор болсон байна. Өнөөдөр би ингэж тодорхой тайлбарлаж байгаа нь та хоёрыг мэдэж, сэтгэл итгэмжлэл олоосой гэсэндээ юм. Түүнээс биш сүр үзүүлж, тушааж байгаа юм биш. V Далай Ламаас авахуулаад шашин, төрийн үүргийг үүрч байсан Далай Лам нарын үйл хэргийг би залгуулах үүрэгтэй. Павонка Ринбүүчи чухал биш. Дашчойлингийн багахан хийд, нийт бусын шавь нар тэдгээрийг тэтгэж байснаас биш шашин, төрийн хэргийг үүрч байгаагүй. Та нар жинхэнэ гэлүгбын шашинтан хүн шиг байж, Богд Зонховын таалал лугаа зохилдсон үйлийг үйлдэх нь маш чухал шүү! Та нарыг хийдэд нь буцааж оруул гэж тушааж чадахгүй. Тушаах хүсэл ч алга. Хэсэг хугацаанд тайван суу! Ойлгосон уу? Шүгдэнгийн нийгэмлэг Далай Ламыг эсэргүүцэж, шүүхэд өгч байсан. Намайг гадаадад явах үед Шүгдэнгийн нийгэмлэг маш хүчтэй эсэргүүцдэг бөгөөд боломж гарвал бараг алах байх гэмээр үйлдлүүд хийдэг нь өрөвдмөөр. Би тэднийг энэрч, өрөвдөхөөс биш уурлаж өш хонзон санадаггүй. Толгой нь эргэж хэдхэн хүний эрхэнд орсон тэд нар нигүүлсэхийн орон юм. Төвдийн ард түмэн амиа зольж байдаг. Төвдөд Чавдогийн их хийд хийгээд Враг-яв зэрэг нутгуудад юу ч болоогүй юм шиг тайван сууж байна. Энэтхэгт танай Бомра аймгийн Шүгдэн шүтдэг лам нар болон Гандангийн Докан аймгийнханд ямар ч сэтгэл зовнисон зүйл байдаггүй. Иймэрхүү байдалтай байж байгаа нь гомдмоор. Төвдийн зургаан сая хүн, Бурханы шашин, төр засгаасаа илүү сахиус гэгдэх бугийг чухалд тооцож байгаа нь маш том алдаа юм. Тийм учраас олон хүмүүс гомдож буй энэ үед би шууд тушаах нь сайн биш. Хэсэг хугацаанд хүлээ. Ойлгосон уу? Ёс зохилдонгуй, тийн ариун санаагаар тайван сууж бай. Аяндаа болно. Би ч гэсэн ярьж болох байх. Хэсэг хугацаанд Сэра хийдийн цогчин хуралд хурахгүй бол сайн байна. Ойлгосон уу? Ном заахад гэмгүй. Та өөрөө цааш явахын хэрэг байхгүй: шавь нар өөрсдөө нааш ирэх болно. Шавь нартаа ч гэсэн Далай Ламын өмнө авла орхилыг ёсчлон үйлдсэн гэдгээ тайлбарлах хэрэгтэй. Олон хүмүүс мэдэх болно. Ойлгосон уу? Хүмүүс итгэж, тайвширвал надад ч

гэсэн хэлэхэд амар байх болно.

# 2009 оны 1-р сарын 11-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн ариун орон Варанасид *“Бодьсадвын Явдалд Орохуй”* хийгээд *“Бясалгалын Дунд Зэрэг”* номын хөтөлбөр хайрлах үедээ Гималайн бүс нутгийн Ладак, Монба хийгээд Бутан, Балба зэрэг орнуудаас хүрэлцэн ирсэн сүсэгтэн олонд Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Энэ ташрамд хэлэхэд, Та бүхэн бүгдээрээ Шүгдэн гэж сонссон байх. Өнөөдөр энд Гималайн бүс нутгийн олон үндэстнүүд цугласан байгаа тул бага зэрэг тайлбарлая гэж бодлоо. Өчигдөр ярьж байсанчлан бид бүгдийн тахил, мөргөлийн орон, аврал, итгэл, өмөг түшиг нь Бурхан Багш юм. Тэгээд дараа нь тантрын дөрвөн аймгийн Ядам Бурхадын чуулган орохоос биш их сүртэй хүний зүрх, илд барьсан сахиуснуудыг тэдгээрийн дунд оруулж тооцдоггүй. Бид нар Бурханы номыг сайн мэддэггүй үед, урьд Ладакийн зарим нутагт сахиусны өрөөнд хар хонины зүрх сугалж хилэнцээ наманчилдаг заншил байсан тухай сонсож байсан. Үнэн эсэхийг нь сайн мэдэхгүй. Ладакууд та нар ичсэний хэрэггүй. Сахиусны өрөөнд Бурхан Багшийн лагшин дүр байдаг. Хамгийн чухаг нь тэр л юм. Түүнээс илүүгээр нутаг орныхоо тэнгэр, савдгийг шүтэж болно гэж үү? Тэднийг Бурхан Багшаас илүүд тооцон шүтдэг мэт байдаг. Жишээ нь олонх хүмүүс хийдийн доторх шүтээнүүдэд мөргөх үедээ Бурхан Багшийн лагшин дүрийн өмнө ирээд аварч өршөө гэж боддог байх. Цааш сахиусны өрөөнд орохоороо амьсгалаа намсгаж, амаа гараараа хааж явдаг. Сахиусны өрөөний үүдний хажуу ч гэсэн сүрдмээр дүртэй соёо нь арзайсан зүйлс зурчихсан, хүмүүст айдас төрүүлмээр байдаг. Тэдгээр нь алдаа юм. Надад огтхон ч сайхан харагддаггүй. Үнэн хэрэгтээ бидний сэтгэлээ тушаах орон нь Бурхан Багш юм. Нигүүлсэл хийгээд адис жинлавыг Бурхан Багш хайрлана. Авралыг ч Бурхан

Багш хайрлана. Түүнээс илүү сахиусыг чухал гэж үзэх нь алдаа юм. Сахиусанд ертөнцийн хийгээд ертөнцөөс гэтэлсэн хоёр төрлийн сахиус байдаг. Ертөнцөөс гэтэлсэн сахиуснууд дариудын үйлсийг бүтээх нь тийм ч хурдан биш, ертөнцийн хилэнтэнгүүд үйлс маш хурдан бүтээдэг гээд худалдаа наймаанд явахдаа тэдгээрт тахил үйлддэг. Өөрт таагүй зүйл тохиолдсон ч тэдгээрт соёрхол тавихаас биш Бурхан Багшид сүжиглэж, аврал одуулах төдийг ч санадаггүй мэт байдаг. Энэ нь түгээмэл алдаа мэт харагддаг. Шүтдэг тэнгэр, сахиус нь ч Бурхан Багш хийгээд түүний шавь, мэргэн бүтээлчин, дээд төрөлхтөн нараас зарлиг сонсож, сахиусанд тушаагдсан нэгэн бол өөр хэрэг. Тийм биш бол будлиантай.

Должал буюу Шүгдэн гэгч гарсан үе нь V Далай Ламын үе юм. Шүгдэн V Далай Ламын үед гарсан тул түүний тухай хамгийн сайн мэддэг хүн нь V Далай Лам байсан юм. Хүндэтгэлийн бус энгийн үгээр хэлбэл, тэрээр болж буй юмсыг сайн мэддэггүй, ухаан муутай нэгэн байгаагүй. V Далай Лам маш их эрдэмтэй, хурц ухаантай хүн байсан. Далдын юмс нугуудыг ч тодорхой болгоодог байсныг нь гурван язгуурын Ядам Бурхадын нигуурыг үргэлжид болгоодог байснаар нь мэдэж болно. Мөн ая дан, зурай зурлага хийгээд мэргэ төлгөнд машид мэргэн нэгэн байсан. Тэр адилын гэлэн бээр Шүгдэнг юу гэж танин барьсан бэ гэвэл, V Далай Ламын зохиосон нэгэн гэрч бичиг байдаг. Шүгдэнг хатуу үйлээр гэсгээн үйлдэх үедээ V Далай Лам тэр бичгээ бичсэн юм. Тэнд:

*“...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Шашин хийгээд амьтан бүхэнд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгохтун...”*

хэмээн Зургаан Мутарт Махгалаас авахуулаад Сэтав хүртэлх сахиуснуудын нэрийг дуудан үйлсээ даатгасан байдаг.

Энэ дөрвөн мөртөөр Шүгдэн гарсан шалтгаан, түүний мөн чанар, үйлддэг үйлийнх нь ялгамжаа сэлтийг үзүүлдэг. Шалтгаан нь юу вэ гэвэл, *Буруу ерөөлт...* гэдгээр буюу буруу ерөөлийн эрхээр төрсөн. Энэ нь Шүгдэн гарсан шалтгааныг зарлиглаж байгаа юм. *...тангаргийн буг ад зэтгэр...* гэснээр Шүгдэнгийн мөн чанарыг үзүүлдэг. Буруу ерөөл тавьсны

эрхээр тангаргийн буг ад зэтгэр болон төрсөн нь тийм ч гэмтэй зүйл биш юм. Харин үйлддэг үйл нь юу вэ гэвэл, *...Шашин хийгээд амьтан бүхэнд хорлож үйлдвээс...* хэмээснээр шашин, амьтанд хорлол үйлддэг нэгэн болохыг зарлигласан байдаг. V Далай Ламыг худал зарлигласан гэдгийг батлахад бэрх юм. Тэгж батлахын тулд V Далай Ламаас илүү эрдэм чадалтай байх хэрэгтэй. V Далай Ламаас эрдэм чадлаараа илүү гарсан нэгэн бээр, V Далай Ламын зарлигласан нь буруу гэж хэлэхээс биш V Далай Ламтай эрдэм чадал эн чацуу биш нэгэн бээр түүний эцэслэн шийдээд зарлигласныг шууд үгүйсгэж хаанаас чадах.

Эхэндээ би Шүгдэнг хичээн шамдаж шүтдэг байсан. Хожим 1974 оны үед нэг эргэлзээ төрсөн юм. Тэр үед хоёр багш маань хоёулаа лагшин тунгалаг байсан. Эргэлзээгээ арилгахын тулд удаа дараалан шинжилж, судалсан. Эцэстээ Шүгдэнг шүтэх нь сайн биш гэдгийг мэдээд хоёр багшдаа, ингэж, ингэж шинжиж үзэхэд ийм, ийм үр дүн гарлаа гээд бүгдийг айлтгасан бөгөөд тэр үед V Далай Ламын гэрч бичгийг олоогүй байсан. Тэр үед хоёр багш маань хоёулаа, шинжиж судалсан чинь маш сайн болсон байна. Хуурмаг зүйл алга. Болсон байна гэж айлдсан юм.

Лин Ринбүүчи багшийн хувьд Шүгдэнг огтхон ч шүтдэггүй байсан. Тижан Ринбүүчи багш Павонка Ринбүүчигээр дамжин Шүгдэнг шүтдэг байсан. Гэсэн ч тэр үед би Тижан Ринбүүчийд бүгдийг нь айлтгасан. Багш маань, *шинжиж үзсэнд чинь хуураг зүйл огтхон ч байхгүй. Гарцаагүй нэг учир шалтгаан байгаа юм байна. Тиймээс шинжиж үзээд юу гэж шийдсэн яг түүгээрээ шийд* гэж айлдсан. Багш нар маань тийн айлдаж зөвшөөрч байснаас биш багшийгаа таалал барсны дараа би санаж бодож явснаа хэрэгжүүлсэн хэрэг огтхон ч биш юм.

Тиймээс бид нар мэдсэн мэдээгүй хамаагүй, Шүгдэнг шүтсэнээр тус гарахгүй. Өөрөө бодож шийдээд, Шүгдэнг шүтвэл тустай, буянтай гэж үзвэл энэ нь тухайн хүний хэрэг. Юугаа шүтэх нь хувь хүний өөрийн эрх. Өөрөө мэдсээр байж хор идэж байгаа бол өөрийнх нь л мэдэх хэрэг гэхээс өөр хэлэх зүйл байхгүй. Шүтэх шүтэхгүй нь хувь хүний эрх. Хэдий тийм боловч учир явдлыг нь сайн мэдэж ойлгоогүйн

эрхээр шүтэж байгаа бол сайн биш юм. Эдгээрийг та бүхэнд тайлбарлая гэж бодож байсан юм аа.

# 2010 оны 1-р сарын 8-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Бодьгаяад *“Ертөнцөөс Хэтэрсэн Магтаал”*, *“Бодь Мөрийн Зул”*, *“Зогчэн – Сэтгэлийн Алжаалыг Сэргээгч”*, *“Бодь Мөрийн Хураангуй Утга”*-ын хөтөлбөр болон *“Жанрайсигийн Авшиг”* хайрлах үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Энэ удаад Жанрайсигийн авшиг хүртээх учир Шүгдэнгийн тухай тайлбарлая гэж бодлоо. Энд төвдүүд маш ихээр ирсэн байна. Мөн гадаадын иргэд, түүнчлэн хятадаас ном сонсохоор олон хүн ирсэн байна. Тиймээс хуран цугласан олны өмнө тайлбарлая гэж бодсон юм. Юу вэ гэвэл, хэсэг хугацаанд Шүгдэнг тахиж шүтэх явдал их гарсан. Түүнийг Богд Зонховын шашны маш чухал сахиус гэж санаад би ч гэсэн бусдыг дуурайн шүтдэг байсан.

Аажмаар гарал үүслийг нь шинжилж үзэхэд тэр нь шашны сахиус биш байсан. Энэ тухай бүгдийг нарийвчлалгүйгээр, гол утгыг нь хурааж яривал, Шүгдэн нь V Далай Ламын үед гарсан. V Далай Ламтай таарч нийцээгүй нөхцөл байдлын улмаас гарсан байдаг. V Далай Ламын намтар “Дүгүлийн Гой-сан”-д Шүгдэнг хатуу үйлээр гэсгээх үедээ гэрч бичиг зохиосон тухай гардаг. Тэр гэрч бичиг V Далай Ламын гадаад зарлигийн “Да” ботийн сахиусны үйлс даатгалын хэсэгт байдаг. Гэрч бичигт юун тухай айлдсан байдаг вэ гэвэл, эхний жижиг үсгээр бичигдсэн өмнөтгөл хэсэгт: ...Гадхасагийн Ла-Ажалын хичээл зүтгэлээр Хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүрд хуурамчаар тодорсон тэрээр (эцэстээ) ерөөл буруудан тангаргийн буг болоод... хэмээн өгүүлсэн байдаг. Тэрээр олон амьтанд хорлол хөнөөл үйлдсэн учир хатуу үйлээр гэсгээн зохиосон тухай мөн өмнөтгөл хэсэгт өгүүлдэг.

Жижиг үсгээр бичсэн тэр хэсгийн гол утга нь: Гадхаса

гэдэг нь Дагважанцангийн төрсөн нутаг бөгөөд Ла-Ажал нь Дагважанцангийн ээжийнх нь нэр юм. Ла-Ажал нь их зальжин хүн байсан бөгөөд түүний хичээл зүтгэлээр Хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүрд хуурамчаар тодорсон хэмээсний Хувилгаан Сономгэлэгбалсан нь Банчин Сономдагвын хойд дүр бөгөөд Дагважанцан Хувилгаан Сономгэлэгбалсангийн жинхэнэ хойд дүр биш боловч аз завшаан, башир аргын эрхээр хойд дүрээр нь тодорсон байдаг. Тийм учраас Хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүрд хуурамчаар тодорсон хэмээсэн бөгөөд эцэстээ Винайг Баригчийн (Банчин Сономдагва. Орч.) хувилгаан дүр гэгдэх болсон юм.

Хожим тэрээр муу нөхцөл хийгээд буруу ерөөлийн эрхээр тангаргийн буг болж төрсөн тул гэрч бичигт Зургаан Мутарт Махгал тэргүүтэн билэг чанар төгөлдөр сахиуснууд хийгээд ертөнцийн гол гол догшин сахиуснуудын алдрыг дуудан үйлсээ даатгасан нь:

*“...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун...”*

хэмээн Махгалаас авахуулан сахиуснуудын алдрыг дуудаад сахиусны ерөөл зохиосон байдаг.

Дээрх шүлгийн гол утга нь юу вэ гэвэл, *...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх* гэсэн нь Хувилгаан Сономгэлэгбалсангийн хойд дүр биш байж хойд дүрд хуурамчаар тодорсон учир *дээд бус хуурмаг дээд* гэж зарлигласан бөгөөд Дагважанцан гэсэн нь түүний жинхэнэ нэр юм.

Дагважанцан нас бараад буг болсон шалтгаан нь буруу ерөөл бөгөөд түүний эрхээр тангаргийн бугийн мөн чанартай болж төрсөн юм. Тэр нь ч, тангаргийн буг Шүгдэн болж төрснийхөө дараа IV Ванчин Богд Лувсанчойжижанцангийн хийд болох Зангийн Дашлхүмбэд очиход Дашлхүмбийн Намсрай сахиус нөхөд сэлтийн хамтаар хийдээ хамгаалж зогсоод оруулаагүй тул бага зэрэг догшрон сажавын хийд уруу явсан бөгөөд тэр үедээ сажавын их эзэнд (Дагти Сономринчин. Орч.) дүрсээ үзүүлсэнд,

сажавын эзэн, чи хэн юм хэмээн асуусанд, би гэлүгбын тангаргийн буг байна хэмээн өөрөө өөрийнхөө мөн чанарыг хэлсэн байдаг. Тиймээс гэрч бичигт, *Ерөөл буруудсан тангаргийн буг ад зэтгэр энэ бээр* хэмээн зарлигласан байдаг. Түүний үйлддэг үйл нь юу вэ гэвэл, *Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс* хэмээн шашин хийгээд амьтан бүхэнд хорлон үйлдэж байна гэсэн үүгээр үйлддэг үйлийг нь үзүүлж байна. Тиймээс Шүгдэн гэж юу юм бэ гэвэл, шалтгаан буруу ерөөлийн эрхээр тангаргийн бугийн мөн чанарт төрсөн, шалтгаан түүний үр буюу үйлддэг үйл нь шашин хийгээд амьтан бүхэнд хорлон үйлдэгч мөн тул итгэл аврал нь болж өмгөөлөлгүй үнсэн тоsорго болгогтун хэмээн зарлигласан юм.

Анхандаа би үүнийг мэддэггүй байсан. Хожим олон асуудал гарах болж, судалж үзэхэд V Далай Ламын зохисон энэ гэрч бичгийг олсон юм. Гэрч бичгийг тухай үеийн байдлыг бүгдийг нь мэддэг хүн зохиосон. V Далай Лам магад утгадаа Номын Хаан Тисрон-Дэзангийн үйлсийн хувилгаан мөн бөгөөд Ловон Бадамжунай бээр V Далай Ламын тухай эш үзүүлсэн байдаг. Түүнчлэн тэрээр эглийн шавь нарын үзэгдэлд ч гэсэн гурван язгуурын Ядам Бурхадын нигуурыг үргэлжид болгоодог байсан учир *"Арилсан Үзэгдлийн Номын Аймаг"*-г зохиосон юм. Мөн чойрын гол таван боть номд мэргэшсэн бөгөөд түүнчлэн нинмава болон сажавын олон номыг сонссон байдаг. Дуун ухаан, яруу найраг тэргүүтэн таван ухаан, янагуух үнэн хийгээд үнэмлэхүй үнэнийг оносон билгүүн тэргүүтэн эрдэм бүхэн бүрдсэн маш хурц ухаантай нэгэн байсан.

Бурханы номын үүднээс хэлбэл, эш онолын эрдэмтэй, гурван язгуурын Ядам Бурхадын нигуурыг үргэлжид болгоогч, эглийн шавь нарийн үзэгдэлд ч маш хурц ухаантай тэр адилын Шагжийн гэлэн хүн худал хэлэхгүй байх гэж бодож байна. Тиймээс V Далай Ламтай эн тэнцэх эрдэм чадалтай дээд төрөлхтөн гарч ирээд, V Далай Ламын энэ зарлиг тийм утгатай биш гээд шинээр тайлбарлах нэгэн гарч ирэх хүртэл V Далай Ламын зарлигийг үнэнд тооцох хэрэгтэй юм. Миний хувьд ч гэсэн V Далай Ламын эцэслэн шийдсэнийг хүлээн зөвшөөрөхөөс өөр хэлэх юм байхгүй.

Урьд нь би Шүгдэнг шүтдэг байсан. Шүгдэнг шүтсэн тэр нь эндүүрэл болохыг мэдэж, гэмшин үйлдээд шүтэхээ больсон. Шүтэхээ болихдоо ч удаа дараалан шинжилж үзээд шийдвэрээ гаргасан. Тэгж анх би шүтэхээ больсон юм. Өөр хэн нэгэн шүтэхээ болих хэрэгтэй гэж сануулсны улмаас шийдвэрээ гаргаагүй. Тэр үед Гандан Жанзэ дацанд өлзий бусын олон ёр гарч байна хэмээн анх Тижан Ринбүүчигээр шинжлүүлсэн байдаг. Тэр нь ч, тухай үед Жанзэ Цорж байгаад хожим Гандан Ширээт болсон Пара аймгийн лам Жамбалшэнпэн бээр Жанзэ дацангийн ажил үйлс бүтэхгүй байгааг шинжиж өгөхийг Тижан Ринбүүчийд айлтгасанд, айлтгалын хариуд, сахиус хилэгнэснээс болж хэмээн зарлиг хайрласан гэж Жамбалшэнпэн надад хэлж байсан. Түүний дараа надаас ч гэсэн шинжиж өгөхийг хүсээд хөрөнгө нэгийг ирүүлсэн бөгөөд Жанзэ дацан үнэхээр Богд Зонховын эш онолын шашныг баригч том дацан учир би ч гэсэн чухалчлан шинжиж үзсэн. Жанзэ дацанд өлзий бусын ёр олон гарсан нь сахиус хилэгнэснээс болсон эсэхийг шинжихэд сахиус хилэгнэснээс болсон гэж буусан бөгөөд сахиус хилэгнэсэн нь Шүгдэнг шүтсэнээс болсон уу, эсвэл өөр шалтгааны улмаас болсон уу гэж шинжихэд Шүгдэнг шүтсэний эрхээр сахиус хилэгнэсэн гэж буусан. Тиймээс тэр үед Жанзэ дацангийн хамба болон Намжал дацангийн хамба хоёрт, “Төлөг ингэж буулаа. Гэсэн ч хариу бичигтээ сахиус хилэгнэсэн байгаа тул Балдан Лхамын тахилга үйлдэх хэрэгтэй гэснээс өөр юм тодорхой бичсэнгүй. Жинхэнэ учир шалтгаан нь ийм байна. Та хоёр холбогдох хүмүүстэй нь уулзаж тайлбарлаж хэлбэл сайн байна” гэж хэлсэн юм.

Аажмаар асуудал улам хурцдаж, эцэстээ цанидын сургуулийн багш хийгээд хятад хэлний орчуулагч: хятад хэл маш сайн, номдоо ч сайн хүн байсан. Мөн өөр нэг хүний хамтаар гурван хүн алуулсан. Тэр мэт олон бэрхшээл үүссэн. Тэр үед Дарамсалагийн цагдаагийн газрын мөрдөгчид мөрдлөг хийсний эцэст гэмт этгээдүүд Дели дэх Шүгдэнгийн нийгэмлэгээс ирсэн болохыг илрүүлж, шүүхэд шилжүүлсэн байдаг.

Нэг гол зүйл нь, Төвдөд намайг Шүгдэнг хорьж эхэлснийг мэдэх үед, “Энэ нь Далай Багшийн жинхэнэ санаа

биш. Нинмавынханд найр тавихдаа Шүгдэнг хорьж байгаа юм. Улс төрийн шалтгаантай хорьж байна." гэсэн цуу яриа гаргасан байдаг. Шүгдэн хорьсон учир шалтгаан тийм биш болохыг өмнө нь хэлсэн. Сэтгэл гарган судалж, шинжлээд шийдсэн зүйлийг минь гуйвуулан ярих болсон тул тодорхой тайлбарлахаас өөр аргагүй болсон юм. Улмаар байдал бүүр ч тодорхой болсон.

Тиймээс шашин ном шүтэх эсэх нь хүний эрх. Тэнгэр шүтнэ үү, буг чөтгөр тэргүүтнийг шүтнэ үү, өөрсдийн л мэдэх хэрэг. Гэхдээ мэдэхгүйн эрхээр шүтэж байгаа бол тайлбарлаж өгөх нь миний үүрэг. Миний зүгээс үүнийг хэлдэг. Тайлбарлаж хэлснийг минь сонсох, сонсохгүй нь өөрсдийн бодох хэрэг. Анхнаасаа би, миний хэлснийг сонсох, сонсохгүй нь өөрсдийн чинь бодох хэрэг гэж хэлж байсан. Бодит байдлыг би олон удаа тайлбарласан. Мэдсээр байж хэлэхгүй өнгөрөөх нь миний алдаа. Мэдсэнээ тайлбарлаж хэлэх нь миний үүрэг юм. Тайлбарлаж хэлснийг минь сонсохгүй гэвэл өөрсдөө л хохирохоос, надад ямар ч ялгаа байхгүй.

Багш шавийн тангараг чухал учир Шүгдэнг шүтдэг хүмүүс авшиг хийгээд сахил санваар хүртэх тэргүүтнийг айлтгавал таарахгүй. Өчигдөр, уржигдар хоёр авла орхилыг ялгасан Бурханы номыг тайлбарласан учир түүнийг багшийн хуран мэдэл агуулалгүйгээр сонсоход болохгүй зүйл үгүй. Одоо сахил өгч, авшиг хүртээх учир багш шавийн хуран мэдлээр үйлдэх хэрэгтэй. Тиймгүйгээр үйлдэж болохгүй. Тиймээс энэ тухай тодорхой ярья гэж санаад хэлж байгаа юм шүү. Та нар бүгдээрээ ойлгосон уу?

Төвдөөс ирсэн хийгээд Энэтхэгт байдаг хүмүүсийн ихэнх нь миний судалж, шинжлээд тайлбарласанд бүгдээрээ сэтгэл итгэмжлэн, авла орхилыг ёсчлон үйлдсэнд баярлалаа гэж хэлье. Их хийдүүдийн хуврагууд ч гэсэн маш сайн байсан. Зарим нэг нь зан байдлаа өөрчилж байсан ч тэр нь өөр хэрэг. Ихэнх нь миний ярьж байгаад учир шалтгаан байгааг харж, хүндэтгэн сонссонд баярлалаа гэж хэлье.

Хятад үндэстэн та бүхний дотор Тайвань болон эх газрын хятадад Шүгдэнг шүтэгч зарим хүмүүс их хичээл зүтгэл гарган олон үйл ажиллагаа хийж байгаа мэд байдаг.

Илүүтэйгээр Хятадын төрийн зүгээс, Далай Лам Шүгдэнг хорьж байгаа учир, түүний хорьж байгаа зүйлийг ихэд чухалчлан үзээд засгийн газрынхаа зүгээс Шүгдэнгийн нийгэмлэг болон Шүгдэнг шүтэгчдийг онцгойлон дэмждэг. Төвдөд, нэгэн үе Шүгдэнг шүтдэг байсан ч хожим шүтэхээ больсон хийдүүдээр явж Шүгдэнг шүтэхээ болих нь буруу. Шүтэх хэрэгтэй хэмээн ухуулж, дэмжлэг үзүүлдэг. Үүний улмаас асуудал бага зэрэг хурцдаж, улс төрийн аястай болсон. Тиймээс Хятадаас ирсэн сүсэгтнүүдэд энэ тухай тодорхой ярья гэж бодсон юм.

Түүнчлэн барууны орны сүсэгтнүүд ч олон ирсэн байна. Та бүхэн ч гэсэн бодит байдлыг мэдэх хэрэгтэй. Тэр нь ч, бүх талын байр байдлыг мэдээд өөрсдөө шинжилж үзэх хэрэгтэй. Жишээлбэл, V Далай Ламын зарлигуудыг та бүхэн судалж үзэх хэрэгтэй бөгөөд хоёрдугаарт, олон нийтийн мэддэг, миний Шүгдэнг хориглох болсон нэг шалтгаан нь, би Бурханы шашны дамжлага урсгалуудыг алагчаалалгүй үзэх үзлийг ихэд чухалчилдаг. Бурхан Багшийн шавь нар хийгээд тэр дундаа Цастын оронд Бурханы шашинтнууд хоорондоо хол байхын хэрэг огтхон ч алга. Шүгдэнг шүтдэг тэр хүмүүс, Шүгдэнг шүтдэг гэлүгбын шашинтан хүн гэртээ "Бадамгатан" тэргүүтэн нинмавын номыг хадгалах юм бол Шүгдэнгийн хорлол ирнэ хэмээн цээрлэдэг. Сон Ринбүүчи маш их эрдэмтэй, сайн хүн байсан. Гэсэн ч урьд нэгэн үе Сон Ринбүүчи Шүгдэнг их хүчтэй шүтдэг байсан. Шүгдэнг шүтвэл худалдаа наймаа, ажил үйлс бүтнэ хэмээн Шүгдэнгийн бумба бүтээдэг байв. Тиймээс зарим төвд суурингийн айлууд Шүгдэнгийн бумба бүтээлгэж, гэртээ байсан нинмавын номыг өөр айлуудад тараан, манайх одоо жинхэнэ цэвэр гэлүгба боллоо хэмээн өгүүлэх зэрэг байдал гарч байв. Ориссагийн нэг айл тийн хэлж байсан гэдэг.

Би өөрөө ч гэсэн урьд "Тантрын Нууц Шим" номын эш хөтөлбөрийг сонсохыг маш их хүсдэг байв. Күнү Лама Данзанжалцангийн дэргэдээс ном сонсож эхэлсний дараа Ринбүүчигээс дахин "Тантрын Нууц Шим"-ийг сонсох хүсэлтэй байгаагаа Лин Ринбүүчийд айлтгасан юм. Лин Ринбүүчи, болгоомжлох хэрэгтэй гэж зарлигласан. Ёнзон Ринбүүчи бага зэрэг болгоомжлон: намайг "Тантрын Нууц

Шим"-ийг сонсвол Шүгдэнгийн хорлол ирнэ гэж эмээсэн хэрэг. Тэр үед надад шашин номоо чөлөөтэй шүтэх эрх байгаагүй. Хожим Шүгдэнг хорьсны дараа л би шашин номоо чөлөөтэй шүтэх эрхтэй болсон. Шашин ном шүтэх эрх чөлөөг булаагчийг, хоёр хоригдохууныг сайтар хорь гэдэг шиг хорьсон. Зарим хүмүүс Шүгдэнг хорьсноор шашин ном шүтэх эрхтэй харшилж байна гэдэг. Нэг талаасаа энэ нь шашин номын яриа огтхон ч биш юм. Ганжуурын зуун найман боть, данжуурын хоёр зуун хорь орчим ботиудыг үзэхтүн. Тантрын хэсэгт Дөрвөн Мутарт Махгал зэргийг л тантар дотор зарлигласнаас биш ертөнцийг эгэл буг, хилэнтэн нарыг шүт гэж ганжуур, данжуурын гурван зуу гаруй ботиудын дотор гардаггүй. Манай Төвдөд тэнгэр лус тахих зэрэг ихээр дэлгэрээд Бурхан Багшаас газар орны тэнгэр лусыг илүүд үздэг мэт байдаг. Энэ нь бидний алдаа юм. Аврал одуулахуйн суртгаалд ертөнцийн тэнгэр тэргүүтэнд сүжиглэн, сэтгэл итгэмжилж үйлдэж болохгүйг зарлигласан байдаг. Тиймээс өмнөх дүрийн Далай Лам Павонка Ринбүүчийд зарлиг зэмлэл хүртээж байсны нэгэнд, Шүгдэнг шүтэн үйлдэж байгаа чинь аврал одуулахуйн суртгаалтай харшилж байна хэмээн зарлигласан байдаг. Энэ түүх Павонка Ринбүүчийн өөрийнх нь намтарт гардаг. Павонка Ринбүүчи миний дамжлагын багш бөгөөд санаанд багташгүй эрдэмтэй хүн байсан. Мөрийн зэрэг хийгээд оюун судлахуйн номын эзэн байсан. Харин Шүгдэнг шүтсэн нь Ринбүүчийн алдаа байсан юм. Ринбүүчи Шүгдэнг шүтсэнийг намтраас нь харвал, айж эмээгээд шүтсэн мэт байдгаас биш сайндаа шүтээгүй байдаг. Энэ нь бодит үнэн юм. Түүнчлэн Авралт Богд Тижан Ринбүүчи багш маань санаанд багташгүй эрдэм чадалтай хүн. Дэмчиг Бурхан бодтой. Дэмчигийн номын аймгийн эзэн байсан. Павонка Ринбүүчийн шавь нарын ахмад тул таалалдаа шинжилж үзэлгүйгээр Шүгдэнг сахиусанд шүтдэг байсан. Эдгээрийг та бүхэн мэдэх хэрэгтэй.

Шүгдэнг хорьсон тухайд, хоёр ёнзон багшийгаа таалал барсны дараа намайг санаж явснаа хэрэгжүүлсэн мэтээр зарим нь ярьдаг. Шүгдэнг шүтэхээ болихдоо би, ажиглал шинжлэлийг ямар мэт үйлдсэн тухайгаа бүгдийг хоёр ёнзон багшийнхаа лагшин тунгалаг, амьд сэрүүн байхад нь

айлтгасан. Тэр үед Лин Ринбүүчи багш, маш сайн болсон байна. Одоо үнэхээр цэвэр боллоо гэж айлдсан бол Тижан Ринбүүчи багш, шинжилж судалсанд чинь хуурмаг зүйл огтхон ч байхгүй. Үнэхээр нэг учир шалтгаан байгаа юм байна гэж айлдсан. Тэгэхэд миний сэтгэл амарсан юм. Хоёр багшийн маань таалалд нийцэн, дэмжлэг, зарлиг зөвшөөрлийг олсон сэлт нь хоёр багш маань амьд сэрүүн байх үед болсноос биш хоёр багшийн маань таалал номын агаарт шингэсний дараа би өөрийнхөө санаж явснаа хэрэгжүүлсэн хэрэг огтхон ч биш юм. Бодит байдал ийм байна.

# 2010 оны 8-р сарын 31-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн өмнөд Энэтхэг дэх Сэра-Мэ дацанд *“Цагаан Дарь Эхийн Насны Авшиг”* хүртээх үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

**<— Гарчиг руу буцах**

Өмнө айлдсан нугууд нь Бурханы шашны ерөнхий танилцуулга юм. Цагаан Дарь Эхийн насны авшиг хүртээсний дараа бат оршил өргөхдөө урт уншлага унших хэрэггүй байх гэж бодлоо. Авшиг хүртээх нь Бурханы номыг ерөнхийлөн тайлбарлахтай адилгүй. Ерөнхийдөө Бурханы номыг тайлбарлахад ямар ч хүн ирж сонсож болно. Шашин номыг эсэргүүцдэг хүн байсан ч хамаагүй ирж болно. Багш шавийн хуран мэдлээр үйлдэх хэрэгтэй номыг номлох үед тангараг ариун бус төрөлхтөн номд суувал сайн биш байдаг. Тийм учраас миний зүгээс үргэлж хэлж байдаг: энэ үест Шүгдэнг шүтэгч нар V Далай Ламтай тангараг буруудсан байгаа бөгөөд XIII Далай Ламтай ч мөн адил тангараг буруудсан байгаа. Анхандаа би ч гэсэн Шүгдэнг шүтээд тангараг буруудсан байсан ч хожим бодит байдлыг мэдсэн. Энэ тухай ярих болгондоо би үргэлж V Далай Ламын зохиосон гэрч бичгийн тухай ярьдаг. Тэр бичиг V Далай Ламын нийтэд алдаршсан сүнбүмийн "Да" боть доторх номын сахиусны үйлс даатгалын хэсэгт байдаг бөгөөд тэнд:

"*...Дээд бус хуурмаг дээд Дагважанцан хэмээх*
*Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс*
*Аварч өмөөрөн бүү зохио, үнсэн товорго болгогтун...*"

хэмээн зарлигласан байдаг.

Энэ дөрвөн мөрт шүлгээр Шүгдэн гарсан шалтгаан, түүний мөн чанар, үйлддэг үйлийнх ялгамжааг өгүүлдэг.

Дагважанцан Шүгдэн болж төрснийхөө дараа сажавын их эзэн Сономринчинтэй таарсан байдаг. Тэр үед Сономринчин түүнээс, чи хэн юм хэмээн асуусанд, би гэлүгбын тангаргийн буг байна хэмээн өөрөө өөрийнхөө хэн болохыг хэлсэн байдаг. Тиймээс мөн чанар нь тангаргийн буг, үйлддэг үйл нь шашин хийгээд амьтан бүхэнд хорлогч мөн хэмээн зарлигласан юм.

Сажавын их эзэн Сономринчингийн үеэс сажава нар Шүгдэнтэй барилдлагатай болсон байдаг ч сажавын олон дээдсүүд эдийн ад хэмээн танин барьж тахиж шүтдэггүй байв. Үүнийг зарим нь эсэргүүцдэг. Мөн гэлүгбын ихэнх хутагт хувилгаадууд хориглосон байдаг. Хожим Павонка Ринбүүчийн үеэс эхлэн хүчтэй шүтэгдэх болсон юм. Ерөнхийдөө Павонка Ринбүүчи Цогт Хэрүга Бурхан бодитой бөгөөд Дэмчиг Бурханы номын аймаг, мөрийн зэрэг, оюун судлахуйн номын эзэн, үнэхээр санаанд багташгүй эрдэмтэй хүн байсан. Зарим нь Ринбүүчийг гүтгэн үйлддэг. Тэр нь алдаа юм шүү. Мөн юу зохиосон үйл бүгдийг нь сайнд үзэх хэрэггүй юм. Өмнөх дүрийн Далай Лам Шүгдэнг хүчтэй хорьж байх үед Ринбүүчи Шүгдэнг шүтдэг байсан бөгөөд XIII Далай Ламыг таалал барсны дараа Шүгдэнг шүтэхийг хүчтэй дэлгэрүүлсэн нь эндүүрэл байсан юм. Хожим би ч гэсэн бодит байдлыг бүгдийг нь мэдээд хориглох болсон. Зарим нь үүнийг Далай Багшийн зарлиг гэдэг. Энэ нь алдаа юм. Далай Лам яагаад Шүгдэнг хориглох болсон учир шалтгаан, түүхэн баримт, урьдын дээдсүүд Шүгдэнг хэрхэн танин барьсан зэргийг бүгдийг мэдэх хэрэгтэй болохоос биш юу юуг нь ч мэдээгүй байж янз бүрийн юм ярих нь утгагүй хэрэг. Тэдгээр бүгдийг мэдэх хэрэгтэй. Тэгвэл яагаад Шүгдэнг хориглох болсныг минь ойлгож чадна.

Өнөөдрийн нөхцөл байдлыг авч үзвэл, Хятадын засгийн газар Шүгдэнг шүтэгчдийг онцгойлон дэмждэг. Илүүтэйгээр зарим хийдүүдэд Шүгдэнг шинээр шүтэх хэрэгтэй хэмээн ухуулга, сурталчилгаа хийж байна. Энэ нь ч Шүгдэнг хориглох болсны нэг шалтгаан болдог.

Та бүхний ихэнх нь тодорхой мэдэж байгаа. Одоо тэд ном хэлэлцэх байдлаар их дуу чимээ гаргаж байгаа тул би ч гэсэн энэ тухай ярихгүй байхын арга алга. Нэг хэсэг танай

Сэра-Мэ дацанд олон бэрхшээл учирсан. Үүнд Бомра аймгийнхан хэтэрхий тоомжиргүй хандаж, эцэстээ хүн алах, зодож нүдэх, галдан шатаах зэргийг үйлдэн хятадын коммунистуудад толгойгоо тушаан биеэ өргөх мэтийг үйлдсэн. Энэ байдал нь ерөөл буруудсан тангаргийн буг буюу хятад чөтгөрийн шинж юм. Төвдөөс ирэгсдийн дунд энэ тухай мэддэггүй хүмүүс байдаг ч энэ нь өөр хэрэг. Харин мэдсээр байж тэр зүг уруу явж байгаа хүмүүст миний зүгээс хэлэх зүйл байхгүй. Юугаа шүтэх нь өөрсдийнх нь дур. Гэсэн ч Шүгдэнгийн тухай бодит байдлыг хэлэхгүй бол миний алдаа болно. Сонсох сонсохгүй нь харин та бүхний өөрсдийн чинь шийдэх хэрэг.

Бурханы шашны дамжлага, урсгалуудын эв түнжинг авч үзвэл, нэг хэсэг Төвдийн хам нутагт үл зохилдох байдал их гарах болсон. "Сайтар Номлолын Зүрхэн"-д хоёр боть тайлбар бичсэн мэргэний эрхт Ала Жигмэддамчойн намтарт Чэнзэ Чойжилодой Ринбүүчи Жигмэддамчойд захиа илгээсний дотор: Павонка Ринбүүчийн зарим нэгэн шавь нар шинэ хийгээд хуучин тогтсон тааллыг тэмцэлдүүлж, Бадамжунайн лагшин дүр хийгээд амарлингуй, догшин Бурхадын дүрийг эвдэх, Базар Гүрү уншихад тус эрдэм байхгүйн ёс, Бадмагатан тэргүүтэн номыг гал усанд үйх тэргүүтэн буруу номын явдал олныг гаргаж, мөн бас маанийн хүрд эргүүлэх, өөд болоочид долоон тасалбарыг барих тэргүүтэн хэрэггүйн ёс олныг номлож төрөлхтөн нугуудыг буруу үзлийн оронд байгуулсан хийгээд чухаг дээд гурав бүхний хураангуй хаан Шүгдэнг авралын дээдэд барь хэмээн сургах хийгээд өмнийн дамжлагын зарим нэг жижиг хийдийн олон лам нар Шүгдэн бууж байна хэмээн зүг бүхэнд галзууран гүйж, шүтээний гурван орныг эвдэж нураах тэргүүтэн гэм олныг үйлдэж байгаа бөгөөд хоёрдугаар Ялгуусан Богд Зонховын шашинд том шарх гаргаж буй тул нийтэд туслах захиа бичиг нэгийг зохион хэвлээд Үй, Зан, Хам гуравт түгээвэл шашны хямралыг арилгахад ач ихтэй болохыг айлтгая хэмээн бичсэн байдаг.

Түрүү жил хам нутгийн нэгэн хийдийн гэсгүй байсан лам надтай уулзсан юм. Тэрээр, тэр нутагт нинмава, гаржүдбын зэрэг арван долоон хийд байдгаас гэлүгбын хийд

нь урьд Шүгдэнг шүтдэг байх үед хийдүүд хоорондоо түнжингүй, өглөгийн эздүүд нь ч хоорондоо таардаггүй байсан. 1990 онд тэр хийд Шүгдэнг шүтэхээ больсноос эхлээд тэндэхийн хийдүүдийн эв түнжин сайжирч, өглөгийн эздүүд ч хоорондоо тангараг нэг болцгоосон гэж ярьж байсан. Энэ нь бодит байдал юм. Тиймээс эдгээрийг мэдэж байх хэрэгтэй.

# 2010 оны 10-р сарын 7-ний өдөр. Дээрхийн Гэгээнтэн Тайваниас ном сонсохоор ирсэн мянга дөрвөн зуу гаруй сүсэгтэнд Жанрайсигийн авшиг хүртээх үедээ Шүгдэнгийн тухай айлдсан айлдвар

<— Гарчиг руу буцах

Одоо санваар хүртээх тул багшийн хуран мэдэл агуулах хэрэгтэй. Багш шавь хоорондын тангараг ариун байх хэрэгтэй. Анхандаа би Шүгдэнг шүтдэг байсан. Хожим судалж үзэхэд Шүгдэн гэгч тэр V Далай Ламын үед гарсан байдаг. V Далай Лам Шүгдэнг хэрхэн танин барьсан бэ гэвэл, түүний сүнбүмын "Да" ботид:

"*...Буруу ерөөлт тангаргийн буг ад зэтгэр энэ бээр*
*Амьтан бүхэн хийгээд шашинд хорлож үйлдвээс...*" хэмээн зарлигласан байдаг.

Үүнийг би хожим мэдсэн. Шүгдэнг тахиж шүтэж болохгүй гэдгийг мэдсээр байж үүнийгээ бусдад хэлэхгүй байхын аргагүй. Харин тайлбарлаж хэлснийг минь сонсох сонсохгүй нь хүмүүсийн өөрсдийн мэдэх хэрэг. Шүгдэнгийн тухай бодит үнэнийг бусдад хэлэх нь миний үүрэг юм. Үүнийг зарим хүмүүс эсэргүүцдэг. Тайваньд ч гэсэн үүнийг эсэргүүцдэг хүмүүс байдаг. Сэргон ширээтийн хувилгаан үүнийг эсэргүүцдэг. Тийм учраас хэрвээ энд Шүгдэн шүтдэг хүн байгаад авшиг болон сахил хүртвэл тангараг доройтох тул сайн биш юм. Авшиг, сахил хүртэж болохгүй. Та бүхэн үүнийг сэтгэлдээ магадалж үйлдээрэй. Үүнийг би төвдүүдэд ч гэсэн хэлдэг бөгөөд түүнчлэн гадаадын хүмүүст ч гэсэн хэлдэг.